



МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ЕРӨНХИЙ ГАЗАР
НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХӨГЖЛИЙН
ХӨТӨЛБӨРИЙН МОНГОЛ ДАХЬ СУУРИН
ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР



Empowered lives.
Resilient nations.

БАЙГАЛЬ ОРЧИН, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ХЯНАЛТАД ХҮНИЙ ЭРХ, ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЗАРЧМЫГ ХАНГАХ НЬ

СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

*/БАЙГАЛЬ ОРЧНЫ ХОЛБОГДОЛТОЙ ЗӨРЧЛИЙН
ХЭРГИЙГ ШАЛГАХ АРГАЧЛАЛ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН/*

Улаанбаатар хот
2019 он

БАЙГАЛЬ ОРЧИН, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН ХЯНАЛТАД ХҮНИЙ ЭРХ, ХУУЛЬ ДЭЭДЛЭХ
ЗАРЧМЫГ ХАНГАХ НЬ СУРГАЛТЫН ГАРЫН АВЛАГА

Байгаль орчны холбогдолтой зөрчлийн хэргийг шалгах аргачлал, эрх зүйн орчин

Хоёр дахь хэвлэл

Редактор:	Н.Батбаяр
Боловсруулсан:	Б.Батзориг /Хууль зүйн ухааны доктор/ Б.Цогтбаатар /Хууль зүйн докторант/
Эмхэтгэсэн:	С.Нямжав /Магистрант/
Дизайн:	О.Билгүүн
Формат:	В5
Хэвлэлийн хуудас:	15.5 х/х
Хэвлэсэн тоо:	500ш



Empowered lives.
Resilient nations.

НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Шведийн Байгаль орчны агентлагаас хэрэгжүүлж буй “Байгалийн нөөцийн тогтвортой удирдлагыг хангах байгаль орчны засаглал төсөл”-ийн хүрээнд боловсруулаж хэвлэв.

Энэхүү гарын авлагыг үнэ төлбөргүй тараах ба худалдан борлуулахыг хориглоно.

ГАРЧИГ

УДИРТГАЛ	5
БҮЛЭГ 1: ЗӨРЧИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ	7
1.1 Зөрчлийн тухай хуулийн зорилго	7
1.2 Зөрчлийн тухай ойлголт	9
1.3 Зөрчил үйлдсэн хугацааг тооцох.....	11
1.4 Шийтгэл оногдуулах	14
1.5 Шийтгэлийн төрөл	15
1.6 Зөрчлийн үр дагаврыг арилгах	17
1.7 Тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчид шийтгэл оногдуулах.....	18
1.8 Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдүүдэд оногдуулах албадлагын арга хэмжээ	18
1.9 Хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх.....	21
1.10 Зөрчлийн тухай хуулийг буцаан хэрэглэх асуудал	22
БҮЛЭГ 2: ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ ..	24
2.1 Зөрчил шалган шийдвэрлэх ерөнхий ажиллагаа	26
2.2 Зөрчил шалгах тодорхой ажиллагаа	43
2.3 Тэмдэглэх үйл ажиллагаа	48
2.4 Нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагааны төрлүүд	51
2.5 Зөрчил шалгах ажиллагааг дуусгах	54
2.6 Шийтгэл оногдуулсан шийдвэрийг биелүүлэх	59
БҮЛЭГ 3: ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ЕРӨНХИЙ АНГИД ЗААСАН ОЙЛГОЛТУУДЫГ ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД АВЧ ҮЗЭХ НЬ	69
3.1 Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих	69
3.2 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих	80
3.3 Аюулгүй ажиллагааны журам зөрчих.....	84
3.4 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих	88
3.5 Амьтны тухай хууль зөрчих.....	96
3.6 Байгалийн ургамлын тухай хууль зөрчих	111
3.7 Ойн тухай хууль зөрчих.....	119
3.8 Газрын хэвлийн тухай хууль зөрчих	139
3.9 Ашигт малтмалын тухай хууль зөрчих.....	148
3.10 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих	162
3.11 Усны тухай хууль зөрчих	171
3.12 Ус бохирдуулсан төлбөрийн тухай хууль зөрчих	181
3.13 Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах	182
3.14 Цөмийн энергийн тухай хууль зөрчих	186
3.15 Авто замын тухай хууль зөрчих.....	187
ХАВСРАЛТ. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ХЭЛБЭРИЙН ЗАГВАРУУД	190
Зөрчлийн талаар амаар болон холбоо, мэдээллийн хэрэгслээр гаргасан гомдол, мэдээллийг хүлээн авсан тухай	190
Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэл	191
Битүүмжилсэн хөрөнгө орлого, эд зүйлийг хадгалах хамгаалах үүрэг хүлээсэн хүнд хүлээлгэн өгөх тухай тэмдэглэл.....	193
Хүлээн авсан, битүүмжилсэн эд зүйл, баримт бичгийг зөрчлийн хэрэгт хавсаргах тухай тэмдэглэл	194
Хэргийн материалыг хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулсан тухай тэмдэглэл	195
Зөрчил шалган шийдвэрлэх үйл ажиллагааны тэмдэглэл	197
Зөрчлийн хэрэг нээх тухай тэмдэглэл	199
Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх тухай санал	200
Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх тухай тогтоол	201
Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах тухай тогтоол.....	202
Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, эд зүйлд шинжилгээ хийлгэх тухай тогтоол.....	203

Шинжээч томилж, шинжилгээ хийлгэх тухай тогтоол	205
Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, эд зүйлд үнэлгээ хийлгэх тухай тогтоол.....	207
Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоол.....	209
Зөрчлийн хэргийг прокурорт хүргүүлэх тухай тогтоол.....	211
Орчуулагч, хэлмэрч томилох тухай тогтоол	212
Албадлагын арга хэмжээ авхуулах тухай хүсэлт.....	213
Хариу мэдэгдэх хуудас.....	214
Эрх бүхий албан тушаалтан шүүх хуралдаанд гаргасан тайлбар.....	215
Баталгаа.....	216
Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах хугацааг сунгах тухай тогтоол	217
Хүсэлтийг бүрэн хангах тухай тогтоол.....	218
Хүсэлтийг хэсэгчлэн хангах тухай тогтоол	219
Хүсэлтийг хангахаас татгалзах тухай тогтоол.....	220
Хэтэрсэн хугацааг сэргээх тухай тогтоол	221
АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	222

ҮГИЙН ТОВЧЛОЛ:

- Зөрчлийн тухай хууль----- ЗТХ
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль-----ЗШШТХ
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль----- ЭХХШТХ
- Эрүүгийн хууль-----ЭХ
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль-----ТХШТХ
- Мэргэжлийн хяналтын улсын байцаагч----- МХУБ
- Байгаль орчны хяналтын улсын байцаагч-----БОХУБ
- Байгаль орчин, аялал жуулчлалын яам-----БОАЖЯ
- Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам-----УУХҮЯ
- Ашигт малтмалын тухай хууль-----АМТХ

_____ о О о _____

УДИРТГАЛ

Улс орны экологийн аюулгүй байдлыг хангах, байгаль орчныг хамгаалах зорилгоор тэдгээрийн эсрэг үйлдэгдэж буй зөрчлийг илрүүлэх, шалган шийдвэрлэх, хууль эрхзүйн хүрээнд нотлох ажиллагаа явуулахад мэргэжлийн хяналтын улсын байцаагчид тодорхой мэдлэг, мэргэшил, ур чадвартай байх зайлшгүй шаардлага тулгарч байгаа тул энэхүү бүтээлийг байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчдын энэ чиглэлийн өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглах ширээний ном болгохыг зорилоо.

Энэхүү гарын авлагад 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжтой уялдуулан байгаль орчны холбогдолтой тодорхой төрлийн зөрчлийг шалгах арга аргачлал, түүний дотор зөрчлийг зүйлчлэх, шалган шийдвэрлэх арга ажиллагаа, түүний гэмт хэргээс ялгагдах онцлог, төрийн хяналт шалгалтын үйл ажиллагаа зөрчилтэй хэрхэн холбогдох болон ялгагдах тухай, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд иш татсан байдлаар тусгагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн зохицуулалтыг хэрхэн ашиглах тухай, хойшлуулшгүй тохиолдол гэж юу болох тухай, зөрчил шалган шийдвэрлэх харьяаллын асуудал, Зөрчлийн хуулийн тусгай ангийн ойлголт, тодорхой төрлийн зөрчлүүдэд холбогдох нэр томъёоны ойлголт, прокурортой хэрхэн хамтран ажиллах тухай болон холбогдох тушаал, дүрэм, журам, эрх зүйн акт зэрэг асуудлуудыг тусгасан болно.

Гарын авлагад амьдрал, практикт түгээмэл тохиолддог тодорхой төрлийн зөрчлийн жишээг зохиомжилсон хэлбэрээр тусгайлан авч үзэж тогтоогдсон баримтын хүрээнд Зөрчлийн хуулийн ерөнхий ангийг ашиглан зүйлчлэх, шалган шийдвэрлэх арга ажиллагааг дэлгэрэнгүй тайлбарлаж өгсөн нь мэргэжлийн хяналтын улсын байцаагчдад ашиглахад илүү дөхөмтэй болсон гэж найдаж байна.

Зохиогчдын зүгээс нийгмийн шаардлагад үндэслэн судалгааны өргөн цар хүрээг хамруулж улсын байцаагчийн ажлыг мөрдөн шалгах үйл ажиллагаатай уялдуулан судалсан анхны бүтээл байсныг харгалзан дутуу, ташаа зүйл гарвал уншигч та ойлгон хүлцэж, шүүмжлэхээс илүү авах гээхийн ухаанаар харж, үйл ажиллагаанд хэрэглэх боломжийг тунгаан үзэхийг хүсье.

Мөн энэхүү гарын авлагыг байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагчдаас гадна бусад чиглэлийн улсын байцаагчид ч тодорхой төрлийн зөрчилтэй тэмцэх, шалган шийдвэрлэх ажиллагаандаа амжилттай ашиглана гэдэгт итгэлтэй байна.

Та бүхэнд төрийн албаны болоод мэргэжлийн ёсзүйг чанд баримтлан, ашиг сонирхлоос ангид байж, хууль дээдлэх зарчим, нийтийн эрх ашгийг урьтал болгон ажиллаж хууль тогтоомжийг сахин мөрдүүлэх эрхэм үйлстээ амжилт гаргахыг хүсье.

МХЕГ-ЫН ДАРГА,
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН ЕРӨНХИЙ БАЙЦААГЧ

Н.ЦАГААНХҮҮ



БҮЛЭГ 1. ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ҮНДСЭН ОЙЛГОЛТ

1.1 Зөрчлийн тухай хуулийн зорилго

Хүн бүр өдөр тутам нийгмийн харилцаанд оролцдог. Хүмүүсийн хоорондын харилцаа, нийгмийн дэг журмыг Улсын Их хурлаас тогтоосон хууль, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм, журмаар зохицуулдаг. Энэ нь иргэн, хуулийн этгээдийг зохих хэмжээний хууль, эрх зүйн мэдлэгтэй байхыг шаарддаг. Иргэн, хуулийн этгээд болон түүний удирдлага өөрийн ажиллаж, үйл ажиллагаа явуулж байгаа салбарын хууль тогтоомж, хэм хэмжээ тогтоосон акт, эрх зүйн баримт бичгийн талаар мэдлэгтэй байх нь тодорхой хэмжээгээр өөрийгөө болон бизнесээ эрсдлээс хамгаалах боломжийг танд олгож байдаг. Хууль, тогтоомж зөрчигчдөд хариуцлага хүлээлгэдэг тогтолцоог урьд авч үзэхдээ эрүүгийн хариуцлага, захиргааны хариуцлага гэж ерөнхийд нь ангилж гэмт хэрэгт ял оногдуулж, захиргааны зөрчилд захиргааны шийтгэл хүлээлгэж байсан.

Монгол Улсын Захиргааны хариуцлагын тухай хууль 1992 оны 12 дугаар сарын 15-наас эхлэн хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээр захиргааны албадлагын арга хэмжээ, түүний дотор шийтгэлийн төрөл хэмжээг нарийвчлан тогтоож захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулах болсон юм.

Зөрчлийн тухай хууль	Захиргааны хариуцлагын тухай
1.1 дүгээр зүйл. Хуулийн зорилго 1. Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.	1 дүгээр зүйл. Хуулийн зорилт Энэ хуулийн зорилт нь захиргааны зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага хүлээлгэхтэй холбогдон үүссэн харилцааг зохицуулахад оршино.

Гэмт хэрэг, зөрчлийг ялгаж заагласан үйлдэлд хүлээлгэх хариуцлага нь хоорондоо уялдаагүйгээс нэг бол эрүүгийн хариуцлага хэмээн ял шийтгэх нэг бол захиргааны хариуцлага хэмээн батлагдсан хууль болгонд торгох шийтгэл тусгаж ирсэнийг хууль зүйн нэгдсэн бодлогоор цэгцэлж Зөрчлийн тухай хуулийг хууль тогтоогчоос батлан гаргажээ.

Түүнчлэн урьд нь үйлчилж байсан 2002 оны Эрүүгийн хуулийн Тусгай ангид заасан зарим гэмт хэрэг, Захиргааны хариуцлагын тухай хууль, бусад хуульд заасан захиргааны зарим зөрчил нь ижил, төстэй байсан бөгөөд Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга болон Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгаар дээрх бэрхшээлийг шийдвэрлэсэн.

Өөрөөр хэлбэл, бусдын өмч хөрөнгөнд халдсан нийгмийн хор аюул багатай үйлдэл, нийгмийн хэв журам зөрчсөн, нийтийн амгалан тайван байдал алдагдуулсан үйлдэл, түүнчлэн дүрэм, журам, норм, стандарт зөрчсөн, эсхүл тодорхой нэрлэн заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэж үзэхээр зохицуулалт хийсэн.

Гэмт хэрэг, зөрчлийн ялгаа

	Гэмт хэрэг	Зөрчил
Өмнө нь	Эрүүгийн хуулиар зохицуулдаг байсан	Захиргааны хариуцлагын тухай хуулиас гадна 230 гаруй хуулиар зохицуулдаг байсан
Одоо	Эрүүгийн хуулиар зохицуулна	Зөрчлийн тухай хуулиар зохицуулна
Өмнө нь	Захиргааны зөрчлийг хуульчилсан хуулийн заалт нь Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн бүрэлдэхүүнтэй давхардсан байсан	
Одоо	Давхардлыг арилгасан	
Өмнө нь	Иргэд ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг болохыг Эрүүгийн хуулиас мэдэж болдог	Иргэд, хуулийн ямар үйлдэл, эс үйлдэхүй зөрчил болохыг 230 гаруй хуулиас хайж олж чадвал мэдэж болдог.
Одоо	Иргэд ямар үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг болохыг Эрүүгийн хуулиас мэдэж болдог	Иргэд ямар үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил болохыг Зөрчлийн хуулиас мэдэж болдог

Зөрчлийн шийдвэрлэх тухай хууль нь дараах бүтэцтэй. Үүнд:

Бүлгийн дугаар	Хуулийн бүтэц (бүлгийн дугаар, гарчиг)	Зүйлийн тоо
ЕРӨНХИЙ АНГИ		
Нэгдүгээр бүлэг	Нийтлэг үндэслэл	5
Хоёрдугаар бүлэг	Зөрчил	5
Гуравдугаар бүлэг	Шийтгэл	8
Дөрөвдүгээр бүлэг	Албадлагын арга хэмжээ	5
ТУСГАЙ АНГИ		
Тавдугаар бүлэг	Нийтийн хэв журам, аюулгүй байдлын эсрэг зөрчил	18
Зургаадугаар бүлэг	Нийгмийн ёс суртахуун, хүн амын эрүүл мэнд, эрүүл ахуйн журмын эсрэг зөрчил	22
Долоодугаар бүлэг	Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил	17
Наймдугаар бүлэг	Нийтийн өмч, өмчлөх эрхийн эсрэг зөрчил	8
Есдүгээр бүлэг	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил	10
Аравдугаар бүлэг	Аж ахуйн үйл ажиллагааны журмын эсрэг зөрчил	28

Арваннэгдүгээр бүлэг	Үнэт цаас, банк, санхүү, гааль, татвар, даатгалын журмын эсрэг зөрчил	31
Арванхоёрдугаар бүлэг	Барилга, үйлдвэрлэл, эрчим хүчний журмын эсрэг зөрчил	11
Арвангуравдугаар бүлэг	Хөдөө аж ахуй, газар тариалангийн талаар тогтоосон журмын эсрэг зөрчил	8
Арвандөрөвдүгээр бүлэг	Мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, тээврийн хэрэгслийн ашиглалт, хөдөлгөөний аюулгүй байдлын журмын эсрэг зөрчил	10
Арвантавдугаар бүлэг	Төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааны эсрэг зөрчил	27
Арванзургадугаар бүлэг	Монгол Улсын хилийн аюулгүй байдлын болон гадаадын иргэн, харъяалалгүй хүн Монгол Улсад зорчих журмын эсрэг зөрчил	4
Арвандолдугаар бүлэг	Бусад зүйл	1

1.2 Зөрчлийн тухай ойлголт

Зөрчлийн тухай хуульд “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, энэ хуульд шийтгэл оногдуулахаар заасан үйлдэл, эс үйлдэхүйг зөрчил гэнэ.” хэмээн тодорхойлсон.

Захиргааны хэм хэмжээ гэж “Хуулиар эрх олгосон хүрээнд Төрийн эрх бүхий байгууллага Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу боловсруулж, баталсан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам” юм. Эдгээр дүрэм, журам нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлсэн байх шаардлага. Тэдгээр нь албан ёсны цахим сайтад байрласан байх учир <http://legalinfo.mn/law/?cat=27> гэсэн хаягаар хайлт хийж Засгийн газар, агентлаг, Улсын их хурлаас томилогддог байгууллага, тэдгээртэй адилтгах байгууллага гэсэн сонголтуудаас хайлт хийнэ.

Зөрчил нь хүн, хуулийн этгээдийн идэвхтэй үйлдэл буюу эс үйлдэл зан үйлээр дамжин илэрдэг.

Үйлдэл хийх гэдэг нь хүн, хуулийн этгээдийн идэвхтэй байдал, үйл хөдлөлөөр илэрхийлэгдэнэ. Жишээ нь: Дархан цаазтай газар ан агнасан.

Эс үйлдэл нь тухайн хүн тодорхой нөхцөлд өөрийн хийх ёстой байсан буюу гүйцэтгэх үүрэгтэй байсан үйлдлийг хийгээгүйгээс нийгэмд аюултай хор уршиг бий болгоно. Жишээ нь: Хөдөлмөр хамгаалал хариуцсан ажилтан ажлын талбай дээр ажиллаж байгаа хүмүүст хөдөлмөр хамгааллын журам зөрчиж байгааг мэдсээр байж түүнийг засаж залруулах, зөрчлийг таслан зогсоохгүй үл тоож байгааг хэлнэ.

Хүмүүс дараах үндэслэлээр хуулийн хариуцлага хүлээхгүй гэж үздэг ч, Зөрчлийн тухай хуульд “Тодорхой үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцсоныг мэдээгүй нь тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг шийтгэл, албадлагын арга хэмжээ хэрэглэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.” гэж заасан. Тухайлбал:

- бичиг үсэг мэдэхгүй
 - хууль олж уншаагүй
 - ийм хууль батлагдсаныг мэдээгүй
 - хуулийг буруу ойлгосон
 - хууль ойлгомжгүй бичигдсэн учир хууль зөрчсөнөө мэдээгүй
 - мэргэжлийн хүнээс асуухад энэ үйлдлийг хууль бус үйлдэл биш гэж хэлсэн
 - бүх хүмүүс л хууль зөрчдөг шүү дээ
 - миний мэдэхийн энэ үйлдлийг хууль бус гэж үздэггүй шүү дээ гэх мэт
- Зөрчлийн тухай хуульд тусгайлан зааж шийтгэл оногдуулахаар хуульчлаагүй бол Зөрчлийн тухай хуулийг төсөөтэй хэрэглэхгүй. Өөрөөр хэлбэл Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах, шийтгэл оногдуулж болохгүй.

Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна. Тухайлбал, эцэг, хүү хоёр хамт загас агнахыг хориглосон хугацаанд загас агнасан бол тус тусад нь Зөрчлийн тухай хуульд зааснаар шийтгэл оногдуулна. Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуулийн уялдаа холбооны өөр нэг чухал асуудал бол гэмт хэрэг, зөрчил нь нийгмийн хор аюулын шинж чанар, хэр хэмжээгээрээ ялгагдах хэдий боловч харилцан бие биенийгээ нөхөх замаар хоорондоо харилцан нөхцөлдсөн байдаг оршино. Учир нь гэмт хэргийн нийгэмд аюултай шинж байнга хувьсан өөрчлөгдөж байдаг ойлголт бөгөөд үүнтэй холбоотойгоор Эрүүгийн хууль гэмт хэргийн шинж, Зөрчлийн тухай хуулиар зөрчлийн шинжийг ялган зааглана. Урьд нь Захиргааны хариуцлагын тухай хууль ба захиргааны хариуцлагын хэм хэмжээ тогтоосон бусад хууль тогтоомжийн заалтад гэмт хэрэг, захиргааны зөрчлийг ялгааг “...эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол...” гэсэн шинжээр зааглаж ирсэн уламжлалыг хэвээр авч үлдсэн. Иймд дээр дурдсан эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэсэн нь гэмт хэрэг, зөрчлийг объектив, субъектив шинжээр, эсхүл тодорхой хохирол, хор уршиг учруулсан мөнгөн дүнгээр ялган зааглахыг хэлнэ.

Зөрчлийн тухай хуулийн 2.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой ч түүнийг хангах талаар зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэн гэж үзнэ” гэсэн нь зөрчил үйлдэх хэлбэрийг заасан. Урьд бидний үзэж байсанчлан зөрчлийн гэм буруу гэсэн ойлголт байхгүй болсон бөгөөд санаатай, эсхүл

болгоомжгүйгээр зөрчил гаргасан нь зөрчлийн зүйлчлэлд нөлөөлөхгүй.

1.3 Зөрчил үйлдсэн хугацааг тооцох

Зөрчлийн үр дагавар хэзээ илэрснээс үл хамааран тухайн зөрчил үйлдэгдсэн үеийг зөрчил үйлдсэн хугацаанд тооцно. Тухайлбал, бэлчээрт байгаа мал хордож болзошгүй үл мэдэгдэх бодис уурхайгаас алдагдсан мэдээллийн дагуу шалгахад Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчсөн зөрчил гурван сарын өмнө үйлдэгдсэн нь тогтоогдвол зөрчил үйлдэгдэж байгаа талаарх мэдээлэл ирсэн өдрөөр бус хууль зөрчиж эхэлсэн үеийг зөрчил үйлдсэн хугацаа гэж тооцно. Гэхдээ Химийн бодисын тухай хууль зөрчсөн зөрчил нь тодорхой хугацаанд үргэлжилсэн бол үйлдэгдэж дууссан, эсхүл таслан зогсоосон үеийг зөрчил үйлдсэн хугацаанд тооцно.

Хөөн хэлэлцэх хугацааг тоолох. Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацаа нь шинэ ойлголт биш бөгөөд урьд нь Захиргааны хариуцлагын тухай хуулиар захиргааны хариуцлагад татах хугацаа хэмээн нэрлэж 3 сараар тогтоож байв. Захиргааны шийтгэл хүлээсэн этгээд уг шийтгэлийг эдэлж дууссанаас хойш нэг жилийн дотор захиргааны журам дахин зөрчөөгүй бөгөөд хууль тогтоомжид өөр хугацаа заагаагүй бол захиргааны шийтгэлгүйд тооцож ирсэн. Зөрчлийн тухай хуульд зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг торгох шийтгэлийн хэмжээнээс харгалзан 6 сараас 2 жил хүртэл хугацаатай тогтоосон.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахгүй байх, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй байх хугацаа		Хуулийн этгээд	
Хөөн хэлэлцэх хугацаа	Хүн	Энэ хуулийн тусгай ангид зөвхөн хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар заасан бол торгох шийтгэлийн хэмжээг арав дахин нэмж дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтооно.	
Тайлбар	Зөвхөн зөрчил үйлдсэн хүнд үйлчилнэ	Зөрчлийг хуулийн этгээд үйлдсэн бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийн хэмжээг арав дахин нэмж дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтооно.	
Зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар өнгөрсөн	энэ хуульд хүнд арваас таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан	энэ хуульд хуулийн этгээдэд зуугаас таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан.	
Жишээ	1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбодох газарт тайлагнаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Тооцох: Таван зуун нэгжийг 10 дахин багасгаж хөөн хэлэлцэх хугацааг тогтооно. /500:10=50 нэгж/	

Зөрчил үйлдсэнээс хойш нэг жил өнгөрсөн	энэ хуульд хүнд таван зуугаас дээш арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан	энэ хуульд хуулийн этгээдэд таван мянгаас дээш нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан	
Жишээ	1.Монгол Улсын хуулиар ховор, нэн ховор амьтны жагсаалтад ороогүй боловч Зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн хавсралтад орсон амьтан, ургамал, эсхүл тэдгээрийн гаралтай эд зүйлийг зохих зөвшөөрөлгүйгээр улсын хилээр нэвтрүүлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлолтын туршилтын хугацааг хэтрүүлж олборлолт явуулсан бол учруулсан хохирол, нехөнтөлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.	5.Банкны тухай хуульд заасан, эсхүл Монголбанкнаас тогтоосон зээл, зээлтэй адилтган тооцох актив хөрөнгө, баталгаа, батлан даалтад тавьсан хязгаарлалтыг арван таваас дээш нэгж-хувиар зөрчсөн бол банкныг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно. Тооцох /100000:10=10000 нэгж/
Зөрчил үйлдсэнээс хойш хоёр жил өнгөрсөн	энэ хуульд хүнд арван мянгаас дээш хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан	энэ хуульд хуулийн этгээдэд зуун мянгаас дээш хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан	
Зөрчил үйлдсэнээс хойш зургаан сар	хуулийн тусгай ангид баривчлах шийтгэл оногдуулахаар заасан		

Хөөн хэлэлцэх хугацааг тоолоход дараах зүйлийг анхаарч үзнэ. Үүнд:

1. Хэд хэдэн зөрчил үйлдсэн бол зөрчил бүрт хөөн хэлэлцэх хугацааг тус тусад нь тоолно.
2. Хөөн хэлэлцэх хугацааг зөрчил үйлдсэн өдрөөс эхлэн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагаа эхлүүлэх өдрийг хүртэл тоолно.
3. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно. Өөрөөр хэлбэл, зөрчил гаргагч хүн, хуулийн этгээдэд холбогдох зөрчил шалган шийдвэрлэх явуулж эхэлсэн бол уг хөөн хэлэлцэх хугацааг зогсоож, Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулна. Гэвч зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээснээр хөөн хэлэлцэх хугацаа хязгааргүй зогсохгүй. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан хэрэг бүртгэлт явуулах хугацаа дууссанаар зөрчил шалгах ажиллагаа дуусч, хөөн хэлэлцэх хугацаатай холбоотой асуудал үүсэхгүй.
4. Зөрчлийг хөөн хэлэлцэх хугацааг өөр хуулиар тогтоосон бол тухайн хуулийг дагаж мөрдөнө.
5. Хэрэв хүн, хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй ба энэ хуулийн дагуу шийтгэл оногдуулах үндэслэлтэй бол хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн тоолно. Тухайлбал, Татварын ерөнхий хуульд заасны дагуу татвар ногдуулах, татварын зөрчлийг хөөн хэлэлцэх хугацааг таван жил байхаар тогтоосон байна. Дээр дурдсан жишээтэй адил нөхцөлөөр зарим зөрчилд тухайн салбарын хуульд хөөн хэлэлцэх хугацааг тусгайлан тогтоосон бол уг хөөн хэлэлцэх хугацааг тоолох журмыг баримтлана.

1.4 Шийтгэл оногдуулах

Монгол Улсын Үндсэн хуулиар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн болохыг тунхаглан хуульчилсан. Аливаа улс, гүрэн хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг хамгаалах зайлшгүй шаардлага гардаг. Иймд Монгол улсад хууль, тогтоомж нэг мөр хэрэгжих боломжийг төрөл бүрийн аргаар хамгаалдаг. Үүнд Зөрчил, Эрүүгийн хуулийн зохицуулалт ордог. Өөрөөр хэлбэл хуулийг зөрчвөл хүлээлгэх хариуцлагыг хуульчилж олон нийтэд хууль зөрчсөнөөс үр дагаврыг таниулах замаар урьдчилан сэргийлдэг. Түүнчлэн хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдэд хуулийн хариуцлага хүлээлгэх замаар хууль, шударга ёсыг тогтоодог.

Шийтгэл нь шүүгч, эрх бүхий албан тушаалтнаас хуулиар олгогдсон эрхийн хүрээнд Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд хүлээлгэх хууль зүйн хариуцлагын төрөл мөн.

- Шийтгэл нь гарцаагүй байснаар зөрчлөөс урьдчилан сэргийлэх шинжийг агуулна;
- Хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акттай уялдана;
- Хүнийг хууль сахигч иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэнэ;
- Зөрчигдсэн эрхийг сэргээх, зөрчил гаргасан этгээдийн эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг шийтгэл хүлээлгэх замаар хязгаарладаг.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэлийн зорилго нь:

1. хүн, хуулийн этгээдийг зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх,
2. зөрчил үйлдсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх,
3. шударга ёсыг тогтооход оршино.

Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүнд энэ хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

Гадаад улсын дипломат эрх ямба, дархан эрх эдэлж байгаа хүнд шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх эсэхийг Монгол Улсын олон улсын гэрээ, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

1.5 Шийтгэлийн төрөл

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараахь шийтгэл оногдуулна:
Үүнд:

1. Торгох шийтгэл;
2. Баривчлах шийтгэл;
3. Эрх хасах шийтгэл.

Шийтгэл нь дараах хэлбэртэй. Үүнд: 1. Үндсэн шийтгэл (торгох, баривчлах шийтгэл) 2. Нэмэгдэл шийтгэл (эрх хасах шийтгэл)

Торгох шийтгэл. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ. Торгох шийтгэлийг торгуулийн нэгж /цаашид “нэгж” гэх/-ээр тооцно. Нэг нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. Ханшны өөрчлөлтөөс хамаарах Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд нэг нэгжид хамаарах төгрөгний хэмжээ ихсэх буюу багасч болно.

Торгох шийтгэлийн хэмжээ нь:

- хүнд арваас хорин мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг,
- хуулийн этгээдэд нэг зуугаас хоёр зуун мянган торгуулийн нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.

Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлогыг харгалзан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэж болно. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хөрөнгө, орлого, нөхөн төлбөр, хохирлын тодорхой хувиар тооцсон хэмжээгээр торгох шийтгэлийг оногдуулна. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оргох шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтны саналаар шүүх баривчлах шийтгэлээр солино.

Баривчлах шийтгэл. Зөрчил үйлдсэн хүнийг долоо хоногоос гуч хоногийн хугацаагаар тусгай зориулалтын байранд саатуулахыг баривчлах шийтгэл гэнэ. Баривчлах шийтгэлийг шүүгч оногдуулна.

Шүүх дараах тохиолдолд баривчлах шийтгэлийг оногдуулахгүй. Үүнд:

1. жирэмсэн эмэгтэй,
2. арван дөрөв хүртэлх насны хүүхэдтэй ганц бие эцэг, эх,
3. хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн,
4. баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүн.

Дээрх дурдсан хүн болох нь Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад тогтоогдсон бөгөөд шүүх баривчлах шийтгэл оногдуулаагүй бол Зөрчлийн хуулийн тусгай ангид заасан баривчлах нэг хоногийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр тооцож торгох шийтгэл оногдуулж болно. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны үед саатуулагдсан хугацааг баривчлах шийтгэл эдлүүлэх хугацаанд оруулан тооцно. Цэргийн алба хаагчид оногдуулсан баривчлах шийтгэлийг цэргийн ангийн саатуулан хорих байранд эдлүүлнэ.

Эрх хасах шийтгэл. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн тодорхой мэргэжлийн үйл ажиллагаа явуулах, эсхүл бусад тодорхой эрхийг гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар хязгаарлах, эсхүл зөвшөөрлийг хүчингүй болгохыг эрх хасах шийтгэл гэнэ. Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрх гэдэгт хуулиар, тодорхой журмаар эрх олгохоор заасан үйл ажиллагаа хамаарна. Хууль, захиргааны хэм хэмжээний актад заасан журмын дагуу тооцсон онооны бүртгэлийг үндэслэж эрх хасах шийтгэлийг оногдуулж болно. Тухайлбал, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Засгийн газраас баталсан Замын хөдөлгөөний дүрэмд зааснаар жолоочийн үйлдсэн зөрчилд онооны бүртгэл хөтлөх бөгөөд тодорхой оноо

нь хасагдсан нөхцөлд тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасдаг.

Зөрчлийн хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх хасах шийтгэлийг торгох шийтгэл дээр нэмж оногдуулна. Түүнчлэн зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх хууль, захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон журмыг байнга, эсхүл ноцтой зөрчсөн, эсхүл тусгайлан олгогдсон зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах, эрхээ хэрэгжүүлэх журмыг зөрчсөн зөрчилд нь оногдуулсан шийтгэлийг биелүүлэхээс санаатайгаар зайлсхийсэн бол эрх хасах шийтгэлийг үндсэн шийтгэл дээр нэмж оногдуулна.

Тусгайлан олгох зөвшөөрөл нь Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль болон бусад хуулиар олгогдсон эрхлэх үйл ажиллагааны зөвшөөрөл байна.

Байнга зөрчсөн гэдгийг нэг зөрчлийг хоёр буюу түүнээс удаа үйлдсэн, ноцтой гэдэгт зөрчлийн улмаас төр, хүн, хуулийн этгээд, нийтийн эрх ашигт сэргэх боломжгүй, эсхүл мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх хэмжээ нь их хохирол, хор уршиг учруулсан байхыг хэлнэ.

1.6 Зөрчлийн үр дагаврыг арилгах

Эрх бүхий албан тушаалтан өөрийн санаачилгаар, эсхүл Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан зөрчлийн үр дагаврыг арилгах, учирч болзошгүй хохирол, хор уршгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах зорилгоор зөрчлийн үр дагаврыг арилгах зорилгоор ариутгах, хоргүйжүүлэх, цэвэршүүлэх, засвар үйлчилгээ хийх, холбогдох бүтээгдэхүүнийг борлуулахыг хориглох, иргэний гүйлгээнээс буцаан татах, хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох, энэ талаар олон нийтэд зарлан мэдээлэх зэрэг арга хэмжээ авч болно. Хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол зөрчил илэрсэн өдрөөс үйл ажиллагааг зогсооно. Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авахыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд, зөрчил үйлдсэн хүн арван найман насанд хүрээгүй бол түүний хууль ёсны төлөөлөгчид хугацаа тогтоон даалгаж болно.

Хуульд заасан тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол үйл ажиллагааг зогсоож, энэ талаар нийтэд мэдээлнэ. Ариутгах, хоргүйжүүлэх, цэвэршүүлэх, засвар үйлчилгээ хийх, холбогдох бүтээгдэхүүнийг борлуулахыг хориглох, иргэний гүйлгээнээс буцаан татах, хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох, энэ талаар олон нийтэд зарлан мэдээлэх зэрэг арга хэмжээний зардлыг зөрчил үйлдсэн

хүн, хуулийн этгээд хариуцна.

Зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ.

1.7 Тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчид шийтгэл оногдуулах

Тээврийн хэрэгсэл ашиглан энэ хуулийн Арван дөрөвдүгээр бүлэгт заасан зөрчил үйлдсэн нь автомат ажиллагаатай зураг-дүрс бичлэгийн техник, хэрэгслээр бэхжүүлэгдсэн бол тээврийн хэрэгслийн өмчлөгч, эзэмшигчид энэ хуульд заасан шийтгэл оногдуулна.

Тээврийн хэрэгслийг өөр хүн эзэмшиж, эсхүл ашиглаж байсан нь тогтоогдсон бол өмчлөгч, эзэмшигчийг шийтгэлээс чөлөөлж, зөрчил үйлдсэн хүнд шийтгэл оногдуулна.

1.8 Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах албадлагын арга хэмжээ

Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураана. Зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого” гэж зөрчил үйлдэн олж авсан мөнгө, эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг арилжаалж бий болгосон бусад эд хөрөнгө, эд хөрөнгийн эрх, тэдгээрийг түрээслэх, ашиглах замаар олсон бүх төрлийн орлогыг ойлгохоор Зөрчлийн тухай хуульд заасан.

Хураасан хөрөнгө, орлогыг хохирол нөхөн төлөхөд зарцуулах, эсхүл устгах, шилжүүлэх эсэхийг холбогдох хуульд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Хуульд өөрөөр заагаагүй бол хөрөнгө, орлогоос хохирол нөхөн төлөхөд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах

Албадлагын арга хэмжээ	Шийдвэрлэх субъект
Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, зэвсэг, хэрэгслийг хураана.	эрх бүхий албан тушаалтан
Зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах	шүүх

Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл гэдэгт зөрчил үйлдэхдээ ашигласан зэвсэг, хэрэгсэл, эд зүйл, тээврийн хэрэгсэл, уналга, зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг ойлгохоор Зөрчлийн тухай хуульд заасан.

Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл нь зөрчил үйлдсэн хүний

амьжиргааны эх үүсвэр болсон эд зүйл, хэрэгсэл бол тэдгээрийг хураахгүй.

Хохирол, нөхөн төлбөр гаргуулах

Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдээс учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, зөрчлийн улмаас учирсан хохирол барагдуулах, хор уршгийг арилгах арга хэмжээнд зарцуулж, үлдсэн хэсгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

Албадан эмчлэх

Зөрчил үйлдсэн хүн донтох сэтгэцийн эмгэгтэй болох нь эмнэлгийн дүгнэлтээр тогтоогдсон бол шүүх түүнийг албадан эмчилгээнд хамруулахаар шийдвэрлэж болно.

Албадан сургалт

Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид өөрөөр заагаагүй бол шүүх баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил үйлдсэн хүнд албадан сургалтад хамруулах албадлагын арга хэмжээг хэрэглэж болно. Албадан сургалтыг баривчлах шийтгэлийг эдэлж байх хугацаанд эрх бүхий байгууллага хэрэгжүүлнэ. Албадан сургалт арван цагаас тавин цагийн хугацаатай байна.

Улсын байцаагчид хэдийгээр хураах эрх олгогдсон боловч хэрэв энэ эрхээ хуульд заасан үндэслэл журмыг зөрчиж хэрэгжүүлбэл эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр зохицуулалт байгааг анхаарах хэрэгтэй.

Эрүүгийн хуулийн 13.7 дугаар зүйлд. “Хууль бусаар нэгжих, хураан авах, битүүмжлэх” гэмт хэргийг зааж өгсөн байна.

1. Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж хүний бие, хүний эд зүйл, тээврийн хэрэгсэлд нэгжлэг хийсэн, эд хөрөнгө битүүмжилсэн, хураан авсан бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2. Энэ гэмт хэргийг өс хонзон, шунахай, хувийн сэдэлттэйгээр үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Нөгөө талаар улсын байцаагч урьд өмнө нь “үйл ажиллагааг нь зогсоож лац тавьсан чинь, лац таслаад хууль бус үйл ажиллагааг үргэлжлүүлсэн, надад үүнээс өөр эрх байхгүй болохоор яах юм” гэх гомдлыг гаргадаг байсан. Гэтэл одоогийн ЗШШТХ-иар улсын

байцаагч “лац тавих” тухай зохицуулалт байхгүй. Лац тавих бол хураах, битүүмжлэх зэрэг ажиллагааны явцад хэрэглэж болох үйлдэл юм. Иймд улсын байцаагч та “лац тавиад орхих” биш прокурорын хяналт дор хуульд заасан үндэслэл журмын дагуу хураах, битүүмжлэх ажиллагааг явуулаад тэр тухайгаа тэмдэглэл үйлдэх бай уг тэмдэглэлдээ тухайн эд ангийг хөдөлгөхгүй байхын тулд ажиллагааны явцад хаана хаана хэрхэн лац тавьсан талаараа тодорхой дурдаж өгөх юм. Энэ тохиолдолд уг ажиллагаа нь Эрүүгийн хуулиар бүрэн хамгаалагдах бөгөөд улсын байцаагчийн хууль ёсны дагуу битүүмжилсэн, хураасан эд хөрөнгийг завшсан, үрэгдүүлсэн тохиолдолд эд хөрөнгийг хадгалах, хамгаалах үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан доор дурдсан эрүүгийн хариуцлага хүлээнэ.

Эрүүгийн хуулийн 21.10 дугаар зүйл. Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх

1. Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг хадгалах, хамгаалах үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас эд хөрөнгө устсан, үрэгдсэн, гэмтсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас нэг жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2. Битүүмжилсэн, хураан авсан эд хөрөнгийг хадгалах, хамгаалах үүрэг бүхий албан тушаалтан завшсан бол нийтийн албанд ажиллах эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

1.9 Хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх

Хуулийн этгээдийг төлөөлөн, түүний ашиг сонирхлын төлөө Зөрчлийн тухай хуульд заасан зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдэд энэ хуулийн тусгай ангид заасан шийтгэл оногдуулна.

Хуулийн этгээд нь хууль, захиргааны хэм хэмжээний актыг биелүүлэх боломжтой байсан боловч түүнийг биелүүлэх зохих арга хэмжээг хэрэгжүүлээгүй бол зөрчил үйлдсэнд тооцно. Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ хэрэглэсэн нь тухайн зөрчлийг үйлдсэн хүнийг эрүүгийн хариуцлага, шийтгэл, албадлагын арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл болохгүй. Зөрчил үйлдсэн хүнд шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг үйлдсэн хуулийн этгээдийг шийтгэл, албадлагын арга хэмжээнээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг үүргээ биелүүлээгүйтэй нь

холбогдуулж шийтгэл оногдуулсан нь уг үүргээ биелүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй.

Нэг үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан хоёр, эсхүл түүнээс дээш зөрчлийн шинжтэй бол аль хүнд шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд нь шийтгэл оногдуулна.

Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан бол зөрчилд оногдуулах торгох, баривчлах шийтгэл дээр нэмж бусад зөрчилд оногдуулахаар заасан нэмэгдэл шийтгэл, албадлагын арга хэмжээг оногдуулна.

Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд хуулийн этгээдэд шийтгэл оногдуулна.

Зөрчил үйлдсэн арван зургаагаас арван найман насны хүний хувийн байдал, зөрчлийн шинж, зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдлыг харгалзан шийтгэлээс чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэж болно.

5. Зөрчил үйлдсэн хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, түүнийг санаатайгаар дампууруулсан, татан буулгасан бол доор дурдсан журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ:
 - 5.1. Бусад хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд;
 - 5.2. Бусад хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд;
 - 5.3. Хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйлдсэн зөрчилд холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд;
 - 5.4. Хуулийн этгээдийн зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөгдөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд;
 - 5.5. Компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс зөрчил үйлдсэн нь тогтоогдсон бол толгой компанид;
 - 5.6. Зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх явцад хуулийн этгээдийг санаатайгаар татан буулгасан бол торгох шийтгэл, хохирол, хор уршиг нөхөн төлүүлэх албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг эд хөрөнгө хуваарилагдсан хувьцаа эзэмшигчид;
 - 5.7. Аливаа хэлбэр, арга, хэрэгслээр эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг үндэслэлгүйгээр тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн авсан нэгдмэл сонирхолтой этгээдэд, эсхүл эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг хариу төлбөргүйгээр шилжүүлэн авсан бусад хуулийн этгээдэд

шилжүүлэн авсан хөрөнгийн хувь хэмжээгээр.

6. Хуулийн этгээдэд энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэх нь шийтгэлийн зорилгыг хангах боломжгүй бол шүүгч зөрчил үйлдэгдэх үед тухайн зөрчилд холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг бүхэлд нь хариуцаж байсан хуулийн этгээдэд шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.
7. Энэ зүйлд заасан хуулийн этгээд өөрчлөн байгуулагдахаас өмнө тухайн зөрчлийн талаар мэдсэн эсэхээс нь үл хамааран шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.
8. Гадаад улсын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар Монгол Улсын нутаг дэвсгэрт зөрчил үйлдсэн бол хуулийн этгээдийн нэгэн адил шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ.

1.10 Зөрчлийн тухай хуулийг буцаан хэрэглэх асуудал

Зөрчлийн тухай хууль нь 2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн. Энэ цаг хугацаанаас эхлэн торгох, эрх хасах шийтгэл оногдуулахаар хуульчилж байсан заалтууд хүчингүй болсон. Өөрөөр хэлбэл 7 сарын 1-нээс эхлэн 230 гаруй хуульд заасан эрүүгийн хариуцлага хүлээхээргүй бол дараах хариуцлага хүлээлгэнэ, Зөрчлийн тухай хуулийн заалтыг зөрчсөн бол дараах хариуцлага хүлээлгэнэ гэсэн заалтууд хүчингүй болно.

Зөрчилд тооцох, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээг тухайн зөрчил үйлдэх үед дагаж мөрдөж байсан хуулийн дагуу шийдвэрлэнэ.

Зөрчилд тооцохгүй болсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хөнгөрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хуулийг буцаан хэрэглэнэ.

Шинээр зөрчилд тооцсон, оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг хүндрүүлсэн, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан хуулийг буцаан хэрэглэхгүй.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийн эрх зүйн байдлыг дээрдүүлсэн хууль хүчин төгөлдөр болохоос өмнө шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгэсэн бол хуулийг буцаан хэрэглэхгүй ба шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шийдвэрийг гүйцэтгээгүй байгаа тохиолдолд буцаан хэрэглэнэ.

Зөрчил нь 2017 оны 7 дугаар сарын 1-нээс өмнө үйлдэгдсэн зөрчилд шийтгэл оногдуулж байгаа тохиолдолд		
2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнөх хуулиудад	2017 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Зөрчлийн хуульд	Шийдэл
Шийтгэл оногдуулах зөрчил хуульчлагдсан.	Шийтгэл оногдуулах зөрчил хуульчлагдсан заалт хүчингүй болсон.	Шийтгэл оногдуулахгүй.
Шийтгэл оногдуулсан зөрчил хуульчлагдаагүй байсан.	Шийтгэл оногдуулах зөрчил шинээр хуульчлагдсан.	Шийтгэл оногдуулахгүй.
Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл нь хүнд	Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл хөнгөн	Хөнгөн шийтгэл оногдуулна
Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл нь хөнгөн	Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулах шийтгэл нь хүнд	Хөнгөн шийтгэл оногдуулна

БҮЛЭГ 2. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээрийн 1-д “...Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцах...”-аар заасан. Ийнхүү төр Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуулиар хамгаалагдсан эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх, улмаар хууль зөрчсөн хүн, хуулийн этгээдийн үйлдэл, эс үйлдэхүйг хуулийн дагуу шалгаж тогтоон, хуулийн хариуцлага хүлээлгэх үүргийг өөртөө хүлээсэн. Хууль сахиулагч, улсын байцаагч, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнуудын хувьд үйл ажиллагаа явуулахад бусад төрийн албан хаагчдаас илүү эрхийг хуулиар олгодог. Энэ нь хүний эрхэнд халдах хязгааргүй эрх мэдэл биш.

Хүний эрх бол хүнээс салшгүй бөгөөд түүний амьдрах зайлшгүй шаардлагатай арга хэлбэр, нөхцөл нь болдог. Хувь хүн нийгэм төр бусад бодгалиуд хоорондоо харилцах хүний оршихуйг илэрхийлсэн эрх чөлөөг тодорхойлдог хувь хүний тодорхой онцлог мөн чанар юм. Орчин үеийн нийгмийг эрх чөлөө, тэгш байдал, шударга ёсны зарчим дээр үндэслэсэн хүний эрхгүйгээр төсөөлөх боломжгүй. Хууль ёсны эрх дээр тулгуурласан хувь хүний эрх чөлөөний хүрээг тодорхойлдог нийгмийн хөгжлийн үнэт зүйл болж төрийн хэмжээлшгүй эрх мэдлийг хязгаарлагч болсон байна. Хүний жам ёсны эрх болох амьд явах эрх, халдашгүй дархан байх эрх, өөрийн амьдрах аргаа чөлөөтэй сонгох эрх чөлөө, шүтэж бишрэх, итгэл үнэмшилтэй байх эрх чөлөө хувийн амьдралын бие даасан байдал болон бусад эрхийг хэн ч хасах ёсгүй. Төр эдгээр хүний жам ёсны эрхийг хүлээн зөвшөөрч, зохих ёсоор хангах үүрэгтэй.

Халдашгүй чөлөөтэй байх эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүний эрхийн тухай Европын конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт зэрэг олон улсын гэрээ, конвенц болон үндэсний хууль тогтоомжинд баталгаажуулсан байдаг. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 29 дүгээр зүйлд зааснаар бусдын эрх, эрх чөлөөг зохих ёсоор хүлээн зөвшөөрөх, ёс суртахууны шударга шаардлага, нийгмийн хэв журам, сайн сайхныг хангах зорилгоор төрөөс хуульчлан хүний эрхийн зарим хязгаарлалт тогтоож болно.

Иймд аливаа улс орон үндэснийхээ хууль тогтоомжоор хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон хувийн өмчийг гэмт халдлагаас хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагааны явцад хүний халдашгүй эрхэнд зохих үндэслэл журмын дагуу халдахыг зөвшөөрсөн байдаг.

Хуулийг нийгмийн харилцааг зохицуулах шинжээр нь хэд хэдэн төрөлд ангилж авч үздэгийн нэг нь нийгмийн харилцааг хамгаалах хэм хэмжээ байдаг. Хамгаалах хэм хэмжээ нь хуулиар зохицуулсан хэм хэмжээг хамгаалах, зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, зөрчигдсөн тохиолдолд мөрдөн шалгах, хянан шийдвэрлэх, төрийн албадлагын арга хэмжээ авах, хууль зүйн хариуцлага ногдуулах, биелүүлэх, хяналт тавих ажиллагааг тодорхойлсон шинжтэй байна. Хамгаалах хэм хэмжээг нийгмийн харилцаанд үйлчлэх шинжээр нь хариуцлага тусгасан болон процедур тусгасан гэж ангилдаг. Эрүүгийн болон Зөрчлийн хуулиудын зорилго Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө, нийтийн болон үндэсний ашиг сонирхол, Үндсэн хуулийн байгуулал, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдлыг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд оршино. Эрүүгийн болон Зөрчлийн хуулиар хориглосон үйлдэл, эс үйлдэхүй үйлдсэн хүн, хуулийн этгээдийн илрүүлэх, нотолж тогтоон хариуцлага хүлээлгэх, иргэн хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиудын үндсэн зорилго байдаг. Өөрөөр хэлбэл шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмыг хангах хууль зүйн баталгаа юм.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль нь дараах бүтэцтэй. Үүнд:

Бүлгийн дугаар	Хуулийн бүтэц (бүлгийн дугаар, гарчиг)	Зүйлийн тоо
Нэгдүгээр бүлэг	Нийтлэг үндэслэл	15
Хоёрдугаар бүлэг	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэгч	4
Гуравдугаар бүлэг	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны оролцогч	7
Дөрөвдүгээр бүлэг	Зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах журам	15
Тавдугаар бүлэг	Эрх хязгаарлах арга хэмжээ	5
Зургаадугаар бүлэг	Зөрчлийн хэрэг бүртгэлт	11
Долоодугаар бүлэг	Шийтгэл оногдуулах	6
Наймдугаар бүлэг	Эрүүгийн хэргийн шүүхийн зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа	2
Есдүгээр бүлэг	Зарим зөрчил шалган шийдвэрлэх журам	3
Аравдугаар бүлэг	Хууль хүчин төгөлдөр болох	1

2.1 Зөрчил шалган шийдвэрлэх ерөнхий ажиллагаа

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд баримтлах хууль, тогтоомж

Зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий улсын байцаагч нь дараах хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгоно.

- Төрийн албаны тухай хууль
- Салбарын хууль /Ашигт малтмалын тухай, Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай, Ойн тухай гэх мэт/
- Зөрчлийн тухай хууль
- Эрүүгийн хууль
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дараах дүрэм, журмыг мөрдлөг болгоно. Үүнд:

№	Хуулийн үндэслэл	Эрх зүйн баримт бичгийн нэр	Батлах эрх бүхий этгээд
1	1.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг	Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлыг тооцох журам	Засгийн газар
2	4.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг	Зөрчил шалгах ажиллагааны тэмдэглэл, шийдвэрийн маягт	Улсын ерөнхий прокурор
3	4.10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг	Шинжилгээнд зориулж авсан хэв загвар, дээж авах, хадгалалт, тээвэрлэлт, температурын горим	Засгийн газар
4	4.13 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны тэмдэглэлийн маягт	Улсын ерөнхий прокурор
5	5.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	Эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журам	ХЗДХ-ийн сайд, Улсын ерөнхий прокурор
6	5.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Саатуулах байрны дэглэм, журам	ХЗДХ-ийн сайд
7	5.5 дугаар зүйлийн 12 дахь хэсэг	Барьцааны мөнгийг хадгалах, буцаан олгох журам	Улсын ерөнхий прокурор, Сангийн болон ХЗДХ-ийн сайд


8	6.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Зөрчлийн талаархи мэдээллийг төлбөртэй авах журам	Сангийн болон ХЗДХ-ийн сайд
9	7.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг	Хохирол, нөхөн төлбөрийг тооцох журам	Улсын ерөнхий прокурор
10	7.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэг	Шийтгэлийн хуудасны загвар	Засгийн газар
11	7.5 дугаар зүйлийн 12 дахь хэсэг	Хураан авсан эд зүйл, зэвсэг, хэрэгслээс хохирол нөхөн төлүүлэх, улсын орлого болгох, устгах журам	Засгийн газар

Дээрх дурдсан хууль, тогтоомж, дүрэм, журмыг <http://legalinfo.mn> цахим хаягаар орж авна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны нууцлал

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэрэгжүүлэгчид албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүн, байгууллага, төрийн нууцыг задруулахгүй байх, түүнийг хамгаалах үүрэгтэй. Мөн энэ ажиллагаанд оролцсон, байлцах явцдаа хувь хүн, байгууллага, төрийн нууцыг мэдэх болсон хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг сануулж, бичгээр баталгаа гаргуулж авна. Хувь хүний нууцын тухай Монгол Улсын хуулийн 2 дугаар зүйлд “Хувь хүний нууц” гэж Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжид нийцүүлэн нууцалсан бөгөөд задруулбал тухайн хүний хууль ёсны ашиг сонирхол, нэр төр, алдар хүндэд илтэд хохирол учруулж болзошгүй мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хэлнэ.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлд зааснаар хувь хүний нууц нь дараахь төрөлтэй байна.



Хувь хүний өөрийн архив, хадгаламж, тэмдэглэл, битүүмжлэл болон тэдгээрт хамаарах дүрс, дуу, дуу-дүрсний бичлэгийг нууцалж болно.

Байгууллагын нууцын тухай Монгол Улсын хуулийн 3 дугаар зүйлд “Байгууллага” гэж тодорхой чиг үүрэг, бүрэн эрх бүхий хуулиар хүлээн

зөвшөөрөгдсөн хуулийн этгээдийг хэлнэ;

“Байгууллагын нууц” гэж хүний эрх, нэр төр, алдар хүнд тухайн байгууллагын хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор холбогдох хуулиар нууц гэж тогтоосон мэдээ, баримт бичиг, биет зүйлийг хамруулах бөгөөд байгууллагын албаны үйл ажиллагааны онцлогтой холбоотой, эсхүл шударга өрсөлдөөнд зах зээл, давуу талаа хамгаалах зорилгоор байгууллага өөрөө нууцалж хамгаалалтдаа авсан, задруулбал хууль ёсны ашиг сонирхолд нь хор уршиг учруулж болох нууц мэдээ, технологийн шийдэл, төсөл, судалгаа-шинжилгээний баримт бичиг, шаардлагатай техник, тоног төхөөрөмжийг байгууллагын нууцад хамааруулж болно.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлд “төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг, харин “албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг гэж тодорхойлсон байна. Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс зарим барилга, байгууламж /цаашид “объект” гэх/, төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа тодорхой үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулж болохоор заасан байна. Шүүгч, прокурор, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах болон эрх бүхий албан тушаалтан нь хувь хүн, байгууллага, төрийн нууцтай холбоотой ажиллагаанд оролцсон, байлцсан хүнд нууцыг задруулахгүй байх үүргийг хүлээлгэнэ. Мөн задруулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар бичгээр түүнд сануулж гарын үсэг зуруулах, эсхүл өөрөөр нь баталгаа бичүүлж авна.

Зөрчил шалгах эрх бүхий улсын байцаагчийн явуулж байгаа зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан

Улсын байцаагчийн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад прокуророос гадна зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан хяналт тавих, удирдлага зохион байгуулалтаар ханган дэмжлэг үзүүлнэ. Энэ хүрээнд дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг зохион байгуулалт, мэргэжлийн удирдлагаар хангах;
2. Зөрчлийн талаархи гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлж, прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэх;
3. Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах үүргийг нэг, эсхүл хэд хэдэн эрх бүхий албан тушаалтанд даалгах;
4. Шаардлагатай тохиолдолд зөрчлийн хэрэг бүртгэлтийг явуулах эрх бүхий албан тушаалтныг өөрчлөх;
5. Зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулах шаардлагатай бол хэрэг бүртгэлтийн хугацааг 14 хүртэл хоногоор сунгах;
6. Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэхээр прокурорт танилцуулж, шийдвэрлүүлэх;
7. Шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтны бүрэн эрхийг хэрэгжүүлэх;

Зөрчил шалгах эрх бүхий улсын байцаагчийн үйл ажиллагаа шийдвэрт гомдол гаргах

Хохирогч, холбогдогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч зөрчлийн хэрэг бүртгэлтийн шатанд улсын байцаагчийн шийдвэр, үйл ажиллагааны талаар прокурорт гомдол бичгээр гаргаж болно. Прокурор гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор шийдвэрлэж, шийдвэрийг гомдол гаргасан оролцогчид биечлэн танилцуулах, эсхүл харилцаа, холбооны хэрэгсэл ашиглан хүргүүлнэ. Гомдол гаргасан хохирогч, холбогдогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор тухайн нэгжийн дээд шатны прокурорт гомдол гаргаж болно. Тухайн нэгжийн дээд шатны прокурор гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор хянан шийдвэрлэнэ.

Прокурор шаардлагатай гэж үзвэл гомдлыг шийдвэрлэх хүртэлх хугацаанд эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн биелэлтийг түдгэлзүүлж болно. Хохирогч, холбогдогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад гаргасан гомдол, түүнийг хэрхэн хянан шийдвэрлэсэн тухай Зөрчлийн хэрэг бүртгэлтийн материалд хавсаргана. Улсын байцаагчийн зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд оногдуулсан шийтгэл, Зөрчлийн тухай хуульд заасан албадлагын арга хэмжээ оногдуулсан шийдвэртэй холбоотой асуудлаар хохирогч, холбогдогч, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч прокурорт гомдол гаргахгүй. Тус асуудлаар зөвхөн шүүхэд гомдол гаргана.

Эрх бүхий байгууллагын холбогдох ажилтан нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан оролцогчийн хүсэлт, гомдлыг хүлээн авч байгууллагын бүртгэлд бүртгэн, эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтанд шийдвэрлүүлэхээр даруй шилжүүлнэ. Оролцогчийг биечлэн ирж амаар гаргасан хүсэлт,

гомдлыг бичгээр өгөхийг шаардахгүй бөгөөд хүсэлт, гомдлыг тэмдэглэл үйлдэн хүлээн авч, тухайн этгээдээр гарын үсэг зуруулан бүртгэлд бүртгэж, холбогдох албан тушаалтанд даруй шилжүүлнэ. Энэ тохиолдолд хүсэлт, гомдол гаргагчийн гэрийн хаяг, холбоо барих утас зэргийг тэмдэглэлд тодорхой бичсэн байвал зохино. Буцах хаяггүй, бичсэн хүний нэр, гарын үсэггүй ирүүлсэн хүсэлт, гомдлыг эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтанд танилцуулж, шалгахгүйгээр архивт шилжүүлнэ. Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан оролцогчийн гомдлын дагуу холбогдох зөрчлийн хэрэг, материалтай бүрэн танилцаагүй, хянаагүй байхдаа урьдаас таамаглан шийдвэр гаргаж болохгүй. Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан шаардлагатай гэж үзвэл эрх бүхий албан тушаалтны шийдвэрийн биелэлтийг гомдлыг хянан шийдвэрлэж дуусах хүртэл гомдол гаргагчийн зөрчигдсэн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг цаг алдалгүй авна. Хүсэлт, гомдлыг хянан шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтны шийдвэрийг тогтоол хэлбэртэй гаргана. Тогтоолыг 2 хувь үйлдэх ба 1 хувийг хэрэг, материалд, 1 хувийг дугаарын дагуу бичиг хэргийн нэгж болгон архивт хадгална. Эрх бүхий албан тушаалтан, зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан хүсэлт, гомдлыг хянан шийдвэрлэсэн талаар оролцогчид бичгээр хариу мэдэгдэнэ.

Оролцогчид өгөх хариу мэдэгдэх хуудсанд дараахь шаардлага тавигдана. Үүнд:

1. Хариу мэдэгдэх хуудас нь тухайн эрх бүхий байгууллагын нэр, хаяг бүхий албан бланк дээр бичигдэнэ.
2. Хүсэлт, гомдол гаргасан оролцогчийн овог, нэр, хаяг, утсыг тодорхой бичнэ.
3. Хариу мэдэгдэх хуудас нь тухайн эрх бүхий байгууллагын бичиг хэргийн ажилтнаас олгосон он, сар, өдөр, индекс, дугаартай байна.
4. Хариу мэдэгдэх хуудсанд хүсэлт, гомдлыг хүлээн авсан эсхүл хүлээн авахаас татгалзсан хууль зүйн үндэслэл, шалтгааныг ойлгомжтой, товч тодорхой дурьдаж өгнө.
5. Шаардлагатай гэж үзвэл холбогдох хуулийн зүйл, хэсгийг иш татаж болно.
6. Хариу мэдэгдэх хуудсыг зөрчлийн хэрэг, материалд авагдсан нотлох баримтанд тулгуурлан үндэслэлтэй бичсэн байвал зохино.
7. Тухайн хүсэлт, гомдлыг хянан шийдвэрлэсэн албан тушаалтны шийдвэрийг эс зөвшөөрвөл хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан, прокурорт гомдол гаргах эрх болон гомдол гаргах хугацааны талаар

заавал дурьдана.

8. Хариу мэдэгдэх хуудсанд тухайн хүсэлт, гомдлыг хүлээн авч хянан шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтан өөрийн албан тушаал, нэр, зэрэг дэв, цолыг бичиж, гарын үсэг зурсан байна.

Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авах, бүртгэх

Мэргэжлийн хяналтын эрх бүхий байгууллага, эрх бүхий албан тушаалтан нь хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас гаргасан зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.1, 6.2 дугаар зүйлд заасан журмын дагуу хүлээн авч, бүртгэлд бүртгэнэ.

Дараахь тохиолдолд эрх бүхий албан тушаалтан прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулна. Үүнд:

1. Хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх явцад энэ хуулиар шалган шийдвэрлэхээр харьяалуулсан зөрчлийн шинжтэй үйлдэл, эс үйлдэхүйг илрүүлсэн;
2. Хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас зөрчлийн талаар гомдол гаргасан, эсхүл мэдээлсэн;
3. Зөрчил үйлдсэн хүн өөрийгөө илчилж ирсэн;
4. Байгууллага, албан тушаалтнаас харьяаллын дагуу зөрчлийн талаархи холбогдох баримтыг шилжүүлэн ирүүлсэн;

Хүлээн авсан зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон тэмдэглэл үйлдэж хүлээн авсан гомдол, мэдээллийн хамгийн арын хуудсанд дардас дарж, уг гомдол, мэдээллийг байгууллагын бүртгэлийн дэвтэрт бүртгэсэн дугаар, хүлээн авсан он, сар, өдөр, цаг, минутыг бичиж тэмдэглэнэ. Хүлээн авсан зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харъяалах газар, хэлтэс, тасаг, хэсгийн удирдах албан тушаалтанд танилцуулж, шалгаж шийдвэрлэх албан тушаалтанд цохолт хийлгүүлнэ.

Зөрчлийн бүртгэл хариуцсан ажилтан нь цохолт хийгдсэн **зөрчлийн талаарх гомдол**, мэдээллийг шалгаж шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтанд даруй шилжүүлэн өгч, бүртгэлд гарын үсэг зуруулан хүлээлгэж өгнө. Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл гаргагчид эрх, үүргийг нь танилцуулж, санаатай худал мэдээлвэл хуулийн дагуу хариуцлага хүлээх талаар сануулж, энэ тухай тэмдэглэл үйлдэж, гарын үсэг зуруулна.

Гомдол, мэдээлэл нь илтэд зөрчлийн шинжгүй бол хүлээн авахгүй байж болно. Энэ тухай гомдол, мэдээлэл гаргагчид тайлбарлан өгч, буцаана. Тухайн зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл ногдуулсан эрх бүхий албан тушаалтны болон шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр байгаа, эсхүл шалгагдаж буй асуудлаар дахин гомдол, мэдээлэл гаргавал хүлээн авахгүй байж болно.

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд үйлдсэн зөрчлөө сайн дураараа

хүлээсэн мэдээллийг шаардлагатай гэж үзвэл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлж, хүлээн авна.

Нэг этгээдэд хамаарах нэг үйл явдлын талаар 2 буюу түүнээс дээш гомдол, мэдээллийг хүлээн авсан тохиолдолд бүртгэлийн нэг дугаарт бүртгэнэ.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтан нь хүлээн авч, бүртгэсэн зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг харъяалах прокурорын газрын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлнэ. “Даруй” гэсэн цаг хугацааг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.7-д зааснаар (...“даруй” гэж боломжит богино хугацааг...) ойлгоно.

Зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлэх

Эрх бүхий аалтан Зөрчлийн тухай хуульд заасан шинжтэй үйлдэл, эс үйлдэхгүйг илрүүлсэн, эсхүл гомдол, мэдээллийг хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор шалгаж, дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана:

1. Гомдол, мэдээллийг харьяаллын дагуу шилжүүлэх.
2. Гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзах.
3. Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх.
4. Зөрчлийн хэрэг нээх.

Эрх бүхий албан тушаалтан нь дээр дурдсан шийдвэрийг бичгэн хэлбэрээр гаргана. Энэ нь тогтоол хэлбэртэй байна. Тус шийдвэрт дараах зүйлийг тусгана. Үүнд:

- Гомдол, мэдээллийг хянан үзээд тогтоогдсон нөхцөл байдал, татгалзаж буй үндэслэлийг тодорхой дурьдаж өгнө.
- Шийдвэр гаргах хууль зүйн үндэслэл.
- Шийдвэр гаргасан хүний албан тушаалтан, нэр.
- Шийдвэрийн хувийг гомдол, мэдээлэл гаргагчид гардуулж өгсөн буюу мэдэгдсэн тухай.

Зөрчлийн хэрэг нээх

Эрх бүхий албан тушаалтан дараах тохиолдолоос бусад нөхцөлд зөрчлийн хэрэг нээнэ. Үүнд:

1. Зөрчлийн талаархи гомдол, мэдээлэл тухайн байгууллагын харьяаллын бус бол.
2. Хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн;
3. Зөрчлийн шинжгүй.
4. Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн;
5. Тухайн зөрчилд хариуцлага тооцсон хуулийн зүйл, хэсэг, заалт хүчингүй болсон.

6. Зөрчил үйлдсэн хүн нас барсан.
7. Тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтны, эсхүл шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр бол.

Өөрөөр хэлбэл, өргөдөл, гомдол, мэдээлэл болон илэрсэн нөхцөл байдлыг шалгахад дээрх нөхцөл илэрсэн бол “Зөрчлийн хэрэг бүртгэлд” буюу зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоох, шийтгэл оногдуулах эсэхийг шийдвэрлэх зорилготой ажиллагааг явуулахгүй.

“Зөрчлийн шинжгүй” гэдэг нь тухайн үйлдэл, эс үйлдэхүй Зөрчлийн хуулиар урьдчилан хориглосон заалт буюу нийтээр дагаж мөрдөхөөр тогтоосон журмыг зөрчөөгүй байхыг ойлгоно. Өөрөөр хэлбэл, зөрчлийн эрх зүйн хэм хэмжээгээр нийтээр дагаж мөрдөхөөр урьдаас журамлан тогтоогоогүй бол уг үйлдэл, эс үйлдэхүй нь нийгэмд хор уршиг учруулсан ч захиргааны хариуцлага хүлээлгэхгүй.

Зөрчлийн тухай хуульд заасан **“хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн”** гэдэгт тухайн зөрчил үйлдэгдсэнээс хойш хуульд заасан тодорхой хугацаа өнгөрсөн байхыг ойлгоно. Харин **“зөрчил үйлдэгдсэн хугацаа”** гэж “зөрчлийн үр дагавар хэзээ илэрснээс үл хамааран тухайн зөрчил үйлдэгдсэн үеийг ...тооцно” гэж Зөрчлийн тухай хуулийн 2.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон байна. Хэрэв зөрчил тодорхой хугацаанд үргэлжилсэн бол үйлдэгдэж дууссан, эсхүл таслан зогсоогдсон үеийг зөрчил үйлдсэн хугацаанд тооцно гэжээ. Зөрчлийн тухай хуульд хөөн хэлэлцэх хугацааг зөрчилд оногдуулах шийтгэлээс хамаарч дараахь байдлаар тогтоосон байна.

	Зөрчил	Хөөн хэлэлцэх хугацаа
1	10-500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэй зөрчил	Тухайн зөрчил үйлдэгдсэнээс хойш 6 сар өнгөрсөн
2	500-аас дээш 10.000 нэгжтэй хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэй зөрчил	Тухайн зөрчил үйлдэгдсэнээс хойш 1 жил өнгөрсөн
3	10.000-аас дээш 20.000 нэгжтэй хэмжээний төгрөгөөр торгох шийтгэлтэй зөрчил	Тухайн зөрчил үйлдэгдсэнээс хойш 2 жил өнгөрсөн
4	Баривчлах шийтгэл оногдуулахаар заасан зөрчил	Тухайн зөрчил үйлдэгдсэнээс хойш 6 сар өнгөрсөн
5	Зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг өөр хуулиар тогтоосон бол	Тухайн хуульд заасан хугацаа өнгөрсөн
6	Зөрчлийг хуулийн этгээд үйлдсэн бол	Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийн хэмжээг арав дахин нэмж дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтооно.

7	Зөрчлийн тухай хуулийн хуулийн тусгай ангид зөвхөн хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар заасан зөрчил бол	Зөрчлийн тухай хуулийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан торгох шийтгэлийн хэмжээг арав дахин багасгаж торгох шийтгэлийн хэмжээтэй дүйцүүлэн хөөн хэлэлцэх хугацааг тогтооно.
8	хүн, хуулийн этгээдийн хууль бус үйлдэл, эс үйлдэхүй эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бөгөөд энэ хуулийн дагуу шийтгэл оногдуулах үндэслэлтэй бол	Хөөн хэлэлцэх хугацааг эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзах тухай шийдвэр гарсан өдрөөс эхлэн тоолно.

Мөн хэд хэдэн зөрчил үйлдсэн бол зөрчил бүрд хөөн хэлэлцэх хугацааг тус тусад нь тоолно. Хөөн хэлэлцэх хугацааг зөрчил үйлдсэн өдрөөс эхлэн зөрчлийг шалган шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх өдрийг хүртэл тоолно. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа эхэлснээр хөөн хэлэлцэх хугацааг тоолохыг зогсооно. Хөөн хэлэлцэх хугацааг өөр хуулиар тогтоосон бол тухайн хуулийг дагаж мөрдөнө. Тухайлбал: Татварын ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлд “Татвар нөхөн ногдуулах, алданги, торгууль ногдуулах хөөн хэлэлцэх хугацаа 5 жил байх бөгөөд Монгол Улсын Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа татварын хууль тогтоомжид хамаарахгүй” гэж заасан байна.

“Тухайн зөрчилд хариуцлага тооцсон хуулийн зүйл, хэсэг, заалт хүчингүй болсон” гэдэг нь нийгмийн шаардлага, төрийн бодлоготой холбогдуулан тухайн цаг хугацаанд дагаж мөрдөгдөж байсан хууль хүчингүй болж, шинээр хүчин төгөлдөр хууль мөрдөгдөж эхлэхэд урьд өмнө дагаж мөрдөгдөж байсан хуулийн зүйл, хэсэг, заалт хүчингүй болсон байхыг ойлгоно.

“Зөрчил үйлдсэн хүн нас барсан” гэдэг нь тухайн зөрчилд хариуцлага хүлээх чадвар бүхий этгээд нь нас барсан тухай факт, баримт материал байгаа тухай ойлголт юм. Харин нас барсан хүнийг цагаатгах, эсхүл бусад хүмүүст холбогдох нөхцөл байдал шинээр илэрснээс уг хэргийг сэргээн хэлэлцэх явдал үүнд хамаарахгүй.

“Тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтны, эсхүл шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр бол” гэдэгт тухайн зөрчлийн хэргийг урьд нь хэрэгсэхгүй болгосон шүүхийн тогтоол, магадлал хүчинтэй байгаа, эсхүл урьд өмнө нь зөрчлийн хэрэг нээн шалгасан тогтоол, шүүхийн тогтоол, магадлалаар зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон бөгөөд уг шийдвэр хүчин төгөлдөр байгаа явдлыг хамааруулан ойлгоно.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулах хугацаа

Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулж нотлох баримт цуглуулах шаардлагатай гэж үзвэл хэргийн хугацаа дуусахаас 3 хоногийн өмнө зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан

тушаалтанд танилцуулж, хугацааг сунгуулна.

Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан нь эрх бүхий албан тушаалтнаас зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах үндсэн хугацаанд ямар ажиллагаанууд хийж гүйцэтгэсэн, хугацаа сунгуулах болсон үндэслэл, цаашид хийж гүйцэтгэх ажиллагааны талаар асууж тодруулан, хэргийн материалтай биечлэн танилцсаны үндсэн дээр хугацаа сунгах эсэх асуудлыг шийдвэрлэнэ. Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан нь зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах хугацааг сунгах үндэслэлтэй гэж үзвэл тогтоол үйлдэнэ. Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах хугацааг сунгахдаа зөрчлийн хэрэгт хийгдэх ажиллагаанаас хамаарч хэсэгчлэн, эсхүл бүтнээр нь тогтоож болно. Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах хугацааг сунгах тухай тогтоолд эрх бүхий албан тушаалтны нэр, зөрчлийн холбогдогчийн нэр, зөрчлийн утга, зөрчлийн хэрэг бүртгэлтийн үндсэн хугацаанд хийсэн ажил, тогтоогдсон нөхцөл байдал, хугацаа сунгах үндэслэл, цаашид хийх ажиллагааг тодорхой тусгана. Эрх бүхий албан тушаалтан, прокурор нь зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах хугацааг сунгасан талаарх мэдээллийг прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлнэ.

Зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах журам

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн Дөрөвдүгээр бүлэгт зөрчил шалгах тодорхой ажиллагаанууд, тэдгээрийг явуулах журам, прокурорын зөвшөөрөлтэй явуулах болон эрх бүхий албан тушаалтан бие даан явуулах ажиллагаа, зөрчил шалгах тодорхой ажиллагааны тэмдэглэл үйлдэх журам, зөрчлийн нотлох баримт, түүний эх сурвалж, зөрчлийг нотлох ажиллагааны журмыг тус тус шинээр зохицуулж өгсөн. Энэ нь өөр өөр хууль болон салбар байгууллагын журам, заавраар харилцан адилгүй явуулж байсан зөрчил шалгах ажиллагааг хуульд заасан нэг стандарт, журмаар явуулах нөхцлийг бүрдүүлсэн. Мөн хуульд зөрчил шалгах ажиллагаа нэг бүрийн журмыг нарийвчлан зааж өгсөн. Хуулийн нарийвчилсан зохицуулалт нь эрх бүхий албан тушаалтны зүгээс дур мэдэн ажиллагаа явуулж, хүний эрхийг зөрчих боломжийг хязгаарлах, улмаар зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагаанд хүний эрх, эрх чөлөө баталгаатай хангагдах давуу талтай.

Зөрчил шалгах ажиллагаа

1. Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасны дагуу зөрчил шалгах ажиллагаа явуулж, нотлох баримт цуглуулж, бэхжүүлнэ.
2. Зөрчил шалгах ажиллагаа нь зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийх, баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд зүйл, баримт бичгийг хураан авах, эд хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах, шинжилгээ хийлгэх

ажиллагаанаас бүрдэнэ.

3. Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд прокурорын зөвшөөрлөөр явуулахаар зааснаас бусад ажиллагааг явуулах шийдвэрийг бие даан гаргана.
4. Зөрчил шалгах ажиллагааны явцад гэмт хэргийн шинж тогтоогдвол эрх бүхий албан тушаалтан даруй прокурорт мэдэгдэж, холбогдох баримтыг хүргүүлнэ.
5. Энэ бүлэгт заасан зөрчил шалгах ажиллагааны тэмдэглэл, шийдвэрийн маягтыг Улсын ерөнхий прокурор батална.

Захиргааны хариуцлагын тухай хуулийн “Нийтлэг үндэслэл” гэсэн 1 дүгээр бүлгийн 11, 12, 14, 15, 17 дугаар зүйлд заасан зөрчил шалгах тодорхой ажиллагаа болон бусад салбарын хуулиудад заасан зөрчил шалгахтай холбоотой тодорхой ажиллагаануудыг шинээр батлагдсан Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд “Зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах журам” гэсэн 4 дүгээр бүлэгт нэгтгэн, уг ажиллагааг явуулах үндэслэл, журмыг хуульчилж өгчээ. Үүнд:

1. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 6.8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт тус тус салгаж, агуулгыг нь өөрчлөн, дэлгэрэнгүй байдлаар тусгаж өгсөн. Тухайлбал: Зөрчил шалгах тодорхой ажиллагааны төрлийг нэмэгдүүлсэн. Үүнд баримт бичиг, мэдээлэл гаргуулан авах, эд хөрөнгө битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах, мэдүүлэг авах, шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах гэх мэт.
2. Захиргааны хариуцлагын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 3 дахь заалтыг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг буюу “...прокурорт мэдэгдэж, холбогдох баримтыг хүргүүлнэ.” гэж агуулгын хувьд өөрчилсөн.
3. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтэд хяналт тавих бүрэн эрх нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор мөн хуулийн 4.1 дүгээр зүйлийн 3, 5 дахь хэсгийг шинээр нэмж зохицуулсан.
4. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн удирдах ажилтны бүрэн эрх, гүйцэтгэх үүргийг анх удаа тодорхой хуульчилж өгсөн. /Хуулийн 2.3, 2.4 дүгээр зүйл/. Үүний нэг жишээ нь Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт “Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд прокурорын зөвшөөрлөөр явуулахаар зааснаас бусад ажиллагааг явуулах шийдвэрийг бие даан гаргана.” гэж заасан явдал юм.

Зөрчил шалгах ажиллагаа	
Эрх бүхий албан тушаалтан бие даан шийдвэрлэх	Прокурорын зөвшөөрлөөр хэрэгжүүлэх
1	Бусдын орон байрнаас бусад газар болон хүний бие, эд зүйлд үзлэг хийх
2	Байгууллага, хувь хүний нууцтай холбоотойгоос бусад мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авах
3	-
4	Хүнд холбогдуулан хийхээс бусад шинжилгээ хийх
	Хүнд холбогдуулан шинжилгээ хийлгэх зэрэг ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр хэрэгжүүлэхээр заасан.
5	Эд зүйл, баримт бичиг хураан авах
6	Эд хөрөнгө битүүмжлэх
7	Мэдүүлэг авах
8	Шинжилгээнд зориулж хэв загвар, дээж авах
9	Зөрчлийн тухай хуульд баривчлах шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчлийг шалгахад дараахь ажиллагааг явуулж болно: <ul style="list-style-type: none"> • хэргийн газрын үзлэг; • таньж олуулах; • туршилт хийх; • нүүрэлдүүлж мэдүүлэг авах; • ердийн ажиглалт явуулах; • мэдүүлгийг газар дээр нь шалгах.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцдаа гэмт хэргийн шинжийг илрүүлсэн бол прокурорт даруй мэдэгдэнэ.”, 2.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт “Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцдаа гэмт хэргийн шинжийг илрүүлсэн бол прокурорт даруй мэдэгдэнэ.”, 4.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт “Зөрчил шалгах ажиллагааны явцад гэмт хэргийн шинж тогтоогдвол эрх бүхий албан тушаалтан даруй прокурорт мэдэгдэж, холбогдох баримтыг хүргүүлнэ.”, 6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Зөрчлийн талаархи гомдол, мэдээлэл тухайн байгууллагын харьяаллын биш болох нь тогтоогдвол зөрчлийн хэрэг бүртгэлтийг удирдах албан тушаалтан ажлын 3 өдрийн дотор харьяаллын дагуу шилжүүлж, прокурорын нэгдсэн бүртгэлд даруй бүртгүүлнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг хянан шалгах явцад гэмт

хэргийн шинжтэй болохыг тогтоовол холбогдох баримтыг харьяаллын дагуу шалгуулахаар прокурорт даруй шилжүүлнэ.”, 6.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн тохиолдолд хэрэг бүртгэлтийн хугацааг үргэлжлүүлэн тоолно.” гэж тус тус заажээ. Дээрх заалтуудын агуулгаас үзэхэд эрх бүхий албан тушаалтан зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон зөрчлийн хэрэг гэмт хэргийн шинжтэй болох нь тогтоогдвол харьяаллын дагуу шилжүүлэх шийдвэр гаргахаар байна. Иймд эрх бүхий албан тушаалтан харьяаллын дагуу шилжүүлэх шийдвэрээ танилцуулж, шийдвэрлүүлж байх нь зүйтэй. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх тухай шийдвэрт үндэслэлийг тодорхой дурдаж өгвөл зохино. Прокурор нь эрх бүхий албан тушаалтны шийдвэр, холбогдох хэрэг, материалыг даруй хянаж, хууль зүйн үндэслэлтэй гэж үзвэл тогтоолыг батлан, гарын үсэг зурж, зөрчил шалгах эрх бүхий байгууллагад буцаан хүргүүлнэ. Прокурор зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлэх үндэслэлгүй гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд албан бичгээр буцаан хүргүүлж болно.

Эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл болон зөрчлийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлсэн тухай оролцогч нарт даруй мэдэгдэж, гомдол гаргах эрхийг нь хангаж ажиллах шаардлагатай.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.1 дүгээр зүйлийн 5 дахь хэсэгт заасан “Зөрчил шалгах ажиллагааны тэмдэглэл, шийдвэрийн маягт”-ыг Улсын Ерөнхий прокурорын тушаалаар баталж гаргах ба энэ нь эрх бүхий албан тушаалтнууд улсын хэмжээнд нэгдсэн нэг загвараар үйлдэж байх нөхцөлийг бүрдүүлэх юм.



Прокуророос зөвшөөрөл авах ажиллагаа

1. Эрх бүхий албан тушаалтан энэ хуульд заасан прокурорын зөвшөөрлөөр явуулах ажиллагааны саналыг 24 цагийн дотор прокурорт хүргүүлнэ.
2. Эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 4.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 4.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 4.7 дугаар зүйл, 4.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажиллагаа явуулах зөвшөөрлийг прокуророос авахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.2, 22.3 дугаар зүйлд заасан журмыг баримтална.
3. Хойшлуулшгүй тохиолдолд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулсан бол хүчинтэйд тооцох эсэхийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.4 дүгээр зүйлд заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

Прокурорын зөвшөөрөл авах асуудлыг Захиргааны хариуцлагын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, *Прокурорын байгууллагын тухай хуулийн /2002 он/ 11 дүгээр зүйлийн 11.2, 11.6 дахь хэсгээр тус тус зохицуулж байсан боловч хүний эрхийг хөндсөн* ажиллагаануудыг нэг бүрчлэн, тодорхой зааж өгсөн зохицуулалт байгаагүй. Өөрөөр хэлбэл, Захиргааны хариуцлагын тухай хуульд зөвхөн хилийн дэглэм зөрчигчийн хувийн байдлыг тогтоох зорилгоор прокурорын зөвшөөрлөөр түүнийг 10 хоног хүртэл хугацаагаар саатуулах зохицуулалт байсан. Харин прокурорын байгууллагын тухай хуульд ерөнхий байдлаар буюу хуульд тусгайлан заасан тохиолдолд зөвшөөрөл өгөх прокурорын бүрэн эрхийг тусгаж өгсөн байсан. Гэвч яг ямар тодорхой ажиллагаа явуулахад Прокурор зөвшөөрөл өгөх талаар нарийвчлан зааж өгөөгүйгээс прокурор энэ бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан ба хуулийн энэ заалт амьдралд төдийлөн хэрэгждэггүй байсан.

Харин Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулиар

1. Бусдын орон байранд үзлэг хийх;
2. Байгууллага, хувь хүний нууцтай холбоотой мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс гаргуулан авах;
3. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах;
4. Хүнд холбогдуулан шинжилгээ хийлгэх зэрэг ажиллагааг прокурорын зөвшөөрлөөр хэрэгжүүлэхээр заасан.

Эрх бүхий албан тушаалтан нь дээр дурьдсан зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах зөвшөөрлийг прокуророос авахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухайн хуулийн 22.2, 22.3 дугаар зүйлд заасан журмыг баримтлахаар хуульд заасан. Эрх бүхий албан тушаалтан нь дээр дурьдсан ажиллагааг явуулах бол тухайн ажиллагааг явуулж эхлэхээс 24 цагийн өмнө зөвшөөрөл хүсэх саналыг бичгээр үйлдэж, прокурорт

хүргүүлнэ. Саналд дараахь зүйлийг тусгасан байна: Үүнд:

- а) Санал гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр;
- б) Ажиллагааны төрөл;
- в) Ажиллагаа явуулах зорилго, үндэслэл;
- г) Ажиллагаанд хамраглах хүн, хуулийн этгээд, байгууллага, объект;
- д) Ажиллагаа явуулах газар, нэвтрэх, дамжин орох орон байрны хаяг, эзэмшил газрын байршил;
- е) Ажиллагаа явуулах хугацаа;
- ё) Ажиллагааг шөнийн цагаар явуулах бол энэ тухай үндэслэл бүхий тайлбар;

Прокурор нь эрх бүхий албан тушаалтны саналыг хүлээн авч, зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэхдээ тухайн ажиллагааг явуулах үндэслэл, шаардлага байгаа эсэхийг сайтар хянан, зөрчил шалгах ажиллагаанд оролцогчдын хууль ёсны эрх, ашиг сонирхлыг зөрчихгүй байхыг анхаарч, зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэрийг гаргана.

Зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох прокурорын шийдвэрт дараахь зүйлийг тусгасан байна. Үүнд:

- а) Ажиллагааны нэр;
- б) Ажиллагааны зорилго;
- в) Ажиллагаа явуулах байгууллага, албан тушаалтан;
- г) Ажиллагаа явуулах газар, нэвтрэх, дамжин орох орон байрны хаяг, эзэмшил газрын байршил;
- д) Ажиллагаанд хамрагдах хүн, хуулийн этгээд, байгууллага, объект;
- е) Ажиллагаа явуулах хугацаа;
- ё) Ажиллагааны явцад хүний эрхийг хангах арга хэмжээ;
- ж) Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа;
- з) Зөвшөөрөл олгосон прокурорын нэр, он, сар, өдөр;

Прокурорын зөвшөөрөлд тухайн ажиллагааг шөнийн цагаар явуулж болох эсэх, олон нийтийн хөдөлгөөнийг хязгаарлах эсэх, зөвшөөрлийн хувийг гардуулж өгөх тухай тусгаж болно. Хэрэв прокурорын зөвшөөрлөөр явуулах зөрчил шалгах ажиллагааг явуулах газар, байршил, үргэлжлэх хугацаа өөрчлөгдвөл эрх бүхий албан тушаалтан нь хойшлуулшгүй тохиолдлоос бусад үед зөвшөөрөл олгосон прокурорт урьдчилан мэдэгдэнэ. Эрх бүхий албан тушаалтны саналд заасан зөрчил шалгах ажиллагааг явуулах үндэслэлгүй гэж үзвэл прокурор саналыг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргана.

Эрх бүхий албан тушаалтан хойшлуулшгүй тохиолдолд Зөрчил шалган

шийдвэрлэх тухай хуулийн 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажиллагаануудыг прокурорын зөвшөөрөлгүй явуулж болно. Хойшлуулшгүй тохиолдол гэдгийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1.26-д зааснаар /хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгаа/ ойлгож хэрэгжүүлнэ. Эрх бүхий албан тушаалтан нь уг хойшлуулшгүй ажиллагааг явуулахаас өмнө прокурорт даруй мэдэгдэж, ажиллагаа дууссанаас хойш 24 цагийн дотор тухайн ажиллагааг хүчинтэйд тооцуулахаар зөвшөөрөлгүй явуулах болсон үндэслэлийг нотлох баримт, тайлбарыг бичгээр прокурорт хүргүүлнэ.

Прокурор нь эрх бүхий албан тушаалтны ирүүлсэн баримт, тайлбарыг хүлээн авсан даруйд зөрчил шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг шийдвэрлэнэ. Прокурор зөрчил шалгах ажиллагааг даруй хийхгүй бол нотлох баримт гэмтэх, устах, зөөвөрлөх, нуун далдлах бодит эрсдэл байсан эсэхийг хянан шийдвэрлэхийн тулд тухайн зөрчил шалгах ажиллагаанд оролцсон хүнийг дуудаж мэдүүлэг авч, шаардлагатай нэмэлт материалыг эрх бүхий албан тушаалтнаас гаргуулан авч болно.

Прокурор нь эрх бүхий албан тушаалтнаас ирүүлсэн нотлох баримт, тайлбартай танилцсаны дараа дараахь шийдвэрийн аль нэгийг гаргана. Үүнд:

- а) Зөрчил шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох;
- б) Зөрчил шалгах ажиллагаа, нотлох баримтыг хүчингүй болгох;

Харин прокурор зөвшөөрөл олгоогүй нь шинэ үндэслэл бий болж, тухайн зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах санал гаргахад хамаарахгүй гэдгийг анхаарах нь зүйтэй.

2.2 Зөрчил шалгах тодорхой ажиллагаа

Мэдүүлэг авах

Эрх бүхий ч албан тушаалтнаас зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий мэдээллийг хүмүүсийн харилцаанд хэрэглэдэг аргын тусламжтайгаар цуглуулан авч байгааг мэдүүлэг авах гэнэ. Хүмүүсээс мэдүүлэг авах арга нь нотлох баримт цуглуулах хамгийн энгийн, эртнээс нааш хэрэглэж ирсэн нийтлэг бөгөөд түгээмэл арга юм. Мэдүүлэг авах ажиллагаагаар зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий ямар ч мэдээллийг авч болдог. Эрх бүхий албан тушаалтан хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл өгөх чадвартай хүнээс шаардлагатай мэдээллийг аман буюу бичгэн хэлбэрээр түүнчлэн дохио зангаагаар гарган авна: Мэдүүлэг өгч байгаа хүн нь өөрийн төрөлх, буюу сайн мэдэх хэл дээр мэдүүлэг өгөх

эрхтэй. Энэ тохиолдолд хэлмэрч, орчуулагчийг оролцуулдаг.

Байцаалт явуулахдаа тухайн хүн ямар нэг байдлаар ярих боломжгүй байгаа тохиолдолд бичгээр мэдүүлэг, асуулт, хариулт өгөх боломжтой. Зарим тохиолдолд мэдээллийг зурган хэлбэрээр гарган өгч болно. Мэдүүлэг авах ажиллагааг 3 цагаас илүүгүй хугацаагаар тасралтгүй явуулах ба түүнээс илүү цагаар явуулах бол 1 цагийн завсарлага олгох ба өдөрт байцаалтыг 6 цагаас хэтрүүлж болохгүй. Насанд хүрээгүй хүнийг байцаахдаа нэг удаа нэг цаг, өдөрт 2 цагаас хэтрүүлж болохгүй ба нэг цагаас илүү мэдүүлэг авах тохиолдолд 30 минутаар завсарлана. Хугацааг тоолохдоо мэдүүлэг өгөх хүнээс биеийн баяйцаалт явж, эрх үүргийг танилцуулснаас эхлэн хугацааг тоолно. Хугацаа мэдүүлэг өгсөн эсэхээс үл хамааран тоологдоно. Тухайлбал: эрх бүхий албан тушаалтан асуухгүй удах, мэдүүлэг өгөгч мэдүүлэхгүй удах гэх мэт.

Мэдүүлэг авахын мэдүүлэг өгөгч хүнийг ямар оролцогчоор оролцох, ямар эрх, үүрэг эдлэх, түүнчлэн ямар асуудлаар мэдээлэл авах гэж байгаа талаар урьдчилан мэдэгдэнэ. Гэрч, хохирогчид худал мэдүүлэх, мэдүүлэг өгөхөөс санаатай зайлсхийсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх учрыг тайлбарлана. Доор дурдсанаас бусад тохиолдолд мэдүүлгийг шөнийн цагаар авахыг хориглоно. Үүнд:

1. Шөнийн цагаар явагдаж байгаа үйлдвэрлэл, ажил, үйлчилгээний газарт гарсан зөрчлийг газар дээр нь шийдвэрлэх бол;
2. Олон нийтийн аюулгүй байдал, хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд аюул учирч болох нөхцөл байдал үүссэн, эсхүл үүсч болзошгүй бол;
3. Зөрчлийн ул мөр устах, холбогдогч оргон зайлж болзошгүй;
4. Гудамж, талбай, олон нийтийн газарт шөнийн цагаар үйлдэгдсэн зөрчлийг хялбаршуулсан журмаар газар дээр нь шалган шийдвэрлэх бол;

Мэдүүлэг өгч байгаа хүмүүсийг тус тусад нь дангаар байцаана. Мэдүүлэг өгөгч гэрч, хохирогчоос холбогдогчтой садан төрлийн ямар холбоотой болохыг асууж хэрэв садан төрөл бол тэдгээрийн эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхтэйг тусгайлан тайлбарлан өгч бичгээр баталгаажуулдаг. Хэрэв мэдүүлэг өгөхийг зөвшөөрсөн бол үнэн зөв мэдүүлэх үүрэгтэйг тайлбарлана. Шаардлагатай гэж үзвэл хөндлөнгийн гэрч байлцуулж болох ба бусад оролцогчдыг оролцуулж байгаа тохиолдолд мэдүүлэг өгөгчид урьдчилан мэдэгдэж тухайн оролцогчдод эрх, үүргийг нь тайлбарлан өгнө.

Мэдүүлэг өгөгч этгээдийг хөтөлж байцааж болохгүй. Өөрөөр хэлбэл, таны харсан машин хар өнгийн машин байсан уу? Та түүнийг буруутай гэж үзэж байна уу? гэх мэт.

Зарим тохиолдолд мэдүүлэг өгч байгаа этгээдэд урд өгсөн мэдүүлгийг

уншуулах буюу бусад зүйлийг үзүүлж болно. Мэдүүлэг өгөгч сандарч тэвдэн, баримжаагаа алдахад хүрвэл аль болох тайвшруулах нь нотолгооны ач холбогдлыг алдагдуулахгүй байхад тустай. Эрх бүхий албан тушаалтны буруутай үйл ажиллагааны улмаас тухайлбал, мэдүүлэг өгч байгаа хүнтэй хатуу ширүүн, догшин, дээрэнгүй, бүдүүлэг харьцах, зохимжгүй асуулт тавих, удаан хугацаагаар хүлээлгэх, үл тоосон байдал гаргаснаас үнэн зөв мэдээлэл олж авах боломжийг алдагдуулдаг. Хүн, нөхцөл байдлыг илэрхийлэн гаргахын зэрэгцээ тухайн байдлыг үнэхээр үнэмшилтэй, зүй тогтолын логик уялдаа холбоог гарган тайлбарлаж байгаа нь нотолгооны ач холбогдолыг ихэсгэх, нотлох баримтыг үнэлж хэрэглэхэд ач холбогдолтой.

Үзлэг

Нотлох баримт цуглуулах үзлэгийн арга эртнээс хэрэглэж ирсэн уламжлалт аргын нэг юм. Үзлэгийг хэрхэн явуулснаас шалтгаалан зөрчлийг хурдан шуурхай шалгах, зөрчил гарсан эсэхийг нотлох гол баримтууд олдох боломжтой. Тиймээс үзлэгийг түргэн шуурхай, чанартай явуулах ёстой.

Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгдсэн байдал, зөрчлийн ул мөр, эд мөрийн баримтыг олох, зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий байдлыг тодруулах зорилгоор зөрчил үйлдэгдсэн газар буюу бусад газар, эд зүйл, баримт бичиг, хүний биед үзлэгийг явуулдаг.

Үзлэгийн үндсэн зорилт:

1. Зөрчил үйлдэгдсэн эсэх, хэрэв зөрчил үйлдэгдсэн бол хэн ямар зорилгоор, ямар аргаар, ямар нөхцөл байдлын дунд энэ зөрчлийг үйлдсэн байж болох вэ? гэдэг асуултыг бүрэн тайлбарлах,
2. Зөрчил үйлдэхэд оролцогчдын тухай ба хэрэг явдлын жинхэнэ бодит байдлын тухай сэжиглэлийг дэвшүүлэх,
3. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хөрөнгө, орлогыг эрж олох,
4. Зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдлыг тогтоох,
5. Эд мөрийн баримт болон бичиг баримтад байгаа мэдээллийг гарган авах гэх мэт.

Үзлэгээр хийхдээ дараахь зүйлийг удирдлага болгоно. Үүнд:

Юуны түрүүнд үзлэгийн тактикийг маш сайн боловсруулсан байх ёстой.

1. Үзлэгийн зорилтыг тодорхойлох шаардлагатай. Тухайлбал: Үйлдвэр дээр хөдөлмөр хамгааллын журам зөрчсөний ямар үр дагавар үүссэн эсэх,
2. Үзлэг хийхийн өмнө тухайн объектод хамгийн түрүүнд хэн орсон, юу юу хөдөлгөсөн гэдгийг тогтоосон байна.
3. Хөндлөнгийн 2-оос доошгүй гэрчтэй байна. Хөндлөнгийн гэрч оролцох боломжгүй бол дуу-дүрсний бичлэг ашиглана.

4. Үзлэгээр зөвхөн аливаа зүйлийн гадаад шинж чанарыг илэрхийлнэ. Дотоод мөн чанарыг танин мэдэх нь шинжээчийн үүрэг байдаг
5. Үзлэгээр илэрсэн бүх баримтыг хөндлөнгийн гэрчид заавал үзүүлэх буюу дуу-дүрсний бичлэг хийж байгаа бол тусгайлан бичлэгт харагдахуйц байрлалаар бичнэ.
6. Үзлэгийн явцад хөндлөнгийн гэрч болон бусад оролцогчид эрх бүхий албан тушаалтын зөвшөөрөлгүй аливаа зүйлд гар хүрч болохгүй. Энэ нь тухайн үйл ажиллагааны нотолгооны ач холбогдлыг алдагдуулах буюу бууруулж болно.
7. Хойшлуулж болохгүй тохиолдолд шөнийн цагаар явуулж болно.
8. Үзлэгийн явцад нотлох баримтыг хураан авах ажиллагаа явуулж болно.
9. Үзлэгийн явцад техник хэрэгсэл ашиглаж болно.
10. Үзлэгийг эрх бүхий албан тушаалтан удирдан явуулна. Зарим тохиолдолд тусгай мэргэжлийн хүн удирдан явуулж болно. Тухайлбал, тарвага агнасан байх нөхцөл байдал тогтоогдвол халдвар өвчин судлалын мэргэжилтэн үзлэгийг явуулж болно.
11. Үзлэгээр цугларсан эд мөрийн баримт, ул мөр болон үр дүн нь нотлох баримт болно.

Үзлэг хийхдээ тухайн байгууллага, эд зүйлийн сайн мэдэх хүнийг мэргэжилтнээр оролцуулна. Харин эрх бүхий албан тушаалтан тухайн зүйлийн талаар тодорхой хэмжээний мэдлэгтэй, эсхүл үзлэгийн явцад тусгай мэргэжил шаардахгүйгээр биет зүйлүүдийн болон бусад юмсын гадаад онцлог шинжийг мэдэж болно. Илэрсэн нотлох баримтын дотоод мөн чанарыг мэдэх аливаа оролдлого нь нотолгооны ач холбогдлыг шууд бууруулна.

Үзлэгийн явцад нотлох баримтыг хамгаалахад анхаарах асуудал

Шаардлагатай нутаг дэвсгэр болон бусад эд зүйлд аль болох түргэн шуурхай цаг алдалгүй яаралтай үзлэг хийх нь зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий ул мөрийг илрүүлж, буруутай хүн, хуулийн этгээдэд хариуцлага тооцоход чухал ач холбогдолтой. Үзлэг хийж буй орчинг дахин сэргээх боломж хязгаарлагдмал тул үзлэгийг маш нягт нямбай хийх хэрэгтэй. Зөрчил үйлдэгдсэн газрыг хамгаалах ажиллагаа нь тухайн газар очсон эрх бүхий албан тушаалтан очсоноос эхэлнэ. Тэд хамгаалалт аваад дотогш ямар ч хүн оруулах, гаргах бололцоогүй болгодог. Өөрсдөө ч тийшээ орж болохгүй. Мөн хэргийн газарт байсан, орж гарсан хүмүүсийг тэнд байлгаж байдаг. Хэргийн газрыг хэсэг, хэсгээр нь хуваан үзлэг хийж болно. Цаг агаар, нутаг орны онцлогоос хамаарч эд мөрийн баримт устахаар бол түүнийг маш шуурхай хамгаалах хэрэгтэй. Мөн хэргийн газрын ул мөрүүдийг хамгаалан дээгүүр нь бүтээх, хаалт тавих, бэхлэн

хамгаалах материалуудыг энгийн мод, төмөр, хулдаас, гялгар уутаар хамгаалж болно.

Үзлэгийн явцад гэмт зөрчил гаргагч зугатаах буюу эрж олох гэж байгаа зүйлийг бусдад дамжуулах, хаях, устгах зэрэг үйлдлүүдээс урьдчилан сэргийлэхийн тулд нотлох баримтын эх сурвалжийг хамгаалах асуудал чухлаар тавигдана. Үзлэг эхэлсэн үеэс үзлэг хийж байгаа газар нутаг орон байрнаас хүн гарч явах болон зөвшөөрөлгүй дотуур нь явах, зарим тохиолдолд юм ярих үйлдлийг хүртэл хязгаарлах нь нотлох баримт цуглуулах ажиллагааг түргэн шуурхай явуулах, нотлох баримтыг устахаас урьдчилан сэргийлж байгаа хэлбэр юм.

Үзлэгийн явцад техник хэрэгсэл ашиглах нь

Үзлэгийн явцад зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтуудыг ихэвчлэн нууж далдалсан байдаг учир түүнийг эрж хайхад хүний мэдрэхүйн эрхтэний хүчин чадал мөхөсдөх тохиолдолд гардаг. Тиймээс төрөл бүрийн металл болон бусад бодисыг эрж хайх хүчин чадал бүхий техник, хэрэгслийг ашиглах шаардлагатай. Эдгээрийг тусгай мэргэжилтний тусламжтайгаар ажиллуулдаг. Түүнчлэн үзлэг нэгжлэг хийж байгаа зүйлийн гадаад, дотоод мөн чанарыг сайн мэдэх хүмүүсийг мэргэжилтнээр оролцуулах тухайн ажиллагаагаар цуглуулсан мэдээллийн нотолгооны ач холбогдлыг ихэсгэдэг. Үзлэгийн явцад хөндлөнгийн гэрчийг оролцуулах боломжгүй байгаа тохиолдолд явц, үр дүнг техник, хэрэгсэл ашиглан бэхжүүлнэ. Техник хэрэгсэл хэрэглэж үзлэг, нэгжлэгийн явц үр дүнг бэхжүүлэхдээ түүнийг ашиглах чадвар бүхий хүний туслалцааг авах нь нотолгооны ач холбогдлыг бууруулахгүй байхад ихээхэн чухал юм.

Эд зүйл хураан авах

Зөрчил шалган шийдвэрлэхэд ач холбогдолтой эд зүйл, баримт бичиг байна гэх хангалттай үндэслэл байвал түүнийг эзэмшигчээс нь прокурорын зөвшөөрлөөр хураан авна. Эд зүйлийг хураан авч байгаа хэлбэрээс шалтгаалан эрх бүхий албан тушаалтын

- Идэвхтэй үйл ажиллагаагаар нотлох баримтыг хураан авах,
- Бусад оролцогчдын идэвхтэй үйл ажиллагаагаар нотлох баримтыг олж, цуглуулан хураах гэсэн үндсэн хоёр төрөлтэй.

Түүнчлэн эрх бүхий албан тушаалтан үзлэг хийж байх явцад ач холбогдол бүхий биет нотлох баримт илэрч олдвол түүнийг эд мөрийн баримтаар хураан авдаг. Гэрч, хохирогч, холбогдогч нар өөрсдийн сайн дураараа эсхүл өөрсдийн идэвхтэй хууль ёсны үйл ажиллагааны үр дүнд олдсон хэрэгт ач холбогдол бүхий эд мөрийн баримтыг эрх бүхий албан тушаалтанд гаргаж өгдөг. Эрх бүхий албан тушаалтан эд зүйл хураан авах ажиллагаа явуулж байгаа тохиолдолд дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Эд зүйл хураан авах ажиллагаа явуулах үндэслэлийг нотолсон байна.
2. Хөндлөнгийн 2-оос доошгүй гэрч оролцуулсан байна. Түүнчлэн бусад хүмүүс оролцож болох бөгөөд эрх үүргийг нь тайлбарлан өгсөн байна. Тэд тухайн ажиллагааны дэг журмыг сахих үүрэгтэй.
3. Эд зүйл хураан авах шийдвэрийг эд зүйл хураалгаж байгаа хүнд танилцуулсан байна. Танилцуулах явцад тухайн этгээд сонсохыг хүсэхгүй байгаа нь энэ ажиллагаанд нөлөөлөхгүй.
4. Улсын нууц агуулсан баримт, бичиг, эд зүйлийг хураан авахдаа тухайн байгууллагын удирдлага мэдэгдсэний үндсэн дээр хураан авах бөгөөд хөндлөнгийн гэрчүүд улсын нууцтай харьцах эрх бүхий хүмүүс байвал зохино.
5. Хураан авах ажиллагаагаар нотлох баримтыг цуглуулах явцад саад учруулбал албадан авна.

2.3 Тэмдэглэл үйлдэх ажиллагаа

Тэмдэглэл үйлдэх ажиллагаа гэдэг нь Зөрчил эрх бүхий албан тушаалтан дангаараа буюу бусдын тусламжтайгаар цугларсан нотлох баримтуудыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөрчлийн хэрэгт буулган авах идэвхтэй ажиллагааг хэлнэ.

Зөрчил шалган шийдвэрлэх тодорхой ажиллагааны явц, дэс дараалал, илэрсэн нөхцөл байдал, авсан арга хэмжээ, үр дүнгийн талаарх тэмдэглэлийг хэрхэн үйлдэх, мөн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцыг дуу-дүрсний бичлэгээр хэрхэн бэхжүүлэхийг агуулгын хувьд өөрчлөн, илүү дэлгэрэнгүй, нарийвчлан зохицуулж өгсөн байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тэмдэглэл үйлдэх нийтлэг журмыг дэлгэрэнгүй тусгасан. Гэвч зөрчил шалгах тодорхой ажиллагаа бүрийн онцлогоос хамаарч, тэмдэглэлд юуг тусгах вэ гэдэгт анхаарал хандуулах ёстой.

Нотлох баримтыг дараахь аргаар бэхжүүлнэ.

1. Тэмдэглэл хөтлөх;
2. Бичлэг хийх (дуу, дүрс), гэрэл зураг авах;
3. Зурж, тэмдэглэх; (тодорхой эд зүйл болон байгаль орчинг байгаа байдлаар нь буюу тоймлон харж зурах)
4. Схем, төлөвлөгөө үйлдэх; (тухайн зүйлийг тодорхой дүрс тэмдэгтээр орлуулан зурж тэмдэглэх)
5. График, шугам зураг үйлдэх; (нотлох баримтыг техникийн маш нарийн үзүүлэлтээр нь зурж тэмдэглэх)
6. Эд зүйлийг бүхлээр бэхжүүлж авах; (нотлох баримтыг байгаа байдлаар нь тухайлбал: унадаг дугуйг тэр хэвээр нь хураан авч бэхжүүлэх)

7. Тодорхой эд зүйлийн хэсэг буюу ул мөрийн буулгаж авах; (тухайн эд ангийн тодорхой нэг хэсгийг нь авах, тухайлбал: ачааны машины дугуйг салган авах)

8. Харьцуулан шинжлэхээр хэв загвар авах гэсэн нийтлэг аргууд байна. Эдгээрээс тэмдэглэл (тэмдэглэл) хөтлөх, дүрс, дууны бичлэг хийх, хэв загвар авах, схем төлөвлөгөө хийх зэрэг аргууд нь илүү өргөн хэрэглэгддэг. Дээрх бүх ажиллагаанууд нь тэмдэглэлд тусгагдах замаар давхар баталгааждаг.

Хоёр үндсэн аргаар тэмдэглэл хөтөлдөг.

- Практик хамгийн өргөн хэрэглэгддэг нь хэвлэмэл маягыг /бланк/ бөглөж тэмдэглэл хөтлөх,
- Хэвлэмэл маяггүй гараараа болон компьютер ашиглан тэмдэглэл үйлдэх

Тэмдэглэлүүд:

- *Мэдүүлгийн тэмдэглэл:*

Гэрчийн мэдүүлгийн тэмдэглэл;

Хохирогчийн мэдүүлгийн тэмдэглэл;

Холбогдогчийн мэдүүлгийн тэмдэглэл;

Шинжээчийн мэдүүлгийн тэмдэглэл;

Насанд хүрээгүй гэрч, хохирогчийн мэдүүлгийн тэмдэглэл;

Өсвөр насны холбогдогчийн мэдүүлгийн тэмдэглэл;

- *Үзлэгийн тэмдэглэл:*

Зөрчлийн газар болон бусад газарт үзлэг хийсэн тэмдэглэл;

Хүний биед үзлэг хийсэн тэмдэглэл;

Хүүрэнд үзлэг хийсэн тэмдэглэл;

Эд мөрийн баримтанд үзлэг хийсэн тэмдэглэл;

Баримт бичгэнд үзлэг хийсэн тэмдэглэл;

Амьтанд үзлэг хийсэн тэмдэглэл;

- *Эд зүйл хураан авсан тэмдэглэл:*

Эд зүйл хураан авсан тэмдэглэл;

Шуудан цахилгаанаар явуулсан зүйлийг хураан авах тэмдэглэл;

Бичиг баримт хураан авсан тэмдэглэл;

Зөрчил шалгах ажиллагааны явцыг бэхжүүлэхдээ дараахь журмыг баримтална. Үүнд:

1. Нотлох баримт цуглуулах талаар явуулж байгаа ЭХХША-ны үйл явцыг нарийвчлан, дэс дараалан, нэг бүрчлэн бичнэ.

2. Тухайн ажиллагааг хэд дэх удаагаа явуулж байгааг тэмдэглэлд тусгана.
3. Нотлох баримт цуглуулж, бэхжүүлж байгаа албан тушаалтан, оролцогч этгээдүүдийн нэр, шаардлагатай хаяг болон бусад мэдээллийг тусгаж, тэдгээрт эрх, үүргийг нь тайлбарлаж өгсөн эсэх талаар тусгана.
4. Нотлох баримт цуглуулахдаа дүрс, дууны бичлэг хийсэн, гэрэл зураг авсан, схем, гар зураг үйлдэж түүнийг тэмдэглэлд бэхжүүлнэ.
5. Нотлох баримт цуглуулах талаар явуулж байгаа ажиллагаа эхэлсэн, дууссан огноог бичсэн байна.
6. Тэмдэглэлд оруулсан завсар, өөрчлөлтийг тайлбарлан бичнэ.
7. Нотлох баримт бэхжүүлж дууссаны дараагаар тэмдэглэлийг оролцогчдод уншиж өгсөн уншуулсан эсэх талаар болон тэдний гаргасан санал хүсэлтийг тэмдэглэлд тусгаж гарын үсэг зуруулна. Тэмдэглэл хэд хэдэн хуудастай байвал түүний нүүр болгон дээр гарын үсэг зуруулна.
8. Тэмдэглэлийг ажиллагааны явцад буюу дараа нь гаргацтай бичнэ.

Тухайн ажиллагааны явцыг тэмдэглэлд тусгаагүй бол тухайн мэдээлэл нь нотолгооны ач холбогдолгүй. Тухайлбал, мэдүүлэг өгсөн хүний ярьсан зарим зүйлийг тэмдэглэлд тусгаагүй, үзлэг хийх явцад илэрсэн зарим зүйлийг тэмдэглээгүй эсхүл буруу тэмдэглэсэн бол тэр нь нотлох баримт болохгүй. Өөрөөр хэлбэл шүүхийн шийдвэрийн үндэслэл болохгүй. Хэрэв тухайн ажиллагааг нотлох ямар нэг баримт байхгүй бол ажиллагааны явцад тухайн зүйл илрээгүй, оролцогч мэдүүлэг өгөөгүй гэсэн үг. Оролцогчид гарын үсэг зураас татгалзсан эсхүл эрхтэн дутуу буюу бусад шалтгааны улмаас гарын үсэг зурж чадахгүй бол тэмдэглэлийн эцэст эрх бүхий албан тушаалтан тайлбар хийж гарын үсэг зурж батална. Тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан этгээдэд тухайн шалтгааныг тайлбарлах бололцоо олгож түүнийг нь тэмдэглэлд тусгана.

Нотлох баримтыг техник хэрэгсэл ашиглан бэхжүүлж байгаа тохиолдолд дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Техник хэрэгсэл ашиглаж байгаа талаар оролцогчдод мэдэгдэнэ.
2. Тухайн техник, хэрэгслийг ажиллуулахдаа мэргэжилтнийг урьж оролцуулна.
3. Техник хэрэгсэл ашиглах саналыг хэн ч гаргаж болно.
4. Бичлэг хийхдээ хэсэгчилж хийж болохгүй.
5. Ажиллагаанд хэрэглэсэн техник хэрэгсэл, дүрс, дууг буулгасан хальс болон бусад зүйлүүдийн марк, загварыг тэмдэглэлд тодорхойлон бичсэн байх ёстой.
6. Нотлох баримт цуглуулах ажиллагаанд оролцож байгаа хүмүүс болон

тэдгээрт эрх үүргийг тайрбарлан өгч байгаа хэсгийг тусгасан байна. Түүнчлэн мэдүүлэг өгч буй хүний биеийн байцаалтыг бичлэгт оруулна.

7. Ажиллагаа эхэлсэн, дууссан буюу завсарласан цаг, минутыг тусгана. Эдгээрийг хэлж бичүүлэх нь үр дүнтэй.

Техник хэрэгсэл ашиглахдаа дараах зүйлүүдийг анхаарах хэрэгтэй. Үүнд:

- Нотлох баримтыг бэхжүүлэхэд хэрэглэсэн багаж, техник хэрэгслийн марк дугаар, хүчин чадлыг тэмдэглэсэн байна. Түүнчлэн дагалдах хэрэгслүүдийн үзүүлэлтүүдийг тусгана. Тухайлбал: ямар марк, чанартай хальс хэрэглэсэн, ашигласан гэх мэт. Энэ нь нотлох баримтыг шалгахад ихээхэн ач холбогдолтой.
- Нотлох баримтыг бэхжүүлэх үед багаж, техник хэрэгслийн заалтууд ямар байсан. Тухайлбал: PAL, SECAM системийн алин дээр дүрс буулгасан гэх мэт.
- Хэн тухайн техник хэрэгслээс нотлох баримтыг бэхжүүлсэн.
- Хичнээн удаа, хаанаас, ямар зүйлийн зургийг авсан, ул мөрийг бэхжүүлсэн, ямар хальсан дээр хичнээн цаг, минутын бичлэг хийснийг тэмдэглэнэ.
- Гэрэл зургийн хальсийг боловсруулаад үзэхэд гэрэл цохиулсан, дүрсний болон дууны шаардлага хангасан эсэхээс шалтгаалахгүйгээр тэмдэглэлд хавсаргана.

Зөрчил тулгах тодорхой ажиллагааны үр дүнг бэхжүүлэх, нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагааны төрлүүд мэдүүлгийг бэхжүүлэх ажиллагаа

Гэрч, хохирогчийн мэдүүлгийг тэмдэглэл үйлдэж бэхжүүлж авна. Нэг хэрэгт дуудагдсан гэрч нарыг тус тусад нь байцааж тэмдэглэл хөтөлнө. Гэрч, хохирогчийн биеийн байцаалтыг шалгаж, худал мэдүүлвэл хүлээлгэх хариуцлагыг сануулсан тухайгаа тэмдэглэнэ. Шаардлагатай гэж үзвэл биеийн байцаалтыг тэмдэглэлд тусгана. Гэрч, хохирогч нь сэжигтэн, яллагдагчтай ямар холбоотой болохыг тогтоож, хамаатан садны холбоогүй бол мэдүүлэг авах ажиллагаа ердийн журмаар явагдана. Харин хамаатан садны холбоотой бол тэдний эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг нь тайлбарлан өгнө. Тэд мэдүүлэг өгөхөөс татгалзвал ажиллагааг явуулахгүй. Зөвшөөрвөл мэдүүлэг авах ажиллагааг ердийн журмаар явуулна. Энэ тохиолдолд тухайн гэрч, хохирогч үнэн зөв ярих үүргээс чөлөөлөгдөхгүй. Харин хүссэн үедээ мэдүүлэг өгөхөөс татгалзаж болно. Мэдүүлгийг нэгдүгээр биен дээр (би, миний гэх мэт) аль болох үгчлэн найруулга зүй, үг үсгийн алдаагүй бичих хэрэгтэй. Мэдүүлгийг биечлэн бичих эрхтэйг тайлбарлан өгч хүсвэл өгсөн мэдүүлгийг нь л өөрөөр нь бичүүлж, асуулт,

хариулт зэргийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч бичнэ.

Тэмдэглэлийг байцаалт явагдаж байх үед буюу дуусмагц үйлдэнэ. Тэмдэглэлийг бичиж дуусаад оролцогчдод уншиж өгөх буюу уншуулж энэ тухайгаа тэмдэглэлд тэмдэглэнэ. Мэдүүлэг авах ажиллагаанд оролцсон буюу мэдүүлэг өгсөн этгээд тэмдэглэлд нэмэлт, засвар оруулах эрхтэйг тайлбарлан өгч оруулсан засвар өөрчлөлтийг тэмдэглэлд тусгана.

Тэмдэглэлд мэдүүлэг өгөгчийн үйлдсэн зураглал, хүснэгт, зургийг хавсаргана. Тэмдэглэлд орсон нэмэлт, засвар, оруулгыг тайлбарлан бичнэ. Тэмдэглэл олон хуудастай бол нүүр болгоны доор мэдүүлэг өгсөн этгээд болон байлцсан хүмүүс гарын үсгээ зурна. Мэдүүлэгтээ гарын үсэг зурж байгаа нь үнэн зөв мэдүүлэг өгч байгаагийн баталгаа бус харин тухайн ажиллагааг болон хэлсэн зүйлийг нь үнэн зөв тэмдэглэсэн талаар баталж байгаа явдал юм. Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тэмдэглэлийн төгсгөлд гарын үсгээ зурна.

Үзлэгээр цугларсан нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагаа

Тэмдэглэлийг үзлэг хийж байх явцад буюу түүний дараагаар эрх бүхий албан тушаалтан үйлдэх бөгөөд ямар нэг хүндэтгэн үзэх буюу бусад ямар нэг шалтгаанаар өөр хүн хөтөлж болохгүй хөтөлдөг. Тухайлбал: өвлийн хүйтэн, цас, бороотой үед үзлэгийн тэмдэглэл бичих боломж муутай. Үзлэгт хүмүүс ямар эрх, үүрэгтэйгээр оролцож байгааг тайлбарлан өгч гарын үзэг зуруулна. Үзлэгийн явц, үр дүнг хуульд заасны дагуу тэмдэглэл үйлдэж түүнд нөхцөл байдлыг маш тодорхой бичих хэрэгтэй. Хүн болгон аливаа зүйлийг нүдэнд харагдтал бичих чадваргүй тул тэмдэглэлд тэр болгоныг бүрэн тусгах боломж хязгаарлагдмал. Энэ байдлыг арилгахын тулд нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагааг дүрс, дууны бичлэг хийх, схем, гар зургийн аргатай хослуулан хэрэглэдэг. Үзлэгийн явцад тусгай мэргэжилтний тусламжийг авах нь тухайн аргаар бэхжүүлсэн нотлох баримтын нотолгооны ач холбогдлыг ихэсгэх буюу баталгаажуулна. Энэ нь тэмдэглэлд тусгах бололцоогүй нөхцөл байдал болон бусад зүйл ийг аль болох байгаа чигээр нь тусгах боломжийг нэмэгдүүлнэ.

Гэрэл зураг авах, дүрс, дууны бичлэг хийхдээ тэмдэглэлд ашигласан техник хэрэгсэлийн марк, загвар, түүнчлэн дүрс, дуу болон бусад зүйлүүдийг тусгасан материалыг тусгасан байх ёстой. Хичнээн кадр зураг дарсан, хичнээн минутын бичлэг хийсэн, хичнээн хуудас зураг, схем хавсаргасан зэргийг тодорхой тусгахаас гадна ямар эд зүйлийг хаанаас ямар байрлалтай байхад нь гэрэл зураг авч байгаа талаар тэмдэглэлд тусгадаг. Энэ нь хавтаст хэргээс нотлох баримт устаж алга болохоос урьдчилан сэргийлэх, нотолгооны ач холбогдлыг алдагдуулахгүй байхад чиглэнэ. Үзлэг хичнээн сайн, чанартай хийгдсэн ч гэсэн тэмдэглэлийг учир дутагдалтай хөтөлсөн бол нотлох баримтын ач холбогдлыг бууруулна.

Тэмдэглэлд тусгагдаагүй нотлох баримтыг албан ёсны нотлох баримтын хэмжээнд үнэлэх буюу шүүхийн шийдвэрийн үндэслэл болгохгүй.

Үзлэгээр илэрсэн зүйлийг тэмдэглэлд тусгахдаа хүмүүст харагдаж, мэдрэгдэж байгаа байдлаар нь бичихээс бус шууд дүгнэлт өгөн түүний шинж чанарыг тодорхойлж болохгүй. Тухайлбал; эрх бүхий албан тушаалтан, үзлэгийн явцад шар өнгийн металл бөгжийг хураан авч бэхжүүлэхдээ “алтан бөгж” хураан авлаа гэж бичжээ. (харахад үнэхээр алтан бөгж шиг харагдаж байв) Түүнийг хураан авсны дараа шинжилгээ хийлгэхэд алт биш хуурамч болох нь тогтоогджээ. Сүүлд хохирогчид бөгжийг буцаан өгөх болоход эд зүйл хураан авсан тэмдэглэлд та алтан бөгж хураан авсан гэж байна шүү дээ наадах чинь дуураймал бөгж байна. Миний алтан бөгжийг өгөөдөх хэмээн нэхэж процессийн хүндрэл учирчээ. Мөн цус гэж бичихгүй цусархаг улаан өнгийн шингэн зүйлээр бохирлогдсон гэх мэтээр бичих нь тухайн нотлох баримтыг бэхжүүлэх ажиллагааны нотлох чадварыг бууруулах болон процессийн хүндрэл бий болгохгүй байх зэрэг ач холбогдолтой. Түүнчлэн хэргийн газраас Япон улсад үйлдвэрлэсэн SONY зурагт хураан авсан гэж тэмдэглэхгүй харин Япон улсад үйлдвэрлэв гэсэн бичигтэй SONY гэсэн маркийн зурагт хураан авлаа гэдэг. Магадгүй тэр нь Хятад улсад дууриалган үйлдвэрлэсэн зурагт байж болно. Тэмдэглэл бичиж дууссаны дараа үзлэгт оролцсон бүх оролцогчдод уншуулж санал хүсэлтийг нь тэмдэглэсний эцэст түүнд тусгагдсан бүх мэдээлэл нь албан ёсны нотлох баримтын хүчин чадалтай болно.

Тэмдэглэлд хэргийн газрыг схемээр бэхжүүлэн хавсаргаж болно. Учир нь тухайн зөрчил эсвэл эрүүгийн хэрэг хэдэн жилийн дараа илэрч буруутай этгээдэд хариуцлага хүлээлгэх эсэх нь тодорхойгүй байдаг.

Хүний биед үзлэг хийж байгаа бол хөндлөнгийн гэрч болон үзлэг хийж байгаа хүмүүс нь ижил хүйсийн хүн байна.

2.4 Зөрчил шалгах ажиллагаатай холбоотой бусад арга хэмжээ

Эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмын дагуу зөрчил шалгах тодорхой ажиллагаа явуулах үед оролцогч, иргэн, албан тушаалтан зориуд саад учруулбал хууль ёсны шаардлагыг биелүүлэхийг анхааруулж, үл биелүүлсэн тохиолдолд албадлага хэрэглэнэ. Энэ талаар зөрчил шалгах ажиллагаа явуулсан тухай тэмдэглэлд тодорхой тусгана. Албадан гүйцэтгэсний улмаас учирсан эд материалын хохирлыг тухайн эрх бүхий албан тушаалтан хариуцахгүй. Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил шалгах ажиллагаанд саад учруулсан иргэн, албан тушаалтанд хуульд заасны дагуу хариуцлага тооцуулж болно.

Эрх хязгаарлах арга хэмжээ

Манай улс НҮБ-ын гишүүн улсын хувьд хүний эрх, эрх чөлөөг хязгаарлах үндэслэл, журмыг дотоодын хууль тогтоомжийн хүрээнд хуульчлан тогтоохдоо Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон Улс төрийн эрхийн олон улсын пакт, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцид заасан суурь зарчимд нийцүүлэх үүрэг хүлээсэн.

Иймд олон улсын хүний эрхийн стандартад нийцүүлэн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа дахь эрх хязгаарлах арга хэмжээг зөвхөн хуульд заасан үндэслэл, арга хэрэгсэл, журмын дагуу хэрэгжүүлэх, хүний эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлах зохицуулалтыг хуульчлан тогтоох шаардлага зүй ёсоор тулгарч байна. Энэ ч утгаар зөрчил шалган шийдвэрлэхтэй холбоотой хүний эрхийг хязгаарлах арга хэмжээний тодорхой төрлүүдийг хуулийн Тавдугаар бүлгээр тогтоож, хэрэгжүүлэх журмыг нарийвчилж, прокурорын хяналтаас гадуур хүний эрхийг хязгаарлахыг хориглохоор хуульчилсан байна.

Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны хэвийн нөхцөлийг хангах зорилгоор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлд дараахь эрх хязгаарлах арга хэмжээг хэрэглэхээр заажээ: Үүнд:

- Хүнийг саатуулах;
- Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох;
- Холбогдогчийн баримт бичгийг хураан авах;
- Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх;

Зөрчлийн тухай хуулийн зорилт нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчлийн шинж байдлыг тогтоох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршдог.

Иймд зөрчлийг шуурхай шалгах, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зохих шийтгэл оногдуулах, энэхүү ажиллагааны явцад хүн, хуулийн этгээдийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нөхцлийг бүрдүүлэхэд эрх хязгаарлах арга хэмжээний зорилго оршино. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрх хязгаарлах албадлагын арга хэмжээг хуульд заасан үндэслэл, журмын дагуу давхардуулан хэрэглэж болно. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар нийтлэг зөрчилд 58 хоног, зарим зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа 148 хоногоор тус тус тогтоогдсон тул хүн, хуулийн этгээдийн эрх хязгаарлах арга хэмжээний хугацаа зөрчлийн хэрэг бүртгэлтийн дээрхи хугацаанаас хэтрэхгүй байна. Энэ нь хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж чирэгдүүлэх, ялгаварлан

гадуурхах зэрэг хууль бус эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааг хязгаарлаж хүн, хуулийн этгээд хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалсан эрх зүйн зохицуулалт байна. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд зааснаар эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор хамтран батална.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад эрх бүхий албан тушаалтан, прокурор, эрүүгийн хэргийн шүүгч Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу хязгаарлахаас гадна энэхүү эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл, журмыг нэг стандарт горимд оруулах шаардлагаар журамлана. Түүнчлэн прокурор зөрчлийн хэрэг бүртгэлтийн явцад зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийг бүртгэх, шалгах ажиллагаа хуулийн хүрээнд явагдаж байгаа эсэхийг хянах, чиг үүргийн хүрээнд хүний эрх, эрх чөлөөг зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох шуурхай арга хэмжээ авах үүрэгтэй байна. Эрх бүхий албан тушаалтан, прокурор, эрүүгийн хэргийн шүүгч дараахь тохиолдолд эрх хязгаарлах арга хэмжээг хүчингүй болгоно. Үүнд:

- зөрчлийн хэрэг бүртгэлт дууссан;
- эрх хязгаарлах арга хэмжээ авсан үндэслэл арилсан;
- эрх хязгаарлах арга хэмжээг үндэслэлгүй авсан нь тогтоогдсон;

Зөрчлийн холбогдогчийн зорчих эрхийг хязгаарлах арга хэмжээ нь зөрчил шалган шийдвэрлэх нийт хугацаанаас хэтэрч болохгүй.

Хүнийг саатуулах

Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний халдашгүй байдлыг хангах зорилгоор ЗШШТ хуульд заасан үндэслэлээр хязгаарлан саатуулах үндэслэл, журам, нөхцлийг дараах байдлаар хуульчлан баталгаажуулжээ.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль		
Албан тушаалтан	Зорилго	Хугацаа
тагнуулын болон цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах	холбогдогчийг хэн болохыг тогтоох зорилгоор	6 цаг хүртэл
цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч	зөрчил үйлдсэн согтуурсан, мансуурсан холбогдогчийг	24 цаг хүртэл хугацаагаар
хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах	хилийн дэглэм зөрчсөн хүний хувийн байдлыг тогтоох зорилгоор	7 хоног хүртэл хугацаагаар
гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн гаргасан хүсэлтээр эрүүгийн хэргийн шүүх	холбогдогчийн хувийн байдлыг тогтоох, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд саад учруулж болзошгүй бол	тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг 14 хоног хүртэл, цаашид хугацааг 30 хүртэл хоногоор нэг удаа сунгаж болно.

Улсын байцаагч хүн саатуулах эрхгүй.

Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох

Зөрчлийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд, эсхүл шууд бусаар хор хохирол учруулж байгаа, учруулж болох нөхцөл байдал үүссэн талаархи эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэлтэй гэж үзвэл прокуророос дараах арга хэмжээг авах шийдвэр гаргана. Үүнд:

- зөрчлийн холбогдогчийн холбогдогчийн ажил, үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчилэн түр зогсоох;
- барилга байгууламж, машин, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, үйл ажиллагааг түр зогсоох;

Харин эрх бүхий албан тушаалтан нь хүний амь нас, эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд шууд хохирол учирч болзошгүй гэж үзвэл Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээг хойшлуулшгүй тохиолдолд авна.

Дээрх тохиолдолд хуульд заасан үндэслэл, журмын дагуу заасан үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээг хойшлуулшгүй авсан талаар прокурорт даруй мэдэгдэнэ. Энэ тохиолдолд прокурор нь уг эрх хязгаарлах арга хэмжээг хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэглэсэн эсэхийг холбогдох материалыг хянан дараах шийдвэрийг гаргана. Үүнд:

- үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээний эрх хязгаарлах арга хэмжээг үндэслэлгүй авсан нь тогтоогдвол хүчингүй болгох;
- энэхүү эрх хэмжээ хязгаарлах арга хэмжээг хүчинтэйд тооцох шийдвэр гаргах;

Үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээний эрх хязгаарлах арга хэмжээ авсан талаар иргэн, хуулийн этгээд нь хуульд заасан журмын дагуу прокурорт гомдол гаргаж болно.

ЗШШТ хуульд заасан үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээний шийдвэрийн хэрэгжилтийг эрх бүхий албан тушаалтан хангуулах арга хэмжээ авна.

Энэхүү прокурорын шийдвэрийг биелүүлээгүй үйл ажиллагаа, ашиглалтыг түр зогсоох эрх хязгаарлах арга хэмжээний эрх хязгаарлах арга хэмжээ авагдсан зөрчлийн холбогдогч, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл ногдуулна.

Баримт бичгийг хураан авах

Хуульд заасан чиг үүргийн хүрээнд эрх бүхий албан тушаалтан холбогдогчийн жолоодох эрхийн үнэмлэх, мэргэжлийн үнэмлэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл зэрэг баримт бичгийг хураан авч, хураан авсан тухай баримтыг холбогдогчид өгнө.

Тухайлбал, мэргэжлийн үнэмлэх, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох эрх хязгаарлах арга хэмжээтэй хэрэгжүүлэх зорилгоор хураан авч болно.

Эрх бүхий албан тушаалтан шаардсан бол тухайн хүн, хуулийн этгээд холбогдох баримт бичгээ шалгуулах үүрэгтэй.

Баримт бичгийг хураан авах эрх хязгаарлах арга хэмжээг хэрэгжүүлэхэд иргэн, хуулийн этгээд санаатайгаар саад учруулбал хуульд заасан албадлага хэрэглэж гаргасан зөрчилд нь Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл ногдуулна. Холбогдогч хураалгасан баримт бичгийг ашиглах зайлшгүй шаардлагатай бол эрх бүхий албан тушаалтанд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

Монгол Улсын хилээр гарах

Прокурор зөрчил шалгах ажиллагаанд саад учруулж болзошгүй талаархи эрх бүхий албан тушаалтны саналыг үндэслэлтэй гэж үзвэл дараах зөрчилд холбогдогчийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлж болно. Үүнд:

- Зөрчлийн тухай хуульд арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд;
- хөрөнгө, орлого, хохирлын тодорхой хувиар тооцсон торгох шийтгэлийн хэмжээ нь арван мянгаас дээш нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд;

Өөрөөр хэлбэл, Зөрчлийн тухай хуульд арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг хүртэл торгох шийтгэл оногдуулах эсхүл хөрөнгө, орлого, хохирлын тодорхой хувиар тооцсон торгох шийтгэлийн хэмжээ нь арван мянга хүртэл нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох шийтгэл оногдуулахаар заасан зөрчил гаргасан зөрчлийн холбогдогчид зорчих эрхийг хязгаарлах арга хэмжээ хэрэглэхгүй. Холбогдогчийн Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээний нийт хугацаа зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаанаас хэтрэхгүй бөгөөд прокурорын шийдвэрийг холбогдох байгууллага, албан тушаалтан хэрэгжүүлнэ.

Монгол Улсын хилээр гарах эрхийг түр түдгэлзүүлэх арга хэмжээг барьцаагаар солиулах тухай холбогдогчийн гаргасан хүсэлтийг прокурор хангах үндэслэлтэй гэж үзвэл мөнгөн хэлбэрээр барьцаа авч, Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх арга хэмжээг түр хугацаагаар цуцалж болно. Барьцааны хэмжээг холбогдогчийн хувийн байдал, холбогдсон зөрчил, түүнд оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээг харгалзан тогтоож барьцааг холбогдогч өөрөө, эсхүл түүний өмнөөс бусад хүн, хуулийн этгээд гаргаж болно. Холбогдогчийн өмнөөс барьцаа гаргасан хүн, хуулийн этгээд барьцааны үүрэг биелэгдэхээс өмнө үүргээсээ татгалзаж, барьцааны мөнгийг буцаан авах эрхгүйгээр хуульчлагдсан. Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд бусдын өмнөөс барьцаа гаргахыг хориглоно. Холбогдогч зөрчил шалгах ажиллагаанд саад учруулахгүй байх үүргийг хүлээж, зөрчсөн тохиолдолд барьцааг улсын орлого болгоно. Барьцааны мөнгийг төрийн сан дахь тусгай дансанд байршуулах бөгөөд барьцааны мөнгийг хадгалах, буцаан олгох журмыг Улсын ерөнхий прокурор, санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлана.

2.5 Зөрчил шалгах ажиллагааг дуусгах

Эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн хэрэг бүртгэлтийг дуусгахаас өмнө оролцогч, тэдгээрийн өмгөөлөгчийг зөрчлийн хэрэгтэй танилцах боломжоор хангана. Арван найман насанд хүрээгүй оролцогчид зөрчлийн хэргийг танилцуулахад түүний хууль ёсны төлөөлөгч, эсхүл өмгөөлөгчийг оролцуулна. Арван найман насанд хүрээгүй оролцогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчиж болзошгүй гэж үзвэл зөрчлийн хэргийг танилцуулахад түүний хууль ёсны төлөөлөгчийг оролцуулахгүй. Зөрчил шалгах ажиллагааг дуусгах энэхүү журам нь зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхэд мөрдөгдөхгүй. Оролцогч, тэдгээрийн өмгөөлөгч нь зөрчлийн хэрэгтэй танилцсаны дараа нэмэлт ажиллагаа хийлгэх хүсэлтээ ЗШШТ хуульд заасан журмын дагуу бичгээр гаргаж болно. Эрх бүхий албан тушаалтан нь холбогдогч, түүний өмгөөлөгчөөс нэмэлт ажиллагаа хийлгэх саналыг үндэслэлтэй гэж үзвэл зөрчил шалгах нэмэлт ажиллагаа явуулна. Эрх бүхий албан тушаалтан зөрчил шалгах ажиллагааг дуусгаж дараахь шийдвэр гаргасан даруй прокурорын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ. Үүнд

- Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох;
- Шийтгэл оногдуулах;
- Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэл байгаа бол шийтгэлээс чөлөөлөх;

Арван найман насанд хүрээгүй холбогдогчийг шийтгэлээс чөлөөлөхдөө түүний хувийн байдлыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 18.3 дугаар зүйлд заасаар дараах байдлаар тогтоосон байна. Үүнд:

1. Төрсөн он, сар, өдөр, нас;
2. Амьдралын нөхцөл байдал ба хүмүүжилтэй холбоотой мэдээлэл;
3. Гэмт хэрэг үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл;
4. Гэмт хэрэг хамтран үйлдэгч байсан эсэх;
5. Сэтгэцийн өвчинтэй холбогдолгүй боловч ухаан санаа нь гүйцэд хөгжөөгүйн улмаас өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа эсэхэд эргэлзээ төрвөл шинжээч томилж, дүгнэлт гаргуулах;

Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох

Дараахь үндэслэл тогтоогдвол эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргана. Үүнд:

- Зөрчлийн шинжгүй;
- Зөрчлийн тухай хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн;
- Тухайн зөрчилд хариуцлага тооцсон хуулийн зүйл, хэсэг, заалт хүчингүй болсон;
- Зөрчил үйлдсэн хүн нас барсан;

- Тухайн зөрчлийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулсан эрх бүхий албан тушаалтны, эсхүл шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр бол.
- Зөрчил үйлдэх үедээ шийтгэл хүлээх насанд хүрээгүй;
- Зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацаа дууссан;
- Тулгарсан аюулыг өөр арга хэрэгслээр арилгах боломжгүй нөхцөлд учирч болох аюулын хэр хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр үйлдсэн Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн шинжтэй үйлдэл болох нь тогтоогдвол;
- Сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хүн болох нь тогтоогдвол;

Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг гомдол, мэдээлэл гаргагч, холбогдогчид ажлын 3 өдрийн дотор биечлэн танилцуулах, эсхүл харилцаа холбооны хэрэгсэл ашиглан хүргүүлнэ. Оролцогч зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг эс зөвшөөрвөл ЗШШТ хуульд заасан журмын дагуу гомдол гаргаж болно. Прокурор нь дараахь үндэслэл тогтоогдвол эрх бүхий албан тушаалтны зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг хүчингүй болгож эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, эсхүл зөрчлийн хэрэг бүртгэлтэд буцаана. Үүнд:

- Гэмт хэргийн шинжтэй бол;
- Илтэд зөрчил үйлдсэн;

Прокурор эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах, эсхүл зөрчлийн хэрэг бүртгэлтэд буцаах шийдвэр гаргасан даруй эрх бүхий байгууллагад хэргийг шилжүүлнэ. Зөрчил үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд шийтгэл оногдуулахгүйгээр хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэж болно. Төрийн албан хаагч хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуульд заасан зөрчлийн шинжтэй бол холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ. Харин төрийн албан хаагчийн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүйтэй холбоогүй зөрчилд энэ хуульд заасан нийтлэг журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн хэрэг бүртгэлтийн бүх ажиллагааг хийж, хэргийг шийдвэрлэх хангалттай нотлох баримт цугларсан гэж үзвэл энэ тухай холбогдогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэж, зөрчлийн хэргийн материал танилцуулсан тухай тэмдэглэл үйлдэнэ. Холбогдогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч хүсвэл түүнд зөрчлийн хэргийн материалд авагдсан зөрчлийг хянан

шийдвэрлэхэд ач холбогдолтой эд зүйл, баримт бичиг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг танилцуулж болно. Холбогдогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч зөрчлийн хэргийн материалтай танилцах үед бичгээр санал, хүсэлт гаргасан бол зөрчлийн хэргийн материалд хавсаргана. Санал, хүсэлтийг эрх бүхий албан тушаалтан хүлээн авах үндэслэлтэй гэж үзвэл бүрэн, эсхүл хэсэгчлэн хангах, хангахаас татгалзаж, энэ тухай тогтоол гаргана.

Холбогдогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс гаргасан санал, хүсэлтийг эрх бүхий албан тушаалтан хангахаас татгалзсан бол прокурорт гомдол гаргах эрхийг тайлбарлаж өгнө. Зөрчлийн хэрэг бүртгэлт явуулах хугацаа дууссан тохиолдолд холбогдогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс нэмэлт ажиллагаа хийлгэхээр гаргасан саналыг хүлээн авахгүй.

Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох шийдвэр гаргах нь:

Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох эрх бүхий албан тушаалтны шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна. Тогтоолыг 2 хувь үйлдэх ба 1 хувийг зөрчлийн хэргийн материалд, 1 хувийг дугаарын дагуу бичиг хэргийн нэгж болгон архивт хадгална.

Эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох тухай тогтоолд дараахь зүйлийг тусгана. Үүнд:

- а) Зөрчлийн хэрэг бүртгэлтээр шалгаж тогтоогдсон нөхцөл байдлууд;
- б) Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгох үндэслэл, баримтлах хуулийн зүйл, хэсэг;
- в) Эрх хязгаарласан зарим арга хэмжээг хүчингүй болгох;
- г) Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 5.3, 5.5 д заасан эрх хязгаарлах арга хэмжээг цуцлуулах асуудлыг прокуророор шийдвэрлүүлэх талаар тусгах;
- д) Хураан авсан, битүүмжилсэн, шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан хөрөнгө, орлого, эд зүйл, тэдгээрийг шийдвэрлэх талаар прокурорт хандах талаар;
- е) Зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай гомдол, мэдээлэл гаргагч, оролцогч нарт мэдэгдэх талаар;
- ё) Оролцогч нарын гомдол гаргах эрхийн талаар тодорхой дурьдана;

Эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон тухай шийдвэрийг гомдол, мэдээлэл гаргагч, оролцогчид Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар мэдэгдэж, гомдол гаргах эрхийг нь хангаж ажиллана. Эрх бүхий албан тушаалтан нь зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон даруйд харъяалах прокурорын газрын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

Шийтгэл оногдуулах

Зөрчил үйлдсэн, зөрчил үйлдэх үедээ арван зургаан насанд хүрсэн, хэрэг хариуцах чадвартай хүнд энэ хуульд заасан шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ. Зөрчлийн тухай хуулийн тусгай ангид заасан тохиолдолд эрх бүхий албан тушаалтан нь хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн 3.3 дугаар зүйлд заасан дараах шийтгэл оногдуулна. Үүнд:

1. Торгох шийтгэл;
2. Эрх хасах шийтгэл;

Торгох шийтгэлийг үндсэн, эрх хасах шийтгэлийг нэмэгдэл шийтгэлийн хэлбэрээр оногдуулна. Харин зөрчлийн тухай хуульд заасан баривчлах шийтгэлийг Эрүүгийн хэргийн шүүхээс оногдуулах тул Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 9.2 дугаар зүйлээр тусгайлан зохицуулсан байна. Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулахдаа дараахь нөхцөл байдлыг нотолж тогтоосон байна. Үүнд:

1. Тухайн хүн, хуулийн этгээдийн зөрчил үйлдсэнийг нотлох баримт бүрдсэн эсэх;
2. Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу зөрчил үйлдсэн хуулийн этгээдийн хариуцлагыг нөхөн хүлээх этгээд байгаа эсэх, өөрөөр хэлбэл компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс зөрчил үйлдсэн нь тогтоогдсон бол толгой компани байгаа эсэх;
3. Тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь Зөрчлийн тухай хуульд заасан шийтгэл оногдуулах зүйл, хэсэг, заалтад нийцэж байгаа эсэх;
4. Торгох шийтгэлийг хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэх үндэслэлтэй эсэх;
5. Зөрчлийн тухай хуульд хохирол төлүүлэх, нөхөн төлбөр гаргуулахаар заасан бол хохирол, нөхөн төлбөрийн хэмжээг тогтоох;
6. Зөрчил үйлдсэн хүн төрийн албан хаагч мөн эсэх /Төрийн албан хаагч хуулиар хүлээсэн албаны чиг үүргээ хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь Зөрчлийн тухай хуульд заасан зөрчлийн шинжтэй бол холбогдох хууль тогтоомжид заасан сахилгын шийтгэл хүлээлгэнэ/;
7. Зөрчил үйлдэгдсэн хугацаа (хэрэв хөөн хэлэлцэх хугацаа өнгөрсөн бол шийтгэл оногдуулахгүй); Тухайн зөрчлийн шинж (зөрчил үйлдсэн арга, зөрчил ямар нөхцөлд үйлдэгдсэн болох, учруулсан хохирлын хэрхэмжээ гэх мэт) болон тухайн хүний хувийн байдал (нас, өмнө шийтгэлтэй байсан, зөрчил үйлдэхдээ согтуурсан, мансуурсан байдалтай байсан эсэх гэх мэт)-ыг харгалзан нэмэгдэл шийтгэл, албадлагын арга хэмжээг тогтооно. Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулахдаа зөрчил

үйлдсэн хүн, хуулийн этгээдийг шийтгэлээс чөлөөлөх үндэслэл байгаа эсэхийг нотолж тогтоосон байвал зохино. Энэ нөхцөл байдал нь:

1. Тулгарсан аюулыг өөр арга хэрэгслээр арилгах боломжгүй нөхцөлд учирч болох аюулын хэр хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр зөрчил үйлдсэн бол;
2. Сэтгэцийн эмгэгийн улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюулыг ухамсарлах, өөрийн үйлдлээ удирдан жолоодох чадваргүй хэрэг хариуцах чадваргүй хүн зөрчил үйлдсэн бол;

Хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах:

Зөрчил үйлдсэн хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, түүнийг санаатайгаар дампууруулсан, татан буулгасан бол доор дурдсан журмаар шийтгэл оногдуулж, албадлагын арга хэмжээ хэрэглэнэ: Үүнд:

1. Бусад хуулийн этгээдтэй нийлүүлэн нэг хуулийн этгээд үүсгэсэн бол шинээр бий болсон хуулийн этгээдэд;
2. Бусад хуулийн этгээдэд нэгтгэсэн бол нэгтгэж авсан хуулийн этгээдэд;
3. Хуваах, тусгаарлах замаар өөр хуулийн этгээд үүсгэн байгуулсан бол үйлдсэн зөрчилд холбогдох эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, үйл ажиллагааг шилжүүлэн авсан хувь хэмжээгээр нь зохих хуулийн этгээдэд;
4. Хуулийн этгээдийн зохион байгуулалтын төрөл, хэлбэр, үндсэн зорилгоо өөрчлөх замаар өөрчлөгдсөн бол тухайн өөрчлөгдөн зохион байгуулагдсан хуулийн этгээдэд;
5. Компани нь толгой компани, түүний үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигчийн ашиг сонирхлын үүднээс зөрчил үйлдсэн нь тогтоогдсон бол толгой компанид;
6. Зөрчлийн хэргийг шалган шийдвэрлэх явцад хуулийн этгээдийг санаатайгаар татан буулгасан бол торгох шийтгэл, хохирол, хор уршиг нөхөн төлүүлэх албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг эд хөрөнгө хуваарилагдсан хувьцаа эзэмшигчдэд;
7. Аливаа хэлбэр, арга, хэрэгслээр эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг үндэслэлгүйгээр тухайн хуулийн этгээдээс шилжүүлэн авсан нэгдмэл сонирхолтой этгээдэд, эсхүл эд хөрөнгө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрхийг хариу төлбөргүйгээр шилжүүлэн авсан бусад хуулийн этгээдэд шилжүүлэн авсан хөрөнгийн хувь хэмжээгээр;

Шийтгэл оногдуулсан шийдвэр

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах шийдвэр нь шийтгэлийн хуудас хэлбэртэй байх ба маягтыг Засгийн газар батална.

Эрх бүхий албан тушаалтаны шийтгэл оногдуулах тухай шийдвэрт дараах зүйлийг тусгасан байна. Үүнд:

1. Зөрчлийг шалган шийдвэрлэсэн он, сар, өдөр;
2. Шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтны нэр, албан тушаал;
3. Зөрчлийн талаар тогтоогдсон нөхцөл байдал;
4. Шийтгэл оногдуулах, албадлагын арга хэмжээ авах үндэслэл, хуулийн зүйл, хэсэг, заалт;
5. Оногдуулах шийтгэл, албадлагын арга хэмжээ;
6. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлыг хуваарилсан тухай;
7. Шийтгэл, зардлыг сайн дураараа биелүүлэх хугацаа, хэлбэр, нөхцөл;
8. Хураан авсан, битүүмжилсэн эд зүйлийн шийдвэрлэлтийн талаар;
9. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд үүргээ биелүүлээгүйтэй нь холбогдуулан шийтгэл оногдуулсан бол уг үүргээ нөхөн биелүүлэхийг даалгах, эсхүл үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлыг тус тус тусгана.

Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдэгчийн хөрөнгө, цалин хөлс, бусад орлогыг харгалзан торгох шийтгэлийг нэг жил хүртэл хугацаанд хэсэгчлэн төлүүлэхээр шийдвэрлэсэн бол шийтгэлийн хуудсанд хэсэгчлэн төлөх хэмжээ, хугацааг заана. Эрх бүхий албан тушаалтан дараах байдлаар шийтгэлийн хуудасны хувийг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор дараах байдлаар хүргүүлнэ: Үүнд:

1. биечлэн танилцуулах;
2. харилцаа холбооны хэрэгсэл ашиглах;

Прокурор эрх бүхий албан тушаалтын шийтгэл оногдуулсан шийдвэртэй танилцаад хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлт бичиж харъяалах шүүхэд хүргүүлнэ.

Эрх бүхий албан тушаалтан гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг шүүхийн өмнө хамгаалах үүрэгтэй. Хэрэв шүүхийн өмнө хамгаалж чадахгүй бол гаргасан шийдвэр хүчингүй болгож хүн, хуулийн этгээдэд учруулсан хохирлоо нөхөн төлнө.

Албадлагын арга хэмжээ хэрэглэх

Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд дараахь албадлагын арга хэмжээ авна. Үүнд:

1. Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх;
2. Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураах;
3. Хохирол, нөхөн төлбөр гаргуулах;

4. Албадан эмчлэх;
5. Албадан сургалтад хамруулах;

Зөрчлийн тухай хуульд зааснаар албадлагын арга хэмжээг дараахь субъектүүд оногдуулна:

Эрх бүхий албан тушаалтан	Шүүх
<ul style="list-style-type: none"> • Хөрөнгө, орлогыг хураах, шилжүүлэх • Зөрчил үйлдэхэд ашигласан ашигласан эд зүйл, зэвсэг, хэрэгсэл • Хохирол, нөхөн төлбөр гаргуулах 	<ul style="list-style-type: none"> • Албадан эмчлэх • Албадан сургалтад хамруулах • Зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах

Эрх бүхий албан тушаалтан нь зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураах, эсхүл түүний үнийг гаргуулах, түүнчлэн албадан эмчлэх албадлагын арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг шийтгэл оногдуулсан шийдвэр гаргаснаас хойш 24 цагийн дотор харьяалах шүүхэд гаргана. Шүүх хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 2 өдрийн дотор шийдвэрлэнэ. Эрх бүхий албан тушаалтан шүүхийн шийдвэр гарах хүртэл зөрчил үйлдэхэд ашигласан тээврийн хэрэгсэл, уналгыг хураан авах, эсхүл битүүмжлэх арга хэмжээг авна. Албадан эмчилгээнд хамруулах хүнийг донтох сэтгэцийн эмгэгтэй эсэхийг эмнэлгийн дүгнэлтээр тогтоосон байна.

Шийтгэл оногдуулсан шийдвэрт холбогдогчийн гаргасан гомдлыг шийдвэрлэх хүртэл түүнд албадлагын арга хэмжээ авахуулах тухай эрх бүхий албан тушаалтны хүсэлтийг шийдвэрлэхийг шүүх түдгэлзүүлнэ.

Зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авах

Эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай болон бусад хуульд заасан тохиолдод зөрчлийн үр дагаврыг арилгах, учирч болзошгүй хохирол, хор уршгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авна. Хуульд заасны дагуу тусгай зөвшөөрөлтэйгээр эрхлэх үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол эрх бүхий албан тушаалтан зөрчил илэрсэн өдрөөс үйл ажиллагааг зогсоож нийтэд мэдээлнэ. Эрх бүхий албан тушаалтан нь өөрийн санаачилгаар, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан үндэслэлээр зөрчлийн үр дагаврыг арилгах зорилгоор ариутгах, хоргүйжүүлэх, цэвэршүүлэх, засвар үйлчилгээ хийх, холбогдох бүтээгдэхүүнийг борлуулахыг хориглох, иргэний гүйлгээнээс буцаан татах, хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчлийг арилгах хүртэлх хугацаанд үйл ажиллагаа, ашиглалтыг зогсоох, энэ талаар олон нийтэд зарлан мэдээлэх зэрэг арга хэмжээ авч болно. Эрх бүхий албан тушаалтан зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авахыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд, зөрчил үйлдсэн

хүн арван найман насанд хүрээгүй бол түүний хууль ёсны төлөөлөгчид хугацаа тогтоон даалгаж болно.

Эрх бүхий албан тушаалтан тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагааг зогсоосон тухай байгууллагынхаа вэб хуудсаар мэдээлж болно. Шаардлагатай гэж үзвэл олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглан мэдээлэх арга хэмжээ авч болно. Зөрчлийн үр дагаврыг арилгах тухай эрх бүхий албан тушаалтны даалгаврыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд биелүүлээгүй, эсхүл энэ арга хэмжээний зардлыг тогтоосон хугацаанд төлөөгүй бол шүүхэд хүсэлт гаргаж, шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлнэ.

2.6 Шийтгэл оногдуулсан шийдвэрийг биелүүлэх

Эрх бүхий албан тушаалтан шийтгэл оногдуулсан, албадлагын арга хэмжээ авсан шийдвэрийнхээ биелэлтийг өөрөө хариуцаж зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд мэдэгдэх, түүнийг биелүүлэхтэй холбоотой мэдээллээр хангана. Тухайн хүн, хуулийн этгээд шийдвэрийг хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор сайн дураар биелүүлнэ. Шийтгэлийн хуудсыг зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд хүлээн аваагүй нь шийтгэл, албадлагын арга хэмжээг албадан хэрэгжүүлэхээс чөлөөлөх үндэслэл болохгүй. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд нь торгох шийтгэлд заасан торгуулийг бэлнээр /бэлэн мөнгөөр шууд/, эсхүл бэлэн бус /банкны дансаар дамжуулан/ төлнө.

Эрх бүхий албан тушаалтан нь эрх хасах шийтгэл оногдуулсан талаар зохих бүртгэлийн байгууллагад мэдэгдэж, шийдвэрийн хувийг даруй хүргүүлнэ. Эрх бүхий албан тушаалтан нь албадлагын арга хэмжээ авахаар шийдвэр гаргасан бол зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хураан авах, эсхүл битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах арга хэмжээг даруй авна. Эд зүйлийг хураан авах, битүүмжлэхдээ хуульд заасан журмыг баримтална. Хураан авсан, битүүмжилсэн эд зүйлийн хадгалалт, хамгаалалтыг тухайн байгууллага хариуцна. Хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан бол эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүлээн авсан бүртгэлийн байгууллага хэрэгжүүлнэ. Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээд тогтоосон хугацаанд шийдвэрийг биелүүлээгүй бол шүүхийн шийдвэр гүйцэтгэх журмаар албадан гүйцэтгүүлэхээр эрх бүхий албан тушаалтан харьяалах шүүхэд хүсэлт гаргана. Шүүх хүсэлтийг ажлын 2 өдрийн дотор шийдвэрлэх бөгөөд хүсэлтийг хангах үндэслэлтэй гэж үзвэл албадан гүйцэтгүүлэхээр гүйцэтгэх хуудас бичнэ. Шүүхийн шийдвэрт гомдол гаргахгүй.

Шийтгэл оногдуулсан шийдвэрт гомдол гаргах

Оролцогч дараах эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан шийдвэрийг эс зөвшөөрвөл тухайн шийдвэрт гомдол гаргах эрхтэй. Яг ямар эрх бүхий албан тушаалтны гаргасан шийдвэрт гомдол гаргаж байгаагаас хамаарч Эрүүгийн болон Захиргааны хэргийн шүүхэд гаргана.

Эрүүгийн хэргийн шүүх		Захиргааны хэргийн шүүх
Шийдвэр гаргасан субъект	<ol style="list-style-type: none"> 1. Консулын эрх бүхий албан тушаалтан 2. Хилийн төлөөлөгч, түүний орлогч, туслах офицер 3. Төрийн тусгай хамгаалалтын эрх бүхий ажилтан 4. Аймаг, нийслэл, дүүргийн цэргийн штабын дарга 5. Тагнуулын байгууллагын эрх бүхий алба хаагч 8. Ахлах шийдвэр гүйцэтгэгч 9. Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч 10. Хүүхдийн эрхийн улсын байцаагч 	<ol style="list-style-type: none"> 1. Гамшигаас хамгаалах улсын хяналтын байцаагч 2. Мэргэжлийн хяналтын улсын байцаагч 3. Гаалийн улсын байцаагч 4. Татварын улсын байцаагч 5. Оюуны өмчийн улсын байцаагч 6. Нийгмийн даатгалын байцаагч 7. Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч 8. Гал түймрийн улсын хяналтын байцаагч 9. Санхүүгийн зохицуулах хорооны хянан шалгагч 10. Монгол банкны хянан шалгагч 11. Улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч 12. Архив, албан хэрэг хөтлөлтийн хяналтын улсын байцаагч 13. Нягтлан бодох бүртгэлийн улсын байцаагч 14. Статистикийн улсын байцаагч 15. Нислэгийн аюулгүй ажиллагааны хяналт хариуцсан байцаагч 16. Төмөр Замын тээврийн улсын байцаагч 17. Улсын байцаагчийн эрхтэй байгааль хамгаалагч
Журам	Шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргана.	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргана.

БҮЛЭГ 3. ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТЫГ ТОДОРХОЙ ТӨРЛИЙН ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД АВЧ ҮЗЭХ НЬ

3.1 Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 5.11 дүгээр зүйлд дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Химийн хорт, аюултай бодис:
 - 1.1. экспортлох;
 - 1.2. импортлох;
 - 1.3. хилээр дамжуулан тээвэрлэх;
 - 1.4. үйлдвэрлэх;
 - 1.5. тээвэрлэх;
 - 1.6. хадгалах;
 - 1.7. худалдах;
 - 1.8. ашиглах;
 - 1.9. устгах үндсэн шаардлага, журам, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг зөрчсөн бол зөрчлийг арилгуулж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Хуульд заасны дагуу батлагдсан химийн хорт, аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаарх журам зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Химийн хорт, аюултай бодистой холбогдсон үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Химийн хорт, аюултай бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хүлцэх хэмжээний талаарх стандартыг зөрчсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, зарцуулалтад дотоод хяналт тавиагүй бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мэргэжлийн нэршил, холбогдох хууль тогтоомж:

“Химийн хорт бодис” гэж хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд хортой нөлөө үзүүлэх, улмаар үхэл, мөхөлд хүргэх үйлчилгээтэй химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ.

“Химийн аюултай бодис” гэж тэсрэмтгий, шатамхай, идэмхий, исэлдүүлэгч, цочромтгой шинж чанартай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ.

Химийн бодисыг шинж чанар болон хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд үзүүлэх нөлөөллөөр нь:

- Хортой;
- Аюултай гэж тус тус ангилна.

Химийн хорт болон аюултай бодисын үйл ажиллагаа эрхлэх гэж байгаа бол хамгийн түрүүнд “Тусгай зөвшөөрөл” авах ёстой. Тусгай зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас авна. Уг зөвшөөрөлийг “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийн 15 дугаар зүйлийн 15.6.3, “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-ийг үндэслэн олгодог.

Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэхэд тавих үндсэн шаардлага:

Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, үйлдвэрлэх, ашиглах зөвшөөрөл авахдаа тухайн бодисын талаар дараахь мэдээллийг бүрдүүлнэ.

- Бодисын нэр, томъёо;
- Худалдааны болон техникийн нэр;
- Олон улсын бүртгэлийн дугаар;
- Ашиглах газар, зориулалт, хугацаа, тоо хэмжээ;
- Физик, химийн болон хор аюулын шинж чанар;
- Болзошгүй осол, эрсдлийн үед авах арга хэмжээ;
- Үйл ажиллагаа явуулах ажлын байрны дүгнэлт;
- Тухайн бодис, түүний хольц, хаягдлыг устгах аргачлал, тээвэрлэх арга;
- Химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хилээр

дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэхдээ “химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, ашиглах, худалдах, усгаар аж ахуйн үйл ажиллагааны тусгай ЗӨВШӨӨРӨЛ

**ХИМИЙН ХОРТ БОЛОН АЮУЛТАЙ БОДИС ЭКСПОРТЛОХ,
ИМПОРТЛОХ, ХИЛ ДАМЖУУЛАН ТЭЭВЭРЛЭХ, ҮЙЛДВЭРЛЭХ,
АШИГЛАХ, ХУДАЛДАХ, УСГААР АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛ**

Огноо: _____ Дугаар: _____ Утас/факс: _____

Аж ахуйн нэгжийн нэр: _____
 Аж ахуйн нэгжийн гэрчилгээний дугаар: _____
 Байсгрийн дугаар: _____
 Нэр: _____


Утас: _____
 Дарын хэлний зэрэг, аюултай бодис: _____
 Нөлөөрлөх, худалдах: _____ аж ахуйн үйл ажиллагааны эрхтэй тусгай зөвшөөрлийн гэрээг хувиар харж авч.

№	Боловсрол		Төлбөр	Огноо болон бүтээгдэхүүний дугаар/АМ	Аймаг	Үйлдвэрлэх эрх	Төлбөр
	Мөнгө	Өгөөц					
1							
2							
3							
4							
5							
6							
7							
8							

Утасны мэдээлэл өгөгүүлэх бичиг: _____

Зөвшөөрлийн өгөгөөг: _____
 Төрийн газрын бичиг: _____
 Хэргийн байр: _____

Химийн бодисын тусгай зөвшөөрлийг Төрийн захиргааны төв байгууллагаас авах бөгөөд дараах үе шатыг дамждаг.



“Пестицид” гэж мал, амьтан, ургамлыг аливаа өвчнөөс сэргийлэх, хөнөөлт шавж, мэрэгч, хогийн ургамлаас хамгаалах зориулалттай химийн бодис, тэдгээрийн нэгдлийг хэлнэ. Эхлээд Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллагаас химийн бодисын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авна. Үүний дараа Хүнс хөдөө, аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамнаас ямар зориулалтаар “Пестицид”-ийг ашиглахаар тухай хүсэлт гарган Тусгай зөвшөөрөл авна. “Эрсдлийн үнэлгээ” гэж химийн хорт болон аюултай бодис, тэдгээрийн нэгдэлтэй харьцах явцад хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал, амьтанд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг судлан тогтоож, үнэлгээ өгөх, сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах талаар авах арга хэмжээг тодорхойлохыг хэлнэ.

Химийн хорт болон аюултай бодисын эрсдлийн үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ.

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуульд нийцүүлэн гарсан дүрэм, журамаас гадна дараах олон улсад нэгдэн орсон гэрээ, конвенцууд байдаг. Үүнд:

- Химийн хорт болон аюултай бодисыг импортлох, хил дамжуулан тээвэрлэх, худалдах журам,
Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, журам,
- Химийн хортой ба аюултай бодисын эрсдлийн үнэлгээ хийх журам,
- Пестицид, химийн бордоо, ахуйн хортон шавж, мэрэгч устгалын болон ариутгал, халдваргүйтэлийн бодисыг турших, ашиглах журам,
- Полихлорт бифенилийн бүртгэл хөтлөх, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, устгах, импортлох, экспортлох, хил дамжуулан тээвэрлэх журам,
- Озон задалдаг бодисыг импортлох, ашиглах зөвшөөрөл олгох журам,
- Монгол улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт,
- Монгол улсад ашиглахыг хязгаарласан химийн хорт болон аюултай бодисын жагсаалт,
- Химийн хорт болон аюултай бодисын ангилал,
- Химийн хорт болон аюултай бодисын ангилалыг ашиглах аргачлал,
- Химийн хорт болон аюултай бодисын ангилалын жагсаалт,
- Хор, аюулын лавлах мэдээлэл,
- Аюултай зарим химийн бодис болон пестицидийг олон улсын хэмжээнд худалдаалахад хэрэглэх, жрьдчилан мэдээлж зөвшилцөх журамын тухай РОТТЕРДАМЫН КОНВЕНЦ,
- Озоны үе давхарыг задалдаг бодисын тухай МОНРЕАЛЫН ПРОТОКОЛ,
- Аюултай хог хаягдлыг хил дамжуулан тээвэрлэх, зайлуулахад хяналт тавих тухай БАЗЕЛИЙН КОНВЕНЦ,
- Удаан задардаг органик бохирдуулагчийн тухай СТОКГОЛЬМЫН КОНВЕНЦ,

Дээрх хууль, дүрэм, журмыг дараах хаягнаас татан авч үзэж болно.

- <http://legalinfo.mn/law/details/526?lawid=526>

- https://upload.wikimedia.org/wiktionary/mn/a/ae/Himiin_hort_bolon_ayultai_bodis_garin_avlaga.pdf
- http://www.greenassessment.mn/wp-content/uploads/2017/03/20151008_A-356.396-Химийн-хорт-болон-аюултай-бодисын-ангилал-батлах-тухай.pdf
- <http://www.mne.mn/>

Зүйлчлэлийн асуудал

“Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих” зөрчлийн шинж нь: Хууль ёсны эрх авсан этгээд боловч үйл ажиллагаанд тавигдах үндсэн шаардлага, журам, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горим зөрчсөн; химийн хорт, аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаарх журам зөрчсөн; химийн хорт, аюултай бодистой холбогдсон үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр явуулсан байдаг.

Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд “Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах” гэж заасан. Үүнд:

Химийн хорт, аюултай бодисыг хууль бусаар /эрх, хууль ёсны зөвшөөрөлгүй этгээд/ улсын хилээр нэвтрүүлсэн, үйлдвэрлэсэн, хадгалсан, худалдсан, авсан, тээвэрлэсэн, бусдад дамжуулсан, зориулалтын бусаар ашигласан; энэ гэмт хэргийн улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, хүний амь нас хохирсон; их хэмжээний хохирол учирсан нь зөрчлөөс ялгагдах шинж бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дээрх шинж илэрвэл даруй прокурорт мэдэгдэж, холбогдох материалын хамт хүргүүлнэ.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

5.11 дүгээр зүйл. “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих” зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Химийн хорт, аюултай бодис экспортлох, импортлох, хилээр дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, тээвэрлэх, хадгалах, худалдах, ашиглах, устгах талаарх хууль зүйн нэр томъёог олж судлан, хэрэгт хавсаргах;
2. Дээрх үйлдлүүдэд тавигдах 1/ үндсэн шаардлага, 2/ журам, 3/ аюулгүй ажиллагааны дүрэм, 4/ технологийн горим, 5/ химийн хорт, аюултай бодистой холбогдох үйл ажиллагааг зохицуулах, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах талаарх журам зэрэг тухайн зөрчлийн онцлогт тохирох эрх зүйн актыг олж судлан, хэрэгт хавсаргах;
3. “Химийн хорт болон аюултай бодисын тухай” хууль болон “ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай” хуулийг

үндэслэн эрх бүхий байгууллагаас олгогдсон химийн хорт болон аюултай бодис экспортлох, импортлох, хил дамжуулан тээвэрлэх, үйлдвэрлэх, худалдах, ашиглах, устгах тусгай зөвшөөрөлтэй эсэхийг холбогдох төрийн захиргааны байгууллагаас лавлагаа авч шалгах.

4. Зориулалтын бусаар ашигласан химийн хорт болон аюултай бодисын хэмжээ, онцлог, шинж байдал болон ямар журмын зүйл заалтыг зөрчсөн үйлдэл гаргасан, хорт, аюултай бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хүлцэх хэмжээний талаарх стандартыг зөрчсөн эсэхийг шалгахын тулд холбогдох аргачлалын дагуу дээж авч шинжилгээ хийлгэх тогтоол бичиж шинжлүүлэн /ЗШШТХ 4.11.4.Тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн эрх бүхий албан тушаалтан өөрөө бие даан шинжилгээ хийж болно./ холбогдох дүгнэлтийг авч хэрэгт хавсаргана. Зөрчил үйлдэгдсэн тогтоосон хил хязгаараас агаар, хөрс, ус, ургамлын дээжийг шинжилгээнд зориулж хэд хэдэн газраас авахдаа тохиолдол бүрийг тоочиж бичих; Дээжийг авахдаа харилцан адилгүйгээр авна. Агаарын дээжийг мэргэжилтнээр тусгай багажийн тусламжтайгаар авна. Хөрсний дээжийг өнгөн шорооноос эгц доошоогоо 50-60 сантиметрт ухаж авахдаа 2 дээж авах /хожим маргаан үүсвэл дахин шинжлэх зорилгоор/, уснаас дээж авахдаа савыг сайтар уг авах гэж байгаа усаар зайлж мөн 2-ыг авна. ЭХХШТХ-ийн 27 дугаар бүлэгт зааснаар шинжилгээ хийлгэх ажиллагаа явагдана.
5. Шаардлагатай гэж үзвэл зөрчлийн газраас авсан дээжийг тогтоосон хязгаараас гаднах эрүүл газрын хөрс, ургамал, агаар, уснаас хяналтын дээжийг авч харьцуулж болно.
6. Зөрчлийн улмаас шалгаж буй бодис нь химийн хортой, аюултай бодисын жагсаалтад орсон эсэхийг шалгах;
7. Байгаль орчны сайд, эрүүл мэндийн сайдын хамтарсан 2003 оны 126/171 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Аюултай, хортой химийн бодис агуулсан бүтээгдэхүүнийг импортлох, тээвэрлэх, ашиглах үйл ажиллагааг зохицуулах тухай журам"-ыг зөрчсөн эсэхийг шалгах;
8. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 28/40/29 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам" зөрчсөн эсэхийг шалгах;
9. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, хүнс, хөдөө аж ахуй,

- хөнгөн үйлдвэрийн сайд, эрүүл мэндийн сайдын 2009 оны 63/67/87 тоот хамтарсан тушаалаар батлагдсан Монгол Улсад хэрэглэх ургамал хамгаалах химийн бодисоос бусад бодисыг турших, бүртгэх, түүнийг хэрэглэх журмыг зөрчсөн эсэхийг шалгах.
10. “Стандартчилал тохирлын үнэлгээний тухай” хуулийн 25.2.3-т заасны дагуу бүтээгдэхүүний зориулалт, чанарын төлөв байдал нь сав, баглаа, боодол, хаяг, шошго, бусад мэдээлэлтэй нийцэж байгаа эсэхийг шалгах;
 11. Засгийн газрын 2007 оны 95 дугаар тогтоолоор “Онцгой хортой химийн бодис”-ын ангилал болон “Монгол улсад ашиглахыг хориглосон, хязгаарласан бодис”-ын жагсаалтад орсон эсэхийг тогтоох;
 12. Байгаль орчны сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын асуудал эрхэлсэн сайдын хамтарсан 2007 оны 151/126/52 дугаар тушаалаар батлагдсан “Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”-ын хэрэгжилтийг хангаж буй эсэхэд анхаарах;
 13. Химийн хорт болон аюултай бодисын ашиглалт, зарцуулалтад дотоод хяналт тавиагүй зөрчлийг шалгахдаа тухайн хуулийн этгээдийн дотоод дүрэм, албан тушаалтны ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажил үүргийн хуваарь зэрэг холбогдох баримт бичгийг гаргуулан авч хэрэгт хавсаргах;
 14. Эд зүйл, баримт бичгийг хураан авах, эд хөрөнгийг битүүмжлэх, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах нь ихэвчлэн дээрх зөрчлийн улмаас хор хохирол учирсан тохиолдолд хор уршгийг арилгах, нөхөн төлүүлэх, эд мөрийн баримт авах зорилгоор прокурорын зөвшөөрөлтэй явуулна. Хураан авах, битүүмжлэх, үйл ажиллагааг түр зогсоох ажиллагааг хойшлуулшгүй тохиолдолд прокурорт мэдэгдэж түүний зөвшөөрөлгүй явуулж 24 цагийн дотор материалыг хүргүүлнэ.
 15. Тухайн зөрчилд хамаарах асуудлаар зөрчил үйлдсэн байж болзошгүй холбогдогч, зөрчлийн талаар мэдэх болсон хүнийг гэрчээр, зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор тус тус хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийн эхэнд тухайн зөрчлийн талаарх мэдүүлж буй бүх зүйлсийг үгчлэн, дэлгэрэнгүй бичих бөгөөд үүний дараа холбогдох асуудлаар тодруулан мэдүүлэг авна. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.

16. Тухайн зөрчлийн шинж, онцлогоос хамаарч зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийж ЭХХШТХ-ийн 28.1, 28.2-д заасны дагуу тэмдэглэл хөтлөн, гэрэл зураг, эсхүл дуу- дүрсний бичлэгээр бэхжүүлнэ. Үзлэгийг явцад хэрэгт ач холбогдол бүхий бүхий л нөхцөл байдлыг тодорхой тоочиж бичих, үл хөдлөх цэг авч хэмжилт хийх, GPS-ийн тусламжтайгаар байршил тодорхойлох, шаардлагатай бусад техник хэрэгсэл ашиглан, мэргэжилтэн оролцуулан явуулж болно.
17. Зөрчлийн газарт үхсэн мал амьтныг нэг бүрчлэн тоолж нэр төрлөөр тоо толгойгоор нь тэмдэглэлд тусгаж шаардлагатай бол шинжилгээнд зориулж дээж авах зорилгоор хураан авахдаа зориулалтын битүүмжлэл сайтай гялгар уутанд хийж муутгахгүй болон халдвар тараахгүйн тулд харуул хамгаалалтай байранд хөргөгч, хөлдөөгчид хийж хадгалах;

Үзлэг, шалгалтын явцад анхаарах зүйлс:

1. Зөрчлийн газарт очихоос өмнө орчны байрлалыг сайтар тодорхойлж хүн, мал, амьтан орж болох бүх чиглэлийг тогтоох, хамгийн гол нь салхины чигийг маш сайн анзаарах, аль болох өндөрлөг газарт байрлалаа эзлэх, хэргийн газарт дур мэдэн дотогш орохгүй байх;
2. Зөрчлийн газрыг хамгаалах арга хэмжээг нэн тэргүүнд авах, тархалтын хүрээг үндэслэн аюулгүй бүс гортиг татаж /хамгаалалтын тууз татах/ хүн, мал, амьтан орох, явах хөдөлгөөн хязгаарлах;
3. Биеэ хамгаалах маск, бээлий, нүдний шил хэрэглэх;
4. Арьс ил гарсан хувцас өмсөхгүй байх;
5. Элдэв нэр хаяг нь тодорхойгүй үл мэдэгдэх бодис, эд зүйлд хүрэхгүй байх;
6. Шаардлагатай бол объектын гадна болон дотор үзлэгийг онцгой байдлын албаны мэргэжилтнүүдийг оролцуулан тэдний тусламжтайгаар хийх, шинжилгээнд дээж материал авахдаа мэргэжилтнүүдээр гүйцэтгүүлэх;
7. Химийн бодисыг цэвэрлэх, тээвэрлэх, булшлах ажиллагааны үед хэрэглэж байсан тоног төхөөрөмж, машин, механизм зэргийг халдваргүйжүүлэх ажиллагааг холбогдох байгууллагын тусламжтайгаар хийж гүйцэтгэж тэдгээрийг аюулгүй газарт байршуулах арга хэмжээг авах;
8. Зөрчлийн газрын үзлэг явуулж дууссаны дараа ойр орчмын айлууд уг хэргийн улмаас нөлөөлөлд орж болзошгүй байдлыг анхаарч тухайн үед байсан айл өрхийн тоо, байнга болон түр оршин суугчдын тоог баг хорооны засаг даргатай хамтран гаргах, хяналт тавих;

Химийн бодистой холбоотойгоор гарч буй нийтлэг зөрчил

1. Онцгой хортой химийн бодис мөнгөн ус, цианит натрийг зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр импортлох, ашиглах,
2. Химийн хорт болон аюултай бодисыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах журмыг зөрчих,
3. Химийн бодисын эрсдэлийн үнэлгээг хийлгэдэггүй, дотоодын хяналтыг хангалтгүй зохион байгуулах,
4. Монгол улсад ашиглахыг хязгаарласан цианит натри зэрэг онцгой хортой химийн бодисыг ашиглан үйлдвэрлэл явуулж буй зарим аж ахуйн нэгж байгууллага шаардлага хангахааргүй техник, технологиор үйлдвэрлэл явуулж байгаагаас хүн, малын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх,
5. Аливаа төслийн техник, эдийн засгийн үндэслэл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээнд химийн процессын механизм, түүнд оролцох бодисуудын тооцоог нарийвчлан тусгахгүй байх,
6. Баяжуулах үйлдвэр, түүний байгууламжууд, хаягдлын сан болон хамгаалалтын даланг зураг төслийн дагуу, шаардлагын түвшинд хүртэл хийдэггүй зэрэг зөрчлүүд нийтлэг илэрч байна.

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ -1

Улсын байцаагч Э нь Химийн хорт болон аюултай бодисын хуульд заасан зохих зөвшөөрлийг авсан “ХХХ” компанийн аймгийн сумын нэртэй газар орших ашигт малтмалын олборлолт, баяжуулалт явуулж байгаа уурхайн үйл ажиллагаа нь Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн төлөвлөгөөт шалгалтын удирдамжийн дагуу ажиллаж байтал “Химийн аюултай бодис болох хугацаа дууссан аммонитыг усанд уусган устгах явцад журам, аюулгүй ажиллагааны дүрэм, технологийн горимыг зөрчсөн үйлдлийн улмаас устгалтын талбай дахь усан сан руу үхэр орж ус уух явцад нутгийн малчин Д-гийн 28 үхэр хордож үхсэн тухай” зөрчлийг илрүүлсэн байна. Энэ тохиолдолд зөвхөн тухайн илэрсэн зөрчилтэй холбогдуулан зөрчлийн хэрэг нээж энэ тухай удирдах албан тушаалтан болон прокурорт мэдэгдэж бүртгэлд оруулах ба тухайн газарт үзлэг хийх, шинжилгээнд зориулан дээж авах, шинжилгээ томилон зөрчлийн нөхцөлд байдалд тохирсон асуултыг сонгож оруулах /үелэх системийн ямар элемент, химийн ямар найрлага, бүтэц, нэгдэл тодорхойлуулах гэж буйгаа нэр зааж тодорхой оруулах, шинжээчийн ажилд дөхөм болох эд мөрийн баримтаар хураан авсан хаяг, шошго, сав, баглаа боодол гэх мэтийг хүргүүлэх/, холбогдогч, гэрч, хохирогчоос мэдүүлэг авах, шаардлагатай

бичиг баримтыг шаардан гаргуулах зэрэг бие даан шийдвэрлэх ажиллагаа явуулахын зэрэгцээ эд зүйл хураан авах, битүүмжлэх зэрэг хойшлуулшгүй тохиолдолд прокурорын зөвшөөрөлгүй явуулах ажиллагаануудыг тухайн газар дээр нь хийж хэрэгжүүлэх зэргээр Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан ажиллагааг явуулна. Анхаарах зүйл: Мал, амьтнаас дээж авах үйл ажиллагааг чанартай гүйцэтгэх, үндсэн болон хяналтын дээжүүдийг авах, дээжүүдийг сайтар битүүмжлэх, муутгахгүйгээр хөргөлтийн нөхцөлд хадгалж тээвэрлэн лабораторид хүргэх явдал чухал юм. Мал амьтан хордсон асуудлаар хэвлэл мэдээллээр гарч улмаар сүр хүчийг үзүүлэн ирсэн ажлын хэсгүүд нь бушуухан булж, шатааж, халдваргүйжүүлэхийг урьтал болгохоос биш авсан биологийн дээжүүд лабораторийн шаардлага хангахгүй болж дахин дээж авах, тодорхой хэргийн нотлох баримтыг устгаж байгаа талаараа ойлголтгүй байдаг.

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ-2

Улсын байцаагч Д нь нөхөрлөлийн аймгийн сумын төвд орших бичил уурхайгаар ашигт малтмалын олборлолт, баяжуулалт явуулж байгаа уурхайн объект нь Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль *тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн* төлөвлөгөөт бус шалгалтын удирдамжийн дагуу ажиллав. Нөхөрлөлийн удирдлагаас “азотын хэт ислийн тусламжтайгаар алтыг ялган баяжуулдаг” гэх тайлбар өгч үйлдвэрлэлийн дамжлага цехүүдийн үйл ажиллагааг танилцуулав. Эцсийн дамжлага болох шатаах зуух бүхий лабораторийг үзэх явцдаа дотор агаарт хяналт хийж явуулын зориулалттай, мөнгөн ус тодорхойлогч “люмикс” нэртэй төхөөрөмжөөр шалгахад мөнгөн усны агууламж /Hg/ өндөр гарсан байна. Улмаар шатаах аяга, хаягдал шламыг дээрх төхөөрөмжөөр шалгахад мөнгөн ус зөвшөөрөгдөх хэмжээнээс 350-500 дахин өндөр хэмжээнд илэрсэн тул цаашид үйлдвэрлэлийн дамжлагуудыг шалгах явцад 1 литрийн шилэн савтай 3.8 кг жинтэй мөнгөн ус мэт хүнд, шингэн зүйлийг олж илрүүлсэн байна. Энэ тохиолдолд улсын байцаагч Д нь *Эрүүгийн хуулийн 24.3 дугаар зүйлд заасан “Химийн хорт, аюултай бодисыг хууль бус эргэлтэд оруулах”* гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэж удирдах албан тушаалтан болон прокурорт даруй мэдэгдэж, шалгалтын явцад авагдсан холбогдох баримт материалын хамт прокурорт шилжүүлнэ. Мөнгөн ус мэт зүйлийн илэрч олдсон байдал зэргийг гэрэл зураг, дүрс бичлэг зэрэг боломжит хэлбэрээр бэхжүүлж хадгалалтын горимын дагуу хадгалах арга хэмжээ авна. Эрүүгийн хэрэг шалгах ажиллагаанд гэрчийн хувьд оролцож мэдүүлэг өгнө.

3.2 Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 5.12 дугаар зүйлд дараах байдлаар заасан.
Үүнд:

1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай мэдээ, тайланг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлээгүй, эсхүл зориуд буруу мэдээлсэн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг эзэмших эрх бүхий этгээд:
 - 2.1. түүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага;
 - 2.2. тэсэлгээний ажил явуулах, үйлчилгээ үзүүлэх журам;
 - 2.3. аюулгүй байдлын бүсийн дэглэм, журам зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мэргэжлийн нэршил, холбогдох хууль тогтоомж:

“**тэсэрч дэлбэрэх бодис**” гэж тэсэлгээний хэрэгсэл, гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцыг хэлнэ.

“**тэсэлгээний хэрэгсэл**” гэж тэсэрч дэлбэрэх бодисын тэсрэлтийг үүсгэх зориулалттай цэнэг агуулсан өдөөгч хэрэгслийг хэлнэ.

“**пиротехникийн хэрэгсэл**” гэж хурц гэрэл гэгээ цацруулдаг буюу чанга дуу чимээ үүсгэдэг баяр ёслол, үзвэр, цэнгээний зориулалтаар ашиглагдах хэрэгслийг хэлнэ.

“**тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлт**” гэж тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагааг хэлдэг. Тэсэрч дэлбэрэх бодис ашиглах тэсэлгээ явуулах тусгай зөвшөөрлийг Төрийн захиргааны төв байгууллага буй яамнаас олгодог.



Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нийцүүлэн гарсан дараах дүрэм, журам байдаг. Үүнд:

- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам,

Дээрхи хууль, дүрэм, журамыг дараах хаягнаас татан авч үзэж болно.

- <http://legalinfo.mn/law/details/9057?lawid=9057>
- http://mram.gov.mn/mram_new/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=13&Itemid=33&lang=mn

Зүйлчлэлийн асуудал

“Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих” зөрчлийн шинж нь: 1/Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай мэдээ, тайланг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлээгүй, эсхүл зориуд буруу мэдээлсэн; 2/Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг эзэмших эрх бүхий этгээд нь түүнийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага зөрчсөн; 3/Тэсэлгээний ажил явуулах, үйлчилгээ үзүүлэх журам зөрчсөн; 4/

Аюулгүй байдлын бүсийн дэглэм, журам зөрчсөн; тТэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан зэргээр илэрдэг.

Эрүүгийн хуулийн 20.4 дүгээр зүйлд заасан “Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хууль бусаар эзэмших” гэмт хэрэг нь байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар олж авсан, шилжүүлсэн, борлуулсан, тээвэрлэсэн, хадгалсан;

20.5 дугаар зүйлд заасан “Галт зэвсэг хууль бусаар бэлтгэх” гэмт хэрэг нь галт зэвсэг, түүний бүрдэл хэсгийг хууль бусаар бэлтгэсэн, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хууль бусаар бэлтгэсэн;

20.6 дугаар зүйлд заасан “Галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис хамгаалахад хайнга хандах” гэмт хэрэг нь байлдааны, хууль сахиулах зориулалттай галт зэвсэг, галт хэрэгсэл, тэсэрч дэлбэрэх бодис, дэлбэлэгч төхөөрөмжийг хадгалах, хамгаалах үүргээ зохих ёсоор биелүүлээгүйн улмаас их хэмжээний хохирол учруулсан зэрэг үйлдлүүд нь

зөрчлөөс ялгагдах шинж бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дээрх шинж илэрвэл даруй прокурорт мэдэгдэж, холбогдох материалын хамт хүргүүлнэ.

Зөрчлийн хувьд тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг эзэмших “эрх бүхий этгээд” субъект болдог бол гэмт хэргийн хувьд ямар нэг “эрхгүй этгээд”, субъект болдгоороо ялгаатай юм.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

ЗТХ-ийн 5.12 дугаар зүйл. “Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль зөрчих” зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн тухай мэдээ, тайланг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд ирүүлээгүй, эсхүл зориуд буруу мэдээлсэн үйлдлийг лавлагаа, мэдүүлгийн үндсэн дээр нотлох; Тухайн хуулийн этгээдийн дотоод дүрэм, албан тушаалтны ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажил үүргийн хуваарь зэрэг холбогдох баримт бичгийг гаргуулан авч хэрэгт хавсаргана.
2. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг эзэмших эрх бүхий этгээд нь түүнийг 1/ үйлдвэрлэх, импортлох, экспортлох, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, аюулгүй байдлыг хангахад тавигдах шаардлага, 2/ тэсэлгээний ажил явуулах, үйлчилгээ үзүүлэх

- журам, 3/ аюулгүй байдлын бүсийн дэглэм, журам зэрэг тухайн зөрчлийн онцлогт тохирох эрх зүйн актыг олж судлан, хэрэгт хавсаргах;
3. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан үйлдлийг шалгахдаа орон байранд үзлэг хийх, интернет орчин болон бусад мэдээлэл тээгчид үзлэг хийх, бичлэгийг эд мөрийн баримтаар хураан авах ажиллагаа хийнэ. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл гэж Зар сурталчилгааны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.5-д заасныг ойлгоно.
 4. Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн нэршил, төрөл, үйлчилгээ зэргийг тогтоохын тулд холбогдох аргачлалын дагуу дээж авч шинжилгээ хийлгэх тогтоол бичиж шинжлүүлэн /ЗШШТХ 4.11.4.Тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн эрх бүхий албан тушаалтан өөрөө бие даан шинжилгээ хийж болно./ холбогдох дүгнэлтийг авч хэрэгт хавсаргана. ЭХХШТХ-ийн 27 дугаар бүлэгт зааснаар шинжилгээ хийлгэх ажиллагаа явагдана.
 5. Тухайн зөрчлийн шинж, онцлогоос хамаарч зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийж ЭХХШТХ-ийн 28.1, 28.2-д заасны дагуу тэмдэглэл хөтлөн, гэрэл зураг, эсхүл дуу- дүрсний бичлэгээр бэхжүүлнэ. Үзлэгийг явцад хэрэгт ач холбогдол бүхий бүхий л нөхцөл байдлыг тодорхой тоочиж бичих, үл хөдлөх цэг авч хэмжилт хийх, GPS-ийн тусламжтайгаар байршил тодорхойлох, шаардлагатай бусад техник хэрэгсэл ашиглан, мэргэжилтэн оролцуулан явуулж болно.
 6. Тухайн зөрчилд хамаарах асуудлаар зөрчил үйлдсэн байж болзошгүй холбогдогч, зөрчлийн талаар мэдэх болсон хүнийг гэрчээр, зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор тус тус хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийн эхэнд тухайн зөрчлийн талаарх мэдүүлж буй бүх зүйлсийг үгчлэн, дэлгэрэнгүй бичих бөгөөд үүний дараа холбогдох асуудлаар тодруулан мэдүүлэг авна. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ

Улсын байцаагч Б нь компанийн аймгийн сумын нэртэй газар орших алтны үндсэн ордын олборлолт явуулж байгаа уурхайн үйл ажиллагаа нь Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг дүгнэхэд чиглэсэн төлөвлөгөөт шалгалтын удирдамжийн дагуу

ажиллаж байтал “Үндсэн ордын тэсэлгээний зориулалтаар ашигладаг нэр бүхий бодисын тоо нь өмнө ирүүлж байсан мэдээнээс дутаж байгааг тогтоосон бөгөөд, тэсрэх бодисын агуулах дотроос “...” компанийн зарлагын баримтаар нэр бүхий 150 ширхэг тэслэх бодисыг бичил уурхайгаар алт олборлогч “нөхөрлөлд 15 сая төгрөгөөр зарсан тухай” үйлдэл илэрсэн байна. Энэ тохиолдолд улсын байцаагч Б нь гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй гэж үзэж удирдах албан тушаалтан болон прокурорт даруй мэдэгдэж, шалгалтын явцад авагдсан холбогдох баримт материалын хамт прокурорт шилжүүлнэ.

3.3 Аюулгүй ажиллагааны журам зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 5.15-д дараах байдлаар заасан. Үүнд:

1. Техник ашиглалт, аюулгүй ажиллагааны журмыг:
 - 1.1. Түлш, эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэх;
 - 1.2. Ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах;
 - 1.3. Зуух, даралтат сав, өргөх, тээвэрлэх механизмыг ашиглах;
 - 1.4. Уул уурхайн, барилгын ажил, тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй бусад ажлыг гүйцэтгэх явцад зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй үйлчлэх, хорт бодисыг:
 - 2.1. Бүртгэх;
 - 2.2. Хадгалах;
 - 2.3. Ашиглах;
 - 2.4. Тээвэрлэх;
 - 2.5. Илгээх;
 - 2.6. Борлуулах;
 - 2.7. Олж авах;
 - 2.8. Бэлтгэх журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мэргэжлийн нэршил, холбогдох хууль тогтоомж:

“тэсэрч дэлбэрэх бодис” гэж тэсэлгээний хэрэгсэл, гадны үйлчлэлийн нөлөөгөөр агшин зуурын хугацаанд химийн урвалд орж, өндөр даралт үүсгэн дулаан ялгаруулах химийн нэгдэл буюу механик хольцыг хэлнэ.

“тэсэлгээний хэрэгсэл” гэж тэсэрч дэлбэрэх бодисын тэсрэлтийг үүсгэх

зориулалттай цэнэг агуулсан өдөөгч хэрэгслийг хэлнэ.

“пиротехникийн хэрэгсэл” гэж хурц гэрэл гэгээ цацруулдаг буюу чанга дуу чимээ үүсгэдэг баяр ёслол, үзвэр, цэнгээний зориулалтаар ашиглагдах хэрэгслийг хэлнэ.

“тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлт” гэж тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, экспортлох, худалдах, тээвэрлэх, хадгалах, ашиглах, устгах үйл ажиллагааг хэлдэг. Тэсэрч дэлбэрэх бодис ашиглах тэсэлгээ явуулах тусгай зөвшөөрлийг Төрийн захиргааны төв байгууллага буй яамнаас олгодог.

Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуульд нийцүүлэн гарсан дараах дүрэм, журам байдаг. Үүнд:

- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам,

Дээрх хууль, дүрэм, журмыг дараах хаягнаас татан авч үзэж болно.

- <http://legalinfo.mn/law/details/9057?lawid=9057>
- <http://mram.gov.mn/>

“Аюулгүй ажиллагааны журам зөрчсөн” гэж уулын болон уурхайн, барилгын, түүнчлэн үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллагад тэсэрч дэлбэрэх аюултай үйл ажиллагааг гүйцэтгэх явцад заавал дагаж мөрдвөл зохих хууль тогтоомжийг огт хэрэгжүүлээгүй эсхүл зохих ёсоор биелүүлээгүйг хэлнэ.

Зүйлчлэлийн асуудал

“Аюулгүй ажиллагааны журам зөрчих” зөрчлийн шинж нь:

Техник ашиглалт, аюулгүй ажиллагааны журмыг: 1/ түлш, эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэх; 2/ ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах; 3/ зуух, даралтат сав, өргөх, тээвэрлэх механизмыг ашиглах; 4/ уул уурхайн, барилгын ажил, тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй бусад ажлыг гүйцэтгэх явцад зөрчсөн 5/тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй үйлчлэх, хорт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх, борлуулах, олж авах, бэлтгэх журам зөрчсөн шинжтэй байдаг.

Эрүүгийн хуулийн 27.9 дүгээр зүйлд “Замын байгууламжийн ашиглалт, засварын аюулгүй байдлын журам зөрчих”, 27.10 дугаар зүйлд “Автотээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих” зэрэг гэмт хэргийг объектын хувьд зөрчлөөс ялгаж заасан шинжтэй байна.

Дээрх зөрчлийг шалган шийдвэрлэх явцад тухайн албан тушаалтан,

хүн, хуулийн этгээд нь “Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, хэлцлээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, эсхүл бусад болгоомжгүй үйлдэл, эс үйлдэхүйн улмаас хүний ам насыг болгоомжгүй хохироосон, хүний эрүүл мэндэд хүнд, хүндэвтэр хохирол учруулсан” гэмт хэргийн шинжтэй нөхцөл байдал илэрвэл /Эрүүгийн хуулийн 10, 11-р бүлгийн зүйл хэсэгт заасан/ даруй прокурорт мэдэгдэж, холбогдох материалын хамт хүргүүлнэ.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

ЗТХ-ийн 5.15 дугаар зүйл. “Аюулгүй ажиллагааны журам зөрчих” зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. түлш, эрчим хүч үйлдвэрлэх, хэрэглэх; 2/ ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах; 3/ зуух, даралтат сав, өргөх, тээвэрлэх механизмыг ашиглах; 4/ уул уурхайн, барилгын ажил, тэсэрч дэлбэрэх аюул гарч болзошгүй бусад ажлыг гүйцэтгэх “Техник ашиглалт, аюулгүй ажиллагааны журам”, “Тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй үйлчлэх, хорт бодисыг бүртгэх, хадгалах, ашиглах, тээвэрлэх, илгээх, борлуулах, олж авах, бэлтгэх журам” зэрэг тухайн зөрчлийн онцлогт тохирох эрх зүйн актыг олж судлан, хэрэгт хавсаргана.
2. Дээрх журмуудыг зөрчсөн үйлдлийг тогтоохдоо эрх бүхий этгээд эсэхийг холбогдох байгууллагаас лавлагаа авах, хариуцсан албан тушаалтан болон зөрчлийн үед байсан хүмүүсийн бүртгэл, тэмдэглэл, зааварчилга, тухайн хуулийн этгээдийн дотоод дүрэм, албан тушаалтны ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажил үүргийн хуваарь зэрэг холбогдох баримт бичгийг гаргуулан авч хэрэгт хавсаргана.
3. Зөрчил үйлдэгдсэн газар, эд зүйлд эзэмшигчийг байлцуулан үзлэг хийх, тухайн газарт хяналтын камер байдаг эсэхийг шалгаж зөрчил үйлдэгдэх үеийн гэрэл зураг, дуу-дүрсний бичлэгийг олж эд мөрийн баримтаар хураан авах ажиллагаа хийнэ.
4. “Тэсэрч дэлбэрэх, цацраг идэвхт, хүчтэй үйлчлэх, хорт бодисыг дэлбэрэх бодис”-ын нэршил, төрөл, үйлчилгээ, хоруу чанар зэргийг тогтоохын тулд холбогдох аргачлалын дагуу дээж авч шинжилгээ хийлгэх тогтоол бичиж шинжлүүлэн /ЗШШТХ 4.11.4. Тусгай мэдлэг, мэргэжил эзэмшсэн эрх бүхий албан тушаалтан өөрөө бие даан шинжилгээ хийж болно./ холбогдох дүгнэлтийг авч хэрэгт хавсаргана. ЭХХШТХ-ийн 27 дугаар бүлэгт зааснаар шинжилгээ хийлгэх ажиллагаа явагдана.
5. Тухайн зөрчлийн шинж, онцлогоос хамаарч зөрчил үйлдэгдсэн газар, хүн, хуулийн этгээдийн эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн

хэрэгсэл, хүний бие, эд зүйлд үзлэг хийж ЭХХШТХ-ийн 28.1, 28.2-д заасны дагуу тэмдэглэл хөтлөн, гэрэл зураг, эсхүл дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлнэ. Үзлэгийг явцад хэрэгт ач холбогдол бүхий бүхий л нөхцөл байдлыг тодорхой тоочиж бичих, үл хөдлөх цэг авч хэмжилт хийх, GPS-ийн тусламжтайгаар байршил тодорхойлох, шаардлагатай бусад техник хэрэгсэл ашиглан, мэргэжилтэн оролцуулан явуулж болно. Энэ төрлийн зөрчлийн үед байгаль орчинд бохирдол үүсгэсэн эсэх нөхцөл байдлыг сайтар тогтоох шаардлагатай тул үзлэг хийх үед анхаарч, шинжилгээнд зориулан дээж авах ажлыг оновчтой явуулах, хяналтын дээж авна.

6. Зөрчлийн улмаас бусдын эд хөрөнгөд хохирол учирсан бол хөрөнгийн үнэлгээний шинжээч, байгаль орчинд хохирол учирсан бол экологи эдийн засгийн хохирол тогтоох шинжээч нарыг томилон оролцуулж хор хохирлын дүнг эцэслэн тогтооно.
7. Тухайн зөрчилд хамаарах асуудлаар зөрчил үйлдсэн байж болзошгүй холбогдогч, зөрчлийн талаар мэдэх болсон хүнийг гэрчээр, зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор тус тус хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийн эхэнд тухайн зөрчлийн талаарх мэдүүлж буй бүх зүйлсийг үгчлэн, дэлгэрэнгүй бичих бөгөөд үүний дараа холбогдох асуудлаар тодруулан мэдүүлэг авна. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.

3.4 Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд дараах байдлаар заасан.
Үүнд:

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан бол хууль бус үйл ажиллагааг зогсоож, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадалгаагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн нь тогтоогдсон бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мэргэжлийн нэршил, холбогдох хууль тогтоомж

Энэ хуулийн **Зорилго** нь байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулахад оршино гэжээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг дараах байдлаар ангиладаг.
Үүнд:

1. Байгаль орчны стратегийн үнэлгээ /цаашид “стратегийн үнэлгээ” гэх/;
2. Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ /цаашид “төлөв байдлын үнэлгээ” гэх/;
3. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ /цаашид “нөлөөллийн үнэлгээ гэх/;

4. хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ;

“Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ” гэж иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаврыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг хэлнэ.

Нөлөөллийн үнэлгээ нь дараах үнэлгээнээс бүрдэнэ.

- байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ;
- байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ.

Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг байгалийн нөөцийг ашиглах, газрын тос болон ашигт малтмал хайх, ашиглах, аж ахуйн зориулалтаар газар эзэмших, ашиглах эрх авах болон төсөл хэрэгжүүлэхээс өмнө хийнэ.




Ерөнхий үнэлгээг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл байгаль орчны албанд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг батлуулдаг.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг тус хуулийн 12 дугаар зүйлд заасны дагуу эрх авсан дотоодын аж ахуйн нэгж гүйцэтгэх бөгөөд эрх бүхий аж ахуйн нэгж нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнгээр тайлан бэлтгэж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулна.

Нарийвчилсан үнэлгээ хийх тусгай зөвшөөрөл

Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний эрх бүхий байгууллагын зөвшөөрлийг Төрийн захиргааны төв байгууллагаас авдаг ба дараах үе шаттай байдаг. Үүнд:

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний салшгүй бүрэлдэхүүн хэсэг байна. Ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага тухайн төслийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батална.



Байгаль орчны сайдын 2014 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-05 тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах, журам”-ын дагуу хийж баталуулдаг.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний баталгаажих нүүр хуудасны загвар

Батлав. БОНХЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн газрын дарга

_____()

эсвэл (Аймаг, нийслэлийн Байгаль орчны газрын дарга)

_____()

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

_____ХХК-ийн захирал _____

_____ -ЫН

(төслийн байршил, нэр)

_____ оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Хянасан:

БОНХЯ-ны ХБОБНГ-ын мэргэжилтэн _____

эсвэл (Аймаг, нийслэлийн БОА-ны мэргэжилтэн) _____

Боловсруулсан:

_____ХХК-ийн БОХ нэгжийн дарга

20 ... он

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулга

Төслийн товч танилцуулга

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө
5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө
6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө
8. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
10. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн нүүр хуудасны жишиг загвар

_____ -ЫН
(төслийн байршил, нэр)

_____ оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хянасан:

БОНХЯ-ны ХБОБНГ-ын мэргэжилтэн _____
эсвэл(Аймаг, нийслэлийн БОГ-ын мэргэжилтэн) _____

Хэрэгжилтийг гаргасан:

_____ ХХК-ийн _____ захирал

_____ ХХК-ийн _____ БОХ _____ нэгжийн _____ дарга

20 ____ он

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайлангийн агуулга

Төслийн товч танилцуулга

Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт

1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт
3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт
6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт
7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт
8. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт
9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт
10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэх загвар

Огноо:

№	Бүрэлдэхүүн хэсгүүд	Биелэлтийн хувь	Тайлбар, үндэслэл
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт		
3	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		
4	Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		
5	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт		
6	Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт		
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт		
8	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт		
9	Олон нийтэдтайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт		
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт, үрдүнгийн хэлэлцүүлгийн тэмдэглэл		
	Дүн (арифметик дундаж)		

Тайлбар: Бүрэлдэхүүн хэсэг бүрт биелэлтээс нь хамааран 0-100%-аар тооцож үнэлгээ өгнө. Бүрэлдэхүүн хэсэг тус бүрт өгсөн үнэлгээг нэмж, арифметик дунджийг гаргана. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний бүрэлдэхүүн хэсгүүдийн биелэлтийн арифметик дундаж хувь нь 80-аас доош байвал хангалтгүй гэж үзнэ. Энэ хуудасны ард нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалал, аюултай хог хаягдал устгасан хүлээж авсан актыг хавсаргана. Орон нутгийн холбогдох тодорхойлолтууд, хуваарьт болон хуваарьт бус аудитын тайлан үүнд орно.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг хүлээж авах, дүгнэх хуудас

Огноо: Дугаар: Байршил:

Ажлын хэсгийн дарга:

_____ (аймаг, нийслэл)-ийн _____
(сум/дүүрэг)-ийн Засаг дарга _____ (эсхүл томилогдсон
албан тушаалтан)

Гишүүд:

Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч(_____)

Байгаль орчны газрын төлөөлөл (_____)

Сав газрын захиргааны төлөөлөл (_____)

Сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч(_____)

Хариуцсан хэсгийн байгаль хамгаалагч(_____)

Нөлөөллийн бүс дэх иргэдийн төлөөлөл(_____)

Газрын даамал (_____)

Хүлээн зөвшөөрсөн:

_____ ХХК-ийн захирал

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэсний үндсэн дээр төсөл хэрэгжүүлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулж байгаа болон учруулсан бол үнэлгээний үнэн зөв хийгдсэн эсэхэд хянан магадлагаа хийнэ.

Зүйлчлэлийн асуудал

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих” зөрчлийн шинж нь: 1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан, 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй, 3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй, 4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадалгаагаар байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн зэрэг шинжтэй байдаг.

Эрүүгийн хуульд дээрх зөрчилтэй шууд адилтган үзэх зүйл, заалт байхгүй тул зөрчлийн шинжээр нь нэг мөр ойлгоно. Эрүүгийн хуулийн Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргийн бүлэгт “тусгай зөвшөөрөлгүй, зохих зөвшөөрөлгүй, тодорхой эрх аваахгүй” этгээдийн үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заасан. Зөрчлийн тухай хуулийн Байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчлийн бүлэгт “хуулийн зарим гол шаардлага хангасан боловч бусад нарийвчилсан шаардлага хангаагүй” үйлдлүүдийг зөрчилд тооцон зохицуулсан байна. Тухайлбал: “тусгай зөвшөөрөлгүй” этгээд ашигт малтмалыг хайх, ашиглах, олборлох чиглэлээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулсан бол “гэмт хэрэгт” тооцсон бол “тусгай зөвшөөрөлтэй” этгээд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ашигт малтмалыг хайх, ашиглах, олборлох чиглэлээр уурхайлалтын үйл ажиллагаа явуулсан бол “зөрчилд” тооцон шалгахаар зохицуулсан байна.

Зарим тохиолдолд практикт хөдөө алслагдмал газар нутагт улсын байцаагч, уул уурхайн чиглэлээр шалгалт хийх явцад аж ахуйн нэгжийн албан тушаалтнаас “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ”, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө” зэрэг цаашид ашиглалтын үйл ажиллагааг үргэлжлүүлэх эрх олгодог бичиг баримтуудыг хуурамчаар үйлдэн /бусдын батлагдсан төлөвлөгөөний тамга тэмдэг, гарын үсэг зэргийг сканердаж өнгөтөөр хэвлэх, засварлах гэх мэт/ гаргаж үзүүлэх явдал байдаг. Энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн **23.2 дугаар зүйлд заасан “Хуурамч баримт бичиг үйлдэх, ашиглах” гэмт хэрэг гэж үзэх үндэслэлтэй.** Үүнд: “Тусгай зөвшөөрөл, эрх олгосон, үүргээс чөлөөлсөн баримт бичиг, тамга, тэмдэг, хэвлэмэл маягт эдийн, эдийн бус баялгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхийг тодорхойлсон баримт бичгийг хуурамчаар үйлдсэн, хуурамч болохыг мэдсээр байж ашигласан, худалдсан бол” эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Мөн зөрчлийн хэрэг нээж шалган шийдвэрлэх ажиллагаа явуулах явцад “Хэрэг шалган шийдвэрлэхэд ач холбогдол бүхий нотлох баримтыг зориуд устгасан, нуусан, засварласан, өөрчилсөн, хуурамчаар үйлдсэн, эсхүл нотлох баримтыг хуурамч болохыг мэдсээр байж хууль сахиулагчид ...гаргаж өгсөн бол” Эрүүгийн хуулийн **21.1 дүгээр зүйлд зааснаар “Нотлох баримтыг хуурамчаар үйлдэх, устгах” гэмт хэрэг үйлдсэнд тооцон шалгах үндэслэл болно.**

Шалган шийдвэрлэх ажиллагаа

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль зөрчих” зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэхгүйгээр, эсхүл зохих байгууллагын шийдвэр гаргуулахгүйгээр үйл ажиллагаа явуулсан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөгүй ажилласан, эсхүл уг төлөвлөгөөг хэрэгжүүлээгүй, биелэлтийг тогтоосон хугацаанд гаргаж, холбогдох газарт тайлагнаагүй, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний шинжилгээ, хянан магадалгаагаар

- байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг буруу хийсэн үйлдэл тодорхой, гэм буруугийн талаар маргаангүй бол ихэвчлэн хялбаршуулсан журмаар шийдвэрлэгдэнэ.
2. Маргаантай тохиолдолд хэрэг бүртгэлт хийж лавлагаа, мэдүүлгийн үндсэн дээр нотлох. Тухайн хуулийн этгээдийн дотоод дүрэм, албан тушаалтны ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүрэг, ажил үүргийн хуваарь зэрэг холбогдох баримт бичиг, эрх зүйн актыг олж судлан, хэрэгт хавсаргана.
 3. Үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарлагдсан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулан материалын шинж онцлогийг нарийн дурдаж тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хураан авна.
 4. Тухайн зөрчилд хамаарах асуудлаар зөрчил үйлдсэн байж болзошгүй холбогдогч, зөрчлийн талаар мэдэх болсон хүнийг гэрчээр, зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор тус тус хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийн эхэнд тухайн зөрчлийн талаарх мэдүүлж буй бүх зүйлсийг үгчлэн, дэлгэрэнгүй бичих бөгөөд үүний дараа холбогдох асуудлаар тодруулан мэдүүлэг авна. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.

3.5 Амьтны тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлд дараах байдлаар заасан.

Үүнд:

1. Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг:
 - 1.1. ашигласан;
 - 1.2. барьсан;
 - 1.3. агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө,

орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мэргэжлийн нэршил, холбогдох хууль тогтоомж:

Энэ хуулийн **зорилго** нь мал, гэрийн тэжээвэр амьтнаас бусад амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, түүний нөөцийг зохистой ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино гэжээ.

“**амьтан**” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавьж, зөөлөн биетэн, эгэл биетнийг хэлнэ.

“**нэн ховор амьтан**” гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг хэлнэ.

“**ховор амьтан**” гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг хэлнэ.

“**агнуурын амьтан**” гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг хэлнэ.

“**агнуурын нөөц**” гэж хэвийн өсөлт, үржилтийг нь алдагдуулахгүй агнах, барих боломжтой агнуурын амьтны тоо, хэмжээг хэлнэ.

“**агнуурын бүс нутаг**” гэж агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий амьтны байршил, тархац нутгийг хэлнэ.

“**Ан агнуурын менежментийн төлөвлөгөө**” гэж тухайн нутаг вэсгэрийн нэгж дэх агнуурын ан амьтны хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхээр ан агнуурын арга хэмжээг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг хэлнэ.

“**Агнах, барихыг түр хориглосон ан амьтан**” гэж хуулиар агнах, барихыг хориглоогүй ч тархац, нөөц, хэвийн өсөж үржих, амьдрах орчин нөхцөл нь хомсдсон, муудсан, доройтсоны улмаас эрх бүхий байгууллагаас агнах, барихыг нь тодорхой хугацаагаар хориглосон ан амьтныг хэлнэ.

“Ан агнуур” гэж ангийн гаралтай түүхий эд ашиглах зорилгоор хуулиар заасан хугацаа, арга, хэрэгсэл, зөвшөөрлийн дагуу агнуурын амьтныг агнах, барих үйл ажиллагааг хэлнэ.

“Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж тухайн зүйл амьтны амьдрах орчин болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдолоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон амьтны мөнгөн үнэлгээг хэлнэ.


Амьтныг дор дурдсан хэлбэрээр хамгаална. Үүнд:

1. Амьтныг ашиглахад хорио, хязгаарлалт тогтоох,
2. Нэн ховор, ховор амьтныг олон улсын болон Монгол Улсын “Улаан ном”, бусад холбогдох гэрээ, конвенцийн хавсралтад тбүртгэх,
3. Амьтны хэвийн өсөлт үржилтийг хадгалах, тархац нутгийг хамгаалах, нүүдлийн замыг чөлөөтэй байлгах,
4. Амьтныг удмын санг хамгаалах, үр хөврөлийг хадгалах,
5. Амьтны нөөц тогтоож, ашиглалтыг зохицуулах
6. Амьтныг сэргээн нутагшуулах,
7. Үйлдвэрлэл, аж ахуйн үйл ажиллагааны явцад амьтан устахаас урьдчилан сэргийлэх,
8. Биотехникийн арга хэмжээ авч хэрэгжүүлэх,
9. Өвчилсөн, байгалийн гамшиг болон бусад аюулд нэрвэгдсэн амьтан тусламж үзүүлэх, авран хамгаалах,
10. Амьтныг хамгаалах арга хэмжээний үндэслэлийг гаргахад чиглэгдсэн эрдэм шинжилгээний ажил гүйцэтгэх,
11. Иргэдийг амьтанд энэрэнгүй ханддаг үзлээр хүмүүжүүлэх, амьтныг хамгаалах талаар олон нийтийн мэдээллийн хэрэгсэлээр сурталчлах.

Нэн ховор амьтныг БОАЖЯ-ны тусгай зөвшөөрлөөр зөвхөн судалгаа, шинжилгээний зориулалтаар агнаж, барьж болох ба бусад зориулалтаар нэн ховор амьтныг агнаж бэлтгэсэн арьс, яс, бусад түүхий эдийг худалдах, худалдан авахыг хориглоно. БОАЖЯ-наас ологсон тусгай зөвшөөрлөөр ховор амьтныг дараах тохиолдолд агнаж, барьж болно. Үүнд:

1. Судалгаа, шинжилгээ, соёл, урлаг, эмчилгээний зориулалтаар,
2. Монгол Улсын болон гадаадын иргэн тусгай төлбөр төлсөн,
3. Тодорхой нутаг дэвсгэрт амьтны сүргийн бүтцийг зохицуулах болон халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор.

Ховор амьтны жагсаалт, ховор амьтныг агнах, барих зөвшөөрөл олгох журмыг Засгийн газар батална. Ан амьтан агнах, барихад олгох зөвшөөрөл нь дараах үе шаттай байдаг.



Иргэн, хуулийн этгээд нэн ховроос бусад амьтныг хамгаалах, өсгөн үржүүлэх, ашиглах зорилгоор тодорхой нөхцөл, болзол бүхий гэрээний үндсэн дээр эзэмшүүлж болно. Амьтныг эзэмшүүлэх журамыг Засаг дарга тогтоож, аймаг, сумдын Ирэгдийн төлөөлөгчдийн хурал шийдвэрлэнэ. Гэмтээлгүйгээр хууль болон гэрээнд заасны дагуу амьтны аль нэг ашигтай шинж чанарыг ашиглах үйл ажиллагааг амьтныг ашиглах гэнэ.

Амьтны дор дурдсан хэлбэрээр ашиглаж болно. Үүнд:

1. Эрдэм шинжилгээний ажил, соёл урлаг, гоо зүйн зориулалтаар ашиглах,
2. Хөрс бүрдүүлэх, байгалийг ариутгах, ургамалд тоос хүртээх зэрэг амьдралын үйл ажиллагааны хэрэгтэй чанарыг ашиглах,
3. Амьдралын үйл ажиллагааны бүтээгдэхүүнийг авах зорилгоор ашиглах.

Амьтныг ашиглах бусад хэлбэрийг БОАЖЯ тогтооно. Ан амьтны амьдрах орчинд нөлөөлөхгүйгээр ашиглах зөвшөөрлийг сум, дүүргийн Засаг дарга олгоно. Жишээлбэл: Амьдралын үйл ажиллагааны бүтээгдэхүүн /зөгийн бал, лав, бугын цусан эвэр, хүдрийн заар зэрэг/-ийг авах зорилгоор амьтныг ашиглахдаа эрүүл мэндэд нь хор хохирол учруулахгүй, тамлан зовоохгүй, тэдгээрийн амьдрах орчныг алдагдуулахгүйгээр гүйцэтгэнэ.




Ховор амьтныг тэжээврээр үржүүлэх, эмийн болон бусад түүхий эд бэлтгэх зориулалтаар ашиглахыг төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэнэ. Амьтны экологи-эдийн засгийн үнэлгээг БОАЖЯ-ны саналыг үндэслэн ЗГ тогтооно. Тусгай төлбөр төлсөн иргэнд зориулалтаар агнуурын амьтан агнах, барих тусгай зөвшөөрлийг БОАЖЯ олгоно.

Агнуурын амьтныг тусгай зориулалтаар агнах, барих тусгай зөвшөөрөл нь дараах төрөлтэй байна. Үүнд:

1. Агнуурын амьтныг эрдэм шинжилгээ, соёл урлаг, эмчилгээний зориулалтаар,
2. Иргэн спорт агнуур болон олзворын ангийн чиглэлээр,
3. Нутаг дэвсгэрт агнуурын амьтны сүргийн бүтцийг зохицуулах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх зорилгоор гэх мэт.

Амьтны мэдээллийн санг тухай шатны Засаг дарга тогтоосон хугацаанд бүрдүүлнэ. Нэн ховор амьтныг амьдаар нь гадаад улсад гаргах зөвшөөрлийг Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний дагуу Засаг дарга олгоно. Бусад амьтныг амьдаар нь, мөн амьтны гаралтай түүхий эд, судалганы ажлын сорьц дээжийг гадаад улсад гаргах журамыг БОАЖЯ батална.



Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Ministry of Nature, Environment and Tourism of Mongolia

АН АГНАХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
SPECIAL HUNTING PERMIT

Зуучлагч компани /Company/.....

Ангийн нүүс /Outfitters/.....

Агчны нэр/Name of hunter/.....

Улс/Country/.....

Агнах ангийн нэр, тоо /Game animal, quantity/.....

Хүчинтэй хугацаа/Valid until/.....

Аймаг/Province/.....

Сум/Soum/.....


Отгор/Nunting camp/.....


Олгосон /Issued date/.....
оны сарын

Тамга/stamp/.....

Гарын үсэг /Signature/.....

Зөвшөөрөл олгосон /Permission issued by/.....





Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам
Ministry of Nature, Environment and Tourism of Mongolia

ЗАГАС БАРИХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
SPECIAL FISHING PERMIT

Зуучлагч компани /Company/.....

Ангийн нүүс /Outfitters/.....

Загасчны нэр/Name of angler/.....

Улс/Country/.....

Барих загасны нэр, тоо /Fish species, quantity/.....

Загасчлах хугацаа/Fishing period/.....

Аймаг/Province/.....

Сум/Soum/.....

Загасчлах гол, отгор/Fishing camp/River/.....

Олгосон /Issued date/.....
оны сарын

Тамга/stamp/.....

Гарын үсэг /Signature/.....

Зөвшөөрөл олгосон /Permission issued by/.....

Note: According to the Ministerial Order, # 79 in 2008, it is prohibited to use multi-barbed hook for catching rare fish species of fish and you must release them once you have caught. You must be aware of the Tariman (one of the rare fish).

Ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн гаралтай эд зүйлийн гадаад худалдааг зохицуулах асуудал:

Хуулийн зорилго нь зэрлэг амьтан ба ургамлын аймгийн ховордсон зүйлийг олон улсын хэмжээнд худалдаалах тухай Конвенцийн хавсралтад орсон зэрлэг амьтан, ургамлын аймгийн ховордсон амьтан, ургамал, тэдгээрийн түүхий эдийг гадаадад худалдаалах зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулна гэжээ. Конвенцийг хэрэгжүүлэх үүрэг бүхий орон тооны бус удирдах зөвлөл, мөн шинжлэх ухааны зөвлөл БОАЖЯ-ны дэргэд тус тус ажиллана. Энэ зөвлөлүүдийн ажиллах журам, тэнд ажиллах боловсон хүчнийг БОАЖЯ-ны сайд батлах ба эдгээр зөвлөлийн бүрэлдэхүүнд байгаль орчин, үйлдвэр, худалдаа, хүнс, хөдөө аж ахуйн төв байгууллагууд, гааль, мэргэжлийн хяналт мөн байгаль орчны чиглэлийн төрийн бус байгууллагын төлөөлөлтэй байна.

Зөвлөлөөс олгосон зөвшөөрөл, гэрчилгээ нь олгогдсон өдрөөс хойш 6 сарын дотор хүчинтэй байх ба эдгээрийг бусдад шилжүүлэх хориотой. Конвенц,

түүний хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрөх, эс зөвшөөрөх санал тайлбараа боловсруулж 14 хоногийн дотор ЗГ-т уламжилна. Уг асуудлыг 30 хоногийн дотор ЗГ хэлэлцээд УИХ-д өргөн мэдүүлнэ. УИХ-ын байнгын хороотой ЗГ зөвшилцөн конвенцийн нарийн бичгийн дарга нарын газарт мэдэгдэх үүрэгтэй.

“амьтан” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга буюу түр нутагшсан хөхтөн, шувуу, мөлхөгч, хоёр нутагтан, загас, хавч хэлбэртэн, шавьж, зөөлөн биетэн, эгэл биетэн хамаарна.

“нэн ховор амьтан” гэж тархац нутагтаа бүхэлдээ, эсхүл ихэнх хэсэгт тоо толгой эрс цөөрсөн, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон амьтныг хэлнэ.

“ховор амьтан” гэж тархац нутагтаа тоо толгой цөөрсөн, нөөц багатай, устаж болзошгүй амьтныг хэлнэ.

“байгалийн ургамал” гэж хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл ургамлыг;

“байгалийн ургамлын нөөц” гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг дахь нийт хэмжээг;

“харь ургамал” гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа зүйл ургамлыг. Ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан дараахь байдлаар ангилна: Үүнд: 1) нэн ховор; 2) ховор; 3) элбэг.

Нэн ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон ургамал хамаардаг. Ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй ургамал хамаарна. Ховор ургамлын жагсаалтыг Засгийн газар баталдаг.

Ан, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, зүйлийг ГАДААД ГАРГАХ зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт:

1. Албан хүсэлт
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Тухайн аж ахуйн нэгжид үйлдвэрлэлийн зориулалтаар загас агнах эрх олгосон аймгийн Засаг даргын захирамж
4. Тухайн аж ахуйн нэгж, сумын Засаг даргын хооронд үйлдвэрлэлийн зориулалтаар загас агнахаар байгуулсан гэрээний хуулбар
5. Үйлдвэрлэлийн зориулалтаар загас агнах төлбөр төлсөн тухай баримт
6. Үйлдвэрлэлийн зориулалтаар загас агнасан тухай сумын БОХУБ-ын тодорхойлолт
7. Тухайн аж ахуйн нэгжийн загас экспортлох тухай албан хүсэлт
8. Худалдан авагч эсвэл хүлээн авагч талтай байгуулсан гэрээний хуулбар
9. Тэмдэгтийн хураамж, гэрчилгээний үнэ гэх мэт...

Ургамал, тэдгээрийн гаралтай түүхий эд зүйл, ойн дагалт баялгийг гадаадад гаргах зөвшөөрөл олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт:

1. Албан хүсэлт
2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
3. Худалдан авагч, эсвэл хүлээн авагч талтай байгуулсан гэрээ
4. Худалдаалах зориулалтаар гадаадад гаргах бол өмнө нь БОАЖЯ-наас олгосон Байгалийн ургамал, ойн дагалт баялаг тэдгээрийн гаралтай түүхий эдийг бэлтгэх зөвшөөрөл
5. CITES-ийн экспорт, импортын мэдэгдэл гэрчилгээ
6. Тухайн орны нутгаас олгосон гарал үүслийн тодорхойлолт
7. Ургамал ашигласны төлбөр төлсөн баримт
8. Тэмдэгтийн хураамж, гэрчилгээний үнэ гэх мэт...

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2016 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн
А/27 тоот тушаалын 1 дүгээр хэсэгт

МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ
ТҮҮХИЙ ЭД, ЗҮЙЛИЙГ ГАДААДАД ГАРГАХ
ЗӨВШӨӨРӨЛ

№
Улаанбаатар хот

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

1. Иргэн, байгууллагын нэр, регистрийн дугаар
2. Иргэн, байгууллагын хаяг, утас /факс/-ны дугаар
3. Мэргэжлийн байгууллагын гэрчилгээний дугаар
4. Экспортлох улсын нэр
5. Худалдан /хүлээн/ авагчийн нэр
6. Түүхий эдийн нэр /олон улсын нэршил/
7. Тоо хэмжээ /тоо, үсгээр/
8. Техникийн болон тээвэрлэх нөхцөл
9. Гаргах боомтын нэр
10. Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа
11. Зөвшөөрөл олгосон:

Эрх бүхий албан тушаалтан /нэр, гарын үсэг, тамга/ 1.....
2.....

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2016 оны 09 дугаар сарын 01-ний өдрийн
А/27 тоот тушаалын 2 дугаар хэсэгт

МОНГОЛ УЛС
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ
ТҮҮХИЙ ЭД, ЗҮЙЛИЙГ ГАДААДААС ОРУУЛАХ
ЗӨВШӨӨРӨЛ

№
Улаанбаатар хот

20... оны ... дугаар сарын ...-ны өдөр

1. Иргэн, байгууллагын нэр, регистрийн дугаар
2. Иргэн, байгууллагын хаяг, утас /факс/-ны дугаар
3. Мэргэжлийн байгууллагын гэрчилгээний дугаар
4. Импортлох улсын нэр
5. Худалдан /хүлээн/ авагчийн нэр
6. Түүхий эдийн нэр /олон улсын нэршил/
7. Тоо хэмжээ /тоо, үсгээр/
8. Техникийн болон тээвэрлэх нөхцөл
9. Ордох боомтын нэр
10. Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа
11. Зөвшөөрөл олгосон:

Эрх бүхий албан тушаалтан /нэр, гарын үсэг, тамга/ 1.....
2.....

“Улсын тусгай хамгаалалттай газар нутаг” гэдэг нь байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинж бүхий газар нутгийг унаган төрхийг хадгалах, хамгаалах зорилгоор тусгай хамгаалалтад авсан, хуулиар зөвшөөрөгдсөн тодорхой хэд хэдэн үйл ажиллагаа явуулдаг газар нутгийг хэлнэ. Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар тусгай хамгаалалттай газар нутгийг дархан цаазат, байгалийн цогцолборт, байгалийн нөөц газар, дурсгалт газар гэж ангилдаг байна.

“Агнуурын бүс нутаг”, “хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд”, хориглосон арга хэрэгслээр” гэдгийг амьтны тухай хуулийн 9, 10 дугаар зүйлд зааснаар ойлгоно.

Зүйлчлэлийн асуудал

“Амьтны тухай хууль зөрчих” зөрчлийн шинж нь: Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрлөөр, эсхүл гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг: ашигласан, барьсан, агнасан, амьтныг ашиглах, барих, агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн, гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан, зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан, агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан зэрэг шинжтэй байдаг.

Эрүүгийн хуулийн 24.5 дугаар зүйлд “Хууль бусаар ан агнах” гэмт хэргийг:

1. “Улсын тусгай хамгаалалттай газар нутагт зөвшөөрөлгүйгээр амьтан агнасан, барьсан, эсхүл ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүйгээр агнасан, барьсан, зориудаар тэжээж гаршуулсан, үржүүлсэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг хадгалсан, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, эд, эрхтэн, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн,
2. Нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй агнасан, барьсан, зориудаар гаршуулан тэжээсэн, амьдрах орчныг алдагдуулсан тэдгээрийн түүхий эдийг бэлтгэсэн, тээвэрлэсэн, хадгалсан, худалдсан, худалдан авсан, гадаад улсад гаргасан, ховор амьтны чихмэл, тэдгээрийн гаралтай түүхий эдийн цуглуулга хийсэн үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заасан байна.

Эрүүгийн хуулиар амьтны асуудлыг “тусгай хамгаалалттай газар нутаг”, “ховор болон нэн ховор амьтныг тусгай зөвшөөрөлгүй” зэрэг газар нутаг, хор уршиг учруулж буй халдлагын зүйлээр нь зөрчлөөс ялгаж гэмт хэрэгт тооцохоор заасан. Зөрчлийн тухай хуулиар амьтны асуудлыг тусгай хамгаалалтад ороогүй газар нутагт, элбэг тархацтай амьтныг “гэрээ зөвшөөрөлгүйгээр” агнасан, барсан зэрэг ойлголтын хүрээнд газар нутаг, хор уршиг учруулж буй халдлагын зүйлээр нь гэмт хэргээс ялгаж зөрчилд тооцохоор заасан байна. Мөн түүнчлэн гэрээ, зөвшөөрөлтэй боловч “зөвшөөрөл, эрхийн бичиг, тусгай зөвшөөрөл” зэргийг бусдад шилжүүлсэн гэх мэт амьтны тухай хуульд хориглосон идэвхтэй үйлдэл илэрсэн бөгөөд дээр дурдсан гэмт хэргийн шинжгүй л бол зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

Амьтны тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчил, гэмт хэрэг нь ихэнхдээ нууц далд аргаар үйлдэгддэг заасан

7.6 дугаар зүйлд. "Амьтны тухай хууль зөрчих" зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих бол эрхийн бичигтэй эсэх, Хэрвээ иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих бол тусгай зөвшөөрөлтэй эсэх, Үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барих бол гэрээ байгуулсан эсэхийг шалгах.
2. Хугацаа дууссан гэрээ, зөвшөөрөлд үзлэг хийж, тухайн бичиг баримтыг эд мөрийн баримтаар хураан авах ажиллагаа хийнэ,
3. Гэрээ, зөвшөөрөлгүйгээр амьтныг: ашигласан, барьсан, агнасан, амьтныг ашиглах, барьсан үйлдлийн хувьд гэрч, холбогдогчоос мэдүүлэг авч уг зөрчлийг хаана, хэрхэн үйлдсэн талаар тогтоож, тухайн газарт болон амьтанд үзлэг хийж буудлага хийсэн газар, сумны хошуу, хонгио, цус, гэдэс дотор болон бусад эд эрхтний үлдэц, тухайн газрын хэв шинж, ан амьтны ялгадас, явдаг зөрөг зам, байгаль цаг уурын онцлог зэрэг хэрэгт нотолгооны ач холбогдол бүхий нөхцөл байдлыг дэлгэрэнгүй тусгаж, нотолгооны ач холбогдол бүхий эд зүйлийг эд мөрийн баримтаар хураан авч тэмдэглэл хөтөлнө.
4. Ангийн эд эрхтэн хураагдсан тохиолдолд тоо, ширхгийг нэг бүрчлэн гаргаж ямар ангийн эд эрхтэн болохыг урьдчилан мэдэх, урин дулааны цагт түргэн муудах үмхийрэхээс урьдчилан сэргийлж сэрүүн газар буюу хөлдөөгч, хөргөгчид хадгалуулах нь зүйтэй. Амьтны эд эрхтэн олноор хураагдсан тохиолдолд хэдэн зүйлийн ямар амьтны эд эрхтэн байгааг нь ялгаж зааглаж нэг бүрчлэн үзлэгийн тэмдэглэлд тусгах нь чухал, практикт хураагдсан эд эрхтэн дундаас нь алга болох хаягдах явдал гардгийг анхаарах хэрэгтэй. Амьтны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 д зааснаар ан амьтан болон тэдгээрийн гаралтай түүхий эдийг цуглуулсан, худалдсан, худалдан авсан гадаадад гаргахыг завдсан этгээдийг тухайн зүйл ан амьтныг агнасан барьсантай адилтган үзэж нөхөн төлбөр ноогдуулна гэж заасан байдаг болохоор зөрчлийн газрын үзлэг дээр их хэмжээний ангийн эд эрхтнийг хурааж авахдаа нэг бүрчлэн тоолж үзлэгийн тэмдэглэлд тусган фото зургаар болон дүрс бичлэгээр бэхжүүлж авах нь зүйтэй юм.
5. Зөрчлийн холбогдогчийн унаж яваа тээврийн хэрэгсэл, ачаа тээшинд түүнийг байлцуулан үзлэг хийж зөрчил үйлдэхэд ашигласан буу, сум зэрэг галт хэрэгсэл, загасны тор, дэгээ, уураг, олс дээс, амьтныг амьдаар нь агуулах сав, эд эрхтнийг хадгалах сав, өгөөш болгон ашиглаж буй амьтан, амьтныг барих, суулгах, бэхлэх зориулалт бүхий тоног хэрэгслэл зэрэг тухайн зөрчлийн онцлогт хамааралтай бүхий л зүйлийг энгийн нүдэнд харагдах байдлаар нь нэг бүрчлэн тэмдэглэж эд мөрийн баримтаар хураан авна.

6. Зөрчлийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан зэвсэг, техник хэрэгсэл, тээврийн хэрэгсэл зэргийн өмчлөгчийг олж шалгаж тогтоох.
7. Зөрчил үйлдэж олсон эд зүйл буюу түүний үнэ, гэмт хэрэг үйлдэхэд хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг хөдөө хээрийн нөхцөлд эсхүл шөнийн цагаар хойшлуулшгүй тохиолдолд хураан авахдаа эхлээд прокурорт дариу мэдэгдэж ажиллагаа дууссанаас хойш 24 цагийн дотор холбогдох баримтын хамт хүргүүлнэ.
8. Агнах зөвшөөрлийг бусдад шилжүүлсэн, ан агнах, загас барих гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийг бусдад шилжүүлсэн үйлдлийн хувьд шилжүүлэн авсан, шилжүүлэн өгсөн холбогдогч, бусад гэрчээс мэдүүлэг авч зөрчлийн шинж байдлыг тогтоох. Шилжүүлэн өгсөн этгээд тухайн баримтаар хэд хэчнээн ан амьтанд халдсан, шилжүүлэн авсан этгээд хэчнээн амьтанд халдсан зэрэг тоо толгойг тогтоох үзлэгийн ажиллагаа хийж тэмдэглэл хөтөлнө.
9. Гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ан агнасан, барьсан зохих гэрээ байгуулахгүйгээр үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнасан, барьсан бол ан амьтны нэр төрөл, тоо толгой, хүйс, нас зэргийг /холбогдох мэргэжилтнийг байлцуулж болно/ үзлэг хийж тогтооно. Мөн ангийн гэрээ, ахуйн зориулалтаар олгосон эрхийн бичиг зэргийг баримтаар хураан авна.
10. Агнуурын бүс нутгаас бусад газарт, эсхүл амьтныг агнах хориотой үед, эсхүл хориглосон хугацаанд, эсхүл хориглосон арга хэрэгслээр амьтныг барьсан, агнасан үйлдлийг шалгахдаа зөрчлийн газарт үзлэг хийж энэ зүйлд заасан шалган шийдвэрлэх ажиллагааны 2, 3-д заасныг хэрэгжүүлнэ. Хууль бусаар ан агнасан хэргийн газарт ямар амьтан болох нь тодорхойгүй байх тохиолдол гардаг өөрөөр хэлбэл тухайн амьтны толгой эд эрхтнийг тасдаад аваад явсан амьтны сэгийг нохой шувуу идсэн тохиолдолд тухайн амьтны үс, цуснаас дээж авах, ямар буугаар буудсан болохыг тогтоохын тулд тухайн амьтны биеэс сумны хошууг олж тогтоон шинжилгээнд өгөх зэрэг хойшлуулшгүй ажиллагааг хийнэ. Тухайн амьтны эд эрхтэн ямар амьтны эд эрхтэн болох нь тодорхойгүй тохиолдолд үс, яс, цус, эвэр, туурай зэргийг шинжилгээнд авч ямар амьтан болохыг тогтоох ДНК шинжилгээ хийх гений сан 2017 онд бүрдсэн тул уг асуудлаар МУИС-ийн Биологийн сургуульд шинжээч томилж болно.
11. Агнуурын амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийн зүйлийг тусгай зөвшөөрөл, гарал үүслийн бичиг, дагалдах тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан **зөрчлийн хувьд** “Амьтны түүхий эдийн зүйлийг хадгалах, худалдах, худалдан авах, тээвэрлэх” зэрэг үйлдэл хийхдээ Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017-04-03-ны А/75 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу гарал үүслийн тодорхойлолт авсан эсэхийг шалгах, **тухайн түүхий эд нь ямар нэр төрлийн, хэдэн толгой, ямар хүйс, настай, ямар ангиллаар хамгаалагддаг амьтных болохыг тогтоох шинжилгээ томилж**

холбогдох дүгнэлтийг гаргуулна. Дээр дурдсан хураан авах ажиллагааг явуулна.

12. Байгаль Орчин, Аялал Жуулчлалын Сайдын 2010 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-д заасан эрх бүхий байгууллага, мэргэжилтнээр зөрчлийн хэргийн хохирол тооцох, нөхөн төлбөр тогтоох шинжээчийн дүгнэлт гаргуулна. Засгийн газрын 2011 оны 23 дугаар тогтоолоор ан, амьтны экологи, эдийн засгийн үнэлгээг тогтоож өгсөн байдаг, үүний дагуу хэдэн толгой, ямар ан, амьтан агнасныг тогтоосноор урьдчилсан байдлаар улсын байцаагч хохирлын хэмжээг тооцоолох боломжтой. Шинжилгээний байгууллагаар Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын тусгай мэргэжил бүхий улсын байцаагч өөрөө магадалгаа гаргах, Шинжлэх ухааны академийн Ерөнхий ба сорилын биологийн хүрээлэнгийн хөхтөн амьтны экологийн лабораторид хандаж дүгнэлт гаргуулж болно.
13. **Амьтанд халдах зөвшөөрлийн бичиг, гэрээ зэрэг бичиг баримт** нь үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарлагдсан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулан материалын шинж онцлогийг нарийн дурдаж тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хураан авах. Тухайн баримтыг үндэслэн холбогдох гэрчээс мэдүүлэг авах, эрх бүхий байгууллагаас лавлагаа хүсэх, илт хуурамч бичиг баримт үйлдсэн, зөрчлийг хаацайлахын тулд албан тушаалтнаас хуурамч баримт бичиг хийж ирүүлсэн бол прокурорт мэдэгдэж дариу шилжүүлнэ.
14. Тухайн зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийн эхэнд тухайн зөрчлийн талаарх мэдүүлж буй бүх зүйлсийг үгчлэн, дэлгэрэнгүй бичих бөгөөд үүний дараа холбогдох асуудлаар тодруулан мэдүүлэг авна. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.
15. Тухайн зөрчлийн хэрэгт эд мөрийн баримтаар хураагдсан эд зүйл нь түргэн муудах буюу гэмтэхээр байвал ЭХХШТХ-ийн 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан холбогдох үндэслэлийг шүүхэд тавьж шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авах

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ

..... аймгийн сумын төв замын постын зохицуулагч, цагдаа М нь оны дугаар сарын-ны өдөр улсын дугаартай тээврийн хэрэгслийн жолооч Б-г саатуулан шалгахад согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон болохыг тогтоож Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1-д заасан зөрчлийн хэрэг үүсгэн шалгав. Тухайн тээврийн хэрэгслийн ачаа тээшинд үзлэг хийхэд 370 толгой тарваганы тулам зохих зөвшөөрлийн бичиг баримтгүй тээвэрлэн явааг тогтоосон байна. Шалгалтын материалын холбогдох хэсгийг прокурорт шилжүүлэхэд прокурор цагдаагийн байгууллагад харьяалал тогтоон шилжүүлсэн.

Цагдаагийн байгууллагаас шалгаад элбэг тархацтай, агнуурын амьтан бөгөөд Эрүүгийн хуулийн 24.5-д хохирлын хэмжээ заагаагүй, тусгай хамгаалалтад ороогүй газар нутгаас агнасан болохыг тогтоож Зөрчлийн тухай хуулийн 7.6-д заасан зөрчлийг цагдаагийн байгууллага шалгах эрх олгогдоогүй тул ЗШШТХ-ийн 1.8-р зүйлийн 6.10-д зааснаар Мэргэжлийн хяналтын улсын байцаагчаар шалгуулахаар харьяаллын дагуу прокурорт шилжүүлсэн. Прокурор дахин харьяалал тогтоож Төв аймгийн МХУБ-гч Л зөрчлийн хэрэг бүртгэлт явуулснаар дараах байдал тогтоогдсон байна. Үүнд: Б нь дүү Н-ийн хамт зохих зөвшөөрөлгүйгээр 2017 оны 07 сарын 05-наас 08 сарын 10-ны өдрийг хүртэл нийт 370 толгой тарвагыг тусгай хамгаалалтад ороогүй боловч Агнуурын бүс нутгаас бусад газар болох тарвага сэргээн нутагшуулж буй аймгийн сумын гэх газраас урхи тавьж агнаад найз Т-гийн өмчлөлийн улсын дугаартай тээврийн хэрэгслийг “өвс ачна” гэж гуйн авч яваад сумын төвд тээвэрлэн ирж хөлдөөгчид хадгалж байгаад улмаар Улаанбаатар хот руу тээвэрлэж явах замдаа саатуулагдсан байна.

Уг зөрчлийг шалгах ажиллагаа:

- Б, Н нарын иргэний бичиг баримтын хуулбар авах,
- Холбогдох хууль, журам, Засгийн газраас баталсан амьтны үнэлгээ зэрэг эрх зүйн баримт бичгийн холбогдох хэсгийг зөрчлийн хэрэгт хийх,
- Зоонезын өвчин судлалын төвд хандаж 370 ширхэг тарвагыг халдваргүйжүүлсэн талаарх баримт авч, прокурорт мэдэгдэж, өөрөө болон мэргэжилтэн байлцуулан үзлэг хийж төрөл, нэршил, нас, хүйс зэрэг экологийн үнэлгээ хийхэд шаардлагатай шинжийг тодорхойлох, мөн үзлэгээр тухайн амьтан хэрхэн агнагдсан, хэрхэн бэлтгэсэн /гэдэс дотрыг гаргасан, эд эрхтнийг авсан, туламлаж өвчсөн, сум орсон гарсан нүх, урхинд баригдсан ор мөр, нугасыг тасалсан, мах, ясны бүрэн бүтэн байдал гэх мэт/ байдлыг тогтоож шаардлагатай зүйлийг эд мөрийн баримтаар хураан авах ажиллагаа хийж, гэрэл зургаар бэхжүүлэн, тэмдэглэл хөтөлж прокурорт мэдэгдэнэ.
- Б,Н нарын орон байранд үзлэг хийх зөвшөөрлийг прокуророос авч үзлэг хийснээр урхи болгон ашигласан олс, төмөр утас, тарвага өвчсөн газар, гэдэс дотор хаясан газар, хөлдөөж хадгалсан хөлдөөгч зэрэг зүйлийг үзэж зургаар бэхжүүлэн, тэмдэглэл хөтөлж, шаардлагатай зүйлсийг эд мөрийн баримтаар хураан авна.
- Т-гийн өмчлөлийн улсын дугаартай тээврийн хэрэгслийг, бичиг баримтын хамт ЗШШТХ-ийн 4.5, ЭХХШТХ-ийн 24.4-д зааснаар прокурорын зөвшөөрлөөр түр хураан авч тэмдэглэл хөтөлнө.
- улсын дугаартай тээврийн хэрэгслийг хураах эсхүл үнийг гаргуулах шийдвэр шүүх гаргаж болзошгүй байдлыг харгалзан хөрөнгийн үнэлгээ хийлгэх.
- аймгийн сумаас 370 тарвага агнах зөвшөөрөл Б.Н нарт олгосон эсэх талаар лавлагаа авч хэрэгт хавсаргах, мөн

сумыг төлөөлөн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцох хохирогчийг тогтоолгон мэдүүлэг авах.

- 370 тарваганы экологи эдийн засгийн хохирлын үнэлгээг тогтоолгох, нөхөн төлбөрийг тооцох.

Үйлдэгдсэн зөрчилд тооцох, түүнд хүлээлгэх хариуцлага:

1. Жолооч Б 2017 оны 08 дугаар сарын 15-ны өдөр **согтууруулах ундаа хэрэглэсэн** үедээ 1,45 хувийн согтолттойгоор улсын дугаартай тээврийн хэрэгслийг жолоодсон үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1-д зааснаар жолоодох эрхийг 1 жилээр хасаж, 400.000 төгрөгөөр торгоно.
2. Амьтны тухай хуулийн 4.1.21-д заасныг зөрчиж **зохиж зөвшөөрөлгүйгээр** тарвага агнасан үйлдэлд ЗТХ-ийн 7.6-р зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”.
3. Амьтны тухай хуулийн 9.1.3-д зааснаар тарвагыг жил бүрийн 10 дугаар сарын 16-ны өдрөөс 8 дугаар сарын 20-ны өдөр хүртэл агнахыг хориглоно. Гэтэл 370 тарвагыг 2017 оны 07 сарын 05-наас 08 сарын 10-ны өдрийг хүртэл **хориглосон хугацаанд** агнасан тул ЗТХ-ийн 7.6-р зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”.
4. Амьтны тухай хуулийн 9.1.3-д зааснаар **“Агнуурын бүс нутгаас бусад газарт амьтан агнасан”** үйлдэлд ЗТХ-ийн 7.6-р зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”.
5. Амьтны тухай хуулийн 10.1.4-д зааснаар “ тарвагыг урхи тавих” аргаар агнах барихыг хориглосон заалтыг зөрчиж **хориглосон арга хэрэгслээр агнасан** байх тул ЗТХ-ийн 7.6-р зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно”.
6. ЗТХ-ийн 4.5-д зааснаар Т-гийн өмчлөлийн улсын дугаартай тээврийн хэрэгслийг хураах ба уг ажиллагааг мөн хуулийн 4.2-р зүйлийн 2-д зааснаар шүүхэд материалыг хүргүүлж шүүгч

тээврийн хэрэгслийг хураах буюу зөрчил үйлдэгчээс үнийг гаргуулан Т-д тээврийн хэрэгслийг нь буцаан өгөх шийдвэрийн аль нэгийг гаргана.

Шийдвэрлэх шатанд Зөрчлийн хуулийн ерөнхий анги хэрэглэх нь:

ЗТХ-ийн 1.3 дугаар зүйлийн 2 "Энэ хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна". **2.2 дугаар зүйлийн 1** "Зөрчлийг хамтран үйлдсэн хүн, хуулийн этгээд тус бүрд шийтгэл оногдуулна". **3.1 дүгээр зүйлийн 4** "Нэг үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан хоёр, эсхүл түүнээс дээш зөрчлийн шинжтэй бол аль хүнд шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд нь шийтгэл оногдуулна". 5 "Энэ хуулийн тусгай ангид заасан бол энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчилд оногдуулах үндсэн шийтгэл дээр нэмж бусад зөрчилд оногдуулахаар заасан нэмэгдэл шийтгэл, албадлагын арга хэмжээг оногдуулна" гэж заасан байна.

Эцэслэн шийдвэрлэх ажиллагаа:

- Жолооч Б-д согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1-д зааснаар жолоодох эрхийг 1 жилээр хасаж, 400.000 төгрөгөөр торгоно.
- Б, Н нарыг тус бүрд нь "аль хүнд шийтгэл оногдуулахаар заасан" ЗТХ-ийн 7.6-р зүйлийн 4 дэх хэсгийг хэрэглэн "гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох" шийтгэл онооно.
- Хууль бусаар олсон хөрөнгө, орлого тогтоогдоогүй.
- Учруулсан хохирол болох 370 тарваганы экологи эдийн засгийн хохирлын үнэлгээг, амьтны тухай хуульд заасан нөхөн төлбөрийн хамт Б, Н нараас адил тэнцүү хэмжээгээр гаргуулж хохирогч байгууллагад өгүүлэх буюу хуульд заасан дансанд төвлөрүүлж баримтыг хэрэгт хавсаргана.
- Зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл болох Т-гийн өмчлөлийн улсын дугаартай тээврийн хэрэгслийг хураах ба уг ажиллагааг мөн хуулийн 4.2-р зүйлийн 2-д зааснаар шүүхэд материалыг хүргүүлж шүүгч тээврийн хэрэгслийг хураах буюу зөрчил үйлдэгчээс үнийг гаргуулан улсын орлого болгож, Т-д тээврийн хэрэгслийг нь буцаан өгөх шийдвэрийн аль нэгийг гаргана.
- Хохирол, нөхөн төлбөр, торгуулийн орлого заасан хугацаанд төлөгдөөгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд иргэний журмаар хандаж нэхэмжлэл гаргана.

3.6 Байгалийн ургамлын тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 7.7 дугаар зүйлд дараах байдлаар заасан. Үүнд:

1.Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж:

1.1.байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд;

- 1.2. Элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мэргэжлийн нэршил, холбогдох хууль тогтоомж

Энэ хуулийн зорилго нь ой болон таримал ургамлаас бусад ургамал / цаашид “ургамал” гэх/-ыг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон харилцааг зохицуулна гэжээ.

“Байгалийн ургамал” гэж хүний оролцоогүйгээр байгалийн жамаар ургаж байгаа зүйл ургамлыг хэлнэ.

“Байгалийн ургамлын нөөц” гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг дахь нийт хэмжээг хэлнэ.

“Байгалийн ургамлын тархац, нөөцийн судалгаа” гэж тухайн зүйл ургамлын тархац нутаг, нөөцийн хэмжээг тогтоох зорилгоор хийгдэж байгаа судалгааг хэлнэ.

“Байгалийн ургамлыг тарималжуулах” гэж байгалийн ургамлыг хамгаалах, удмын санг хадгалах, түүхий эд болгон ашиглах зорилгоор тарьж ургуулах, үржүүлэх ажиллагааг хэлнэ.

“Ургамлын экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж тухайн зүйл ургамлын оршин амьдрах нөхцөл болон экологийн, эдийн засгийн, эрх зүйн, нийгмийн ач холбогдлоор нь үнэлсэн тусгай аргачлалын дагуу тооцсон нэгж жингийн мөнгөн үнэлгээг хэлнэ.

“Харь ургамал” гэж улсын хилийн гаднаас зориудаар болон санамсаргүй байдлаар зөөвөрлөгдөн ирж, нутагшиж байгаа зүйл ургамлыг хэлнэ. Хуурай газар, усны бүх зүйлийн гуурст ургамал, хөвд, хаг, мөөг болон бичил биетээс манай нутгийн нийт сан бүрдэнэ.

Ургамлын нөөцийн нөхөн сэргэх чадвараар нь ангилна. Үүнд: 1. Нэн ховор; 2. Ховор; 3. Элбэг. Нэн ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон ургамал хамаарна.

Ховор ургамалд байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, нөөц багатай устгаж болзошгүй ургамал хамаарна.

Элбэг ургамалд дурдсануудаас бусад ургамлыг хамааруулна. Үүнд:

1. Ургамлын тархац, нөөцийн хэмжээ, үнэлгээ;
2. Ургамлын хатаамал, бэлдмэл, үрийн цуглуулга;
3. Ургамлын судалгааны тайлан, мэдээ баримт;
4. Хяналт-шинжилгээний ажиглалт, хэмжилтийн мэдээ баримт;
5. Ургамал хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний мэдээ.

Ургамал ашиглагч нь төлбөр төлнө. Ургамлыг гал түймэр, өвчин, хөнөөлт мэрэгч амьтан, шавж болон хүний сөрөг нөлөөллөөс хамгаалах ажлыг бүх шатны ЗД улсын төсвийн хөрөнгөөр, гэрээний дагуу газар эзэмшиж ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллага өөрийн хөрөнгөөр хэрэгжүүлнэ. Ингэхдээ БОАЖЯ-наас зөвшөөрснөөс бусад химийн бодис хэрэглэж болохгүй. Нэн ховор ургамалтай газрыг хамгаалах, нөхөн сэргээхээс бусад зорилгоор ашиглахыг хориглоно. Мөн харь ургамлыг БОАЖЯ-ны зөвшөөрөлгүйгээр тарихыг хориглоно. Зөвхөн хязгаарлагдмал битүүмжилсэн талбайд тарина. 5 жил тутамд БОАЖЯ үйлдвэрлэлийн талбайд нөөцийг тогтооно. Үйлдвэрлэлийн зорилгоор бэлтгэх ургамлын нэр, түүх дээд хязгаарыг жил тогтоож зарлана.

Дор дурдсан газруудыг үйлдвэрлэлийн зорилгоор ашиглахыг хориглоно. Үүнд:

1. Суурин газрын ногоон бүс
2. Гол, горхийн эх, нуур цөөрмийн эргээс 2 километрийн доторх газар
3. Нэн ховор амьтны байршил газар
4. Баянбүрд
5. Ургамал талхлагдсан газар
6. Элсний нүүлтээс хамгаалсан газар
7. Хөрсний элэгдлээс хамгаалах зурвас газар

Нэн ховор ургамлыг зөвхөн судалгаа шинжилгээний, ховор ургамлыг ахуйн болон судалгааны элбэг ургамлыг бүх зориулалтаар ашиглана. Ургамал бэлтгэх, ашиглах хэмжээ, хуацааг БОАЖЯ тогтооно. Гадаадын иргэд, гаднын хуулийн этгээд ургамлыг аливаа зорилгоор бэлтгэх хориотой. Сум, дүүргийн Засаг дарга ургамлыг нь үйлдвэрлэлийн аргаар бэлтгэх газрыг тогтоосон хугацаанд, БОАЖЯ-ны дүгнэлтийг үндэслэн гэрээгээр эзэмшүүлэх ашиглуулж болно. Уг гэрээнд дараах зүйлийг тусгана. Үүнд:

1. Ургамлын нэр, ашиглах хэмжээ
2. Ашиглах нөхцөл, болзол
3. Талуудын эрх, үүрэг хариуцлага

Ургамал ашиглагчийн үүрэг:

1. Хууль тогтоомжийг биелүүлэх
2. Түүж бэлтгэх, нөхөн сэргээх журам баримтлах
3. Зөвшөөрөлд заасан хэмжээ, баримтлах хугацаа
4. Нэг наст ургамлын үр боловсросны дараа түүх

5. Ашиглагч, ургамлыг нөхөн сэргээх
6. Гэрээний нөхцөл, болзлыг биелүүлэх үүрэгтэй байдаг.

 МОНГОЛ УЛС БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ		
УРГАМАЛ, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД ЗҮЙЛ, ОЙН ДАГАЛТ БАЯЛГИЙГ ГАДААДАД ГАРГАХ ЗӨВШӨӨРӨЛ		
20... оны ... дугаар сарын ... -ны өдөр	№ ...	Улаанбаатар хот
1. Үйлчлүүлэгч байгууллагын нэр, регистрийн дугаар	
2. Мэргэжлийн байгууллагын гэрчилгээний дугаар	
3. Худалдан / хүлээн / авагч	
4. Гэрээний дугаар	
5. Зөвшөөрлийн хүчинтэй байх хугацаа	
6. Түүхий эдийн нэр /Олон улсын/	
7. Техникийн нөхцөл	
8. Тээвэрлэх төрөл	
9. Гарах боомт	
10. Тоо хэмжээ /тоо, үсгээр/	
11. Хаяг, утас / факс/-ны дугаар	
12. Зөвшөөрөл олгосон:		
Эрх бүхий албан тушаалтан /нэр, гарын үсэг, тамга/	Эрх бүхий албан тушаалтан /нэр, гарын үсэг, тамга/	
.....	
.....	

Байгалийн Ургамлын тухай хуулийн 3 дугаар зүйлд зааснаар Ургамлыг түүний нөөц, нөхөн сэргэх чадварыг нь харгалзан нэн ховор, ховор, элбэг гэж ангилна. Мөн хуулийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт “нэн ховор”, 3.4 дэх хэсэгт “ховор”, 15-17 дугаар зүйлд “ургамал, тэдгээрийн үр, эрхтнийг зохих зөвшөөрөлгүй бэлтгэсэн” зэрэг нэр томъёог тайлбарласан байна.

“Нэн ховор ургамалд” Байгалийн ургамлын тухай хуулийн хавсралтаар тогтоосон, байгалийн жамаар нөхөн сэргэх чадваргүй, тархац нэн хязгаарлагдмал, ашиглах нөөцгүй, устах аюулд орсон ургамал хамаарна.

“Ховор ургамалд” байгалийн жамаар нөхөн сэргэх чадвар хязгаарлагдмал, тархац, нөөц багатай, устаж болзошгүй ургамал хамаарна. Ховор ургамлын жагсаалтыг Засгийн газар батална. Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоол, 2004 оны 165 дугаар тогтоол, 2015 оны 410 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтыг нэмэлт өөрчлөлт оруулах байдлаар баталж иржээ. /тогтоолыг эхээр нь зурган файлаар оруулж болно/ Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нэн ховор ургамлыг зөвхөн судалгаа, шинжилгээний, ховор ургамлыг ахуйн болон судалгаа, шинжилгээний, элбэг ургамлыг судалгаа, шинжилгээний, ахуйн, үйлдвэрлэлийн зориулалтаар тус тус

ашиглаж болно. Ургамлыг ашиглах зөвшөөрлийг эрхийн бичгээр олгоно. Эрхийн бичигт ургамлыг түүж бэлтгэх иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, ургамлын зүйлийн нэр, эрхтэн, түүж бэлтгэх хэмжээ, хугацаа, газрыг заасан байна. Эрхийн бичгийг бусдад шилжүүлэн ашиглуулахыг хориглоно.

Хуш модны самар “ховор” ургамал бөгөөд зарим зохицуулалтын талаар дурдвал:

Хуш модны самрын хувьд тухайн жилийн ургацын байдлыг орон нутаг дахь Ойн анги судалж тогтоон “Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газарт самрын ургацын байдлын мэдээ, дүгнэлтийг тухайн оны 08 дугаар сарын 01-ний дотор хүргүүлнэ.

“Ойн судалгаа, хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газар хуш модны самрын ургалтын мэдээг нэгтгэн дүгнэж, дүгнэлтийг тухайн оны 08 дугаар сарын 20-ны дотор байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь “Ойн судалгаа хөгжлийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүгнэлт, орон нутгаас ирсэн мэдээллийг үндэслэн тухайн жилд самрын нөөцийг ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглаж болох тухай шийдвэрийг тухайн оны 09 дүгээр сарын 1-ний дотор бүсчлэн гаргана. Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны 2014 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн А/166 дугаартай тушаалаар “Ойн дагалт баялгийг хамгаалах, зохистой ашиглах журам”-н 1 дүгээр хавсралтын 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэгт “Хуш модны самрыг 10 дугаар сарын 15-ны өдрөөс дараа оны 03 дугаар сарын 15-ны хооронд бэлтгэхээр хугацааг зааж өгсөн. /Тухайн жилд самрын ургалт, хуурайшилтаас болж Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас түүж бэлтгэх хугацааг өөрчилсөн байж болно./

Зүйлчлэлийн асуудал

“Байгалийн ургамлын тухай хууль зөрчих” зөрчил нь: Зохих зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, ургамал түүж бэлтгэх журам зөрчиж; **байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд, элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор** түүсэн, бэлтгэсэн, худалдсан; Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн; Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан зэрэг шинжтэй байдаг.

Эрүүгийн хуулийн 24.8 дугаар зүйлд “Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх” гэмт хэргийг:

“Зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор **нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтнийг** түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан, хадгалсан, тээвэрлэсэн, боловсруулсан” үйлдлийг гэмт хэрэгт тооцохоор заасан байна.

Эрүүгийн хуулиар ургамлын асуудлыг “нэн ховор, ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтнийг”, гэж хор уршиг учруулж буй халдлагын зүйлээр нь зөрчлөөс ялгаж гэмт хэрэгт тооцохоор заасан. Зөрчлийн тухай хуулиар ургамлын асуудлыг “байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд, элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор” түүсэн, бэлтгэсэн, худалдсан зэрэг ойлголтын хүрээнд мөн хор уршиг учруулж буй халдлагын зүйл, ашиглах зорилгоор нь гэмт хэргээс ялгаж зөрчилд тооцохоор заасан байна. Мөн түүнчлэн Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн; Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан зэрэг гэх мэт Байгалийн ургамлын тухай хуульд хориглосон идэвхтэй үйлдэл илэрсэн бөгөөд дээр дурдсан гэмт хэргийн шинжгүй л бол зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэнэ.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

7.7 дугаар зүйл. “Байгалийн ургамлын тухай хууль зөрчих” зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Элбэг ургамлын зохих зөвшөөрөл Ховор ургамлыг ашиглах болон гадаад улсад гаргах зөвшөөрөлтэй эсэх талаар лавлагаа авах. Зөвшөөрөл, гэрчилгээ, эрхийн бичиг нь нэгдсэн кодтой тохирч байгаа эсэхийг шалгах.
2. Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоол, 2004 оны 165 дугаар тогтоол, 2015 оны 410 дугаар тогтоолоор ховор ургамлын жагсаалтад тухайн ургамал байгаа эсэхийг шалгаж, тогтоолын холбогдох хэсгийг хавсаргах.
3. Байгалийн ховор ургамлыг ахуйн хэрэгцээнд, элбэг ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашиглах, орлого олох зорилгоор түүсэн, бэлтгэсэн, худалдсан; Байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах ач холбогдолтой нутаг дэвсгэр, бэлчээр, хадлангийн газар, мал тэжээх зориулалтаар ашиглахыг хориглосон газар үйлдвэрлэлийн зориулалтаар ургамал түүж бэлтгэсэн, эсхүл мал бэлчээсэн; Ургамлыг түүж бэлтгэх журам зөрчсөн, эсхүл ахуйн зориулалтаар ашиглахаар түүж бэлтгэсэн ургамлыг үйлдвэрлэлийн түүхий эд болгон ашигласан зэрэг үйлдлийн аль нь болохыг тогтоохын тулд холбогдогч, гэрч, хохирогчоос мэдүүлэг авах. Мэдүүлэг авахдаа дараах зүйлийг тодруулж хэвших. Үүнд: ашигласан техник хэрэгслийн марк, төрөл, хүчин чадал, тоо хэмжээ, шатахууны татан авалт, түүсэн, бэлтгэсэн, худалдсан хэмжээ, үнэ, хамрагдсан ажиллагсад, цалин олгосон тооцоо, хөдөлмөрийн гэрээ хийгдсэн эсэх, нийгмийн даатгалын төлөлт, улс орон нутгийн төсөвт төлсөн татвар, хураамжийн хэмжээ.
4. Зөрчлийн улмаас Байгаль орчинд учирсан хохирлыг Байгаль орчин,

- аялал жуулчлалын сайдын 2010 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-д заасан мэргэжлийн байгууллагаар Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2011 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн А-354 дугаар тушаалаар баталсан “Ургамлын нөхөн төлбөрийг төлүүлэх журам, аргачлал”-д зааснаар тогтоолгох
5. Тухайн зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийн эхэнд тухайн зөрчлийн талаарх мэдүүлж буй бүх зүйлсийг үгчлэн, дэлгэрэнгүй бичих бөгөөд үүний дараа холбогдох асуудлаар тодруулан мэдүүлэг авна. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.
 6. Зөрчил үйлдэж олсон элбэг болон ховор ургамал, тэдгээрийн үнэ, хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгслийг эд мөрийн баримтаар хураан авах битүүмжлэх ажиллагааг прокурорын хяналттай явуулах, хөдөө хээрийн нөхцөлд эсхүл шөнийн цагаар хойшлуулшгүй тохиолдолд хураан авахдаа эхлээд прокурорт дариу мэдэгдэж ажиллагаа дууссанаас хойш 24 цагийн дотор холбогдох баримтын хамт хүргүүлнэ. Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зэргийг нарийвчлан тооцох эдгээрт гарах зардлыг хадгалагч, хамгаалагч байгууллага иргэнээр тодорхойлуулан удирдлагад танилцуулж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлаас гаргуулах. Ховор ургамал нь хадгалалтын нарийн нөхцөл шаарддаг, төрийн байгууллагын буруутай үйлдлээс хөгцөрч муудах эрсдэл их тул үүний дагуу сөрөг үр дагаврууд гардаг. Иймд түргэн муудах эд мөрийн баримтын хувьд зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг цаг алдалгүй шуурхай явуулж, ЭХХШТХ-ийн 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтлан холбогдох үндэслэлийг шүүхэд тавьж шуурхай шийдвэрлэх арга хэмжээ авах.
 7. Эд мөрийн баримтаар хураагдсан эд зүйл, тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийг тогтоож, хөрөнгийн үнэлгээ хийлгэх арга хэмжээ авна.
 8. Ойн ангийн дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч зэрэг үүрэг бүхий албан тушаалтнуудын албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс хамаарч зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн бол Төрийн албаны тухай хуульд зааснаар сахилгын шийтгэл хүлээлгэх эсэх талаар хариуцсан дээд шатны байгууллагад бичгээр хандах. Шаардлагатай бол тухайн газар орныг хариуцаж байсан ойн ангийн дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагч зэрэг нь ажил үүргийн хувьд хэн нь юу хариуцдаг болох, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргээс үндэслэн талбай тусгаарлалтыг хэрхэн явуулсан, ойн дагалт нөөц ашиглах эрхийн бичгийн бичилт, хөтлөлт зэргийг үзэх, хуулбарлан авах.
 9. Зохих зөвшөөрөлгүй болон зөвшөөрөлд заасан хугацаа, хэмжээ, зориулалт, ургамал түүж бэлтгэх журам зөрчсөн бол бэлтгэсэн ургамал

нь ямар төрлийн ургамал болох, ямар төрлийн ургамлын үр эрхтэн болохыг үзлэг хийж тогтоох. Үзлэгээр тухайн зөрчилд заагдсан ургамал нь зөрчлийн газарт ургаж байгаа эсэх, бэлтгэсэн байдал, газрын хэв шинж, газар эвдэгдсэн байдал, ургамлыг хэрхэн бэлтгэсэн, ямар уут, сав баглаа боодолтой, боловсруулалтын хувьд хэрхсэн /цайруулсан, иш толгойг тайрсан, багцалсан, үр идээг салгасан, сүүдэрт хатаасан гэх мэт/ харагдах байдал, өнгө, үнэр, хэлбэр дүрс, хүндийн жин, муудсан хөгцөрсөн шинж байгаа эсэх зэргийг мэргэжилтэн оролцуулан тогтоох шаардлагатай. Зөрчлийн газрын үзлэгийн тэмдэглэлд тухайн талбайн тусгаарлалт хийсэн захын цэгүүдийн солбицлыг GPS-ийн тусламжтай тогтоож Байгаль орчин, аялал жуулчлалын яамны кадастрын хэлтэст хүргүүлэн хязгаарлалт, хориглолтын бүстэй давхцалтай эсэхийг шалгуулж, зурагтай лавлагаа авах.

10. Ургамалын талаарх зөвшөөрлийн бичиг, гэрээ зэрэг бичиг баримт нь үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарлагдсан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулан материалын шинж онцлогийг нарийн дурдаж тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хураан авах. Тухайн баримтыг үндэслэн холбогдох гэрчээс мэдүүлэг авах, эрх бүхий байгууллагаас лавлагаа хүсэх, илт хуурамч бичиг баримт үйлдсэн, зөрчлийг хаацайлахын тулд албан тушаалтнаас хуурамч баримт бичиг хийж ирүүлсэн бол прокурорт мэдэгдэж дариу шилжүүлнэ.

Амьдралд түгээмэл үйлдэгддэг хуш модны самартай холбоотой зөлчилд:

- Самарыг хаанаас ямар гарал үүслийн бичгийн дагуу, ямар хугацаанд бэлтгэсэн талаар баримт бичгүүдийг нэн даруй хураан авч үзлэг хийж холбогдох ажиллагааг хийх
- Самарыг хийсэн сав, баглаа боодолтой нь нэг бүрчлэн хиллэж, хэдий хир хэмжээтэй цайруулсан, яснаас нь салгасан самрын үр идээ зэргийн алин болохыг тогтоох
- Үзлэг хийсэн самар, түүний үр идээнээс аль болох өөр өөр газраас дээж авч эрүүл ахуйн шаардлага хангах эсэхийг тогтоолгохоор шинжээч томилох
- Самар нь маш түргэн муудаж, эрүүл ахуйн шаардлага хангахгүй болдог учир “Түргэн муудах буюу гэмтэх эд мөрийн баримтыг” хэрхэх талаар хуулийн шаардлага хангаж шүүхээр даруй шийдвэрлүүлнэ.

Шинжээчээс дараах асуултыг тодруулах: Шинжилгээнд хүргүүлж байгаа самрын шинжлэх ухааны нэршлийг тогтоох, ховор ургамал мөн эсэх хуулиар хамгаалагдсан ангилал, тархац, хэдэн оны ургац болох, энэ жилийн самар мөн эсэх, уг самрыг түүж бэлтгэсэн болон хадгалсан хугацааг тогтоох боломжтой эсэх, самрыг хаанаас түүж бэлтгэсэн болох тогтоох боломжтой эсэх, самраас хөнөөлт болон ургамлын ямар нэг өвчин илэрч байгаа эсэх, хүргүүлсэн самрыг хүнсний зориулалтаар ашиглаж, хэрэглэж болох, болц гүйцсэн эсэх, самрын экологи-эдийн засгийн хохирлын үнэлгээг тогтоох гэм мэт.

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ

..... аймгийн сумын иргэн Л нь зохих зөвшөөрөл авалгүйгээр ховор ургамал болох самрыг ойгоос түүж бэлтгээд, тэнд нь цайруулж, жинлэж үзэхэд 57 кг болсон байна. Бэлтгэсэн самраа аваад сумын төв дээрх самрын ченж Г-д зарж 171.000 төгрөг аваад зогсож байтал улсын байцаагч Д ирж зөрчлийн шалгалт явуулав”. Энэ тохиолдолд нэгэнт “зохих зөвшөөрөл аваагүй”, самар нь “ховор” ургамал тул зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй. Эрүүгийн хуулийн **24.8 дугаар зүйлд “Байгалийн ургамлыг хууль бусаар бэлтгэх”** гэмт хэргийг: “Зохих зөвшөөрөлгүйгээр, хуульд зааснаас өөр зорилгоор ... **ховор ургамал, тэдгээрийн үр, эрхтнийг** түүсэн, бэлтгэсэн, худалдсан, худалдан авсан” бол хариуцлага хүлээлгэхээр заасан ба ямар нэг хохирлын хэмжээ заагаагүй тул дээрх үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Улсын байцаагч Д-гээс авах арга хэмжээ: “Иргэн Л-д холбогдох зөвшөөрөлгүй 57 кг самар ойгоос түүж бэлтгэсэн, 171,000 төгрөгөөр худалдсан, ченж Г зохих зөвшөөрөлгүйгээр 57 кг самрыг 171,000 төгрөгөөр худалдан авсан үйлдлийг” тус тус прокурорт мэдэгдэж, холбогдох материалыг хүргүүлнэ. Прокурор ЭХХШТ хуульд заасан журмаар Эрүүгийн хуулийн 24.8 дугаар зүйлд заасан хэргийг шалгуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

3.7 Ойн тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлд дараах байдлаар заасан.

1. Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Гэрээний дагуу эзэмшүүлсэн ойг:
 - 2.1. Түймэр;
 - 2.2. Хөнөөлт шавж;
 - 2.3. Өвчнөөс хамгаалах арга хэмжээ аваагүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Зохих зөвшөөрөлтэйгөөр мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Мод бэлтгэх, эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний

төгрөгөөр торгоно.

6. Мод, ойн дагалт нөөцийг менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
- 8.4. Тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог хаягдал, үнс, шүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашигласан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
9. Гэрээний дагуу ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм, нормативын дагуу бүрдүүлээгүй, эсхүл түймэр гарсан үед тэдгээрийг ашиглахад бэлэн байлгаагүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гүйлгээний аюулгүй үед нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
10. Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
11. Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар бэлтгэсэн зүйл, олсон орлогыг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хууль тогтоомжид заасан журмын дагуу иргэн өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газартаа, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага эзэмшлийн газартаа өөрийн хөрөнгөөр зориудаар тарьж ургуулсан ой модыг өмчилж болно.

Ойн нөөц болон ойн санг дор дурдснаар эзэмшүүлнэ. Үүнд:

1. БОАЖЯ ойн нөөцийг аймаг, нийслэл, сум, дүүргийн эзэмшилд
2. Сум, дүүргийн Ирэгдийн төлөөлөгчдийн хурлын баг, хорооны ИНХ-ын саналыг үндэслэн Ойн сангийн тодорхой хэсгийг тогтоосон хугацаа, нөхцөл, болзолтойгоор гэрээний дагуу ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтад.

Ойн эзэмшүүлэх гэрээг зохих бэлтгэл хангуулах зорилгоор эхний ээлжинд 1 жилийн хугацаагаар, цаашид 10 жилийн давтамжтайгаар 60 хүртэл жилийн хугацаагаар байгуулж болно. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол эзэмшлийн ой нь хамгаалалт, ашиглалтын аль ч бүсэд хамаарч болно.

Засаг дарга хамгаалалтын бүсэд хамаарах эзэмшлийн ойн сангийн

нэршлийн жагсаалтыг зориулалт, экологи, эдийн засаг, ниймгийн ач холбогдлыг харгалзан тогтооно. Гэрээнд заасны дагуу ойн сангийн тодорхой хэсгийг гэрээгээр эзэмшигч ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшлийн ойд хохирол учруулахгүйгээр иргэн аялал зугаалгаар явах, мал туувар дайран өнгөрөх, зөгий үржүүлэх, түүнчлэн төрийн эрх бүхий байгууллагын зөвшөөрлөөр ойн дагалт баялгийг ашиглах, ан хийж болно.

Хамгаалалт, ашиглалтын хэлбэр, экологи эдийн засгийн ая холбогдлыг нь харгалзан ойн санг дор дурдсанаар ангилна. Үүнд:

1. Хамгаалалтын бүсийн ой
2. Ашиглалтын бүсийн ой

Ой бүхий газар, таримал ой, бут сөөг, мод бэлтгэсэн, ой, хээрийн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн ойн талбай, ойн цоорхой, түүнчлэн ойн захаас гадагш 100 метр газар, тарьц, суулгац бойжуулах мод үржүүлгийн газрын эзлэх талбай нь ойн сангийн газарт хамаарна. БОАЖЯ нь ойн төлөв байдал, ойн сангийн эзлэх талбайн хэмжээ, нөөц, бүрэлдэхүүн, үнэлгээ, тэдгээрийн өөрчлөлт, ойг хамгаалах, ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээний талаарх цогц мэдээллийг агуулсан улсын хэмжээний ойн мэдээллийн сантай байна. Бүх шадны Засаг дарга ой, хээрийн түймрийн цагийн байдлын тухай мэдээг дээд шатны Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага болон онцгой байдлын асуудас эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад өгнө. Ойн сангийн тооллого, ой зохион байгуулалтын ажлыг 10 жил тутамд 1 удаа хийж, түүний нөөц, төлөв байдлыг улсын хэмжээнд шинэчлэн тогтооно. Байгалийн гамшиг, ой, хээрийн түймэр, ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн зэрэг онцгой тохиолдолд ой зохион байгуулалтыг хуульд заасан хугацааг харгалзахгүйгээр хийж болно.

Хамгаалалтын бүсийн ойд цармын бүслүүрийн ой, тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, байнбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс илүү налуу газрын ой хамаарна.

Хориотой зурвасын ойд нуур, рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрон болон голын эргээс 2 тийш 1000 метрийн доторх ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу 2 талын 100 метрийн доторх ой хамаарна.


Усны хагалбар дахь байгаль орчны тэнцлийг хангах, хөрсний эвдрэлээс сэргийлэх зорилгоор цармын бүслүүрийн ойн заагийг төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

Мөн Байгаль орчны тэнцэл, хүн амын эрүүл ахуйн нөхцлийг хангах зорилгоор нийслэл, хот, тосгоны ногоон бүсэд хамаарах ойн заагийг дор дурдсанаар тогтооно. Үүнд:

1. Нийслэлийн ногоон бүсэд хамаарах ойн заагийг Засаг дарга,
2. Нийслэлээс бусад хотын 30 хүртэл километрийн доторх ногоон бүсэд хамаарах ойн заагийг аймаг, сумдын Ирэгдийн төлөөлөгчдийн хурлын саналыг үндэслэн төрийн захиргааны төв байгууллага,
3. Төв, суурин газрын ногоон бүсэд хамаарах ойн заагийг тухайн

сумын Ирэгдийн төлөөлөгчдийн хурлын саналыг үндэслэн аймгийн Ирэгдийн төлөөлөгчдийн хурал тус тус тогтооно.

Ойн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг БОАЖЯ олгодог.





Хууль бусаар мод бэлтгэсэн гэж зохих эрхийн бичиггүйгээр хэрэглээний мод, түлээ бэлтгэсэн, эрхийн бичигт заагдсан нөхцөл, болзлыг зөрчсөн, зохих гэрээ байгуулахгүйгээр ойд үйлдвэрлэлийн зориулалтаар хэрэглээний мод, түлээ бэлтгэсэн Ойн тухай хуулийн 35-р зүйлийн 35.4.1-д заасан хориглосон үйл ажиллагааг явуулж ой мод огтолсон гэмтээснийг ойлгоно.

Зөрчлийг шалгахын тулд Ойн тухай хуульд заасан доорх нэр томъёо зайлшгүй мэдэх шаардлагатай. Үүнд:

- “ойн менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх, эсхүл эзэмшлийн ойг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхэд чиглэгдсэн ойн аж ахуйн арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг цогц байдлаар, тодорхой үе шаттайгаар тусгаж, төлөвлөсөн баримт бичгийг;
- “ойн экологи-эдийн засгийн үнэлгээ” гэж ойн нөөцийн хэмжээ, чанар, хэрэглээний экологи-эдийн засгийн үр өгөөжийг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг;
- “ойн нөхөрлөл” гэж Иргэний хуулийн 481.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 3.2.8-д заасны дагуу зохион байгуулагдаж, үйл ажиллагаа явуулж байгаа иргэдийн сайн дурын байгууллагыг;
- “ойг хамгаалах” гэж ой, хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин

зэрэг ойн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, ойн баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр ойн нөөцийн даацад тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавьж гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг;

- “ойг ашиглах” гэж ойн сангаас зохих журам, заавар, стандартын дагуу ойн баялгийн даацад тохируулан мод, ойн дагалт баялгийг бэлтгэх үйл ажиллагааг;
- “ойн баялаг” гэж ойн модны нөөц, түүний дагалт баялгийн нөөцийг;
- “ойн дагалт баялаг” гэж ойн сангийн газарт ургадаг жимс, жимсгэнэ, мөөг, самар, эмийн болон хүнс, тэжээл, техникийн ургамал, модны холтос, үйс, хусны шүүс, давирхай, ойн хөвд, хөвхөн зэрэг ойгоос авч ашиглаж байгаа аливаа баялгийн нөөцийг;
- “ойн тооллого, ой зохион байгуулалт” гэж ойн сангийн талбай, нөөц, тархац, бүрэлдэхүүн, чанар, төлөв байдал, өөрчлөлтийг тогтоох, хүлэмжийн хийн шингээлтийг тооцох, биомассын судалгаа хийх, ойн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээг цогц байдлаар тодорхойлсон үйл ажиллагааг;
- “ой үржүүлэг” гэж урьд өмнө нь ой байгаагүй газарт таримал ой ургуулахыг;
- “ойн цэвэрлэгээ” гэж ойн түймэр, хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн, хүчтэй салхи, их цасанд өртөн амьдрах чадваргүй болж үхжиж унасан хуурай мод, гишүү, мөчир, мод бэлтгэлийн талбайн үлдэгдлийг цэвэрлэх замаар ойг хамгаалах, ойн төлөв байдлыг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг;
- “ойн санд үзүүлэх хортой нөлөөлөл” гэж аж ахуйн болон үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад ойн санг бүрдүүлэгч хүчин зүйлийн даац чадавхад хохирол учруулсан, ойг бохирдуулж, улмаар ойн төлөв байдлыг доройтуулсан бүхий л сөрөг үйлдлийг;
- “түймрийн аюултай үе” гэж тухайн нутаг дэвсгэрт ой, хээрийн түймэр гарах байгалийн нөхцөл бүрдсэн хуурайшилт бүхий цаг хугацаа буюу жил бүрийн 3 дугаар 20-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр, 9 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдөр хүртэлх хугацааг;
- “ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх” гэж төрийн, төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс ой, хээрийн түймэр үүсэж тархахаас сэргийлэх зорилгоор хэрэгжүүлж байгаа мэдээлэл, сургалт, сурталчилгааны болон ойн аж ахуйн арга хэмжээг;
- “ой, хээрийн түймрийг илрүүлэх” гэж түймэр гарсан тухайн газрын байр зүй, тархалтын хэмжээг тодорхойлох болон түймрийн голомтыг олж тогтоохыг;
- “хил дамнасан ой, хээрийн түймэр” гэж тухайн улсын хил болон хилийн дагуух бүс нутагт гарсан ой, хээрийн түймэр өргөжин дэлгэрч хоёр улсын хилийн зааг, хил дамнаж гарсныг;

- “ой, хээрийн түймрээс учирсан хохирол” гэж түймрийн улмаас хүний амь нас, эрүүл мэнд, байгаль-экологи, эд материалд учирсан хохирол, ой, хээрийн түймэр унтраахад гарсан зардлыг;
- “ой, хээрийн түймрээс учирсан экологийн хохирол” гэж түймрийн нөлөөгөөр байгаль-экологийн тогтолцооны хэвийн байдал, ой, түүний хөрс, ус хамгаалах экологийн үүрэг ач холбогдол алдагдах, амьтан, ургамал устах болон тэдгээрийн төрөл зүйлийн амьдрах орчин доройтох, байгалийн нөөц, баялаг хомсдохыг;
- “ой, хээрийн түймрээс учирсан эд материалын хохирол” гэж түймрийн нөлөөгөөр барилга байгууламж, мал, амьтан, ургамал, өвс тэжээл, малын хашаа саравч, машин тоног төхөөрөмж, гэр, орон сууц, эд материал зэрэг үндсэн ба эргэлтийн хөрөнгө гэмтэх, устах зэргээр улс орон, ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд учирсан шууд хохирлыг;
- “ой, хээрийн түймрийн хор уршиг” гэж Гамшгаас хамгаалах тухай хууль-ийн 4.1.10-т заасныг;
- “ой” гэж мод, бут, сөөг болон бусад ургамал, хаг хөвд, амьтан, бичил биетэн шүтэлцэн орших хам бүрдлийн экологи-газарзүйн онцлог нөхцөл бүхий орчныг;
- “ойн сан” гэж энэ хуулийн 3.1.1-д заасан ой, ой дотор байгаа ойгоор бүрхэгдээгүй болон ойн тэлэн ургахад шаардлагатай талбай бүхий орчныг;
- “ойн нөөц” гэж ойг талбай, ургаа модны эзлэхүүнээр нь илэрхийлснийг;
- “ашиглах нөөц” гэж ойн экосистемийн тэнцвэрт байдлыг хангах нөхцөлтэйгөөр тодорхой хугацаанд авч ашиглаж болох модны дээд хэмжээг;
- “эзэмшлийн ой” гэж ойн нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага гэрээний үндсэн дээр тодорхой хугацаанд хариуцан хамгаалж, эзэмшиж, ашиглаж байгаа ойн сангийн тодорхой хэсгийг;

“Хамгаалалтын болон ашиглалтын бүсийн ойд хуулиар хориглосон үйл ажиллагаа” гэдэг нь Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6 дахь хэсэгт зааснаар хамгаалалтын бүсийн ойд явуулахыг хориглосон дараах үйл ажиллагаа: зам, гүүр барих, ус, эрчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргэлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт нөөцийг ашиглахаас бусад үйл ажиллагаа, Ойн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3. Ойн санг эзэмшиж байгаа нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллага нь ойн санг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэйгээр тусгасан менежментийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа явуулна.

Зүйлчлэлийн асуудал

“Ойн тухай хууль зөрчих” зөрчил нь

“Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн; Гэрээний дагуу

эзэмшүүлсэн ойг: түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах арга хэмжээ аваагүй; Зохих зөвшөөрөлтэйгөөр мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй; Мод бэлтгэх, эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн; Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан; Мод, ойн дагалт нөөцийг менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн; Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй; тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог хаягдал, үнс, чүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашигласан; Гэрээний дагуу ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм, нормативын дагуу бүрдүүлээгүй, эсхүл түймэр гарсан үед тэдгээрийг ашиглахад бэлэн байлгаагүй; Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй; Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан” зэрэг шинжтэй байдаг. Энэхүү зүйлд заасан халдлагын зүйл, үйл ажиллагааны явцад хуульд заасан шаардлага зөрчсөн үйлдэл эс үйлдлээрээ гэмт хэргээс ялгагдана.

Эрүүгийн хуулийн_24.6 дугаар зүйл. Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэргийг:

“Зөвшөөрөлгүйгээр ойд мод бэлтгэсэн, гарал үүслийн гэрчилгээгүйгээр мод, модон материалыг бэлтгэсэн, тээвэрлэсэн, худалдсан, худалдан авсан; Энэ гэмт хэргийг: байнга тогтвортой, бүлэглэж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн ойд, төрийн албан хаагч үйлдсэн; Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн” бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

“Зохих зөвшөөрөлгүйгээр” гэж Ойн тухай хуулийн 31 дүгээр зүйлд зааснаар ИТХ-аас тогтоосон хэмжээнд багтаан сум, дүүргийн Засаг дарга, эсхүл эрх бүхий албан тушаалтан иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагад мод бэлтгэх /иргэн, нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг, бэлтгэх модны төрөл, хэмжээ, бэлтгэх, тээвэрлэж дуусгах хугацаа, газрын нэрийг заасан / эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ олгогдоогүй байхад эрүүгийн хуульд заасан дээрх үйлдэл хийсэн нь зөрчлөөс ялгагдах шинж бөгөөд гэмт хэрэгт тооцно.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

ЗТХ-ийн 7.9 дүгээр зүйлд “Ойн тухай хууль зөрчих” зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Зохих бичиг баримт буюу “мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ” байхгүй, эсхүл Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн А-153 тоот тушаалаар батлагдсан “гарал үүслийн гэрчилгээ олгох, хяналт тавих журам”–ын 6 дугаар зүйлд заасныг зөрчсөн мод, модон материалыг саатуулах журамлах арга хэмжээ авна. Мод, модон материалыг тээвэрлэгч нь төв замаар явж дамжин өнгөрөх хяналтын цэгүүдэд

гарал үүслийн гэрчилгээ болон холбогдох бусад бичиг баримтыг байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагч, цагдаагийн ажилтан нарт шалгуулна. Тухайн модыг хэрэглэгч хүртэл тээвэрлэхэд гарал үүслийн гэрчилгээ дагалдах бөгөөд зөвхөн ачсан модтой хамт байхад хүчинтэй байна. Модны бирж болон захуудаас мод, модон материал худалдан авч өөр аймаг, сум руу тээвэрлэхдээ гарал үүслийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулан, зарлагын баримтын хамтаар тээвэрлэнэ. Гарал үүслийн гэрчилгээгүй, гэрчилгээг баталгаажуулаагүй, дамжин өнгөрөх хяналтын цэгт бүртгүүлээгүй, хугацаа хэтэрсэн зэрэг зөрчилтэй мод, модон материалыг зөвшөөрөлгүй бэлтгэсэн, тээвэрлэсэн гэж үзнэ.

2. “Мод, модон материалын гарал үүслийн гэрчилгээ” нь “Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг”-ийг үндэслэн бичигддэг тул зөрчлийг шалгахдаа “Ойгоос мод бэлтгэх эрхийн бичиг” авсан эсэхийг шалгана. Зөвшөөрөл, гэрчилгээ, эрхийн бичиг нь нэгдсэн кодтой тохирч байгаа эсэхийг шалгах.
3. “Зөвшөөрөлгүйгээр ойн дагалт баялаг бэлтгэсэн; Гэрээний дагуу эзэмшүүлсэн ойг: түймэр, хөнөөлт шавж, өвчнөөс хамгаалах арга хэмжээ аваагүй; Зохих зөвшөөрөлтэйгөөр мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй; Мод бэлтгэх, эсхүл ойн дагалт нөөц ашиглахдаа технологийн горимыг зөрчсөн; Ойн сан бүхий газарт хориглосон үйл ажиллагаа явуулсан; Мод, ойн дагалт нөөцийг менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн; Ойн сан бүхий газарт гал түймэртэй тэмцэх, түүнээс сэргийлэх талаар хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй; тээврийн хэрэгсэл, бусад техникийг шатахуунаар цэнэглэх үед тамхи татах, цонх, хаалгаар нь шатах, дэлбэрэх аюул бүхий хог хаягдал, үнс, чүдэнз хаях, оч баригчгүй тээврийн хэрэгсэл ашигласан; Гэрээний дагуу ашиглалт явуулж байгаа газарт түймэр унтраах багаж, хэрэгсэл, техник, тоног төхөөрөмжийг тогтоосон норм, нормативын дагуу бүрдүүлээгүй, эсхүл түймэр гарсан үед тэдгээрийг ашиглахад бэлэн байлгаагүй; Ойн тухай хуулиар тогтоосон шаардлагыг биелүүлээгүй; Гэрээ байгуулахгүйгээр ойгоос мод бэлтгэсэн, эсхүл гэрээний нөхцөл, болзлыг зөрчин үйл ажиллагаа явуулсан” зэрэг үйлдлийн аль нь болохыг тогтоохын тулд холбогдогч, гэрч, хохирогчоос мэдүүлэг авах. Мэдүүлэг авахдаа дараах зүйлийг тодруулж хэвших. Үүнд: ашигласан техник хэрэгслийн марк, төрөл, хүчин чадал, тоо хэмжээ, шатахууны татан авалт, бэлтгэсэн, худалдсан хэмжээ, үнэ, хамрагдсан ажиллагсад, цалин олгосон тооцоо, хөдөлмөрийн гэрээ хийгдсэн эсэх, нийгмийн даатгалын төлөлт, улс орон нутгийн төсөвт төлсөн татвар, хураамжийн хэмжээ гэх мэтээр асууна.
4. Энэ зөрчилд хуулийн этгээдийн асуудлыг шалгахдаа дараах зүйлийг анхаарна. Үүнд: Тухайн аж ахуйн нэгж нь Улсын бүртгэлийн гэрчилгээтэй эсэх, Үндсэн ашиглалтаар үйлдвэрлэлийн

- зориулалтаар мод бэлтгэх эрх авсан эсэх, Мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулах мэргэжлийн байгууллагын эрхтэй эсэх, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, Менежментийн төлөвлөгөөтэй эсэх талаар төрийн байгууллагаас лавлагаа авах.
5. Зөрчлийн улмаас Байгаль орчинд учирсан хохирлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-д зааснаар тогтоолгох.
 6. Тухайн зөрчлийн улмаас хор хохирол хүлээсэн байгууллага, иргэнийг хохирогчоор хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.
 7. Зөрчил үйлдэж олсон мод, модон материал, тэдгээрийн үнэ, хэрэглэсэн зэвсэг, тээврийн хэрэгсэл, унаа хөсөг болон бусад хэрэгсэлд үзлэг хийж улмаар эд мөрийн баримтаар хураан авах битүүмжлэх ажиллагааг прокурорын хяналттай явуулах, хөдөө хээрийн нөхцөлд эсхүл шөнийн цагаар хойшлуулшгүй тохиолдолд хураан авахдаа эхлээд прокурорт дариу мэдэгдэж ажиллагаа дууссанаас хойш 24 цагийн дотор холбогдох баримтын хамт хүргүүлнэ. Эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалт зэргийг нарийвчлан тооцох эдгээрт гарах зардлыг хадгалагч, хамгаалагч байгууллага иргэнээр тодорхойлуулан удирдлагад танилцуулж зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны зардлаас гаргуулах.
 8. Эд мөрийн баримтаар хураагдсан эд зүйл, тээврийн хэрэгслийн эзэмшигч, өмчлөгчийг тогтоож, хөрөнгийн үнэлгээ хийлгэх арга хэмжээ авна.
 9. Ойн ангийн дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч зэрэг үүрэг бүхий албан тушаалтнуудын албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс хамаарч зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн бол Төрийн албаны тухай хуульд зааснаар сахилгын шийтгэл хүлээлгэх эсэх талаар хариуцсан дээд шатны байгууллагад бичгээр хандах. Шаардлагатай бол тухайн газар орныг хариуцаж байсан ойн ангийн дарга, мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараас гэрчийн мэдүүлэг авч, ажил үүргийн хувьд хэн нь юу хариуцдаг болох, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргээс үндэслэн талбай тусгаарлалтыг хэрхэн явуулсан, ойн дагалт нөөц ашиглах эрхийн бичгийн бичилт, хөтлөлт зэргийг үзэх, хуулбарлан авах.
 10. Зөрчил үйлдэгдсэн газар оронд үзлэгийн ажиллагаа хийх. Үзлэгээр тухайн зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдлыг тогтооно. Үүнд: зөрчлийн учир хураасан, битүүмжилсэн мод нь зөрчлийн газарт ургадаг эсэх, бэлтгэсэн байдал, хөрснөөс дээш тайралтын хэмжээ, дундаж, хожуулын өндөр, голч, холтослог шинж, тайралтаас үүссэн ул мөр, цаг агаарын байдал, газрын хэв шинж, газар эвдэгдсэн

байдал, ойн сангийн ерөнхий харагдах байдал зэргийг өөрөө эсхүл мэргэжилтэн оролцуулан тогтоох шаардлагатай. Зөрчлийн газрын үзлэгийн тэмдэглэлд тухайн талбайн тусгаарлалт хийсэн захын цэгүүдийн солбицлыг GPS-ийн тусламжтай тогтоох, тусгаарлалт хийсэн талбайгаас хэтэрч мод бэлтгэл явагдсан талбайн захын цэгүүдийг тогтоох, хэтэрсэн талбай дахь бэлтгэсэн мод, хожуулын тоо хэмжээг тогтоох ажиллагаа хийнэ.

11. Үзлэгээр тогтоогдсон цэгүүдийг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны кадастрын хэлтэст хүргүүлэн хязгаарлалт, хориглолтын бүстэй давхцалтай эсэх, тусгаарлалтын талбай, хэтрүүлэн огтолсон талбай зэргийг харьцуулан шалгуулж, зурагтай лавлагаа авах. Лавлагаагаар тусгай хамгаалалттай газар нутгийн ой болох нь тогтоогдвол эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар зөрчлийн хэргийг прокурорт даруй шилжүүлнэ.
12. Хууль бус мод бэлтгэлийн талбайд улсын байцаагч мэдээллийн дагуу очиж үзлэг явуулахдаа тухайн газрын байршил, орон зайг тодорхойлоход өөрт хялбар болгох үүднээс газрын зураг, google earth, мод бэлтгэл явагдсан талбай тусгаарлах материал зэрэгт үндэслэн урьдчилан гар схем, бичгийн тэмдэглэгээ хийсэн байвал чиг баримжааг зөв тодорхойлох, тухайн ой ямар бүтэцтэй, аль хэсэгтэй гуу жалгатай, аль аль газраас мод ихээр бэлтгэх боломжтой зэргийг баримжаалах ач холбогдолтой байдаг. Зөрчлийн газрын хамгаалалтыг үзлэгийн өмнөх, үзлэгийн үеийн, үзлэгийн дараа үеийн гэж тооцон, хамгаалалтыг зөв оновчтой байдлаар зохион байгуулахгүй бол ойд бэлтгэгдсэн мод алдагдах байдал үүсэх магадлал өндөр байдгийг анхаарах хэрэгтэй. Учир нь мод өөрөө уг зөрчлийн зайлшгүй эд мөрийн баримт болдог тул хамгаалалтыг зөв зохион байгуулж улмаар эд мөрийн баримтаар хураан авах, битүүмжлэх арга хэмжээ авна. Мод бэлтгэгдсэн талбайд үзлэг явуулахад талбай ихтэй, ойн сан бүхий газар байдаг тул баримжаа алдахгүй байх, мод бэлтгэгдсэн талбайн нийт хэмжээ, зураглалыг зөв гаргахын тул байршил тогтоогч буюу “GPS” багажийг зайлгүй ашиглах шаардлагатай юм. Үзлэгийн тэмдэглэлийг цэгцтэй ойлгомжтой болгохын тулд дугаарлах, догол мөр авах, газар орны нэрээр хаяглах зэрэг байдлаар бичих хэрэгтэй. Жишээ нь: “Баяннуур сумын Алагтолгой уулын ар талд мод бэлтгэсэн талбайд хийсэн үзлэг”. “Хайрхан ХХК-ний үйлдвэрлэлийн хашааны зүсэгч 1-р хөрөөний хажууд хураалтай гуалин модонд хийсэн үзлэг” гэх мэтээр бичиж болох юм.
13. **Мод, модон материалын талаарх зөвшөөрлийн бичиг, гэрээ зэрэг бичиг баримт нь** үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарлагдсан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулан материалын шинж онцлогийг нарийн дурдаж тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хураан авах. Тухайн баримтыг үндэслэн холбогдох гэрчээс мэдүүлэг авах, эрх бүхий байгууллагаас лавлагаа хүсэх, илт хуурамч бичиг баримт үйлдсэн,

зөрчлийг хаацайлахын тулд албан тушаалтнаас хуурамч баримт бичиг хийж ирүүлсэн бол прокурорт мэдэгдэж дариу шилжүүлнэ. Гарал үүслийн гэрчилгээгүй болон, гэрчилгээтэй боловч зөрчилтэй /он, сар, өдөр, цаг, минут тавиагүй, гарын үсгийн тайлал байхгүй, тамга тэмдэг бүдэг, бэлтгэн нийлүүлэг, тээвэрлэгчийн мэдээлэл дутуу, тээврийн хэрэгслийн дугаар тавиагүй, модны нэр төрөл, хэмжээ тавигдаагүй, эсхүл эдгээрийг зассан, баллаж сохолсон, код зөрүүтэй гэх мэт/ олон асуудал практикт үүсдэг байна.

Шинжээчээс дараах асуултыг тодруулах:

Шинжилгээнд хүргүүлж буй /шинжээч ихэвчлэн өөрөө очиж үзэж тодорхойлдог/ мод, модон материалын талаар үйлдэгдсэн зөрчлийн шинж байдлаас хамаарч дараах асуудлуудаас сонгож тавих боломжтой. Үүнд: ямар төрөл, ангиллын, хэдэн настай мод болох, хуурай, нойтон, чийгшил, хэмжээ, зориулалт, үндсэн ашиглалтаар үйлдвэрлэлийн зориулалтаар огтлолдог эсэх, тухайн газрын ойгоос арчилгаа цэвэрлэгээ, үндсэн ашиглалт, үйлдвэрлэлийн огтлолтын зориулалтаар мод бэлтгэх зөвшөөрөл олгогддог эсэх, мод бэлтгэлийн үйл ажиллагаа явагдах талаар ойн нөөц, тооллогод авсан эсэх, тухайн мод бэлтгэл хийсэн газар нутаг нь ямар мужлал, бүсэд хамаарах, хууль бус мод бэлтгэлд өртсөн талбайг нөхөн сэргээхэд ямар хэмжээний зардал гарах, модны экологи-эдийн засгийн үнэлгээг тогтоож байгаль орчинд хэдэн төгрөгийн хохирол учирсан болох гэх мэт байна.

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ-1

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Х нь сумын ойг гэрээгээр эзэмшиж буй нөхөрлөлүүдийн үйл ажиллагааг шалгах төлөвлөгөөт удирдамжийн дагуу шалгалт явуулав. Шалгалтаар гэх газарт гэрээгээр ой эзэмшиж буй нөхөрлөлийн дарга Л нь 2500 га хамарсан ойн түймрийн үед урьд өмнө хамгаалах арга хэмжээ авч байгаагүй нь тогтоогдсон байна. Энэ тохиолдолд улсын байцаагч Х холбогдогч Л-тэй уулзахад гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн тул, ил тодорхой гэж үзэн хялбаршуулсан журмаар шийдвэрлэж торгуулийн арга хэмжээ авна.

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ-2

Ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй -ийн үйл ажиллагаанд шалгалт хийх явцад аймгийн сумын нутгаас 2016 онд цэвэрлэгээний огтлолтын чиглэлээр 400 куб метр модны зөвшөөрөл авч мод бэлтгэсэн атлаа мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй, технологийн горимыг зөрчиж нэг дороос хавтгайруулан огтлолт хийсэн зөрчил дутагдлыг илрүүлэн шалгасан байна. Шалгалтын явцад талбай тусгаарлан өгсөн баримтад тусгагдсан талбайн захын цэгүүдээс хэтрүүлэн 0.5 га талбайд огтлолт хийсэн нь тогтоогдсон байна.

Энэ тохиолдолд 0.5 га талбайн хэтэрсэн огтлолт хийж тухайн талбайд мод бэлтгэх эрх олгогдоогүй тул уг үйлдэлд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй. Эрүүгийн хуулийн **24.6 дугаар зүйлд заасан “Хууль бусаар мод бэлтгэх” гэмт хэрэгт** ямар нэг хохирлын хэмжээ заагаагүй тул дээрх үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ. Улсын

байцаагчаас авах арга хэмжээ: “..... ХХК-ийн талбай тусгаарлан өгсөн захын цэгүүдээс хэтрүүлэн 0.5 га талбайд огтлолт хийсэн” үйлдлийг прокурорт мэдэгдэж, холбогдох материалыг хүргүүлнэ. Прокурор ЭХХШТ хуульд заасан журмаар Эрүүгийн хуулийн 24.6 дугаар зүйлд заасан хэргийг шалгуулахаар цагдаагийн байгууллагад шилжүүлнэ.

Харин “Ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй ХХК-ийн үйл ажиллагаанд шалгалт хийх явцад аймгийн сумын нутгаас 2016 онд цэвэрлэгээний огтлолтын чиглэлээр 400 куб метр модны зөвшөөрөл авч мод бэлтгэсэн атлаа мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй”, “технологийн горимыг зөрчиж нэг дороос хавтгайруулан огтлолт хийсэн зөрчил”-д зөрчил шалгах ажиллагаа явуулна.

Уг зөрчлийг шалгах ажиллагаа:

- ХХК-ийн мэргэжлийн байгууллагын гэрчилгээ, улсын бүртгэлийн гэрчилгээ, цэвэрлэгээний огтлолттой холбоотой гэрээ, эрхийн бичиг, гарал үүслийн гэрчилгээ, удирдлагын иргэний бичиг баримтыг үзэж шалган хуулбарлана авна.
- Холбогдох хууль, журам, Засгийн газраас баталсан модны үнэлгээ зэрэг эрх зүйн баримт бичгийн холбогдох хэсгийг зөрчлийн хэрэгт хийх,
- Зөрчлийн газарт дээр дурдсан аргачлалын дагуу үзлэг хийх.
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцох хохирогчийг тогтоолгон мэдүүлэг авах.

Үйлдэгдсэн зөрчилд тооцох, түүнд хүлээлгэх хариуцлага:

1. “Ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй ХХК нь аймгийн сумын нутгаас 2016 онд цэвэрлэгээний огтлолтын чиглэлээр 400 куб метр модны зөвшөөрөл авч мод бэлтгэсэн атлаа мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй” үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 3-д зааснаар хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй ХХК нь аймгийн сумын нутгаас 2016 онд цэвэрлэгээний огтлолтын чиглэлээр 400 куб метр модны зөвшөөрөл авч мод бэлтгэх явцдаа “технологийн горимыг зөрчиж нэг дороос хавтгайруулан огтлолт хийсэн зөрчил”-д Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 4-д зааснаар хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Шийдвэрлэх шатанд Зөрчлийн хуулийн ерөнхий анги хэрэглэх нь:

ЗТХ-ийн 1.3 дугаар зүйлийн 2 “Энэ хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна”. **2.2 дугаар зүйлийн 1** “Зөрчлийг хамтран үйлдсэн хүн, хуулийн этгээд тус бүрд шийтгэл оногдуулна” гэж заасан байна. Зөрчлийн шинж байдлаас дээрх 2 зөрчлийг “нэг үйлдэл, эс үйлдэхүй” гэж үзэхээргүй байх тул зөрчил тус бүрт хариуцлага хүлээлгэнэ.

Эцэслэн шийдвэрлэх ажиллагаа:

1. “Ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй ХХК нь аймгийн сумын нутгаас 2016 онд цэвэрлэгээний огтлолтын чиглэлээр 400 куб метр модны зөвшөөрөл авч мод бэлтгэсэн атлаа мод бэлтгэсэн талбайгаа цэвэрлээгүй” үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 3-д зааснаар хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Ойн мэргэжлийн байгууллагын эрхтэй ХХК нь аймгийн сумын нутгаас 2016 онд цэвэрлэгээний огтлолтын чиглэлээр 400 куб метр модны зөвшөөрөл авч мод бэлтгэх явцдаа “технологийн горимыг зөрчиж нэг дороос хавтгайруулан огтлолт хийсэн зөрчил”-д Зөрчлийн тухай хуулийн 7.9 дүгээр зүйлийн 4-д зааснаар хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Хохирол, нөхөн төлбөр, торгуулийн орлого заасан хугацаанд төлөгдөөгүй бол албадан гүйцэтгүүлэхээр шүүхэд иргэний журмаар хандаж нэхэмжлэл гаргана.

“ҮЗЛЭГИЙН ЗАГВАР, ЖИШЭЭ”

Тусгай Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэрэгт цагдаагийн байгууллага хэрхэн үзлэг хийж тэмдэглэл хөтөлдөг болох, үүнээс зөрчлийн газрын үзлэг хийхдээ авч ашиглах санаа, арга ажиллагааг мэдүүлэх үүднээс доорх “Хэргийн газрын үзлэг хийсэн” тэмдэглэлийг загвар жишээн дээр зохиомжлон оруулав. /үзлэгт ашиглахаар бол зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.3-т заасныг дурьдана/

Ойн тухай хууль тогтоомж зөрчих гэмт хэргийн газарт үзлэг хийж, техник хэрэгслээр бэхжүүлэн авсан тухай тэмдэглэл

20...-...-... аймгийн сумын нутагМөрдөн байцаах албаны Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн Чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа би Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 126,127,130 дугаар зүйлд заасныг баримтлан захиралтай ХХК нь онд аймгийн, сумын нутаг дэвсгэрт тусгаарлалт хийгдсэн талбайдаа заагдсан хэмжээнээс хэтрүүлэн мод бэлтгэж байгаль орчинд хохирол учруулсан” хэрэгт 2016 онд огтолсон модны хожуулыг нэг бүрчлэн тоолж, уг газраас нийт бэлтгэсэн модны хэмжээг тодорхойлох, мод бэлтгэхийг зөвшөөрч тусгаарласан талбайгаас гадна, зөвшөөрөлгүй буюу талбай хэтэрч мод бэлтгэсэн эсэхийг тогтоох зорилгоор Сэлэнгэ бэлчрийн бүсийн Сум дундын ойн ангиас оны ... дугаар сарын ...-ны өдөр дугаартай актаар, цэвэрлэгээний зориулалтаар мод бэлтгэх талбай тусгаарлан өгсөн аймгийн сумын дүгээр багийн нутаг гэх газарт байрлах мод бэлтгэсэн талбайд хэсэгчилсэн үзлэг хийж тэмдэглэл үйлдэв.

Уг ажиллагааг хөдөө хээрийн нөхцөлд хөндлөнгийн гэрч байлцуулах боломжгүй тохиолдолд явуулж байгаа тул Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 127 дугаар зүйлийн 127.2-д заасныг баримтлан Газар зүйн

байршил тогтоогч “GARMIN 62s” маркийн GPS багаж болон “Nikon D5100” маркийн 13.5 мегапексил нягтралтай, 18-55 мм-ийн 1/3.5-5.6G дурангийн үзүүлэлттэй, джитал тонн технологид суурилагдсан, өнгөт фото зургийн аппарат, COOLSHOT маркийн Лазерийн зайн хэмжигч, туузан метр зэргийг техник хэрэгсэл болгон ашиглаж үзлэгийн явц үр дүнг бэхжүүлсэн болно.

Уг ажиллагаанд бэлчрийн Сум дундын ойн ангийн талбай тусгаарлалтын инженер, регистрийн дугаартай, дугаарын холбоо барих утастай байлцуулав.

Үзлэгийг байгалийн гэрэлд, ердийн, үүлэрхэг бүрхэг зэрэг цаг агаарын олон талт нөхцөлд оны ... сарын -ны өдрийн ... цаг ... минутаас эхлэн-ний өдрийн цаг минутыг хүртэл явуулж МУ-ын ЭБШХ-ийн 130 дугаар зүйлд заасны дагуу тэмдэглэл үйлдэв.

Үзлэгээр илэрсэн нь:

..... ХХК-ийн онд дугаарын актаар тусгаарлан өгсөн талбайд мод бэлтгэсэн гэх газар нь аймгийн сумын ... дүгээр багийн нутаг гэх нэршилтэй газар байх бөгөөд уг газар нь сумын төвөөс баруун хойд зүгт км зайд байрлаж байна.

Үзлэг хийж буй газар нь анхнаасаа талбай тусгаарлалт зөв хийгдсэн эсэхийг тусгаарлалтын баримт дээрх координатаар илэрхийлэгдсэн 1-4 цэгийг байрлал тогтоогчоор шалгаж үзэхэд баримттай тохирч байна. Хэтрүүлэн огтлолт явсан эсэхийг шалгахад 1-2, 2-3-р цэгүүдийн шулуун шугамаар татагдсан талбайн захын хилийг хэтрүүлэн 21-52 метрийн зайд огтлолт явагдсан байна. Хэтэрч огтлолт явуулсан ой модны хожуул бүрийг нэг бүрчлэн хар өнгийн будагчаар дугаарлан, хэтрүүлэн огтлолтод өртсөн талбайн гадна захын цэгүүдийн солбицлын өнцгүүдийг тогтоон цаашид хэргийн газрын үзлэгийн схем үйлдэхэд ашиглах зорилгоор зурагжуулав. Үзлэгийн явцад хэтрүүлэн огтлолтод өртсөн талбайд байгаа шинээр тайралтад өртсөн гэхээр модны хожуул 453 ширхэг байна. Дээрх хожуул тус бүрийг газрын гадаргуугаас дээш жигд 30 см зайд тойргийн хэмжээг авч хожим экологийн хохирол тооцуулахад ашиглах зорилгоор үзлэгийн тэмдэглэлд хүснэгтээр хавсаргав. Шинээр тайралтад өртсөн гэхээр шинж нь хожуулын орой хэсэг цагаан шаргал өнгөтэй, холтос нь улаан хүрэн өнгөтэй, холтос мод хоёр өмхөрч сулраагүй, хожуулын доорх цасан дээр шинэхэн тайралтаас үүссэн гэхээр цагаан шаргал үртэс цацагдсан, ойр орчимд нь шилмүүст ногоон модны дээд үзүүр хэсгийг тайраад эмх замбараагүй хаясан байдалтай байна. Дээрх хожуулын орчимд ачигч, чирэгч зэрэг уулын машин механизмын мөрнүүд гарсан байх ба мөрнүүдийг зургаар бэхжүүлэн, бичлэг хийж дагахад зүүн зүг 860 метр яваад ердийн шороон замтай нийлж улмаар 250 метр яваад шороон замаас баруун зүгт салж баруун тийш 310 метр үргэлжлээд ХХК-ийн ойн аж ахуйн отог дээр ирсэн болно. Уг талбайгаас хойд зүгт 220 метрийн зайд 450 ширхэг тайрч бэлтгэсэн мод байна. Уг моднуудаас 6 метрийн урттай 250 ширхгийг нь 2 метрийн урттай тайрч бонго маркийн ширхэг авто машинд ачсан байна. Үлдсэн 200 ширхэг 6 метрийн урттай моднуудыг хэмжихэд үзүүр хэсгийн голч /диаметр/ 21 см, тойргийн хэмжээ 44 см, суурь хэсгийн

голч 45 см, тойргийн хэмжээ 74 см байв.

Мөн тоолсон хожуулын нас хэмжээг тодорхойлоход харьцуулах зорилгоор тухайн ойд нийтлэг ургасан, тайралтад өртөөгүй ургаа мод 30 ширхгийг сонгон авч тэдгээрийг газрын гадаргуугаас дээш 130 см дэх тойргийн хэмжээг авч тусад нь хүснэгтэн хавсралтад тэмдэглэв. /хавсралт хүснэгтэд “ургаа модны хэмжилт” гэсэн нэр өгч тэмдэглэв/

Үзлэгийн явц, үр дүнг мөрдөн байцаагчаас тэмдэглэлд тусгагдсан зургийн аппаратаар нийт 45 кадр зураг авч бэхжүүлэн EPSON L-100 маркийн өнгөт принтерээр А4 цагаан цаасан дээр хэвлэн тэмдэглэлд хавсаргасан ба үзлэг хийгдсэн газруудын байршил, ойн сангийн байдал болон бусад тэмдэглэгдэхүйц байршлыг тусгасан гар схем зургийг бүдүүвч байдлаар зурж хавсаргасан болно.

Үзлэгийн тэмдэглэл, хавсралтын хамт нийт 6 хуудас материалыг оролцогч нараар өөрсдөөр нь уншуулан танилцуулахад санал хүсэлт гаргаагүй болно.

Оролцсон :

.....

Оролцсон :.....

Үзлэг хийж тэмдэглэл хөтөлсөн : Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн Чиглэлийн ахлах мөрдөгч, цагдаагийн дэд хурандаа.....

..... аймгийн сумын нутаг гэх газрыг бүхэлд нь хамруулан хийсэн оны дугаар сарын-ны өдрийн хэргийн газрын үзлэгийн гэрэл зургийн үзүүлэлт

1. Шилмүүст ногоон модыг тайрч үзүүр хэсгийг хожуулын эргэн тойронд хаясан байдал



2. 200 ширхэг 6 метрийн урттай тайрсан модны байдал



3. 250 ширхэг модны 2 метрээр тайрч Мазда Бонго машинд ачиж тээвэрлэсэн байдал



ХЭРГИЙН ГАЗРЫН ҮЗЛЭГИЙН ТЭМДЭГЛЭЛИЙН ХАВСРАЛТ

Тоо ширхэг	Тойргийн хэмжээ /см-ээр/	Тоо ширхэг	Тойргийн хэмжээ /см-ээр/	Тоо ширхэг	Тойргийн хэмжээ /см-ээр/
1					
2					
3					
4					

3.8 Газрын хэвлийн тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлд дараах байдлаар заасан. Үүнд:

1. Газрын хэвлийг дур мэдэн ашигласан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан, эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Газрын хэвлийг:
 - 4.1. Ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй;
 - 4.2. Ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй;
 - 4.3. Ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй;
 - 4.4. Ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн:

- 5.1. Зураг төсөл зохиох;
- 5.2. Тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсч болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй бол хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8. Ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мэргэжлийн нэршил, холбогдох хууль тогтоомж

“Газрын хэвлий” гэж хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг хэлнэ. Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар газрын хэвлий нь төрийн өмч, өөрөөр хэлбэл бүх ард түмний хөрөнгө юм. Газрын хэвлийг зөвхөн ашиглуулахаар олгоно. Газрын хэвлийг төр өмчлөх эрхийг аливаа хэлбэрээр зөрчихийг хориглоно.

Газрын хэвлийг Монгол Улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэд ашиглана. Мөн Монгол Улсын хууль тогтоомжид заасан тохиолдолд газрын хэвлийг гадаад улсын хуулийн этгээд, иргэн, харьяалалгүй хүнд зохих журмын дагуу ашиглуулж болно.

Газрын хэвлийг дор дурдсан зориулалтаар ашиглуулахаар олгодог. Үүнд:

- 1) Геологийн судалгаа хийх;
- 2) Ашигт малтмал олборлох;
- 3) Ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах;
- 4) Аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах.

Газрын хэвлийд ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал

олборлохтой холбогдсон харилцааг “Ашигт малтмалын тухай” хуулиар зохицуулна.

Газрын хэвлийг ашиглагчид нь газар эзэмшигч, ашиглагчдаас зохих журмын дагуу зөвшөөрөл авна.

Газрын хэвлийг ашиглах хугацаа:

Газрын хэвлийг хугацаагүй буюу хугацаатайгаар ашиглалтад олгож болно. Газрын хэвлийг урьдчилан тодорхой хугацаа тогтоолгүйгээр ашиглалтад олгосон бол хугацаагүй түрээслэн ашиглах гэнэ. Газрын хэвлийг ашиглалтад хугацаатай олгох нийт хугацаа 30 жилээс илүүгүй байна. Шаардлагатай бол тогтоосон хугацааг газрын хэвлийг түрээслэн ашиглуулахаар анх олгосон байгууллагын шийдвэрээр сунгаж болох бөгөөд нэг удаад сунгах хугацаа 20 жилээс дээшгүй байна. Ашигт малтмалын ордыг ашиглах, хугацааг геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад уурхайн эдэлбэрийн зөвшөөрлийг бүртгүүлсэн өдрөөс эхлэн тооцно.

Газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгох үндэслэл, журамд дараах байдлаар зохицуулагдана. Үүнд:

1. Газрын хэвлийг ашиглах эрхийг дор дурдсан тохиолдолд бүрэн буюу хэсэгчлэн дуусгавар болгоно,
 - Газрын хэвлийг цаашид ашиглах шаардлагагүй болсон;
 - Газрын хэвлийг ашиглахаар тогтоосон хугацаа дууссан;
 - Төрийн буюу олон нийтийн бусад хэрэгцээнд зориулан газрын хэвлийг буцаан авах зайлшгүй шаардлага гарсан;
 - Газрын хэвлийг ашиглаж байсан аж ахуйн нэгж, байгууллагыг татан буулгасан;
 - Хүн амын эрүүл мэндэд аюултай байдал бий болсон.
2. Хэрэв газрын хэвлийг ашиглагч нь дор дурдсан зөрчил гаргавал газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгож болно:
 - Газрын хэвлийг олгосноос хойш 3 жилийн хугацаанд ашиглаж эхлээгүй;
 - Газрын хэвлийг олгосон зориулалтаас өөрөөр ашигласан; Хуулиар тогтоосон үүргээ биелүүлээгүй;
 - Газрын хэвлийг ашиглах, хамгаалах бусад журмыг өөр хэлбэрээр ноцтой зөрчсөн.
3. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэд газрын хэвлийг аж ахуйн болон ахуйн хэрэгцээндээ зориулан ашиглах талаар тогтоосон журам, нөхцөлийг зөрчвөл газрын хэвлийг ашиглах эрхийг нь дуусгавар болгож болно.
4. Газрын хэвлийг ашиглах эрхийг дуусгавар болгох өөр үндэслэлийг Монгол Улсын хууль тогтоомжоор тогтоож болно.
5. Газрын хэвлийг ашиглах эрхийг уурхайн эдэлбэр олгосон тухай акт буюу газрын хэвлийг ашиглуулах тухай зөвшөөрөл олгосон байгууллага нь акт буюу зөвшөөрлөө хүчингүй болгох замаар дуусгавар болгоно.

“Газрын хэвлий” гэдэг нь Газрын хэвлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд хөрснөөс доош газрын гүн рүү үргэлжлэх орон зай, түүнийг эзлэн орших материаллаг бүх зүйлс /бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет, түүнчлэн барилга байгууламж/-ийг газрын хэвлий гэнэ гэж заасан байна.

“Газрын хэвлийг ашиглах” гэдэг нь Газрын хэвлийн тухай хуульд зааснаар геологийн судалгаа хийх /Газрын хэвлийн тухай хуулийн 12 дугаар зүйл/, ашигт малтмал олборлох /Газрын хэвлийн тухай хуулийн 13 дугаар зүйл/ ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж, түүний дотор нефть, хий, бусад бодис, материал хадгалах, хортой бодис, үйлдвэрлэлийн хаягдлыг хамгаалан булах, бохир ус зайлуулахад зориулан барилга байгууламж барих, ашиглах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн бусад хэрэгцээг хангах зориулалтаар /Газрын хэвлийн тухай хуулийн 15 дугаар зүйл/ ашигт малтмалын хайгуул хийх, ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг хэлэх бөгөөд ашигт малтмал хайх, ашиглах, олборлохтой холбогдсон харилцааг Ашигт малтмалын тухай хуулиар зохицуулахаар хуульчилжээ. Газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам нь Газрын хэвлийн тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан “газрын хэвлийг ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар ашиглах журам” байна.

Зүйлчлэлийн асуудал

“Газрын хэвлийн тухай хууль зөрчих” зөрчил нь:

“Газрын хэвлийг дур мэдэн ашигласан; Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан, эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн; Газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн; Газрын хэвлийг: ашиглах явцад эвдэрсэн газрыг аюул осолгүй болгож цаашид ашиглаж болохуйцаар засаж тохижуулаагүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг зохих байгууллагад мэдэгдээгүй, ашиглах үед илэрсэн үнэт металл, үнэт чулуу, шинжлэх ухаан, түүх, соёлын үнэт зүйлийг улсад тушаах хуульд заасан шаардлагыг биелүүлээгүй, ашиглах үед түүнийг хамгаалах талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй; Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн: зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн; Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн; Газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсч болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүй; Ашигт малтмалын ордыг гэмтээж сүйтгэсэн, баялаг хэсгийг нь сорчлон олборлосон, эсхүл ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах

шаардлагыг зөрчсөн, олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн” зэрэг шинжтэй байдаг. Энэхүү зүйлд заасан халдлагын зүйл, үйл ажиллагааны явцад хуульд заасан шаардлага зөрчсөн үйлдэл эс үйлдлээрээ гэмт хэргээс ялгагдана.

Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэргийг: “Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доорх барилга байгууламж барьж хууль бусаар газрын хэвлийд халдсан” гэж томъёолсон байна. 2002 оны Эрүүгийн хуулийн 204 дүгээр зүйлд “Газрын хэвлийн хууль тогтоомж зөрчих” гэмт хэргийг тусгайлан заасныг 2017 оны шинэ Эрүүгийн хуулиар **“Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэгт нэгтгэн, нэг зүйлд багтааж хүндрүүлэх шинжүүдийг гэмт хэрэгт тооцсон ба зөрчлийн хуульд заасан дээрх шинжүүдийг “зөрчил” болгон заасан байна.**

24.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн” бол хүндрүүлж үзэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан.

Зөрчлөөс ялгагдах гол шинж нь дээр дурдсан зөрчлийн шинжийг агуулалгүйгээр “... ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доорх барилга байгууламж барьж **хууль бусаар газрын хэвлийд халдсан**” үйлдэл юм. Уг “халдах” үйлдэлд ямар нэг хохирлын хэмжээ заагаагүй бөгөөд онолын хувьд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг тул тодорхой үйлдэл хийснээр төгссөнд тооцогдоно. “Хууль бусаар” гэж газрын хэвлийд халдах тодорхой эрх үүсгэсэн бичигт баримт олгогдоогүй эсхүл газрыг эзэмших, ашиглах эрх үүссэн боловч хуульд заасан тусгай шаардлагаар “газрын хэвлийд халдах” эрх үүсгэсэн баримт бичиг олгогдоогүй, батлагдаагүй, зөвшөөрөгдөөгүй байхад эрүүгийн хуульд заасан дээрх үйлдэл хийсэн нь зөрчлөөс ялгагдах шинж бөгөөд гэмт хэрэгт тооцно.

“Газар доорх байгууламж ашиглалтад оруулах, ашиглах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн” үйлдэл нь Газрын хэвлийн тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасан “... ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн зураг төсөл зохиох, тэдгээрийг барих ашиглалтад оруулахад тавигдах хуулийн шаардлагуудыг хангаагүй байхыг ойлгоно.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

7.10 дугаар зүйлд заасан “Газрын хэвлийн тухай хууль зөрчих” зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Шалгаж буй зөрчлийн онцлогт тохируулан газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, ой, ургамал, амьтан, агаарыг хамгаалах, тэдгээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, стандарт, хэм хэмжээ, дүрэм, журам, шийдвэрийг олж судалсан байх /зохих мэдлэгийг өөртөө хуримтлуулах/;

- Байгаль орчинд нөлөөлөх үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн төсөл, хөтөлбөр, хийгдсэн гэрээний байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, гэрээгээр заасан байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой заалтын биелэлтийг шалгах;
- Тухайн газар нь Тусгай хамгаалалттай газрын хилийн заагт багтаж буй эсэхийг шалган тогтоох /Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд зааснаар газрын хэвлийд халдах нь тусгай журам, шаардлага үйлчилдэг тул гэмт хэрэг эсхүл зөрчлийн алин болохыг ялгах зүйлчлэлийн ач холбогдолтой/;
- Газрын хэвлийн ашиглалтын байдлыг энгийн нүдээр харж үнэлэлт дүгнэлт өгөх ба үзлэг хийхдээ гэмт хэрэг үйлдэгдсэн газар орны онцлог, нөхцөл байдал, одоогийн байгаа байдлыг тодорхойлж үзлэгийн тэмдэглэлд тусгахаас гадна үүссэн газрын эвдрэл, нөхөн сэргээлтийн байдлыг /газрын хэвлийг ухах, ухаш \карьер\, овоолго үүсгэж засаж тохижуулалгүй орхисон гэх мэт/ GPS буюу орон зайн байрлал тогтоогч ашиглан уртраг, өргөргийг тодорхойлно. Энэ төрлийн зөрчлийн газарт үзлэг хийхдээ байршил тогтоогч багаж \GPS\, эвдэрсэн талбайн хэмжээг тогтоох зай хэмжигч, метр, лац, ломбо, фото аппарат, дүрс бичлэгийн камер, дээж авах сав, уут, хүрз, жоотуу, лоом зэрэг багаж хэрэгслийг ашиглах шаардлагатай. Үзлэгийн тэмдэглэлийг цэгцтэй ойлгомжтой болгохын тулд дугаарлах, догол мөр авах, тодорхой объект, газар орны нэрээр хаяглах зэрэг байдлаар бичих хэрэгтэй. Жишээ нь: “Баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн талбайд хийсэн үзлэг”. “Уурхайн эдэлбэр газрын ахуйн хог хаягдлын цэгт хийсэн үзлэг” гэх мэтээр бичиж болох юм.
- Үзлэгээр тогтоогдсон цэгүүдийг орон нутгийн газрын албад, Ашигт малтмалын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны кадастрын хэлтэст хүргүүлэн хязгаарлалт, хориглолтын бүстэй давхцалтай эсэх, тусгай зөвшөөрлийн талбайн байдал, уурхайн эдэлбэр газрын зөвшөөрөл зэргийн талаар зурагтай лавлагаа авах.
- Археологийн болон палентлогийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн эсэх, түүх соёлын үнэт зүйлийг уулын ажлын явцад эвдэж сүйтгэх, зохих байгууллагад мэдэгдсэн эсэхийг шалгах.
- Газрын хэвлий ашиглах явцад илэрсэн үнэт чулуу, үнэт металл, шинжлэх ухаан, түүх соёлын үнэт зүйлийг улсад тушаасан эсэхийг шалгах.
- Нефтийн компаниуд, нефтийн хог шаарыг мембран, флёнк дэвсэсгүйгээр эсвэл техникийн шаардлагын дагуу дэвсээгүйгээс эдгээр нь задарч газрын хөрс усанд шингэж байгаа эсэхийг мэргэжлийн байгууллагын туслалцааг авч тогтоох, /шинжилгээний дээжийг сонгон авч энэ тухай тэмдэглэл үйлдэн шинжлүүлж байх/
- Уул уурхайн техник эдийн засгийн үндэслэлүүдэд чиглэсэн шалгалтыг явуулж байх.
- Геологи, уул уурхайн үйлдвэрлэл, техник, тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагааны талаарх хууль тогтоомж, дүрэм, журмын болон

үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх талаар авсан арга хэмжээг шалгах.

- Ордыг сорчлон олборлохчлоод хаягдал болон эфель олборлох гэсэн аж ахуйн нэгжид лицензээ шилжүүлсэн асуудал байгаа эсэхийг анхаарч шалгах /Уулын ажлын технологийн горимыг зөрчсөнөөс болж байгалийн баялгийг сорчлон олборлож их хэмжээний хаягдал үүсгэж байна. Энэ нь хувиараа буюу гар аргаар ашигт малтмал олборлох боломж бий болгож байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж байна/
- Газрын хэвлийн хууль тогтоомж зөрчсөн тухайн аж ахуйн нэгжийг урьд өмнө төрийн эрх бүхий байгууллага /Мэргэжлийн хяналтын байгууллага, Ашигт малтмалын газар, Усны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, орон нутгийн албадуут гэх мэт/-аас шалгаад тавьсан акт, албан шаардлага, мэдэгдэл, дүгнэлт, шинжилгээний хариу, торгуулийн тасалбар, шийтгэвэр, маргаантай асуудлаар гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, албан бичиг зэрэг тухайн асуудалтай холбогдол бүхий баримт бичигт үзлэг хийж хэрэгт хуулбарлан хавсаргаж байх.
- Мөн тухайн аж ахуйн нэгжийн дотоод бичиг баримтад үзлэг хийж шалгаж буй хэрэгт хамааралтай тушаал, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, хамтран ажиллах болон туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, ашиг хуваарилсан баримт, уулын ажлын төлөвлөгөө, хайгуулын ажлын тайлан, нөөцийн материал, орд газрын болон уурхайн байгууламжийн зураглал, сүүлийн байдлаар хийсэн хөрсний зураглал /3D технологи/, үндсэн, охин, толгой зэрэг компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээ, татварын тайлан, үүсгэн байгуулалт болон хөрөнгө оруулагчтай холбоотой баримт зэргийг хураан авах, хуулбарлан авах ажиллагааг явуулна.
- Газрын хэвлийг ашиглах хамгаалах журам зөрчсөний улмаас мал амьтан, байгаль орчинд хохирол учирсан байдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-аар тооцож тогтоолгох. Хохирол нөхөн төлүүлэх явдлыг хангахад чиглэгдсэн ажиллагааг прокурорт танилцуулан шийдвэрлэх.
- Ашигт малтмал бүхий талбайд барилга байгууламж дур мэдэн барьсан, эсхүл газар доорх усны горимыг ашиглах цооног, геодези, маркшейдерийн тэмдгийг устгасан, эсхүл гэмтээсэн үйлдлийг үзлэг хийж, гэрэл зургаар бэхжүүлэх.
- Газрын хэвлийд геологийн судалгаа хийх журам, шаардлагыг зөрчсөн нь хайгуул хийсэн ашигт малтмалын нөөцийг буруу үнэлэх, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барилга байгууламж барих нөхцөлийг буруу тодорхойлоход хүргэсэн бол гэрч, холбогдогчоос энэ талаар тодорхой мэдүүлэг авах, журамд заасан шаардлага бүрийг тавьж асуух

- Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн: зураг төсөл зохиох, тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн бол зураг төслийг хураан авах, хуульд заасан эрхтэй эсэхийг шалгах, хуульд нийцүүлэн гарсан журмын шаардлага нэг бүрээр эрх бүхий албан тушаалтнаас мэдүүлэг авах, зураг төсөлд баталгаажилт хийсэн эрх бүхий аж ахуйн нэгж, албан тушаалтны үйлдэл тус бүрийг мэдүүлэгт тусгах, барилгын ажил гүйцэтгэхтэй холбоотой тусгай зөвшөөрөл, ажил гүйцэтгэх гэрээ, туслан гүйцэтгэгчийн гэрээ, бараа материалын захиалгыг хуудас, үйлдвэрлэгчийн баталгаа, ажлын яцыг шалгасан төрийн байгууллагын комиссын шийдвэр дүгнэлт зэргийг анхаарах, ашиглалтад хүлээн авсан акт, шийдвэр, тэдгээрийн заалт нэг бүрийг судлах.
- Газрын хэвлийг ашиглах аюулгүй ажиллагааны дүрэм, хэм хэмжээг зөрчсөн; Газрын хэвлийг хамгаалах журам, түүнийг ашиглахад үүсэж болзошгүй аюул осол, хортой нөлөөнөөс ажиллагчид, хүн ам болон мал, ан амьтан, байгаль орчин, барилга байгууламжийг хамгаалах шаардлагыг биелүүлээгүйн улмаас бохирдол үүссэн бол баримтжуулан прокурорт мэдэгдэж цагдаагийн байгууллага эрүүгийн хэрэг үүсгэн шалгах үндэслэл болно.
- Газрын хэвлийг ашиглах, хамгаалах журам зөрчсөний улмаас ан амьтан, байгаль орчинд учруулсан хохиролд төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас томилсон этгээд болон иргэнээс хохирогчоор хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.
- Хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтнуудын албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс хамаарч зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн бол Төрийн албаны тухай хуульд зааснаар сахилгын шийтгэл хүлээлгэх эсэх талаар хариуцсан дээд шатны байгууллагад бичгээр хандах. Шаардлагатай бол тухайн газар орныг хариуцаж байсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараас гэрчийн мэдүүлэг авч, ажил үүргийн хувьд хэн нь юу хариуцдаг болох, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргийг үзэх, хуулбарлан авах.
- **Шалгалтын явцад илэрсэн зөвшөөрлийн бичиг, төсөл, хөтөлбөр, ТЭЗҮ, гэрээ зэрэг бичиг баримт нь үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарлагдсан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулан материалын шинж онцлогийг нарийн дурдаж тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хураан авах. Тухайн баримтыг үндэслэн холбогдох гэрчээс мэдүүлэг авах, эрх бүхий байгууллагаас лавлагаа хүсэх, илт хуурамч бичиг баримт үйлдсэн, зөрчлийг хаацайлахын тулд албан тушаалтнаас хуурамч баримт бичиг хийж ирүүлсэн бол прокурорт мэдэгдэж дариу шилжүүлнэ.**

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ-1

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Х нь ХХК-ийн аймгийн сумын Ногоон нэртэй газарт орших полиметаллийн баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагааг шалгах төлөвлөгөөт удирдамжийн дагуу шалгалт явуулав. Шалгалтаар баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн газар нь уурхайн эдэлбэр газарт ордоггүй, газар ашиглах эрхийн гэрчилгээ болон орон нутагтай байгуулсан гэрээ байгаа боловч хугацаа нь дуусаж сунгуулаагүй, хаягдлын далангийн зураг төсөл нь-улсын “.... ..” компанийн зураг төсөл гэх боловч хянан баталгаажилт хийгдээгүй, хятад ханз бүхий зургийг орчуулгагүйгээр тэр чигт нь хуулбарлан тавьсан, хаягдлын даланд ашигласан флэнк буюу гоёмембран давхарга дэвсэхдээ очлуурт шалгалт хийгээгүйн улмаас шаардлага хангахгүй материалаар хийгдэж нэлэнхийдээ урагдаж салбарсан, цаашид хаягдлын даланд хуримтлагдсан технологийн бохир ус нэмэгдэж байгальд хаягдаж болзошгүй нөхцөл байдал бий болсон байна.

Уг зөрчлийг шалгах ажиллагаа:

- ... ХХК-ийн Дорнод аймгийн сумын нэртэй газарт газар доор барих хаягдлын далангийн барилга байгууламжийн зураг төсөл хаанахын ямар компаниар хийлгэсэн болох, хэрхэн баталгаажуулсан, хаягдлын далан барих захиалгын гэрээ, гүйцэтгэл, ашиглалтад өгсөн баримт, хуульд заасан барилгын тусгай эрхтэй гүйцэтгэгч байсан эсэх, барилгын явцад хийгдсэн ажил гүйцэтгэх гэрээ, туслан гүйцэтгэгчийн гэрээ, бараа материалын захиалгыг хуудас, үйлдвэрлэгчийн баталгаа, ажлын яцыг шалгасан төрийн байгууллагын комиссын шийдвэр, дүгнэлт, ашиглалтад хүлээн авсан акт, шийдвэр, тэдгээрийн заалт, ашиглалтад өгөх үед комисс хүлээн авсан бичиг баримтын жагсаалт, архивын нэгж болсон бичиг баримтууд зэргийг үзэж шалган, шаардлагатайг нь хуулбарлана авна.
- Зөрчлийн газарт бусад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд дурдсан аргачлалын дагуу үзлэг хийх.
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцох хохирогчийг тогтоолгон мэдүүлэг авах гэх мэт.

Үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага:

1. Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 1-д зааснаар “..... аймгийн сумын нэртэй газарт орших полиметаллийн баяжуулах үйлдвэрийн баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн газарт “газар ашиглах эрхийн гэрчилгээ болон орон нутагтай байгуулсан гэрээ” байгаа боловч хугацаа нь дуусаж сунгуулаагүй нь газрын хэвлийг дур мэдэн ашигласан гэж үзэж хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Зөрчлийн тухай хуулийн 7.10 дугаар зүйлийн 5.1, 5.2-д зааснаар “Хаягдлын далангийн зураг төсөл нь хянан баталгаажилт

хийгдээгүй, хаягдлын далан барих, ашиглалтад оруулахдаа технологийн шаардлага хангаагүй” үйлдэл нь “Ашигт малтмал олборлох, эрдэс түүхий эдийг боловсруулах, ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доор барих барилга байгууламжийн: зураг төсөл зохиох; тэдгээрийг барих, ашиглалтад оруулах талаар хуульд заасан шаардлагыг зөрчсөн” гэж үзээд хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.9 Ашигт малтмалын тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлд дараах байдлаар заасан.

Үүнд:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон ашигт малтмалын хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл энэ зорилгоор хуурамч гэрээ байгуулсан, эсхүл үндэслэлгүй бага үнээр борлуулж борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь:
 - 2.1. Ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа хүлээх нийтлэг үүргийг биелүүлээгүй;
 - 2.2. Хайгуулын, ашиглалтын талаар хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан;
 - 2.3. Тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн үйл ажиллагаа явуулсан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох, эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Хайгуулын талбайгаас авсан дээж, сорьц, анхдагч материалыг санаатайгаар устгасан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, эсхүл олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
6. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах талаар тогтоосон журам зөрчсөн бол

хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7. Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд хуулиар тогтоосон журам зөрчиж байгалийн үнэт, эсхүл өнгөт чулууг:
 - 7.1. Олборлосон;
 - 7.2. Худалдсан;
 - 7.3. Худалдан авсан;
 - 7.4. Тээвэрлэсэн;
 - 7.5. Хадгалсан бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мэргэжлийн нэршил, холбогдох хууль тогтоомж

“**Ашигт малтмал**” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд үүсч бий болсон, аливаа хэрэгцээнд ашиглаж болох байгалийн байдлаараа байгаа эрдсийн хуримтлалыг хэлнэ.

“**Цацраг идэвхт ашигт малтмал**” гэж уран болон торийн бүлийн цацраг идэвхт изотоп агуулсан эрдэс баялгийн хуримтлалыг хэлнэ.

“**Ашигт малтмал эрэх**” гэж ашигт малтмалын хэтийн төлөв бүхий талбайд эрдсийн хуримтлал байгаа эсэхийг тогтоох зорилгоор хийгдэж байгаа геологийн судалгааны ажлыг хэлнэ.

“**Ашигт малтмал хайх**” гэж эрдсийн хуримтлалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, түүний нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг хэлнэ.

“**Ашигт малтмал ашиглах**” гэж газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг хэлнэ.

“**Ашигт малтмалын орд**” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтож чанар, нөөц нь тодорхойлогдсон, үйлдвэрийн аргаар олборлоход эдийн засгийн хувьд ашигтай эрдсийн хуримтлалыг хэлнэ.

“**Ашигт малтмалын үндсэн орд**” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд бүрэлдэн тогтож анхлан үүссэн чулуулагтайгаа нэг орон зайд байрлаж байгаа эрдсийн хуримтлалыг хэлнэ.

“**Ашигт малтмалын шороон орд**” гэж анхлан үүссэн чулуулаг, орон зайнаасаа өгөршил, элэгдэл, механик үйл явцын дүнд сарнин салж, дахин хуримтлагдаж улмаар үе, давхарга байдалтай байгаа эрдсийн хуримтлалыг хэлнэ.

“**Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын орд**” гэж үндэсний аюулгүй байдал, улсын эдийн засаг, нийгмийн хөгжилд нөлөөлөх

хэмжээний, эсхүл жилд Монгол Улсын дотоодын нийт бүтээгдэхүүний таван хувиас дээш хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэж байгаа буюу үйлдвэрлэх боломжтой ордыг хэлнэ.

“Хайгуулын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх эрх олгосон баримт бичгийг хэлнэ.

“Ашиглалтын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичгийг хэлнэ.

“Уурхайн эдэлбэр” гэж уурхайн талбайтай давхацсан, ашигт малтмал олборлох геологийн тогтоцын хэсгийг хэлнэ.


“Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрх авсан, эсхүл түүнийг энэ хуульд заасан нөхцөл, журмын дагуу шилжүүлэн авсан хуулийн этгээдийг хэлнэ.

“Бичил уурхай эрхлэх” гэж үйлдвэрлэлийн аргаар ашиглахад эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн, Иргэний хуулийн 35 дугаар зүйлд заасан нөхөрлөл болон 36.4-д заасан хоршооны хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг хэлнэ.

“Ашигт малтмалын ордын нөөц” гэж хайгуулын ажлаар ашигт малтмалын тоо хэмжээ, хэлбэр, агуулга, эрдсийн бүрэлдэхүүн нь нарийвчлан тогтоогдсон, үйлдвэрийн аргаар олборлох боломжтой, эдийн засгийн үр ашигтай, баяжуулах технологи, олборлолтын уул техникийн нөхцөл нь тодорхойлогдсон ашигт малтмалын баялгийн хэсгийг хэлнэ.

“Үүсмэл орд” гэж олборлолт, боловсруулалт, баяжуулалтын явцад ялгагдсан ашигт малтмалын тодорхой агуулга бүхий дахин боловсруулахад эдийн засгийн үр ашиг гаргаж болохуйц хүдэр, ашигт малтмалын овоолгыг хэлнэ.

“Үүсмэл орд ашиглах” гэж энэ хуулийн 4.1.27-д заасан хүдэр, ашигт малтмалын овоолго зэргээс ашигт малтмал ялган авах, боловсруулах, баяжуулах, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг хэлнэ.



Ашигт малтмалын тухай хуульд нийцүүлэн гаргасан дараах дүрэм, журам байдаг. Үүнд:

- Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордыг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам,
- Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтын журам,
- УИХ тогтоол: тодорхой ордыг стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордод хамаарах тухай,
- Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай
- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам
- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтийн асуудлаар санал дүгнэлт, зөвлөмж гаргах үүрэг бүхий мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, мэргэжлийн зөвлөлийн ажиллах журам
- Тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулах журам,
Улсын төсөвт илүү төлсөн ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрийг буцаан олгох журам,
- “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”
- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ байгуулах өргөдлийн маягт,
- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гэрээ (Гэрээний загвар),
- Ашиглалтын тусгай зөвшөөрөл үхий талбайгаас бичил уурхайгаар ашигт малтмал олборлох тухай гурвалсан гэрээ (Гэрээний загвар),
- Бичил уурхайн үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх заавар,
 - Бичил уурхайн аюулгүйн ажиллагааны нэгдсэн дүрэм,

- Бичил уухай эрхлэгчдийн үйл ажиллагааны талаархи мэдээллийн маягт,
- Бичил уурхайн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх болон хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хүрээнд авах арга хэмжээний төлөвлөгөө, тайлангийн маягт,

Дээрхи хууль, дүрэм, журамыг дараах хаягнаас татан авч үзэж болно.

- <http://legalinfo.mn/law/details/63?lawid=63>
- http://mram.gov.mn/mram_new/index.php?option=com_content&view=category&layout=blog&id=13&Itemid=33&lang=mn

Ашигт малтмал хайх үйл ажиллагаа нь Ашигт малтмалын хуульд заасан үндэслэл журмаар олгогдсон ашигт малтмал эрэх, хайх эрх олгосон тусгай зөвшөөрөлтэй талбайд явагдах үйл ажиллагааг ойлгоно. Ашигт малтмал ашиглах, олборлох үйл ажиллагаа нь Ашигт малтмалын хуульд заасан үндэслэл журмаар олгогдсон тусгай зөвшөөрлийн хүрээнд зөвшөөрөгдсөн талбайд ашигт малтмал олборлож ашиглах үйл ажиллагааг хэлнэ. Бичил уурхай гэж Газрын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.11-д заасан зориулалтаар олгосон ашигт малтмалын үйлдвэрлэлийн бус агуулгатай эдийн засгийн үр ашиггүй орд, ашиглалтын болон технологийн хаягдлаар бий болсон үүсмэл орд, илрэл бүхий талбайд ашигт малтмал олборлох зорилгоор Иргэний хуулийн 481.1-д заасны дагуу бүртгэгдээгүй нөхөрлөлийн хэлбэрээр зохион байгуулагдсан иргэдийн эрхэлж байгаа үйл ажиллагааг хэлнэ.

Зүйлчлэлийн асуудал

“Ашигт малтмалын тухай хууль зөрчих” зөрчил нь:

“Тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон ашигт малтмалын хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл энэ зорилгоор хуурамч гэрээ байгуулсан, эсхүл үндэслэлгүй бага үнээр борлуулж борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан; ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа хүлээх нийтлэг үүргийг биелүүлээгүй; хайгуулын, ашиглалтын талаар хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан; тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн үйл ажиллагаа явуулсан; Үнэт металл, эрдэнийн чулууны сорьц, чанарыг тогтоолгох, эсхүл бүртгүүлэх журам зөрчсөн; Хайгуулын талбайгаас авсан дээж, сорьц, анхдагч материалыг санаатайгаар устгасан; Ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, эсхүл олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн; Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах талаар тогтоосон журам зөрчсөн; Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд хуулиар тогтоосон журам зөрчиж байгалийн үнэт, эсхүл өнгөт чулууг: олборлосон; худалдсан; худалдан авсан; тээвэрлэсэн; хадгалсан” зэрэг шинжийг агуулсан үйлдэл эс үйлдэхгүйг хууль тогтоогч зөрчилд тооцсон байна. Энэхүү зүйлд заасан халдлагын зүйл, үйл ажиллагааны явцад хуульд заасан шаардлага зөрчсөн үйлдэл эс үйлдлээрээ гэмт хэргээс ялгагдана.

Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэргийг: “Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан, эсхүл ашигт малтмал олборлохоос өөр зориулалтаар газар доорх барилга байгууламж барьж хууль бусаар газрын хэвлийд халдсан” гэж томъёолсон байна. 2002 оны Эрүүгийн хуулийн 204 дүгээр зүйлд “Газрын хэвлийн хууль тогтоомж зөрчих” гэмт хэргийг тусгайлан заасныг 2017 оны шинэ Эрүүгийн хуулиар **“Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэгт нэгтгэн, нэг зүйлд багтааж хүндрүүлэх шинжүүдийг гэмт хэрэгт тооцсон ба зөрчлийн хуульд заасан дээрх шинжүүдийг “зөрчил” болгон заасан байна.**

24.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Тусгай зөвшөөрөлтэйгөөр ашигт малтмалын хайгуул, ашиглалт, олборлолт, боловсруулалт явуулсан талбайд нөхөн сэргээлтийн ажлыг зохих журмын дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд ноцтой хохирол учирсан” гэж Ашигт малтмалын тухай хуульд заасан тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргээс тодотгон оруулж, хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон заасан байна.

24.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн” бол хүндрүүлж үзэн эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан. Зөрчлөөс ялгагдах гол шинж нь дээр дурдсан зөрчлийн шинжийг агуулалгүйгээр **“Тусгай зөвшөөрөлгүйгээр ... хууль бусаар газрын хэвлийд халдсан”** үйлдэл юм. Уг “халдах” үйлдэлд ямар нэг хохирлын хэмжээ заагаагүй бөгөөд онолын хувьд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг тул тодорхой үйлдэл хийснээр төгссөнд тооцогдоно. “Хууль бусаар” гэж газрын хэвлийд халдах тодорхой эрх үүсгэсэн бичигт баримт олгогдоогүй байхад эрүүгийн хуульд заасан дээрх үйлдэл хийсэн нь зөрчлөөс ялгагдах шинж бөгөөд гэмт хэрэгт тооцно.

“Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд хуулиар тогтоосон журам зөрчиж байгалийн үнэт, эсхүл өнгөт чулууг: олборлосон, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн, хадгалсан” үйлдлийн хувьд хэдийгээр тусгай зөвшөөрөлгүй гэдгээрээ эрүүгийн хуульд заасан шинжийг агуулах боловч халдлагын зүйл нь ердийн ашигт малтмал бус “байгалийн өнгөт, үнэт чулуу” байдгаараа зөрчилд тооцон хуульчилсан байгааг анхаарах хэрэгтэй.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

7.11 дүгээр зүйлд заасан “Ашигт малтмалын тухай хууль зөрчих” ЗТХ-ийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

1. Шалгаж буй зөрчлийн онцлогт тохируулан ашигт малтмал, газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, ой, ургамал, амьтан, агаарыг хамгаалах, тэдгээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, стандарт, хэм хэмжээ, дүрэм, журам, шийдвэрийг олж судалсан байх /зохих мэдлэгийг өөртөө хуримтлуулах/;
2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч олборлосон ашигт малтмалын

хэмжээг нуун дарагдуулсан, эсхүл энэ зорилгоор хуурамч гэрээ байгуулсан, эсхүл үндэслэлгүй бага үнээр борлуулж борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан зөрчлийг шалгахдаа холбогдох бичиг баримтаас гадна үйлдвэрлэлийн явцад хөтлөгддөг бичиг тэмдэглэлд үзлэг хийх, Лондон, Торонтогийн бирж дээрх тухайн ашигт малтмалын үнийн дэлхийн зах зээлийн ханшид суурилан гаргадаг Монгол Улсын гаалийн үнийг авч харьцуулах. Хуурамч гэрээний нөхцөлүүдийг сайтар шалгаж биелэгдэх боломжтой байсан эсэх /гадаад экспортын шугамаар биш дотоод зах зээлд хуулийн этгээд хоорондоо худалдсан бол дотоод зах зээлийн дундаж ханш тогтоох/, “дүр эсгэсэн” гэрээ эсэхийг шалгах.

3. Ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа хүлээх нийтлэг үүргийг биелүүлээгүй үйлдлийг шалгахдаа АМТ хуулийн 6 дугаар бүлгийн 35 дугаар зүйлд заасан нийтлэг үүрэгт тулгуурлан заалт бүрээр шалгах;
4. Хайгуулын, ашиглалтын талаар хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан асуудлаар холбогдох этгээдээс мэдүүлэг авах, шалтгааныг тогтоох,
5. Тусгай зөвшөөрлийн талбайгаас хэтрүүлэн үйл ажиллагаа явуулсан бол үзлэг хийж хэтэрсэн талбайн хэмжээ, хохирол тогтоох;
6. Хайгуулын талбайгаас авсан дээж, сорьц, анхдагч материалыг санаатайгаар устгасан үйлдлийн шалтгааныг тогтоох, энэ зорилгоор хуурамч материал бүрдүүлсэн бол эрдэс баялгийн зөвлөлийн шийдвэрт анхаарах,
7. Ашигт малтмалын балансын нөөцийг зохистой ашиглах шаардлагыг зөрчсөн, эсхүл олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн үйлдэлд технологийн аудит томилж дүгнэлт гаргуулах,
8. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах талаар тогтоосон журам зөрчсөн үйлдлийг шалгахдаа Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолд заасан заалт бүрээр шалгах,
9. Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд хуулиар тогтоосон журам зөрчиж байгалийн үнэт, эсхүл өнгөт чулууг: олборлосон; худалдсан; худалдан авсан; тээвэрлэсэн; хадгалсан зөрчлийг шалгахдаа энэ номд заасан Түгээмэл тархацтай ашигт малтмалын хууль зөрчих зөрчлийн шалган шийдвэрлэх ажиллагааг анхаарч явуулах.
10. Байгаль орчинд нөлөөлөх үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн төсөл, хөтөлбөр, хийгдсэн гэрээний байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, гэрээгээр заасан байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой заалтын биелэлтийг шалгах;
11. Тухайн газар нь Тусгай хамгаалалттай газрын хилийн заагт багтаж

- буй эсэхийг шалган тогтоох.
12. Өнгөт болон үнэт чулуу олборлогдсон газарт үзлэг хийхдээ газар орны онцлог, нөхцөл байдал, одоогийн байгаа байдлыг тодорхойлж үзлэгийн тэмдэглэлд тусгахаас гадна үүссэн газрын эвдрэл, нөхөн сэргээлтийн байдлыг /газрын хэвлийг ухах, ухаш \карьер\, овоолго үүсгэж засаж тохижуулалгүй орхисон гэх мэт/ GPS буюу орон зайн байрлал тогтоогч ашиглан уртраг, өргөргийг тодорхойлно. Энэ төрлийн зөрчлийн газарт үзлэг хийхдээ байршил тогтоогч багаж \ GPS\, эвдэрсэн талбайн хэмжээг тогтоох зай хэмжигч, метр, лац, ломбо, фото аппарат, дүрс бичлэгийн камер, дээж авах сав, уут, хүрз, жоотуу, лоом зэрэг багаж хэрэгслийг ашиглах шаардлагатай. Үзлэгийн тэмдэглэлийг цэгцтэй ойлгомжтой болгохын тулд дугаарлах, догол мөр авах, тодорхой объект, газар орны нэрээр хаяглах зэрэг байдлаар бичих хэрэгтэй. Жишээ нь: “2017 оны уулын ажлын төлөвлөгөөгөөр батлагдсан “С блок” гэж тэмдэглэгдсэн ашиглалтын талбай хэтэрсэн гэх газарт хийсэн үзлэг”. “Бичил уурхайн ашиглалт явагдсан гэх талбайд хийсэн үзлэг” гэх мэтээр бичиж болох юм.
 13. Үзлэгээр тогтоогдсон цэгүүдийг орон нутгийн газрын албад, Ашигт малтмалын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны кадастрын хэлтэст хүргүүлэн орон нутгийн тусгай хэрэгцээний газар, хязгаарлалт, хориглолтын бүстэй давхцалтай эсэх, тусгай зөвшөөрлийн талбайн байдал, уурхайн эдэлбэр газрын зөвшөөрөл зэргийн талаар зурагтай лавлагаа авах.
 14. Археологийн болон палентлогийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн эсэх, түүх соёлын үнэт зүйлийг уулын ажлын явцад эвдэж сүйтгэх, зохих байгууллагад мэдэгдсэн эсэхийг шалгах.
 15. Тухайн зөрчил нь Уул уурхайн техник эдийн засгийн үндэслэлтэй хэрхэн холбогдож байгаа, хэрхэн тусгасан зэргээр шалгалт хийх.
 16. Ордыг сорчлон олборлохгоод хаягдал болон эфель олборлох гэсэн аж ахуйн нэгжид лицензээ шилжүүлсэн асуудал байгаа эсэхийг анхаарч шалгах /Уулын ажлын технологийн горимыг зөрчсөнөөс болж байгалийн баялгийг сорчлон олборлож их хэмжээний хаягдал үүсгэж байна. Энэ нь хувиараа буюу гар аргаар ашигт малтмал олборлох боломж бий болгож байгаль орчинд ихээхэн сөрөг нөлөөлөл үзүүлж байна/
 17. Тухайн аж ахуйн нэгжийг урьд өмнө төрийн эрх бүхий байгууллага / Мэргэжлийн хяналтын байгууллага, Ашигт малтмалын газар, Усны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, орон нутгийн албадуут гэх мэт/-аас шалгаад тавьсан акт, албан шаардлага, мэдэгдэл, дүгнэлт, шинжилгээний хариу, торгуулийн тасалбар, шийтгэвэр, маргаантай асуудлаар гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, албан бичиг зэрэг тухайн асуудалтай холбогдол бүхий баримт бичигт үзлэг хийж хэрэгт хуулбарлан хавсаргаж байх.

18. Мөн тухайн аж ахуйн нэгжийн дотоод бичиг баримтад үзлэг хийж шалгаж буй хэрэгт хамааралтай тушаал, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, хамтран ажиллах болон туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, ашиг хуваарилсан баримт, уулын ажлын төлөвлөгөө, хайгуулын ажлын тайлан, нөөцийн материал, орд газрын болон уурхайн байгууламжийн зураглал, сүүлийн байдлаар хийсэн хөрсний зураглал /3D технологи/, үндсэн, охин, толгой зэрэг компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээ, татварын тайлан, үүсгэн байгуулалт болон хөрөнгө оруулагчтай холбоотой баримт зэрэг залгаж буй зөрчилтэй холбоотой баримтуудаас сонголт хийж хураан авах, хуулбарлан авах ажиллагааг явуулна.
19. Зөрчлийн улмаас мал амьтан, байгаль орчинд хохирол учирсан байдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-аар тооцож тогтоолгох. Хохирол нөхөн төлүүлэх явдлыг хангахад чиглэгдсэн ажиллагааг прокурорт танилцуулан шийдвэрлэх.
20. Зөрчлийн улмаас ан амьтан, байгаль орчинд учруулсан хохиролд төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас томилсон этгээдээс хохирогчоор хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.
21. Хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтнуудын албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс хамаарч зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн бол Төрийн албаны тухай хуульд зааснаар сахилгын шийтгэл хүлээлгэх эсэх талаар хариуцсан дээд шатны байгууллагад бичгээр хандах. Шаардлагатай бол тухайн газар орныг хариуцаж байсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараас гэрчийн мэдүүлэг авч, ажил үүргийн хувьд хэн нь юу хариуцдаг болох, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргийг үзэх, хуулбарлан авах.
22. Шалгалтын явцад илэрсэн тусгай зөвшөөрөл, бусад зөвшөөрлийн бичиг, төсөл, хөтөлбөр, ТЭЗҮ, гэрээ зэрэг бичиг баримт нь үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарлагдсан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулан материалын шинж онцлогийг нарийн дурдаж тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хураан авах. Тухайн баримтыг үндэслэн холбогдох гэрчээс мэдүүлэг авах, эрх бүхий байгууллагаас лавлагаа хүсэх, илт хуурамч бичиг баримт үйлдсэн, зөрчлийг хаацайлахын тулд албан тушаалтнаас хуурамч баримт бичиг хийж ирүүлсэн бол прокурорт мэдэгдэж дариу шилжүүлнэ.

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ-1

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Х нь аймгийн сумын багт байрлах шороон ордын алт олборлох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, тусгай зөвшөөрөл эзэмшигч 5 компанийн уурхайн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийв. Шалгалтаар дээрх 5 компани нь 40 аж ахуйн нэгжтэй туслан гүйцэтгэгчээр гэрээ байгуулсан бөгөөд байгаль орчны менежментийн төлөвлөгөө батлуулаагүй, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгээгүй, уурхайн талбайн хил тодорхойгүй, байнгын шав тэмдэг тавиагүй, туслан гүйцэтгэгч нараас 8 аж ахуйн нэгж нь алтны уурхайн усан бууны тулаасанд тус бүр 3 куб метр мод зөвшөөрөлгүйгээр бэлтгэн ашигласан, 2 аж ахуйн нэгж нь ажиллагсдын хоолонд тус бүр 8 гөрөөс, 12 тарвага хуулиар хориотой хугацаанд, зохих зөвшөөрөлгүйгээр агнаж махыг хэрэглэсэн зэрэг зөрчил илрэв.

Уг зөрчлийг шалгах ажиллагаа:

- Улсын байцаагч Х нь Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлд зааснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч 5 компаниас байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, уурхайн талбайн хил тодруулсан байнгын шав тэмдэг шаардах бөгөөд туслан гүйцэтгэгчээр гэрээ байгуулсан, тусгай зөвшөөрөл эзэмшигч бус 40 компаниудаас байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, уурхайн талбайн хил тодруулсан байнгын шав тэмдэг шаардах эрх зүйн үндэслэлгүй байна.
- Тусгай зөвшөөрөл эзэмшигч 5 компаниас байгаль орчны менежментийн төлөвлөгөө, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, уурхайн талбайн хил тодруулсан байнгын шав тэмдэг байхгүй зөрчил илэрсэн талаар прокурорт мэдэгдэж бүртгүүлэх ба зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэх боломжтой.
- Туслан гүйцэтгэгч 8 аж ахуйн нэгж нь алтны уурхайн усан бууны тулаасанд тус бүр 3 куб метр мод зөвшөөрөлгүйгээр бэлтгэн ашигласан үйлдэл нь Эрүүгийн хуулиар зохицуулагдах тул баримтжуулсан зохих материалын хамт прокурорт шилжүүлж цагдаагийн байгууллагаар шалгуулна.
- Туслан гүйцэтгэгч 2 аж ахуйн нэгж нь ажиллагсдын хоолонд тус бүр 8 гөрөөс, 12 тарвага хуулиар хориотой хугацаанд, зохих зөвшөөрөлгүйгээр агнаж махыг хэрэглэсэн үйлдэлд “Амьтны тухай хууль зөрчих” зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг энэ номд заасны дагуу явуулна.
- Зөрчлийн хэрэг нээж шалгалт явуулахаар бол Зөрчлийн газарт дээрх шалган шийдвэрлэх ажиллагаанд дурдсан аргачлалын дагуу үзлэг хийх.
- Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцох гэрч, хохирогч, холбогдогчоос мэдүүлэг авах гэх мэт.

Үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага:

1. Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт зааснаар “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа хүлээх нийтлэг үүргийг биелүүлээгүй” гэж үзэн тусгай зөвшөөрөл эзэмшигч 5 компани тус бүрийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Туслан гүйцэтгэгч 2 аж ахуйн нэгж нь
 - Ажиллагсдын хоолонд “тус бүр 8 гөрөөс, 12 тарвага зохих зөвшөөрөлгүйгээр агнаж махыг хэрэглэсэн” үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэгт зааснаар зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
 - Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар “Хуулиар хориотой хугацаанд амьтныг агнасан” үйлдэлд зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Шийдвэрлэх шатанд Зөрчлийн хуулийн ерөнхий анги хэрэглэх нь:

ЗТХ-ийн 1.3 дугаар зүйлийн 2 “Энэ хуульд заасан зөрчил тус бүрд шийтгэл оногдуулна”. **3.1 дүгээр зүйлийн 4** “Нэг үйлдэл, эс үйлдэхүй нь энэ хуулийн тусгай ангид заасан хоёр, эсхүл түүнээс дээш зөрчлийн шинжтэй бол аль хүнд шийтгэл оногдуулахаар заасан зөрчилд нь шийтгэл оногдуулна”. 5 “Энэ хуулийн тусгай ангид заасан бол энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан зөрчилд оногдуулах үндсэн шийтгэл дээр нэмж бусад зөрчилд оногдуулахаар заасан нэмэгдэл шийтгэл, албадлагын арга хэмжээг оногдуулна” гэж заасан байна.

Эцэслэн шийдвэрлэх ажиллагаа:

1. Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 2.1 дэх хэсэгт зааснаар “тусгай зөвшөөрөл эзэмшигч нь ашигт малтмал эрэх, хайх, ашиглахдаа хүлээх нийтлэг үүргийг биелүүлээгүй” гэж үзэн тусгай зөвшөөрөл эзэмшигч 5 компани тус бүрийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Туслан гүйцэтгэгч 2 аж ахуйн нэгж нь ажиллагсдын хоолонд “тус бүр 8 гөрөөс, 12 тарвага зохих зөвшөөрөлгүйгээр, хориотой үед агнаж махыг хэрэглэсэн” үйлдэлд Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж аж ахуйн нэгж тус бүрийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ-2

Цагдаагийн байгууллагаас явуулсан нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн сумын гэх газарт байгалийн өнгөт болон үнэт чулууг тусгай зөвшөөрөлгүйгээр түүж бэлтгэсэн тусдаа 340 үйлдэл бүхий 340 иргэн, тээвэрлэх үйлдэл хийсэн 22 тээврийн хэрэгслийн жолооч 22 иргэн, тэдгээрийг худалдан авч байсан 12 үйлдэл бүхий 12 иргэнийг саатуулан, тэдгээрийн үйлдлийг таслан зогсоосон ба зөрчлийн талаар аймгийн мэргэжлийн хяналтын газарт мэдэгдсэн байна.

Шалгах ажиллагаа:

Зөрчлийн тоо, холбогдогчийн тоо их, нэг цаг хугацаанд бөөнөөрөө ирж байгаа мэдээллийн хувьд хүндрэлтэй боловч хууль заасан зохион байгуулалтын арга хэмжээ авах, үүргээ хэрэгжүүлэх шаардлагатай. Холбогдогч нарыг бүртгэлжүүлэх, иргэний бичиг баримт байхгүй бол аймгийн бүртгэлийн хэлтсийн болон цагдаагийн цахим сан ашиглах байдлаар хамтран ажиллах боломжтой.

Зөвшөөрөлгүйгээр түүж бэлтгэсэн 340 үйлдэл, тээвэрлэх үйлдэл 22, худалдан авсан 12 үйлдэл гээд нийт 374 үйлдэлд хэрэг бүртгэлийн талаар прокурорт мэдэгдэж дугаар авна. Үйлдэл тодорхой, гэм буруугийн хувьд маргаангүй бол хялбаршуулсан журмаар шийдвэрлэнэ. Шаардлагатай бол зөрчлийн хэрэг нээж дээр дурдсан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанаас сонгож явуулна.

Үйлдэгдсэн зөрчилд хүлээлгэх хариуцлага:

Зөрчлийн тухай хуулийн 7.11 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт зааснаар “Тусгай зөвшөөрөлгүй хүн ... хуулиар тогтоосон журам зөрчиж байгалийн үнэт, эсхүл өнгөт чулууг: олборлосон, худалдсан, худалдан авсан, тээвэрлэсэн үйлдэлд 374 иргэн тус бүрийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож шийдвэрлэнэ.

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ-3

Улсын байцаагч Э нь Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны ажлын хэсгийн хамт аймгийн сумын бүс нутагт төлөвлөгөөт бус шалгалтын удирдамжийн дагуу ажиллав. Шалгалтаар тус сумын гэх газарт ХХК нь алт угаах усан буу байрлуулсан, тэрэг техник ажиллах хүчээ татсан байдалтай, амны эхэнд 3 метр куб хэмжээтэй багавтар эрүүл газарт хөрс хуулалт хийсэн, уул уурхайн улмаас хуучин эвдэгдсэн газарт байгаа хаягдал шороон овоолго, эфель, галиас 15.000 орчим куб метр шороог шинээр угаасан, ус ашиглах гэрээ дүгнэлтгүй уурхайлалт явуулсан байдалтай байв. Компанийн захирал нь “Уул уурхайн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх” гэрээ, сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн “Уул уурхайн улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийх ба зардлаа олохын тулд үүсмэл ордын алтыг дахин боловсруулж ялган авах” утга бүхий тогтоол зэргийг үзүүлэн “тусгай зөвшөөрөлгүй бөгөөд энэ газар өмнө нь нинжа нар ороод эвдэгдчихсэн газар” болохыг мэдэгдэв. “Уул уурхайн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх” гэрээг сумын засаг дарга С-тэй байгуулсан байх бөгөөд гэрээний 2.2 дахь хэсэгт “үүсмэл ордын алтыг дахин боловсруулах замаар

нөхөн сэргээлтийн зардлыг гаргана” гэсэн заалт орсон байна.

Зүйлчлэлийн асуудал

Зөрчлөөс ялгагдах гол шинж нь дээр дурдсан зөрчлийн шинжийг агуулалгүйгээр “**Тусгай зөвшөөрөлгүйгээр ... хууль бусаар газрын хэвлийд халдсан**” үйлдэл юм. Уг “халдах” үйлдэлд ямар нэг хохирлын хэмжээ заагаагүй бөгөөд онолын хувьд хэлбэрийн бүрэлдэхүүнтэй гэмт хэрэг тул тодорхой үйлдэл хийснээр төгссөнд тооцогдоно. Нөгөө талаар Ашигт малтмалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7-д “ашигт малтмал ашиглах” гэдэг нь “газрын гадаргуу, түүний хэвлий, хүдрийн овоолго, хаягдал, байгалийн уснаас ашигт малтмалыг ялган авах, олборлох үйл ажиллагаа гэж тодорхойлсон тул. Энэхүү ашиглах эрхийг зөвхөн тусгай зөвшөөрөл эзэмшигч хадгална. Дараах шинжүүд байна. Үүнд:

1. Тусгай зөвшөөрөлгүйгээр амны эхэнд 3 метр куб хэмжээтэй багавтар эрүүл газарт хөрс хуулалт хийсэн үйлдэл нь дангаараа **Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжийг агуулж байна.**
2. Тусгай зөвшөөрөлгүйгээр уул уурхайн улмаас хуучин эвдэгдсэн газарт байгаа хаягдал шороон овоолго, эфель, галиас 15.000 орчим куб метр шороог шинээр угаасан үйлдэл нь дангаараа **Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжийг агуулж байна.**
3. Ус ашиглах гэрээ дүгнэлтгүй уурхайлалт явуулж байгаа нь эрүүгийн хэрэгт экологийн хохирол тогтооход үнэ төлбөргүй ашигласан усны үнийг оруулан тооцож шинжээчийн дүгнэлт гаргана.
4. сумын иргэдийн хурлын тэргүүлэгчдийн “Уул уурхайн улмаас эвдэгдсэн газарт нөхөн сэргээлт хийх ба зардлаа олохын тулд үүсмэл ордын алтыг дахин боловсруулж ялган авах” утга бүхий тогтоол, сумын засаг дарга С-тэй байгуулсан “Уул уурхайн улмаас эвдэгдсэн газрыг нөхөн сэргээх” гэрээний 2.2 дахь хэсэгт “үүсмэл ордын алтыг дахин боловсруулах замаар нөхөн сэргээлтийн зардлыг гаргана” гэсэн заалт нь Монгол Улсын Эрдэс баялагийн зөвлөл, Ашигт малтмалын газрын эрх хэмжээнд халдсан, гагцхүү тухайн байгууллагад эрх нь хадгалагдах эрх зүйн зохицуулалтыг зөрчсөн байна. Энэ тохиолдолд Эрүүгийн хуулийн **22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэрэгт заасан** “Нийтийн албан тушаалтан албан үүрэг, бүрэн эрх, албан тушаалын байдлаа урвуулан ашиглаж, эсхүл зориуд хэрэгжүүлэхгүй байж өөртөө, бусдад давуу байдал бий болгосон” үйлдлийн шинжийг агуулж байна. Дээрх үйлдлүүдэд улсын байцаагч шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүй бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаар шалгагдана.

Шийдвэрлэх ажиллагаа:

- Тусгай зөвшөөрөлгүйгээр амны эхэнд 3 метр куб хэмжээтэй багавтар эрүүл газарт хөрс хуулалт хийсэн. Тусгай зөвшөөрөлгүйгээр уул

уурхайн улмаас хуучин эвдэгдсэн газарт байгаа хаягдал шороон овоолго, эфель, галиас 15.000 орчим куб метр шороог шинээр угаасан үйлдлүүд нь Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлд заасан гэмт хэргийн шинжийг агуулж байх тул прокурор танилцуулан улмаар цагдаагийн байгууллагад шилжигдэнэ.

- сумын иргэдийн хурлын тэргүүлэгчид болон сумын засаг дарга С-тэй холбоотой шийдвэрүүд нь Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэргийн шинжийг агуулж байх тул прокурор танилцуулан улмаар Авлигатай тэмцэх газарт харьяаллаар шилжигдэнэ.

3.10 Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 7.12 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

1. Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд:
 - 1.1. Түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийсэн;
 - 1.2. Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлосон, эсхүл борлуулсан;
 - 1.3. Ашигт малтмалын орд ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуульд заасан нийтлэг үүргийг биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: Энэ зүйлд заасан зөрчлийг үйлдсэн бол эрх бүхий улсын байцаагч тусгай зөвшөөрөл эзэмшигчийн ашигт малтмал хайх, ашиглах үйл ажиллагааг хоёр сар хүртэл хугацаагаар зогсоох ба энэ хугацаанд зөрчлийг засаагүй тохиолдолд тусгай зөвшөөрлийг энэ хуульд заасны дагуу цуцлах тухай асуудлыг тухайн тусгай зөвшөөрлийн талбай оршиж байгаа аймаг, нийслэлийн эрх бүхий албан тушаалтанд гаргана.

Мэргэжлийн нэршил, холбогдох хууль тогтоомж

- 4.1.1. “түгээмэл тархацтай ашигт малтмал” гэж зам, барилгын материалын зориулалтаар ашиглах боломжтой, элбэг тархалт бүхий элс, хайрга, тоосгоны шавар, хүрмэн, боржин, дайрганы зориулалттай барилгын чулууны хуримтлалыг;
- 4.1.2. “түгээмэл тархацтай ашигт малтмал хайх” гэж түгээмэл тархацтай ашигт малтмалын байршил, тоо хэмжээг нарийвчлан тогтоох зорилгоор газрын гадаргуу, түүний хэвлийд геологи, хайгуулын судалгаа хийж, нөөц, баялгийг ашиглах боломжийг судлан техник, эдийн засгийн үнэлгээ хийхийг;
- 4.1.3. “түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглах” гэж түгээмэл тархацтай ашигт малтмалын орд ашиглах техник, эдийн засгийн үндэслэлийн дагуу газрын гадаргуу, хэвлийгээс ашигт малтмал ялган авах, олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах болон түүнтэй холбогдсон бусад үйл ажиллагааг;
- 4.1.4. “түгээмэл тархацтай ашигт малтмалын орд” гэж геологийн хувьсал, өөрчлөлтийн дүнд газрын гадаргуу, түүний хэвлийд бүрэлдэн тогтож чанар, нөөц нь тодорхойлогдсон, үйлдвэрийн аргаар олборлоход эдийн засгийн хувьд ашигтай эрдсийн хуримтлалыг;
- 4.1.5. “тусгай хэрэгцээний газар” гэж Газрын тухай хуулийн 17, 18, 20 дугаар зүйлд заасны дагуу эрх бүхий байгууллагаас улсын болон орон нутгийн тусгай хэрэгцээнд авч ашигт малтмал эрэх, хайх, ашиглахыг хязгаарласан буюу хориглосон газрыг;
- 4.1.6. “түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуульд заасны дагуу ашигт малтмал хайх эрх олгосон баримт бичгийг;
- 4.1.7. “түгээмэл тархацтай ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл” гэж энэ хуульд заасны дагуу ашигт малтмал ашиглах эрх олгосон баримт бичгийг;
- 4.1.8. “түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын талбай” гэж энэ хуулийн 4.1.6-д заасан тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг;
- 4.1.9. “уурхайн талбай” гэж энэ хуулийн 4.1.7-д заасан тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг;
- 4.1.10. “уурхайн эдэлбэр” гэж уурхайн талбайтай давхацсан, ашигт малтмал олборлох геологийн тогтоцын хэсгийг;
- 4.1.11. “түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн төлбөр” гэж тусгай зөвшөөрлийг хүчин төгөлдөр байлгах зорилгоор эзэмшигчээс нь Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 35.6-д заасны дагуу төлөх төлбөрийг;
- 4.1.12. “түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэж энэ хуулийн дагуу ашигт малтмал хайх, ашиглах эрх авсан хуулийн этгээдийг;

4.1.13. “хуулийн этгээд” гэж Иргэний хуулийн 33.1-д заасан компани, нөхөрлөлийг.

Зүйлчлэлийн асуудал

“Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих” зөрчил нь:

“Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд: түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийсэн, олборлосон, эсхүл борлуулсан; ашигт малтмалын орд ашигласан; Хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан; Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан; Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуульд заасан нийтлэг үүргийг биелүүлээгүй” зэрэг шинжийг агуулсан үйлдэл эс үйлдэхгүйг хууль тогтоогч зөрчилд тооцсон байна. Энэхүү зүйлд заасан халдлагын зүйл, үйл ажиллагааны явцад хуульд заасан шаардлага зөрчсөн үйлдэл эс үйлдлээрээ гэмт хэргээс ялгагдана.

Эрүүгийн хуульд:

24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэргийг: “Тусгай зөвшөөрөлгүйгээр ашигт малтмалын эрэл хайгуул, олборлолт, боловсруулалт, ашиглалт явуулсан ...” гэж томъёолсон байна. 2002 оны Эрүүгийн хуулийн 214 дүгээр зүйлд ашигт малтмалыг төрлөөр нь ялгалгүйгээр эрүүгийн хариуцлага тооцдог байсан. 2017 оны шинэ Зөрчлийн хуулиар “түгээмэл тархацтай” гэж ашигт малтмалын төрлөөр нь тусгайлан заасан тул эрүүгийн хуульд заасан “Хууль бусаар ашигт малтмал хайх, ашиглах, олборлох” гэмт хэрэгт “ердийн” ашигт малтмалыг хамруулан ойлгохоор байна. Түгээмэл тархацтай ашигт малтмалыг хууль бусаар олборлосон бол зөвхөн зөрчил гэж үзэн хариуцлага хүлээлгэх тул энд тусгайлсан зүйлчлэлийн асуудал яригдахгүй. Харин нэг анхаарах зүйл бол түгээмэл тархацтай ашигт малтмалыг тусгай зөвшөөрлийн дагуу олборлосон, боловсруулан, ашиглалт явуулсан атлаа нөхөн сэргээлтийн ажлыг хийгээгүй буюу зохих журмыг дагуу хийгээгүйн улмаас байгаль орчинд ноцтой хохирол учирсан бол уг үйлдэлд Эрүүгийн хуулийн 24.2 дугаар зүйлийн 2, 4-д зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх тул зөрчил шалгах явцад уг шинж илэрвэл хор хохирлыг тооцуулан цагдаагийн байгууллагад харьяалал тогтоолгохоор прокурорт хандана.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

7.12 дугаар зүйлд заасан “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих” зөрчлийн хэрэг бүртгээлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Шалгаж буй зөрчлийн онцлогт тохируулан ашигт малтмал, газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, ой, ургамал, амьтан, агаарыг хамгаалах, тэдгээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, стандарт, хэм хэмжээ, дүрэм, журам, шийдвэрийг олж судалсан байх /зохих мэдлэгийг өөртөө хуримтлуулах/;

- “Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийсэн, олборлосон, эсхүл борлуулсан, ашигт малтмалын орд ашигласан зөрчлийн газарт үзлэг хийхдээ газар орны онцлог, нөхцөл байдал, одоогийн байгаа байдлыг тодорхойлж үзлэгийн тэмдэглэлд тусгахаас гадна газрын эвдрэл, газрын хэвлийд үүссэн ухааш нүх, шороон овоолго /эфель, гааль/ тэдгээрийн талбайн захын цэгүүдийн солбицол, урт, өргөн, өндөр, гүн, налуулалт, эзлэхүүн зэргийг хэмжиж тогтоох, эвдэрсэн газар нь олон өнцөгт үүсгэхээр, хол зайнд түр урсгалтай уулын голын хөндий дагаж үргэлжлэхээр, том талбайг хамарсан, ус, нуур, бохирын нуур, тунгаагуур далан гэх мэт олон хэв шинжийг тодорхойлохоор бол GPS-ээр драг /явсан замын бичлэгийн команд/ хийх байдлаар нийт талбайн хилийг тогтоож уг мэдээллээ **Газарзүйн мэдээллийн систем буюу ArcGIS –д** оруулан зураглал гаргах, талбай тооцох ажилд ашиглана. Нөхөн сэргээлтийн байдлыг мөн адил GPS буюу орон зайн байрлал тогтоогч ашиглан уртраг, өргөрөг, талбайн хэмжээг тодорхойлоод үүний дараа нөхөн сэргээлтээр өгсөн талаарх тайлан, хүлээн авсан акт тэдгээрийн солбицол зэргийг харьцуулан шалгаж болно. Энэ төрлийн зөрчлийн газарт үзлэг хийхдээ байршил тогтоогч багаж \GPS\, эвдэрсэн талбайн хэмжээг тогтоох зай хэмжигч /лазерын, электрон/, метр, лац, ломбо, фото аппарат, дүрс бичлэгийн камер, дээж авах сав, уут, хүрз, жоотуу, лоом зэрэг багаж хэрэгслийг ашиглах шаардлагатай. Үзлэгийн тэмдэглэлийг цэгцтэй ойлгомжтой болгохын тулд дугаарлах, догол мөр авах, тодорхой объект, газар орны нэрээр хаяглах зэрэг байдлаар бичих хэрэгтэй. Жишээ нь: “Төв аймгийн Эрдэнэ сумын 3-р баг Буурал хангай уул хэмээх Боржин чулууны түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц тогтоогдсон гэх газарт хийсэн үзлэг”. “Налайх дүүргийн 5-р хороо Илчит нэртэй уулын хойд хэсэгт гар аргаар уулын элс олборлосон гэх талбайд хийсэн үзлэг” гэх мэтээр бичиж болох юм. Үзлэгийн ажиллагааг дүрс бичлэг, гэрэл зургаар бэхжүүлэхдээ зөрчлийн газрын зураг авах цэгийг зөв сонгох ба ерөнхий зураг /холоос газар орны орчны байдалтай цуг, 360 градус эргэлттэйгээр **панарам** зураг авах/, тухайн зөрчлийн газрыг багтаасан зураг, нарийвчилсан, хэсэгчилсэн зэргээр авч болно. Техникийн боломжтой бол хэргийн газрын эгц дээрээс, алсаас, дагууд нь зэргээр бичлэг хийх, зураг авах, солбицол тогтоох зэрэг ажиллагааг зэрэг явуулах боломжтой Pantun-4 загварын нисдэг Дронн ашиглах нь илүү үр дүнтэй ба дронноор авсан мэдээллийг **газарзүйн мэдээллийн систем буюу ArcGIS –д** оруулан зураглал гаргах, талбай тооцох ажилд ашиглана.
- Үзлэгээр тогтоогдсон цэгүүдийг орон нутгийн газрын албад, Ашигт малтмалын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны кадастрын хэлтэст хүргүүлэн орон нутгийн тусгай хэрэгцээний газар, хязгаарлалт, хориглолтын бүстэй давхцалтай эсэх, тусгай зөвшөөрлийн талбайн байдал, уурхайн эдэлбэр газрын зөвшөөрөл зэргийн талаар зурагтай лавлагаа авах.
- Хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй,

эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан зэрэг нь 7.11-д заасан зөрчил шалгах ажиллагаатай адил.

- Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан үлдэл нь шинэлэг зохицуулалт бөгөөд гаргасан гомдол мэдээлэлд дурдсан үндэслэлд тулгуурлан шалган шийдвэрлэх нийтлэг арга ажиллагаанаас сонгож хэрэглэнэ.
- Бичил уурхайгаар ашигт малтмал олборлохтой холбогдсон харилцааг зохицуулах талаар тогтоосон журам зөрчсөн үйлдлийг шалгахдаа Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолд заасан заалт бүрээр шалгах,
- Байгаль орчинд нөлөөлөх үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн төсөл, хөтөлбөр, хийгдсэн гэрээний байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, гэрээгээр заасан байгаль орчныг нөхөн сэргээхтэй холбоотой заалтын биелэлтийг шалгах;
- Археологийн болон палентлогийн судалгааг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн эсэх, түүх соёлын үнэт зүйлийг уулын ажлын явцад эвдэж сүйтгэх, зохих байгууллагад мэдэгдсэн эсэхийг шалгах.
- Тухайн зөрчил нь Уул уурхайн техник эдийн засгийн үндэслэлтэй хэрхэн холбогдож байгаа, хэрхэн тусгасан зэргээр шалгалт хийх.
- Тухайн аж ахуйн нэгжийг урьд өмнө төрийн эрх бүхий байгууллага / Мэргэжлийн хяналтын байгууллага, Ашигт малтмалын газар, Усны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, орон нутгийн албадуут гэх мэт/-аас шалгаад тавьсан акт, албан шаардлага, мэдэгдэл, дүгнэлт, шинжилгээний хариу, торгуулийн тасалбар, шийтгэвэр, маргаантай асуудлаар гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, албан бичиг зэрэг тухайн асуудалтай холбогдол бүхий баримт бичигт үзлэг хийж хэрэгт хуулбарлан хавсаргаж байх.
- Мөн тухайн аж ахуйн нэгжийн дотоод бичиг баримтад үзлэг хийж шалгаж буй хэрэгт хамааралтай тушаал, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, хамтран ажиллах болон туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, ашиг хуваарилсан баримт, уулын ажлын төлөвлөгөө, хайгуулын ажлын тайлан, нөөцийн материал, орд газрын болон уурхайн байгууламжийн зураглал, сүүлийн байдлаар хийсэн хөрсний зураглал /3D технологи/, үндсэн, охин, толгой зэрэг компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээ, татварын тайлан, үүсгэн байгуулалт болон хөрөнгө оруулагчтай холбоотой баримт зэрэг залгаж буй зөрчилтэй холбоотой баримтуудаас сонголт хийж хураан авах, хуулбарлан авах ажиллагааг явуулна.
- Зөрчлийн улмаас мал амьтан, байгаль орчинд хохирол учирсан байдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-аар тооцож тогтоолгох. Хохирол нөхөн төлүүлэх явдлыг хангахад чиглэгдсэн ажиллагааг прокурорт танилцуулан шийдвэрлэх.

- Зөрчлийн улмаас ан амьтан, байгаль орчинд учруулсан хохиролд төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас томилсон этгээдээс хохирогчоор хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.
- Хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтнуудын албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс хамаарч зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн бол Төрийн албаны тухай хуульд зааснаар сахилгын шийтгэл хүлээлгэх эсэх талаар хариуцсан дээд шатны байгууллагад бичгээр хандах. Шаардлагатай бол тухайн газар орныг хариуцаж байсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараас гэрчийн мэдүүлэг авч, ажил үүргийн хувьд хэн нь юу хариуцдаг болох, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргийг үзэх, хуулбарлан авах.
- **Шалгалтын явцад илэрсэн тусгай зөвшөөрөл, бусад зөвшөөрлийн бичиг, төсөл, хөтөлбөр, ТЭЗҮ, гэрээ зэрэг бичиг баримт нь үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарлагдсан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулан материалын шинж онцлогийг нарийн дурдаж тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хураан авах. Тухайн баримтыг үндэслэн холбогдох гэрчээс мэдүүлэг авах, эрх бүхий байгууллагаас лавлагаа хүсэх, илт хуурамч бичиг баримт үйлдсэн, зөрчлийг хаацайлахын тулд албан тушаалтнаас хуурамч баримт бичиг хийж ирүүлсэн бол прокурорт мэдэгдэж дариу шилжүүлнэ.**

Практик үйл ажиллагаатай холбоотой жишээ-1

Мэргэжлийн хяналтын улсын байцаагч Х нь дүүргийн нутагт дэвсгэр гэх газраас түгээмэл тархацтай ашигт малтмал болох элс 20 тонныг олборлон, ачилт хийж, хөдлөх гэж байсан дугаарын Хово маркийн машиныг шалгахад жолооч А нь “Түгээмэл тархацтай ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн бичиг баримт байхгүй, манай ах Б нь дүүргийн ЗДТГ-ын дарга хүн байдаг, энэ бичгийг үз” гээд бичиг үзүүлэхэд “... 1 жилийн хугацаанд Налайх дүүргийн тамгын газрын хэрэгцээнд элс олборлон ачиж болно” гэсэн Б-гийн гарын үсэг бүхий албан тоот байв. Лавшруулан шалгахад элсийг Б-гийн эхнэрийн бетон зуурмагийн үйлдвэрт нийлдүүлдэг болох нь тогтоогдсон байна.

Шийдвэрлэх ажиллагаа:

Зөрчлийн тухай хуулийн 7.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар жолооч А-гийн асуудлыг шийдвэрлэж болох боловч Налайх дүүргийн ЗДТГ-ын дарга Б-гийн асуудал нь Эрүүгийн хуулийн 22.1 дүгээр зүйлд заасан “Эрх мэдэл, албан тушаалын байдлаа урвуулан ашиглах” гэмт хэргийн шинжийг агуулж байх тул гэмт хэргийн хамтран оролцогч эсэхийг эрүүгийн процессын журмаар шалган тогтоох шаардлага байна. Иймд зөрчлийн хэргийн мэдүүлэг, бусад авагдсан баримт материалыг прокурорт танилцуулан улмаар Авлигатай тэмцэх газарт харьяаллаар шилжигдэнэ. Эрүүгийн хэрэгт жолооч Б ах А-гийн гэмт хэрэгт

хамтран оролцоогүй нь тогтоогдож, энэ талаар зөрчлийн хариуцлага тооцуулахаар ирсэн албан бичгийг үндэслэн улсын байцаагчаас Б-д хариуцлага тооцож болно.

“Үзлэгийн загвар, жишээ”

Тусгай зөвшөөрөлгүй хүн, хуулийн этгээд түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуул хийсэн, олборлосон, эсхүл борлуулсан, ашигт малтмалын орд ашигласан талбайд улсын байцаагчаас “Зөрлийн газрын үзлэг хийсэн” тэмдэглэлийг загвар жишээн дээр зохиомжлон оруулав.

Уул уурхайн хууль бус олборлолт явагдсан зөрчлийн газарт үзлэг хийж, техник хэрэгслээр бэхжүүлэн авсан тухай тэмдэглэл

....оны ... сарын -н аймгийн сумын нутаг

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын, Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын газрын улсын ахлах байцаагч Ц би Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.3 дугаар зүйлд заасныг баримтлан аймгийн сумын нутаг гэх газарт “түгээмэл тархацтай ашигт малтмал хууль бусаар олборлосон” тухай иргэн Б.....аас гаргасан өргөдөл гомдлыг үндэслэн дугаартай зөрчлийн хэрэг нээж эрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлуудыг олж илрүүлэн, нотолгооны ач холбогдол бүхий газар орон, хөрс, усны байдлыг техник хэрэгсэл ашиглан бэхжүүлэн авах зорилгоор хэрэг учралын талаар мэдэх, хөрөнгө оруулсан болон уурхай ажиллах үед нь аж ахуй, техник хэрэгсэл хариуцаж байсан гэх Г, Д, Д, Б-ын уурхайд онд баяжуулалт хариуцаж байсан гэх, уурхайн аюулгүй байдал хариуцсан ажилтан нарыг байлцуулан аймгийн сумын нутаг гэх амыг бүхэлд нь хамруулсан хэрэг учралын газрын үзлэгийг оны сарын -ны өдрийн цаг минутаас эхлэн явуулж мөн өдрийн ... цаг минутыг хүртэл хугацаанд үргэлжлүүлэн дуусгаж уг ажиллагааны тэмдэглэлийг үйлдэв.

Уг ажиллагаанд Газар зүйн байршил тогтоогч “GARMIN 62s” маркийн GPS багаж болон “Nikon D5100” маркийн 13.5 мегапексил нягтралтай, 18-55 мм-ийн 1/3.5-5.6G дурангийн үзүүлэлттэй, джитал тонн технологид суурилагдсан , өнгөт фото зургийн аппарат, COOLSHOT маркийн Лазерийн зайн хэмжигч зэргийг техник хэрэгсэл болгон ашиглаж үзлэгийн явц үр дүнг бэхжүүлсэн болно.

Үзлэгийг байгалийн гэрэлд, ердийн, үүлэрхэг бүрхэг зэрэг цаг агаарын олон талт нөхцөлд явуулсан болно.

Үзлэгээр:

..... аймгийн сумын нутаг гэх амыг бүхэлд нь хамруулсан хэрэг учралын газрын үзлэгийг явуулав. “Хуст нарийн” амны ашиглалтын тусгай зөвшөөрлийн зураг, цэгүүд олдоогүй тул эвдрэл болон шороон овоолго бүхий газрыг энгийн нүдээр харж, техник хэрэгслийн тусламжтайгаар явуулав. Үзлэгийн хүрээнд ойролцоогоор 4,5 километрийн урттай 10 метрээс 500 метрийн өргөн зурвас бүхий үргэлжилсэн талбайг

хамруулан явуулсан болно. Мөн үзлэгийн ажиллагааны явцад тухайн уурхайлалт явуулсан хүмүүст холбогдох газрыг мэдэх гэрч бүрээр заалгаж хамаарал бүхий нэрсийг бичиж тухайн хүний нэртэй холбоотой газрын хэддүгээр цэг болохыг тус тус нь гэрчүүдээр тоог бариулан , Газар зүйн байршил тогтоогч “GARMIN 62s” маркийн GPS багажийн дэлгэц дээр гарч ирж буй солбицлын цэгийн хамт зургаар бэхжүүлэв. Тэмдэглэлд дурдсан хүний нэр бүхий цэгийн уртраг, өргөргийг тодорхойлон заасан /координат солбицлыг градус, минут, секундээр бүрэн харуулсан/ мэдээллийг үзлэгийн тэмдэглэлд хавсаргасан болно. Үзлэгт хамрагдсан газар нутаг нэлэнхийдээ шаварлаг, усархаг хөрстэй, хайрга угаалтаас тогтсон гэхээр шар өнгөтэй том том нуур, нуранги үүссэн байдалтай сул хөрс бүхий гүн ухагдсан газар болон, шороон овоолго зэргээс бүрэлдсэн байх ба үзлэгийг амны дороос өгсөх байдлаар цэг тэмдгийг дугаарлан үзлэг хийж тэмдэглэлд тусгав.

“БААТАР”-ын уурхай ажиллаж байсан гэх амны төгсгөл буюу замтай нийлсэн хэсэг

..... ам нь машины стептометрийн заалтаар хэмжиж үзэхэд уртааш ойролцоогоор 5 километрийн урттай 50 метрээс 550 метрийн өргөн зурвас бүхий ертөнцийн зүгээр урдаас хойш өгсөж үргэлжилсэн ам байх ба Баатарын ажиллаж байсан гэх талбай нь уг амны төгсгөл буюу авто машины шороон замын хажууд байна. Уг талбайг гэрчүүдээр заалган тэмдэглэлд дурдсан байдлаар зургаар бэхжүүлэн үзэхэд ухагдаж, угагдсан чулуурхаг шороон овоолго эргэн тойрондоо үүссэн, хайрга угаалтад байгалийн усыг боож ашиглаж байсан гэхээр шар өнгөтэй нуур тогтсон, нуранги үүссэн байдалтай сул хөрс бүхий гүн ухагдсан газар зэргээс бүрдсэн байна. Ямар нэг нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй байх ба хөндөгдсөн газрын гүн нь 10-23 метрийн хэлбэлзэлтэй байна, эргээс тогтоол нуурын усны мандал хүртэлх гүн нь 23 метр байна. Газрын урт өргөнийг 4 цэг болгон Газар зүйн байршил тогтоогч “GARMIN 62s” маркийн GPS багаж ашиглан солбицлуудыг тогтоосон ба улмаар COOLSHOT маркийн Лазерийн зайн хэмжигчээр хэмжихэд 1-2 дугаар цэг хүртэл 66.5 метр , 2-3 дугаар цэг хүртэл 55 метр, 3-4 дугаар цэг хүртэл 62.5 метр, 4-1 дугаар цэг хүртэл 83 метр байв.

“УУГАН”-ын уурхай ажиллаж байсан гэх амны төгсгөлөөс дээш өгсөх дунд хэсэгт

..... амны төгсгөлөөс дээш өгсөх дунд хэсэгт байна. Уг талбайг гэрчүүдээр заалган Баатарын уурхайн талбайн 4,3 дугаар цэгүүдтэй хиллэж байх ба дундуураа шороон далан мэт зүйл татаж тэмдэг тавьсан байв. Олборлолт явсан хязгаар нь хойд зүгт өнчин ганц том модыг хүртэл үргэлжилсэн гэж гэрчүүд заав. Тэмдэглэлийн эхэнд дурдсан байдлаар зургаар бэхжүүлэн үзэхэд ухагдаж угагдсан чулуурхаг шороон овоолго эргэн тойрондоо үүссэн, хайрга угаалтад байгалийн усыг боож ашиглаж байсан гэхээр шар өнгөтэй нуур тогтсон, нуранги үүссэн байдалтай, сул хөрс бүхий гүн ухагдсан газар зэргээс бүрдсэн байна. Ямар нэг нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй байх ба хөндөгдсөн газрын гүн нь 12-21

метрийн хэлбэлзэлтэй байна, эргээс тогтоол нуурын усны мандал хүртэлх гүн нь 21 метр байна. Газрын урт өргөнийг 4 цэг болгон Газар зүйн байршил тогтоогч “GARMIN 62s” маркийн GPS багаж ашиглан солбицлуудыг тогтоосон ба улмаар COOLSHOT маркийн Лазерийн зайн хэмжигчээр хэмжихэд 1-2 дугаар цэг хүртэл 62.5 метр , 2-3 дугаар цэг хүртэл 135.5 метр, 3-4 дугаар цэг хүртэл 99.5 метр, 4-1 дугаар цэг хүртэл 208 метр байв.

“БАЯР”-ЫГ ӨГСӨХ ХЭСЭГТ

..... амны дунд хэсгээс дээш өгсөн эх хүртэл байна. Уг талбайг гэрчүүдээр заалган уурхайн талбайн 4,3 дугаар цэгүүдтэй хиллэж байх ба шороон овоолгын хажуугийн өнчин ганц том модноос хойд зүгт үргэлжилсэн гэж гэрчүүд заав. Тэмдэглэлийн эхэнд дурдсан байдлаар зургаар бэхжүүлэн үзэхэд ухагдаж угагдсан чулуурхаг шороон овоолго эргэн тойрондоо үүссэн, хайрга угаалтад байгалийн усыг боож ашиглаж байсан гэхээр шар өнгөтэй нуур тогтсон, нуранги үүссэн байдалтай, сул хөрс бүхий гүн ухагдсан газар зэргээс бүрдсэн байна. Нөхөн сэргээлтийн ажил хийгдээгүй байх ба хөндөгдсөн газрын гүн нь 14-18 метрийн хэлбэлзэлтэй байна, эргээс тогтоол нуурын усны мандал хүртэлх гүн нь 14.5 метр байна. Уурхай нь ажиллаж хөрс хуулалт, хайрга угаалт ид явагдаж байх бөгөөд уурхай хариуцаж буй, нартай уулзахад “Баярын уурхай бид сайн мэдэхгүй, Баярын овог мэдэхгүй, компанийн нэрийг мэдэхгүй, уурхайн бичиг баримт бидэнд үлдээгээгүй, ашиглалтын тусгай зөвшөөрөл байгаа эсэхийг мэдэхгүй, тендерт орж энэ газрыг нөхөн сэргээлт хийхээр авсан гэж Баяр хэлсэн” гэх тайлбараас өөр зүйл хэлээгүй. Уурхайн ажилчдын 7 гэр баригдсан, олон тооны техник ажиллаж байв. Уурхайн кемпийн солбицлыг болон гэр, техникүүдийг зургаар бэхжүүлэн авлаа. Кемпээс баруун урд зүгт 135.5 метрт 4 зам бүхий конвертай, хайрга бутлуурын машин ажиллаж байна. Уурхай хариуцаж байгаа дээрх иргэдийг дагуулан нийт талбайг үзэхээр хөдлөв уурхайн кемпээс хойд зүгт ам өгсөөд машины стептометрийн заалтаар хэмжиж үзэхэд уртааш 3 километр газарт 1 дүгээр цэг хүртэл хуучин олборлолтод өртөөд нөхөн сэргээлт хийлгүй орхисон гэхээр өвс ургамал ургасан дахин шинээр хөндөгдөөгүй талбай байв. Уурхай гарч ирээд 14 хонож байгаа гэх ба оны ...-р сарын-өөс хойш олборлолт хийж байгаа талбайг заалгаж үзлэг хийхэд. Уг талбайн дээд үзүүр буюу хамгийн хойд захын хэсгийг 2 дугаарын цэг өгч солбицлыг тогтоон зургаар бэхжүүлэн хэсэг газрыг үзэхэд урьд өмнө олборлолтод өртөөгүй хар хөрс шороог хуулан 2 экскаватор ажиллаж байх ба буган чулуу хөшөө бүхий хиргисүүрийн нэг хэсгийг 5/8 метр тэгш дөрвөлжин талбайд 3 метрийн гүнтэйгээр ухаж соёлын өвийг гэмтээсэн байж болзошгүй нөхцөл байдал илрэв. Уг талбайг 2016 оны олборлолт эхэлсэн гэх зассан шороон зам бүхий хэсэг хүртэл газрын өргөнийг 2 цэг болгон Газар зүйн байршил тогтоогч “GARMIN 62s” маркийн GPS багаж ашиглан солбицлуудыг тогтоосон ба улмаар COOLSHOT маркийн Лазерийн зайн хэмжигчээр хэмжихэд 3-4 дугаар цэг хүртэл 72.5 метр , 4,3 дугаар цэгээс 2-р цэг хүртэл 21 метр өргөнтэй 203 метр урттай, овоолгын гүн 14 метр, тогтоол нуурын мандал хүртэл гүн 14.5 метр талбайд олборлолт явсан байв. Үүнээс уруудаж урд зүгт 2014 онд олборлолт явагдсан талбайг гэрч Б..... заалган хэмжихэд

газрын урт өргөнийг 4 цэг болгон Газар зүйн байршил тогтоогч “GARMIN 62s” маркийн GPS багаж ашиглан солбицлуудыг тогтоосон ба улмаар COOLSHOT маркийн Лазерийн зайн хэмжигчээр хэмжихэд 3-4 дугаар цэг хүртэл 72.5 метр, 3-5 дугаар цэг хүртэл 463 метр , 5-6 дугаар цэг хүртэл 164.5 метр, 6-4 дугаар цэг хүртэл 437 метр байв.

Үүгээр үзлэгийг дуусган оролцогчдод танилцуулахад гаргасан санал хүсэлт доор бичихээр зай үлдээв. Явц үр дүнг 53 кадр зургаар бэхжүүлэн, тогтоогдсон солбицол, гар схем, схем тэмдэглэлийн тайлбар зэргийг хавсралт болгон үзлэгийн тэмдэглэлд хавсаргасан болно.

.....

Үзлэгт оролцсон :

1.
2.
3.
4.
5.

Үзлэг хийж тэмдэглэл хөтөлсөн :

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын,
 Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын
 газрын улсын ахлах байцаагчБ.Ц.....

3.11 Усны тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 7.15 дугаар зүйлд дараах байдлаар заасан.

Үүнд:

1. Хуульд заасны дагуу:
 - 1.1. Усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан;
 - 1.2. Цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан;
 - 1.3. Ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй;
 - 1.4. Ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй;
 - 1.5. Усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн;
 - 1.6. Ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан, эсхүл бусдад шилжүүлсэн, эсхүл усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ,

- зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
 4. Гол, мөрний урсацын байгалийн үндсэн голдрилыг өөрчилсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
 5. Хуульд заасан:
 - 5.1. Усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүс тогтоох шаардлага биелүүлэх;
 - 5.2. Усны тоо бүртгэл, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулах;
 - 5.3. Тайлан, мэдээг гаргаж өгөх журам зөрчсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
 6. Рашааны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, эсхүл эдгээр бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
 7. Рашааныг:
 - 7.1. Гэрээ, эсхүл зөвшөөрөлгүй ашигласан;
 - 7.2. Горимын хэмжээнээс хэтрүүлэн гэрээгүйгээр ашигласан;
 - 7.3. Зориулалтыг дур мэдэн өөрчилсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
 8. Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан, эсхүл усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
 9. Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Мэргэжлийн нэршил, холбогдох хууль тогтоомж

“**Ус**” гэдэгт Монгол Улсын нутаг дэвсгэр дэх мөрөн, гол, горхи, булаг, шанд, рашаан, мөнх цас, мөс, мөсөн гол, байгалийн болон хиймэл нуур, цөөрөм зэрэг газрын гадаргын болон газрын доорхи ус хамаарна.

“**Усны нөөц**” гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх усны сан бүхий газарт байгаа гадаргын ус болон газрын доорх усыг хэлнэ.

“**Усны сав газар**” гэж гадаргын ус хурах талбай болон газрын доорх усны нөөцийг бүрдүүлэх тэжээгдлийн муж, тархалтын талбайг хамарсан орон зайг хэлнэ.

“**Усны сан бүхий газар**” гэж нуур, цөөрөм, тойром, гол мөрөн, горхи, булаг, шанд, усан сан, рашаан, намаг, мөстөл, мөсөн голын эзэлж байгаа талбай, тэдгээрийн хамгаалалтын бүсийн газрыг хэлнэ.

“**Гол, мөрний урсац бүрэлдэх эх**” гэж гадаргын урсацын үндсэн хэсэг бүрэлдэн бий болдог өндөр уулсын бүс, сав газрын эхийг хэлнэ.

“**Усны эх үүсвэр**” гэж ус хангамжийн эх үүсвэрт ашиглаж байгаа усны нөөц болон гол мөрний урсац бүрэлдэх эхийг хэлнэ.

“**Рашаан**” гэж физикийн болон химийн өвөрмөц шинж чанар бүхий эмчилгээний ач холбогдолтой байгалийн ус, шаврыг хэлнэ.

“**Рашааны орд**” гэж газрын гадарга, түүний хэвлийд бүрэлдэн тогтсон рашаан агуулж байгаа газрыг хэлнэ.

“**Хилийн ус**” гэж Монгол Улсын хилийн шугамын дагуу буюу огтлон оршиж буй гадаргын ба газрын доорх усыг хэлнэ.

“**Усан сан**” гэж усны нөөцийг хуримтлуулах, ашиглах зориулалтаар бий болгосон хиймэл нуур, хөв, цөөрмийг хэлнэ.

“**Усны нөөцийн менежментийн төлөвлөгөө**” гэж сав газрын усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбогдсон үйл ажиллагааг нэгдмэл байдлаар зохицуулах баримт бичгийг хэлнэ.

“**Усны экологи-эдийн засгийн үнэлгээ**” гэж усны нөөцийн байгалийн үнэ цэнэ, өгөөж, хэмжээ, чанар, хэрэглээний ач холбогдлыг мөнгөн хэлбэрээр илэрхийлснийг хэлнэ.

“**Усны нөөцийн хомсдол**” гэж усны нөөц багасах, усны чанар, байгалийн үнэ цэнэ, өгөөж доройтохыг хэлнэ.

“**Усны бохирдол**” гэж хүний шууд ба шууд бус үйл ажиллагааны улмаас байгалийн усны найрлага өөрчлөгдөж, усны чанар доройтохыг хэлнэ.

“**Бохирдуулах бодис**” гэж хаягдал усанд агуулагдаж, хүрээлэн байгаа орчныг бохирдуулж байгаа бодис, тэдгээрийн хольцыг хэлнэ.

“**Аюултай бохирдуулах бодис**” гэж байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан жагсаалтад орсон бодисыг хэлнэ.

“**Хаягдал ус**” гэж ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээнээс гарч


байгаа бохир ус, шингэн хаягдлыг хэлнэ.

“Ус ашиглагч” гэж ашиг олох зорилгоор үйлдвэрлэл, үйлчилгээндээ ус, усан орчин, рашааныг ашигладаг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ.

“Ус хэрэглэгч” гэж ашиг олох зорилгогүйгээр унд, ахуйн болон гэр бүл, өрхийн хэрэгцээний мал аж ахуй, газар тариаланд ус, усан орчинг ашигладаг хэрэглэгчийг хэлнэ.

“Ус бохирдуулагч” гэж ахуйн хэрэглээ болон үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж, хаягдал ус гаргаж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хэлнэ.

Монгол орны усны сав, хагалбараар нийт 29 сав газрын захиргаад хуваасан байдаг.



Усны мэргэжлийн байгууллагын тусгай зөвшөөрлийг Төрийн захиргааны төв байгууллага буюу БОАЖЯ-наас олгодог. Усны мэргэжлийн байгууллагын эрх олгоход бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт: Үүнд:

1. Аж ахуйн нэгжийн тухай танилцуулга,

2. Аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ,
3. Тухайн чиглэлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах мэргэжлийн боловсон хүчин /диплом, сертификатын хуулбар, ажлын туршилга/
4. Техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийн гэрчилгээ,
5. Зураг /машин механизм, тээврийн хэрэгслийн/
6. Хувийн хэрэг,
7. Тээврийн хэрэгсэлийн гэрчилгээ болон бусад техникийн үзүүлэлт,
8. Мэдээлэл хангамжийн талаар,
9. Аймаг, нийслэлийн байгаль орчны албаны /БОАЖГ/ дүгнэлт, дүгнэлтэд үндэслэсэн аймаг, нийслэлийн Засаг даргын тодорхойлолтыг хавсаргана,
10. Тэмдэгтийн хураамж, гэрчилгээний үнэ төлсөн баримт гэх мэт.

Байгаль орчны асуудал эрхэлсэн Төрийн захиргааны төв байгууллага нь материал хүлээн авсан өдрөөс хойш ажлын 21 хоногт шийдвэрлэнэ.

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг ус ашиглах, хэрэглэх зориулалтаас хамааруулан дараах байдлаар ангилна: Үүнд: 1. Ус хэрэглэгч, 2. Ус ашиглагч.

Ус хэрэглэгчид олгох зөвшөөрөл: Цооног өрөмдөх, худаг гаргах, голоос суваг шуудуу татах зөвшөөрлийг ус хэрэглээний тоо хэмжээ, чанарыг үндэслэн аймаг, нийслэлийн байгаль орчны алба ус хэрэглэгчид олгоно.

Ус хэрэглэгч зөвшөөрөл авахдаа аймаг, нийслэлийн байгаль орчны албанд өргөдөл гаргах бөгөөд өргөдөлд дараах мэдээллийг тусгана:

- Ус хэрэглэх зориулалт, тоо хэмжээ;
- Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн бичгийн хуулбар;
- Худгийн мэдээлэл.

Аймаг, нийслэлийн байгаль орчны алба ус хэрэглэгчийн худаг, цооногийг усны мэдээллийн санд бүртгэж, худгийн паспорт олгоно.

Ус хэрэглэгч ашиглалтын зориулалтыг өөрчлөх, зөвшөөрөлгүйгээр цооног өрөмдөх, худаг гаргах, суваг шуудуу татахыг хориглоно.

Ус ашиглагчид олгох зөвшөөрөл:

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага ус ашиглах хүсэлтээ хоногт хэрэглэх хүчин чадалаасаа хамааран Сум, дүүрэг, Усны сав газрын захиргаа, Төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

Ус ашиглах хүсэлтэд дараах бичиг баримтыг хавсаргана: Үүнд:

- Ашиглах усны эх үүсвэр, эсхүл рашааны эх булаг, түүний байршлыг харуулсан зураг;
- Ус, рашааны нөөц, чанар, найрлагыг тогтоосон хайгуул, судалгааны тайлан, ашиглах боломжит нөөцийн талаарх дүгнэлт;
- Хоногт ашиглах усны хэмжээ, зориулалт;

- Барилга байгууламжийн зураг, төсөл;
- Үйлдвэрлэлийн хүчин чадал, техник, эдийн засгийн үзүүлэлт;
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан, дүгнэлт,

Нэмэлтээр:

- Усны мэргэжлийн байгууллагаар тогтоолгож, /усны нөөцийн зөвлөлөөр баталгаажуулсан рашааны хязгаарлалтын бүсийн зураг/;
- Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дүгнэлт;
- Рашааныг хамгаалах, ашиглах төсөл.

Мөн усны дүгнэлтийг гаргуулахдаа дараах зүйлийг анхаарах ёстой. Үүнд: Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах дүгнэлтийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, 50-100 шоометр ус болон усан орчин ашиглуулах дүгнэлтийг сав газрын захиргаа, 50 шоометр хүртэлх ус ашиглуулах, хурын ус хуримтлуулж, хөв, цөөрөм байгуулах, суваг, шуудуу татах дүгнэлтийг аймаг, нийслэлийн байгаль орчны алба тус тус гаргана. Ус ашиглах тухай хүсэлтийг хүлээн авснаас хойш ажлын 15 өдрийн дотор дүгнэлт гаргана.

Ус ашиглуулах дүгнэлт, холбогдох зөвшөөрөлгүйгээр ус ашиглах, дур мэдэн цооног гаргахыг хориглоно.

Байгальд халтай технологи бүхий үйлдвэр, үйлчилгээний газарт ус ашиглуулах дүгнэлт гаргахыг хориглоно.

Усны тухай хуульд нийцүүлэн гаргасан дараах дүрэм, журам, стандарт байдаг. Үүнд:

- Гол мөрний сав газрын зөвлөлийн дүрэм,
Усны нөөцийг бохирдлоос хамгаалах дүрэм,
- Хүн амын унд ахуйн усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дүрэм,
- Усны сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэм,
- Усны тоо бүртгэл явуулах журам,
- Усны мэдээлэлийн сан болон улсын усны кадастрыг бүрдүүлэх үзүүлэлт хөтлөх журам,
- Хаягдал ус зайлуулах цэг тогтоох журам,
- Ахуйн бохир ус хаях цооногийг доторлож ашиглах журам,
- Ус ашиглах гэрээ
- Ус ашиглуулах дүгнэлт гаргах үйлчилгээний хөлс, ус ашиглах эрхийн бичиг, гэрээний загвар батлах тухай,
- Унд, ахуйн зориулалттай усны төвлөрсөн хангамжийн эх булгийг сонгох журам ба эрүүл ахуйн шаардлага
- Бохир ус цэвэрлэх байгууламжийн байршил, цэвэрлэгээний

технологи, түвшинд тавих үндсэн шаардлага Монгол улсын стандарт MNS4288:1995,

- Хүрээлэн байгаа орчин. Усны чанар. Хаягдал ус. Ерөнхий шаардлага MNS4943:2015,

Дээрхи хууль, дүрэм, журмыг дараах хаягнаас татан авч үзэж болно.

- ✓ <http://legalinfo.mn/law/details/8683?lawid=8683>
- ✓ https://www.standard.gov.mn/index.php?module=standart&cmd=standart_desc&catid=333&id=218

Зүйлчлэлийн асуудал

“Усны тухай хууль зөрчих” зөрчил нь:

“Хуульд заасны дагуу: усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан, цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан, ус ашиглахад тавигдах нөхцөлийг хангуулахаар төрийн албан хаагчийн тавьсан шаардлагыг биелүүлээгүй, ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй, усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, ашиглаж дууссан цооногоо битүүмжилж хүлээлгэн өгөөгүй; Ус ашиглах зөвшөөрлийг бусдад худалдсан, эсхүл бусдад шилжүүлсэн, эсхүл усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан; Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан; Гол, мөрний урсцын байгалийн үндсэн голдрилыг өөрчилсөн” зэрэг шинжийг 1-4 дэх хэсэгт тодорхойлсон. Мөн түүнчлэн “Хуульд заасан усны сан бүхий газарт энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүс тогтоох шаардлага биелүүлэх, усны тоо бүртгэл, эрэл, хайгуул, судалгааны тайлан, хяналт-шинжилгээний дүн мэдээ, ус ашиглалтын бүртгэл, хаягдал усны бүртгэлийг хугацаанд нь явуулах, тайлан, мэдээг гаргаж өгөх журам зөрчсөн” шинжийг 5 дахь хэсэгт заасан бол “Рашааны эх үүсвэрийн хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүс, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, эсхүл эдгээр бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан, Рашааныг гэрээ, эсхүл зөвшөөрөлгүй ашигласан, горимын хэмжээнээс хэтрүүлэн гэрээгүйгээр ашигласан, зориулалтыг дур мэдэн өөрчилсөн” зэрэг рашаан хамгаалахад чиглэгдсэн заалт орсон байна. Сүүлийн үед элбэг үйлдэгдэх болсон “Усны сан бүхий газарт хог хаягдал хаясан, эсхүл машин техник, бохир зүйл угаасан, эсхүл усны нөөцийг бохирдохоос хамгаалах үүргээ биелүүлээгүй, Ус ашигласны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй” зэрэг шинжийг зааж зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна.

2002 оны **Эрүүгийн хуулийн** 208 дугаар зүйлд “Усны тухай хууль тогтоомж зөрчиж их хэмжээний хохирол учруулсан, засаг амьтан олноор үхсэн, тусгай хамгаалалттай газар нутагт үйлдсэн” зэргээр эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан байсныг 2017 оны Эрүүгийн хуулиар бүхэлд хүчингүй болгосон байна. Иймд дээрх зөрчлийн шинжийг тогтоож зөвхөн зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх тул энд тусгайлсан зүйлчлэлийн асуудал яригдахгүй. Харин нэг анхаарах зүйл бол энэ төрлийн зөрчлийг шалгах явцад “Химийн хорт, аюултай бодис,

аюултай, хортой хог хаягдлыг ... усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн” бол уг үйлдэлд Эрүүгийн хуулийн 24.1 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх тул цагдаагийн байгууллагад харьяалал тогтоолгохоор прокурорт хандана.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

7.15 дугаар зүйлд заасан “Усны тухай хууль тогтоомж зөрчих” зөрчлийн хэрэг бүртгэлтийн ажиллагааг явуулахдаа дараах зүйлийг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Шалгаж буй зөрчлийн онцлогт тохируулан усны тухай хууль тогтоомж, газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, ой, ургамал, амьтан, агаарыг хамгаалах, тэдгээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, стандарт, хэм хэмжээ, дүрэм, журам, шийдвэрийг олж судалсан байх /зохих мэдлэгийг өөртөө хуримтлуулах/;
- “Хуульд заасны дагуу: усыг зөвшөөрөл авснаас өөр зориулалтаар ашигласан, цооног өрөмдөх зөвшөөрөлгүйгээр газрын доорх усыг ашигласан, ус ашиглагчийн үүрэг, тавигдах шаардлагыг биелүүлээгүй, усны эх үүсвэрийн онцгой, эсхүл энгийн хамгаалалтын бүс, эсхүл эрүүл ахуйн бүсийн дэглэмийг зөрчсөн, ашиглаж дууссан цооноого битүүмжилж хүлээлгэн өгөөгүй; Усыг үйлдвэрлэлийн зориулалтаар зохих гэрээ, зөвшөөрөлгүйгээр, эсхүл гэрээнд заасан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан; Усны эх, ундаргын онцгой хамгаалалтын бүсэд хориглосон үйл ажиллагаа явуулсан; Гол, мөрний урсцын байгалийн үндсэн голдрилыг өөрчилсөн” зэрэг шинжийн хувьд зөрчлийн газрын үзлэг хийж /үзлэг хийх аргачлалыг өмнөх зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаануудад тухай бүр дурдсан/ хэрэгт ач холбогдол бүхий нөхцөл байдлыг тогтооно.
- Үзлэгээр тогтоогдсон цэгүүдийг орон нутгийн газрын албад, Ашигт малтмалын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яамны кадастрын хэлтэст хүргүүлэн орон нутгийн тусгай хэрэгцээний газар, хязгаарлалт, хориглолтын бүстэй давхцалтай эсэх, тусгай зөвшөөрлийн талбайн байдал, уурхайн эдэлбэр газрын зөвшөөрөл зэргийн талаар зурагтай лавлагаа авах.
- Хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан зэрэг нь 7.11-д заасан зөрчил шалгах ажиллагаатай адил.
- Тухайн зөрчил нь Уул уурхайн техник эдийн засгийн үндэслэлтэй хэрхэн холбогдож байгаа, хэрхэн тусгасан зэргээр шалгалт хийх.
- Тухайн аж ахуйн нэгжийг урьд өмнө төрийн эрх бүхий байгууллага / Мэргэжлийн хяналтын байгууллага, Ашигт малтмалын газар, Усны газар, Байгаль орчин, аялал жуулчлалын яам, орон нутгийн албадуут гэх мэт/-аас шалгаад тавьсан акт, албан шаардлага, мэдэгдэл, дүгнэлт, шинжилгээний хариу, торгуулийн тасалбар, шийтгэвэр, маргаантай

асуудлаар гарсан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, албан бичиг зэрэг тухайн асуудалтай холбогдол бүхий баримт бичигт үзлэг хийж хэрэгт хуулбарлан хавсаргаж байх.

- Мөн тухайн аж ахуйн нэгжийн дотоод бичиг баримтад үзлэг хийж шалгаж буй хэрэгт хамааралтай тушаал, ажлын байрны тодорхойлолт, хөдөлмөрийн гэрээ, хамтран ажиллах болон туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, ашиг хуваарилсан баримт, уулын ажлын төлөвлөгөө, хайгуулын ажлын тайлан, нөөцийн материал, орд газрын болон уурхайн байгууламжийн зураглал, сүүлийн байдлаар хийсэн хөрсний зураглал /3D технологи/, үндсэн, охин, толгой зэрэг компаниудын улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээ, татварын тайлан, үүсгэн байгуулалт болон хөрөнгө оруулагчтай холбоотой баримт зэрэг залгаж буй зөрчилтэй холбоотой баримтуудаас сонголт хийж хураан авах, хуулбарлан авах ажиллагааг явуулна.
- Зөрчлийн улмаас мал амьтан, байгаль орчинд хохирол учирсан байдлыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2010 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн А-156 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны хохирлын үнэлгээ, нөхөн төлбөр тооцох аргачлал”-аар тооцож тогтоологдох. Хохирол нөхөн төлүүлэх явдлыг хангахад чиглэгдсэн ажиллагааг прокурорт танилцуулан шийдвэрлэх.
- Зөрчлийн улмаас ан амьтан, байгаль орчинд учруулсан хохиролд төрийн захиргааны байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас томилсон этгээдээс хохирогчоор хуульд заасан үндэслэл журмын дагуу мэдүүлэг авч энэ тухай тэмдэглэл үйлдэнэ. Мэдүүлгийг ЗШШТХ-ийн 4.8, 4.9-д заасан журмыг баримтлан явуулна.
- Хяналт тавих үүрэг бүхий албан тушаалтнуудын албан үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс хамаарч зөрчил үйлдэгдэхэд нөлөөлсөн бол Төрийн албаны тухай хуульд зааснаар сахилгын шийтгэл хүлээлгэх эсэх талаар хариуцсан дээд шатны байгууллагад бичгээр хандах. Шаардлагатай бол тухайн газар орныг хариуцаж байсан мэргэжилтэн, байгаль хамгаалагч нараас гэрчийн мэдүүлэг авч, ажил үүргийн хувьд хэн нь юу хариуцдаг болох, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт зэргийг үзэх, хуулбарлан авах.
- Шалгалтын явцад илэрсэн тусгай зөвшөөрөл, бусад зөвшөөрлийн бичиг, төсөл, хөтөлбөр, ТЭЗҮ, гэрээ зэрэг бичиг баримт нь үнэн эсэх нь тодорхойгүй, хуулбарлагдсан, эргэлзээтэй баримт материал гаргаж өгвөл тухайн бичиг баримтад үзлэгийн ажиллагаа явуулан материалын шинж онцлогийг нарийн дурдаж тэмдэглэл хөтлөн гарын үсэг зуруулж хураан авах. Тухайн баримтыг үндэслэн холбогдох гэрчээс мэдүүлэг авах, эрх бүхий байгууллагаас лавлагаа хүсэх, илт хуурамч бичиг баримт үйлдсэн, зөрчлийг хаацайлахын тулд албан тушаалтнаас хуурамч баримт бичиг хийж ирүүлсэн бол прокурорт мэдэгдэж дариу шилжүүлнэ.

3.12 Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 7.16 дугаар зүйлд дараах байдлаар заасан.
Үүнд:

1. Ус бохирдуулагчийн тухай болон хаягдал усны хэмжээ, найрлага, бохирдуулах бодисын тухай мэдээллийг нуун дарагдуулсан, эсхүл худал мэдээлэл өгсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлгүй цэгт хаягдал ус нийлүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Ус бохирдуулсны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зүйлчлэлийн асуудал

“Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль зөрчих” зөрчил нь:

“Ус бохирдуулагчийн тухай болон хаягдал усны хэмжээ, найрлага, бохирдуулах бодисын тухай мэдээллийг нуун дарагдуулсан, эсхүл худал мэдээлэл өгсөн; Зөвшөөрөлгүйгээр, эсхүл зөвшөөрөлгүй цэгт хаягдал ус нийлүүлсэн; Ус бохирдуулсны төлбөрийг хугацаанд нь төлөөгүй” зэрэг тодорхой шинжийг зааж зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна.

Эрүүгийн хуульд Дээрх зөрчлийн шинжийг тогтоож зөвхөн Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх тул энд тусгайлсан зүйлчлэлийн асуудал яригдахгүй. Энэ төрлийн зөрчлийг шалгах явцад “Химийн хорт, аюултай бодис, аюултай, хортой хог хаягдлыг ... усны сан бүхий газар, гол мөрний урсац бүрэлдэх эх, эх үүсвэрийн тэжээгдлийн муж, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс дотор хаяж хүний эрүүл мэнд, мал, амьтан, ургамал, тэдгээрийн үр удамд сөрөг нөлөөлөл үзүүлэх, өвчин эмгэг үүсгэх, үхэл, мөхөлд хүргэх нөхцөлийг бүрдүүлсэн” бол уг үйлдэлд Эрүүгийн хуулийн 24.1 дүгээр зүйлд зааснаар эрүүгийн хариуцлага хүлээлгэх тул цагдаагийн байгууллагад харьяалал тогтоолгохоор прокурорт хандана.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

Усны хууль тогтоомж зөрчих зөрчлийн шалган шийдвэрлэх ажиллагаанаас үзнэ үү.

3.13 Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах

Зөрчлийн тухай хуулийн 7.17 дугаар зүйлд дараах байдлаар заасан.

Үүнд:

1. Тусгай хамгаалалттай газар нутагт:
 - 1.1. хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, дэглэм, горим зөрчсөн;
 - 1.2. Менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаа явуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зүйлчлэлийн асуудал

“Тусгай хамгаалалттай газар нутагт хориглосон үйл ажиллагаа явуулах” зөрчил нь:

“Тусгай хамгаалалттай газар нутагт хууль, захиргааны хэм хэмжээний акт, стандарт, дэглэм, горим зөрчсөн, менежментийн төлөвлөгөөнд тусгагдаагүй үйл ажиллагаа явуулсан, Тусгай хамгаалалттай газар нутагт хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол” зэрэг тодорхой шинжийг зааж зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна.

Эрүүгийн хуульд Эрүүгийн хуулийн 24 дүгээр бүлгийн зарим гэмт хэргийн тусгай хамгаалалттай газар нутагт үйлдсэн бол гэж ялгаж заасан, эсхүл үйл ажиллагааны шинж заасан зарим зүйлээс бусад нь зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэгдэнэ.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль зөрчих зөрчлийн шалган шийдвэрлэх ажиллагаанаас үзнэ үү.

3.14 Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 9.7 дугаар зүйлд дараах байдлаар заасан.

Үүнд:

7. Соёлын өвийн, эсхүл түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын дэглэм зөрчсөн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8. Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад илэрсэн соёлын биет өвийг хамгаалах, мэдээлэх арга хэмжээ аваагүй бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зүйлчлэлийн асуудал

“Соёлын өвийг хамгаалах тухай хууль зөрчих” зөрчил нь:

“Соёлын өвийн, эсхүл түүх, соёлын дурсгалт газрын хамгаалалтын дэглэм зөрчсөн, Газрын хэвлийг эзэмших, ашиглах явцад илэрсэн соёлын биет өвийг хамгаалах, мэдээлэх арга хэмжээ аваагүй” зэрэг тодорхой шинжийг зааж зөрчлийн хуулиар хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан байна.

Эрүүгийн хуульд:

- 25.1 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх, устгах
- 25.2 дугаар зүйл. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалыг эвдэх, гэмтээх, устгах
- 25.3 дугаар зүйл. Соёлын биет өвийг завших, үрэгдүүлэх
- 25.4 дүгээр зүйл. Хууль бусаар археологи, палентологийн хайгуул, малтлага хийх
- 25.5 дугаар зүйл. Соёлын биет өвийн хууль бус худалдааг зохион байгуулах, зуучлах
- 25.6 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тогтоосон хугацаанд хилээр оруулж ирэхгүй байх зэрэг зүйлээр соёлын өвгийг хамгаалсан бүлэг байна.

3.15 Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль зөрчих

1. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зохих зөвшөөрөлгүйгээр ажиллах хүч, мэргэжилтэн гадаадаас авч ажиллуулсан, эсхүл ажиллах хүч гадаадад гаргасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө ажлын байрны төлбөрийг хуульд заасан хэмжээгээр төлөөгүй бол төлбөрийг нөхөн төлүүлж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Байгууллага нь:
 - 3.1. Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээний биелэлт, гадаадад хөдөлмөр эрхлүүлж байгаа иргэд, гадаадаас авч ажиллуулж байгаа ажиллах хүч, мэргэжилтний талаархи тайлан, мэдээг хуульд заасан журмын дагуу гаргаагүй;
 - 3.2. Цуцлагдсан, эсхүл сунгасан гэрээний тухай мэдээллийг тухай бүр гаргаагүй;

- 3.3. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүний эрх олгосон байгууллагад албан ёсоор ирүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Байгууллага нь гадаадад хөдөлмөр эрхлүүлж байгаа монгол иргэд, гадаадаас авч ажиллуулж байгаа ажиллах хүч, мэргэжилтнийг хөдөлмөрийн гэрээ дуусмагц эх оронд нь буцаах арга хэмжээ авах үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Анхаарах асуудал

Энэхүү зөрчил нь хэдийгээр **байгаль орчин, амьтан, ургамлыг хамгаалах журмын эсрэг зөрчил** биш боловч зарим тохиолдолд холбогдон гарч ирдэг тул цухас дурдав. Тухайлбал уул уурхайн салбарт гадаад ажиллагсдын квотыг хангах, илүү төлбөр төлөхгүйн тулд олон арга хэрэглэдэг нь манай улсад сөргөөр нөлөөлж байна. Гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниуд ажиллах хүчээ гадаадаас авахыг аль болох эрмэлзэж ямар нэг мэргэжил эзэмшээгүй гадаад иргэдийг “нарийн мэргэжил” эзэмшсэн мэтээр баримт бүрдүүлж Хөдөлмөр халамж үйлчилгээний албанд өгөх ба яг ажлын байрыг шалгахад ямар нэг тусгай мэргэжил шаардахгүй Монгол Улсын жирийн иргэн ажиллах боломжтой ажлын байр байдаг. Уурхайн ойр хавийн иргэд, нутгийн малчдын иргэний үнэмлэхийг хуулбарлан авч уурхайн ажилчнаар бүртгээд квотоо ихэсгэхэд ашиглаад, сул зогсолтын цалин тооцож өгөх буюу өгөхгүйгээр ажиллагсдын баримт бүрдүүлэхэд ашигласаар байдаг. Эсхүл гадаадаас барилгын салбарын квотоор өөр компанийн нэрээр захиалгатай орж ирсэн хүмүүсийг уул уурхайд ажиллуулах, /уул уурхайн квот, төлбөр өндөр/ визний ангилал зөрчих явдал их байна.

3.16 Тусгай зөвшөөрөл эзэмшигч эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулах

Зөрчлийн тухай хуулийн 10.27 дугаар зүйлд дараах байдлаар заасан.

Үүнд:

1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь хууль бусаар саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Анхаарах асуудал

Энэхүү зөрчил нь ашигт малтмалын салбарт үйлдэгддэг. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулиар олгогдсон эрхээ хэрэгжүүлэхэд нь ямар нэг хэлбэрээр шууд болон шууд бусаар саад учруулж буй хууль бус үйл ажиллагааг ойлгоно.

3.17 Төрийн хяналт шалгалтын тухай хууль зөрчих

1. Төрийн хяналт шалгалтад хамрагдах үүрэг бүхий этгээд:

- 1.1. Хяналт шалгалтаас зайлсхийсэн;
- 1.2. Дотоод хяналт шалгалтын журам тогтоож мөрдүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Төрийн хяналт шалгалтад хамрагдах үүрэг бүхий этгээд төрийн хяналт шалгалтад холбогдолтой баримт бичгийг:
 - 2.1. Гаргаж өгөхөөс үндэслэлгүйгээр татгалзсан;
 - 2.2. Засварласан;
 - 2.3. Гэмтээсэн;
 - 2.4. Зайлсхийсэн;
 - 2.5. Устгасан;
 - 2.6. Хуурамч баримт бичиг гаргаж өгсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.18 Цөмийн энергийн тухай хууль зөрчих

1. Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой аюулгүй ажиллагааны шаардлагыг зөрчсөн бол үйл ажиллагааг нь гурван сарын хугацаагаар түр, хэсэгчлэн зогсоож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Цацраг идэвхт ашигт малтмал, цацрагийн үүсгүүр, цөмийн энерги ашиглах талаарх тусгай зөвшөөрөлд заасныг зөрчиж үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
3. Цацрагийн осол, зөрчлийн тохиолдлыг зохих журмын дагуу мэдэгдээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг хурааж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
4. Шаардлагатай мэдээ, тайлан гаргаж өгөөгүй, эсхүл худал мэдээлэл гаргаж өгсөн, эсхүл цацрагтай ажиллагчийг мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамруулаагүй бол үйл ажиллагааг нь гурван сарын хугацаагаар түр, хэсэгчлэн зогсоож хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
5. Цацрагийн үүсгүүрийг хүлээн авсан тухайгаа төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж бүртгүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр

торгоно.

6. Цацрагийн үүсгүүрийн нэр төрлийг өөрчилсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
7. Тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу сунгуулаагүй үйл ажиллагаа явуулсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
8. Хайгуулын талбайгаас авсан дээж, сорьц, анхдагч материалыг санаатайгаар устгасан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь:

- 9.1. Олборлосон цацраг идэвхт ашигт малтмалын хэмжээг нуун дарагдуулсан;
- 9.2. Нуун дарагдуулах зорилгоор хуурамч гэрээ байгуулсан;
- 9.3. Борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан бол олборлосон цацраг идэвхт ашигт малтмалын хэмжээ, борлуулалтын үнийн зөрүүг тооцож улсын орлогод нөхөн төлүүлж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Зүйлчлэлийн асуудал

“Цөмийн энергийн тухай хууль зөрчих” зөрчлийн шинж нь:

“Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой аюулгүй ажиллагааны шаардлагыг зөрчсөн; Цацраг идэвхт ашигт малтмал, цацрагийн үүсгүүр, цөмийн энерги ашиглах талаарх тусгай зөвшөөрөлд заасныг зөрчиж үйл ажиллагаа явуулсан; цацрагийн осол, зөрчлийн тохиолдлыг зохих журмын дагуу мэдэгдээгүй; Шаардлагатай мэдээ, тайлан гаргаж өгөөгүй, эсхүл худал мэдээлэл гаргаж өгсөн, эсхүл цацрагтай ажиллагчийг мэргэжлийн шарлагын хувийн тунгийн хяналтад хамруулаагүй; Цацрагийн үүсгүүрийг хүлээн авсан тухайгаа төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд мэдээлж бүртгүүлээгүй; Цацрагийн үүсгүүрийн нэр төрлийг өөрчилсөн; Тусгай зөвшөөрлийг зохих журмын дагуу сунгуулаагүй; Хайгуулын талбайгаас авсан дээж, сорьц, анхдагч материалыг санаатайгаар устгасан; Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь олборлосон цацраг идэвхт ашигт малтмалын хэмжээг нуун дарагдуулсан, нуун дарагдуулах зорилгоор хуурамч гэрээ байгуулсан, борлуулалтын орлогыг санаатайгаар бууруулсан” зэрэг шинжтэй байдаг.

Эрүүгийн хуулийн 24.4 дүгээр зүйлд “Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бус эргэлтэд оруулах” гэмт хэргийн шинжийг:

“Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бусаар олж авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн,

экспортолсон, импортолсон, худалдсан, булшилсан; Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн” гэж заасан.

Цөмийн бодис, цацраг идэвхт хаягдал, цөмийн материал, цацрагийн үүсгүүрийг хууль бусаар /эрх, хууль ёсны зөвшөөрөлгүй этгээд/ олж авсан, хадгалсан, ашигласан, шилжүүлсэн, экспортолсон, импортолсон, худалдсан, булшилсан нь зөрчлөөс ялгагдах шинж бөгөөд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны явцад дээрх шинж илэрвэл даруй прокурорт мэдэгдэж, холбогдох материалын хамт хүргүүлнэ.

Шалган шийдвэрлэх ажиллагаа

5.11 дүгээр зүйл. “Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль зөрчих”

7.11 дүгээр зүйл. “Ашигт малтмалын тухай хууль зөрчих” зөрчлийн шалган шийдвэрлэх ажиллагаанд заасан арга хэрэгслээс сонгож хэрэг бүртгэлтийн ажиллагааг хийж гүйцэтгэнэ.

3.19 Авто тээврийн тухай хууль зөрчих

Зөрчлийн тухай хуулийн 14.6 дугаар зүйлд дараах байдлаар заасан. Үүнд:

7. Чиглэлийн тээврийн хэрэгслийн чиглэл, замналын зогсоолыг зөвшөөрөлгүйгээр шинээр тогтоосон, эсхүл өөрчилсөн бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
9. Хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас гаргасан нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
10. Хуульд заасан үүргээ:
 - 10.1. Тээвэрлэгч;
 - 10.2. Тээвэрлүүлэгч;
 - 10.3. Зорчигч биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Анхаарах асуудал

Энэхүү зөрчил нь байгаль орчинтой холбоотой зөрчлүүд дээр холбогдох талтай. Тухайлбал “Чиглэлийн тээврийн хэрэгслийн чиглэл ... зөвшөөрөлгүйгээр шинээр тогтоосон, эсхүл өөрчилсөн” зөрчлийн хувьд байгалийн гаралтай бүтээгдэхүүн тээвэрлэх явцад зөвшөөрөгдсөн чиглэлээр явалгүйгээр чиглэлийг өөрчлөн явуулснаас хөрс шинээр эвдэрч байгаль орчинд хохирол учирдаг. Өмнөговь аймаг дахь нүүрсний тээвэрлэлт, зарим төмрийн хүдэр, бусад полиметаллийн уурхайгаас улсын

хил рүү ачих тээвэрлэлт хийх явдаа өгөгдсөн чиглэлийг өөрчлөн явснаас 1 км өргөн зурваст 30-40 машин зам гарч хөрс ихээр эвдэрдэг байна.

3.20 Төрийн албан тушаалтны шийдвэрийг үл биелүүлэх, үйл ажиллагаанд нь саад учруулах

Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлд дараах байдлаар заасан. Үүнд:

1. Төрийн албан хаагчийг хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх зорилгоор:
 - 1.1. Тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг бусдад уриалсан;
 - 1.2. Хууль ёсны дагуу шаардсан холбогдох мэдээ, мэдээллийг цаг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл санаатайгаар худал мэдээлэл өгсөн, эсхүл төөрөгдүүлсэн;
 - 1.3. Хийсэн үйл ажиллагаанд нь саад учруулсан, эсхүл хөндлөнгөөс нөлөөлөхийг оролдсон бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлж байгаа:
 - 2.1. Төрийн албан хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхгүй байхыг уриалсан;
 - 2.2. Төрийн албан хаагчийн үйл ажиллагаанд нь саад учруулсан;
 - 2.3. Төрийн албан хаагчийг хүч хэрэглэхгүйгээр эсэргүүцсэн, эсхүл доромжилсон бол хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: Энэ хуульд заасан “хууль сахиулах чиг үүрэг” гэж цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, төрийн тусгай хамгаалалтын албаны алба хаагчийн хуульд заасан чиг үүргийг ойлгоно.

15.7 дугаар зүйл. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах

1. Шүүх, прокурорын дуудсанаар хүрэлцэн ирэхээс зориуд зайлсхийсэн, эсхүл гэрч, хохирогч, шинжээч мэдүүлэг өгөхөөс зайлсхийсэн, татгалзсан, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.
2. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч шүүхэд хүрэлцэн ирэх, эсхүл шүүхэд мэдүүлэг өгөхөөс татгалзсан, зайлсхийсэн, эсхүл шүүхийн иргэдийн төлөөлөгч, шүүхийн захиргааны ажилтны үйл ажиллагаанд саад учруулсан бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ХЭЛБЭРИЙН ЗАГВАРУУД

ТЭМДЭГЛЭЛ

ЗШША-1

Зөрчлийн талаар амаар болон холбоо,
мэдээллийн хэрэгслээр гаргасан гомдол,
мэдээллийг хүлээн авсан тухай

..... оны .. дугаар хот, сум
сарын ..-ны өдөр Дугаар.....

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын БОГУУХГ-ын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч /эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэр/ би, иргэн СХД-ийн тоотод оршин суух, регистртэй, утастай, Б овогтой Д гаргасан гомдлыг / мэдээлэл/ Цагдаагийн ерөнхий газар Мөрдөн байцаах алба Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Цагдаагийн хошууч Х.Б-ын оны ... дугаар сарын-ний өдрийн 11/52455 дугаар албан бичгээр /гомдол гаргасан хүн, хуулийн этгээд, албан тушаалтны нэр, хаяг, утасны дугаар, регистр, улсын бүртгэлийн дугаар/ шилжүүлэн ирүүлснийг танилцав. Үүнд: “Улаанбаатар хотын тоотод оршин суух хаягтай Б овогтой Б нь гурван /3/ толгой Шонхор шувууг аймгийн сумын нутаг дэвсгэрээс оны дугаар сарын -ны өдөр зохих зөвшөөрөлгүйгээр барьж улсын дугаартай Toyota Landcruiser-80 маркийн автомашинд тээвэрлэж явсан үйлдлийг шалгуулж, арга хэмжээ авхуулах” талаар дурдсан гомдол /мэдээлэл/-ыг оны сарын -ний өдрийн цаг минутад хүлээн авч Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.2 дугаар зүйлд заасны дагуу тэмдэглэл үйлдэв.

Гомдол гаргагч нь гэмт хэрэг, зөрчил, түргэн тусламж, гамшиг, аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, гал түймрийн талаар эрх бүхий байгууллагад хуурамч дуудлага, мэдээлэл өгсөн бол Зөрчлийн тухай хуулийн 15.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан хариуцлага хүлээлгэхийг сануулав.

ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДСЭН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН

ТУШААЛТАН: /...../ /Улсын байцаагч /

/гарын үсэг/ /нэр/

ТАНИЛЦСАН:

ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ

ГАРГАСАН: /...../ /...../

/ гарын үсэг/ /нэр/

ХЯЛБАРШУУЛСАН ЖУРМААР ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНЫ ТЭМДЭГЛЭЛ

.... оны .. дугаар
сарын .. -ны өдөр

..... хот, сум

Дугаар...

Мэргэжлийн хяналтын байгууллагын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Б овогтой Д /эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэр/ би, Цагдаагийн ерөнхий газар Мөрдөн байцаах алба Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Цагдаагийн хошууч Х.Б-ын оны дугаар сарын-ний өдрийн 11/..... дугаар албан бичгээр /гомдол гаргасан хүн, хуулийн этгээд, албан тушаалтны нэр, хаяг, утасны дугаар, регистр, улсын бүртгэлийн дугаар/ Улаанбаатар хотын тоотод оршин суух хаягтай Б овогтой Б нь гурван /3/ толгой Шонхор шувууг аймгийн сумын нутаг дэвсгэрээс оны дугаар сарын -ны өдөр зохих зөвшөөрөлгүйгээр барьж улсын дугаартай Toyota Landcruiser-80 маркийн автомашинд тээвэрлэж явсан үйлдлийг шалгуулж, арга хэмжээ авхуулахаар ирүүлсэн хүсэлттэй танилцаад хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг явуулсан талаар тэмдэглэл үйлдэв.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд регистртэй хувиараа бизнес хийдэг,оот хаягт оршин суух Б овогтой Б, регистртэй, хувиараа хөдөлмөр эрхэлдэг, ...-ийн ... хороо тоот хаягт оршин суух Г овогтой Б нарыг оролцуулж, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар бүлэгт заасан оролцогчийн эрх, үүргийг тайлбарлан өгч гарын үсэг зуруулав.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр регистртэй бичиг баримттай, хувиараа эрхэлсэн ажилтай,тоот хаягт оршин суух Ц овогтой Б оролцсон болохыг тэмдэглэв.

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААГААР ТОГТООГДСОН
НӨХЦӨЛ БАЙДАЛ /тодорхой бичих/**

Орон нутгийн хяналтын хэсгийн зохицуулагч цагдаагийн ахмад Я.С, зохицуулагч цагдаагийн ахмад Г.Г, зохицуулагч цагдаагийн дэслэгч Б.Б нар “Оюутан тээвэр -2” нэгдсэн арга хэмжээний хүрээнд оны .. дугаар сарын ..-ний өдөр ... аймгийн ... сумын нутагт үүрэг гүйцэтгэж байх үед аймгийн сумаас Улаанбаатар хотын чиглэлд явж байсанулсын дугаартай Toyota Landcruiser-80 маркийн автомашинд 3 толгой Шонхор шувуу тээвэрлэж явааг шалгаж журмын дагуу Цагдаагийн ерөнхий газрын Мэдээлэл шуурхай удирдлагын төвд мэдэгдсэн.

Цагдаагийн ерөнхий газрын Мөрдөн байцаах албаны Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөн байцаагч Э.Э холбогдогч Улаанбаатар хотынтоотод оршин суудаг регистртэй Б овогтой Б оны ... дугаар сарын ..-ний өдөр МША-53 маягтаар авсан тэмдэглэл,

Мөрдөн байцаах албаны Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад Б.Т холбогдогч Улаанбаатар хотын тоотод оршин суугч..... регистртэй Г овогтой Б-ээс

..... оны ... дугаар сарын ..-ний өдөр мэдүүлэг авсан тэмдэглэл,
 Мөрдөн байцаах албаны Хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэрэг мөрдөх хэлтсийн эрүүгийн ахлах мөрдөн байцаагч Э.Э зохих зөвшөөрөлгүйгээр барьж улсын дугаартай Toyota Landcruiser-80 маркийн автомашинд тээвэрлэж явсан 3 толгой Шонхор шувууг Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Хүрээлэн буй орчин байгалийн нөөцийн удирдлагын газрын гэрээт ажилтан Н.Х хүлээлгэн өгсөн тухай тэмдэглэл, /.... оны .. дугаар сарын ..-ний өдөр/ Монголын “Амьтан хамгаалах сан” БОМБ-ын тэргүүн С.Д, Амьтны эрх хамгаалах нийгэмлэгийн ажилтан З.Э, “Тоодог идлэг шонхор хамгаалах сан” ТББ-ийн ажилтан Б.Д нарын зэрлэг амьтан суллан тавьсан тухай оны .. дугаар сарын ..-ны өдрийн тэмдэглэл, зураг, видео бичлэг зэрэг нотлох баримтаар тогтоогдож байна.

Зөрчил үүсэхэд ашигласан эд зүйл болох шонхор шувууны даавуун өлгий 3 ширхэг, ширэн толгойвч 1 ширхэг тус тус хураагдаж ирсэн байна.

Иймд холбогдогч Б овогтойрегистртэй хувиараа хөдөлмөр эрхэлдэг /овог, нэр, регистр, улсын бүртгэлийн дугаар, ажил, албан тушаал/ гаргасан зөрчилд нотлох баримт бүрдүүлэх, шалгаж тодруулах шаардлагагүй, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулахгүйгээр хялбаршуулсан журмаар зөрчлийг шалган шийдвэрлэх боломжтой, Зөрчлийн тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2 -д заасан шийтгэл оногдуулах үндэслэлтэй байх тул Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.6 дугаар зүйлд заасныг удирдлага болгон хялбаршуулсан журмаар шийдвэрлэх нь зүйтэй байна.

Ажиллагааны явцыг харуулсан гэрэл зураг 6 удаа авч, байгальд нь буцааж тавьсан зураг 7 дуу, Шонхор шувууг байгальд нь эргүүлэн тавьсан дүрсний бичлэг хийж баталгаажуулан тэмдэглэлд хавсаргав.

Ажиллагааны явцад оролцогч Б.Б-ээс шийтгэлийг заасан хугацаанд нь төлнө гэсэн санал, хүсэлт гаргасныг тэмдэглэлд тусган барагдуулан шийдвэрлэв.

Тэмдэглэлийг оролцогчдод танилцуулахад бичигдсэн байна гэв.

ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДСЭН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН

ТУШААЛТАН: /...../ // Улсын байцаагч Б овогтой Д /

/гарын үсэг/ /нэр/

ТАНИЛЦСАН:

ОРОЛЦОГЧ: /...../ // Б овогтой Ц /

/гарын үсэг/ /нэр/

ГЭРЧ: /...../ /Ц овогтой Б/

/гарын үсэг/ /нэр/

ХОЛБОГДОГЧ: /...../ // Б овогтой Б/

/гарын үсэг/ /нэр/

ТЭМДЭГЛЭЛ

..... оны дугаар
сарын-ны өдөр

..... аймаг сум

Дугаар...

Битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах,
хамгаалах үүрэг хүлээсэн хүнд хүлээлгэн өгөх тухай

Мэргэжлийн хяналтын байгууллагын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Б овогтой Д /эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэр/ би, А овогтой Б регистртэй хувиараа хөдөлмөр эрхэлдэг /гомдол гаргасан хүн, хуулийн этгээд, албан тушаалтны нэр, хаяг, утасны дугаар, регистр, улсын бүртгэлийн дугаар/ А овогтой Б-ээс гаргасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй лицензийн талбайн гадна олборлолт явуулж байна гэсэн /гомдол, мэдээллийн утга/ гэх зөрчлийн талаарх гомдол, мэдээллийн дагуу оны .. сарын .. -ны өдөр Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 7.1 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт зааснаар зөрчлийн хэрэг нээж, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж оны ... сарын ...-ний өдөр прокурорын зөвшөөрөлтэйгөөр битүүмжлэгдсэн Samsung LM520 маркийн шар, улаан өнгөтэй дунд оврын экскаваторыг улсын байцаагчийн 1112, 1311 тоот лацаар лацдав. /битүүмжлэгдсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн нэр, төрөл, хэлбэр, тоо хэмжээ, чанар байдлыг тодорхой бичих/-ыг аймгийн сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч Х.Х-д битүүмжлэгдсэн хөрөнгө, эд зүйлийг хадгалах, хамгаалах үүрэг болгов. /битүүмжлэгдсэн хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах, хамгаалах үүрэг хүлээж буй этгээдийн нэр, хаяг, эрхэлсэн ажил, иргэний бичиг баримтын дугаар/ оны ... сарын ..-ний өдрөөс оны .. сарын ..-ний өдрийг хүртэлх хугацаанд /битүүмжлэгдсэн хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах газрын байршил, хаяг/ хадгалж, хамгаалуулахаар Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 4.6 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу хариуцуулан өгч, Эрүүгийн хуулийн 21.10 дугаар зүйлд заасан хариуцлага хүлээлгэх талаар сануулж, тэмдэглэл үйлдэв.

ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДСЭН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН

ТУШААЛТАН: /..... / / Б овогтой Д..... /

/гарын үсэг/ /нэр/

БАЙЛЦСАН:

ХОЛБОГДОГЧ: /..... / / А овогтой Б..... /

/гарын үсэг/ /нэр/

БАЙЛЦСАН:

ХОХИРОГЧ: /..... / С овогтой Д..... /

/гарын үсэг/ /нэр/

ХӨРӨНГӨ, ЭД ЗҮЙЛИЙГ

ХҮЛЭЭН АВСАН: /..... / / Х овогтой Х..... /

/гарын үсэг/ /нэр/

ТЭМДЭГЛЭЛ

..... оны дугаар

сарын ...-ны өдөр

..... хот, сум

Дугаар...

Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө,
орлого, эд зүйл, баримт бичгийг зөрчлийн хэрэгт
хавсаргах тухай

Мэргэжлийн хяналтын байгууллагын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч Ц овогтой Д /эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэр / би, оны сарын -ны өдөр Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн 4.2 дугаар зүйлийн 1 дахь хэсэгт зааснаар зөрчлийн хэрэг нээсэн Ц овогтой Д -д холбогдох 02-..... дугаартай хэрэгт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйл, баримт бичиг/аль нь болохын доогуур зурах/улаан шар өнгийн HYUANDAI – 3000 LC-7A маркийн экскаваторын 1 ширхэг компьютер нь зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой, зөрчлийг шалган шийдвэрлэх хүртэл түр хугацаагаар хадгалах шаардлагатай байх тул аймгийн ... сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч А овогтой Ч /хүн, хуулийн этгээдийн нэрийг тодорхой бичих/ холбогдох зөрчлийн 02-..... дугаартай хэрэгт 1 ширхэг компьютер нэр бүхий зүйлийг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж дуустал хадгалж, энэ тухай тэмдэглэл үйлдэн, зөрчлийн хэрэгт хавсаргав.

ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДСЭН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН

ТУШААЛТАН:/...../ /..... Ц овогтой Д...../

/гарын үсэг/ /нэр/

ТАНИЛЦСАН:/...../ /..... Ц овогтой Д...../

/гарын үсэг/ /нэр/

ТЭМДЭГЛЭЛ

Хэргийн материалыг хохирогч, түүний хууль ёсны
төлөөлөгч, өмгөөлөгчид танилцуулсан тухай

..... оны дугаар

сарын -ны өдөр хот, сум

Дугаар...

Мэргэжлийн хяналтын байгууллагын Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч С овогтой Б / эрх бүхий байгууллага, албан тушаалтны нэр/ би, оны ... сарын -ны өдөр Зөрчлийн тухай хуулийн тусгай ангийн дугаар зүйлийн дахь хэсэгт зааснаар зөрчлийн хэрэг нээсэн Ө овогтой М -д холбогдох 02-..... дугаартай хэрэгт зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж дууссан, зөрчлийг шалган шийдвэрлэх хангалттай нотлох баримт цугларсан тул энэ талаар хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэж, Монгол Улсын Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.9 дүгээр зүйлд заасны дагуу танилцуулж, тэмдэглэл үйлдэв.

ТЭМДЭГЛЭЛ ҮЙЛДСЭН:

ЭРХ БҮХИЙ АЛБАН

ТУШААЛТАН:/...../ /..... С овогтой Б...../

/гарын үсэг/ /нэр/

ТАНИЛЦСАН:/...../ /.....Ө овогтой М...../

/гарын үсэг/ /нэр/

ТЭМДЭГЛЭЛ

..... оны дугаар
сарын -ны өдөр хот, сум

Дугаар...

